СЭХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч **Айтүүлс ХХК** нь Монгол Улсын “Компанийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн холбогдох журмуудын дагуу өөрийн хувьцаанаас анх удаа олон нийтэд санал болгож байна.

ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Үнэт цаас гаргагч болон үнэт цаастай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл Айтүүлс ХХК болон андеррайтер Стандарт инвестмент ҮЦК-д хандана уу.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

Үнэт цаас гаргагч Айтүүлс ХХК нь Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны болон Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу хороо хүлээн зөвшөөрсөн болон тусгай зөвшөөрөл бүхий аудитын компани, үл хөдлөх хөрөнгийн ба бизнесийн үнэлгээчин, хуульч болон андеррайтерийн компанитай гэрээ байгуулан үнэт цаасны талаарх зохих дүгнэлтүүдийг гаргуулав. Эдгээр байгууллагууд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтнууд нь хоорондоо нэгдмэл сонирхолгүй ба андеррайтер Стандарт инвестмент ҮЦК ХХК-аас бусад нь үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтнуудтай нэгдмэл сонирхолгүй болно. Үнэт цаас гаргагч болон андеррайтер компани нь нэгдмэл сонирхолтой этгээдүүд юм.

АНДЕРРАЙТЕР	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер	Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, 5/3 тоот Утас/Факс: 976-70114433 И-мэйл: info@standardinvestment.mn Вэбсайт: www.standardinvestment.mn
БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ	**АТЕН ХХК**
ATEN COMPANY	Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 2-р 40 мянгат, Пума ХХК-ийн байр, 3 давхар Утас: 976-99040051, 99080050 И-мэйл: aten_company@yahoo.com
ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ	**АТЕН ХХК**
ATEN COMPANY	Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, 2-р 40 мянгат, Пума ХХК-ийн байр, 3 давхар Утас: 976-99040051, 99080050 И-мэйл: aten_company@yahoo.com
АУДИТ	**СҮЛД АУДИТ ХХК**
SULD AUDIT	Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, 8-р хороо, GB Center, 502 тоот Утас: 976-70118016, 99114056 И-мэйл: dolgorsuren@suld-audit.mn Вэбсайт: www.suld-audit.mn
ХУУЛЬ	**МОНГОЛ ЗАРГА ӨМГӨӨЛЛИЙН НӨХӨРЛӨЛ**
Монгол зарга хууль зүйн фирм	Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, 45А байр, 2 давхар, 202, 203 тоот Утас/Факс: 976-77004445 И-мэйл: info@mongolzarga.mn Вэбсайт: www.mongolzarga.mn

ТОВЧИЛСОН ҮГ

Товчлол	Тайлбар
ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АТТ	Арилжааны төлбөр тооцоо ХХК
БҮХ	Байгууламжийн үндсэн хэсгүүд
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
SWOT	Давуу тал, сул тал, боломж, аюул /Strengths, Weaknesses, Opportunites, Threats
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗЗХ	Захирлуудын зөвлөлийн хурал
КаТВ	Кабелийн телевиз
MNS	Монголын үндэсний стандарт
МХБ	Монголын хөрөнгийн бирж
МОНЦАМЭ	Монголын цахилгаан мэдээ
МТШХХГ	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
МТХХ	Мэдээлэл, технологи, харилцаа холбоо
МХТ	Мэдээлэл холбооны технологи
МХХТГ	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар
МШХХТГ	Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
EPS	Нэгж хувьцаанд ногдох ашиг /Earnings per Share
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮДТ	Үндэсний дата төв
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮЦТҮХ	Үндэсний цахилгаан тоноглол үйлдвэрлэгчдийн холбоо
P/E	Үнэ ашгийн харьцаа /Price to Earning ratio
P/B	Үнэ ба эзэмшигчдийн өмчийн харьцаа /Price to Book ratio
ҮЦТХТ	Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв
ҮЦК	Үнэт цаасны компани
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ROA	Хөрөнгийн өгөөж /Return on Assets
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХЦК	Хувьцаат компани

ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ROE	Эзэмшигчийн өмчийн өгөөж /Return on Equity

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Нэр томъёо	Тайлбар
Үнэт цаас гаргагч	Олон нийтэд үнэт цаасаа санал болгож буй компани
Андеррайтер	Үнэт цаасыг олон нийтэд санал болгох мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй компани
Нэгж хувьцаанд ногдох ашиг	Цэвэр ашгийн дүнг гаргасан хувьцааны тоонд харьцуулсан дүн
Үнэ ашгийн харьцаа	Зах зээлийн үнийг нэгж хувьцаанд ногдох ашигт харьцуулсан дүн
Хөрөнгийн өгөөж	Цэвэр ашгийг нийт хөрөнгөд харьцуулсан дүн
Эзэмшигчийн өмчийн өгөөж	Цэвэр ашгийг эзэмшигчийн өмчид харьцуулсан дүн
Апекс программ	Байгууллагын өдөр тутмын нягтлан бодох бүртгэлийг хийж, өгөгдлийн боловсруулалт, тооцооллыг гүйцэтгэн, санхүүгийн нэгдсэн тайлангуудыг гаргадаг санхүү, нягтлан бодох бүртгэлийн цогц программ
Модуляр дата төв	Зөөвөрлөн тээвэрлэхэд хялбар, мөн өгөгдлийн ачааллын хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжтой, цахилгааны болон хөргөлтийн бие даасан дэд бүтцийн шийдэл бүхий нэг ба түүнээс дээш угсармал модулиудаас бүрддэг цогц дата төв
Домэйн нэр	Цахим хуудас буюу вэб сайтын хаяг /itools.mn гэх мэт/
Сервер	Тусгай программ хангамж суулгасан, өндөр хурдны интернэтэд холбогдсон, байнга асаалттай байж, вэб сайтын хэвийн үйл ажиллагааг хангадаг тусгай зориулалтын тоног төхөөрөмж
Вэб байршуулах	Серверийн тодорхой хэмжээний зайнд цахим хуудсыг байршуулж, домэйн нэрийг нь холбон тохируулж, нийтийн хүртээл болгох
Клауд	Үүлэн тооцоолол /cloud computing/: сүлжээнд холбогдсон программ хангамж ба виртуал хэлбэрт шилжсэн техник тоног төхөөрөмж, тэдгээрийг уян хатан удирдан зохицуулах программ хангамж болон түүнд үндэслэсэн үйлчилгээ
Нөөцлөлт	Аливаа мэдээлэл, өгөгдлийн сан, системүүдийг эрсдлээс сэргийлэх үүднээс өөр эх үүсвэрт хуулбарлан хадгалах үйлдэл
Дата хэрэглээ	Интернэтэд хандсан хандалт
Контент	Харилцаа холбооны сүлжээгээр тоон хэлбэрт хувирган дамжуулж байгаа бүтээлийн шинж чанартай тэмдэгт, дохио, текст, зураг, дуу, авиа, дүрс бичлэг болон бүх төрлийн мэдээ мэдээллийг хэлнэ. Мэдээллийн технологи, харилцаа холбооны сувгаар олон нийтэд түгээх, худалдаж борлуулах зорилгоор зохиогчийн эрхийн бүтээлийг тоон хэлбэрт

	хувирган найруулж, дүрсжүүлсэн байдал
Гега байт	Мэдээллийн багтаамжийг хэмжих нэгж
Өргөн зурвас	Мэдээлэл холбооны дамжуулах сувгийн багтаамжийн хэмжээг хэлэх ба олон төрлийн дохиолол, траффикийг нэгэн зэрэг дамжуулах орчин
Шилэн кабель	Гэрлийг дамжуулдаг шил эсвэл хуванцар утас. Мэдээллийг өндөр хурдаар дамжуулах чадвартай.
Киоксал кабель	Зэсэн кабелийн төрөл, мэдээлэл дамжуулдаг
Шөрмөсийн түрээс	Шилэн кабелийн шөрмөсийн түрээс
Суваг түрээс	Шилэн кабель татах боломжтой суваг, түүнийг түрээслэх
TIER	АНУ-ын үндэсний стандартын институтын дата центрийн стандарт
SSL сертификат	Secure locked layer /SSL/ сертификат нь хэрэглэгчээс сервер рүү илгээж байгаа мэдээллийг encrypt буюу шифрлэж нууцлан илгээх ба серверээс хэрэглэгчид ирж байгаа мэдээллийг ямар нэг өөрчлөлтгүй, бүрэн бүтэн дамжуулах механизмыг үүсгэсний баталгаа юм.
IP хаяг	Интернэт протоколын хаяг /Internet protocol address/: интернетэд холбогдсон компьютер бүр өөрийн IP хаяг гэгч тоон хаягтай байдаг. Интернэт дэх олон зуун тооцоолуур дотроос IP хаягаараа ялгарч тооцоолуурууд хоорондоо мэдээлэл дамжуулдаг.
3G	Хөдөлгөөнт холбооны сүлжээний технологийн 3 дах үе
DSL	Телефон утасны шугам ашиглан боломжит өндөр хурдаар интернэтийг дамжуулах технологи
DWDM	Дамжуулах байгууламжийн ерөнхий шаардлага, хэмжилт
EVDO	3G технологийн стандарт
EDGE	GSM шийдэлд зориулсан өргөтгөсөн өгөгдлийн хурд
GPRS	Утасгүй холбооны стандарт, 2.5G технологи
FTTH	Оптик шилэн кабелийг айл бүрт түгээх сүлжээ
Mbps	Мэдээллийн багтаамжийг хэмжих нэгж
SDH	Оптик шилэн кабель болон радио долгионы нягтруулгын төхөөрөмж. Өөр өөр багтаамжаар дамжуулж нягтруулах боломжтой технологи
VPN	Шилэн кабелиар хувийн дотоод сүлжээ зохион байгуулж, онлайн холболт үүсгэх /виртуал хувийн сүлжээ/
VSAT	Сансрын холбоо
Wi-Fi	Радио долгион ашиглан интернэтэд холбогдох холболтын төрөл
Wimax	Утасгүй холбооны төрөл
VMWare	Физик болон виртуал сервер удирдах, хянах зориулалтын

СЭХ
он сар . . . одор
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

программ

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЭХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

АГУУЛГА

Хөрөнгө оруулагчдын анхааралд 1
Үнэт цаасны танилцуулгад оролцсон байгууллагууд 2
Товчилсон үг 3
Нэр томъёоны тайлбар 5
НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ 13
Үнэт цаас гаргагчийн танилцуулга 13
Үнэт цаас гаргагчийн Улсын бүртгэлийн мэдээлэл 16
Компанийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээ 17
Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа 17
Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээ 21
Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ 25
Үнэт цаас гаргагчийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц 28
Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө, өөрийн хөрөнгө, үнэт цаасны тухай 32
Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл 32
Үнэт цаас гаргагчийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч 35
Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр 36
Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэрэгжилтийн тухай 36
Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай 37
Компанийн засаглалын кодексийг хэрхэн мөрдөж буй талаарх мэдээлэл 38
Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого 38
Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл 41
Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн тухай мэдээлэл 43
ХОЁР. ХАРААТ БУС ДҮГНЭЛТҮҮД 44
Хараат бус аудиторын дүгнэлт 44
Хөрөнгийн үнэлгээ 46
Бизнесийн үнэлгээ 48
Хуулийн дүгнэлт 54
ГУРАВ. ТӨСЛИЙН ТУХАЙ 57
Төслийн товч танилцуулга 57
Төслийн үндэслэл 57
Төсөл хэрэгжих байршил 60
Зах зээлийн судалгаа 62
Орчны дүгнэлт, SWOT шинжилгээ 100
Модуляр дата төвийн байгууламж, үйлдвэрлэлийн технологи 105
Төслийн төсөв, санхүү 114
Эрсдлийн шинжилгээ 120
ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ 126
Үнэт цаас эзэмшигчдийн эрх, үүрэг 127
Үнэт цаасыг олон нийтэд арилжих журам 129
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт 139
Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хувилбар 141
ТАВ. АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ 143
Андеррайтерийн дүгнэлт гаргах үндэслэл 143
Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдалд хийсэн дүн шинжилгээ 146
Цаашдын төлөвлөгөө, ирээдүйн боломж 148
Хөрөнгө оруулалтын өгөөж 149

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮДС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

ЗУРГАА. АНДЕРРАЙТЕРИЙН ТАНИЛЦУУЛГА.....154

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Дата төвд 2017 оны 3-р сарын байдлаар ашиглаж буй сервер, тоног төхөөрөмж 19
Хүснэгт 2. Үйлчилгээний төрлүүд 21
Хүснэгт 3. Байршуулах үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд 22
Хүснэгт 4. Түрээслүүлэх үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд 23
Хүснэгт 5. Нөөцлөлтийн үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд..... 23
Хүснэгт 6. Дагалдах үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд 24
Хүснэгт 7. Мэдээллийн аюулгүй байдлын үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд 24
Хүснэгт 8. Сургалтын үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд 24
Хүснэгт 9. Тусламжийн үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд 25
Хүснэгт 10. Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн тойм 25
Хүснэгт 11. Вэб байршуулах (Shared hosting) үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, төгрөгөөр 25
Хүснэгт 12. Реселлер (Reseller hosting) байршуулах үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй..... 26
Хүснэгт 13. Виртуал сервер (VPS) байршуулах үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, төгрөгөөр..... 26
Хүснэгт 14. Сервер байршуулах (Dedicated server) үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, төгрөгөөр 26
Хүснэгт 15. Бизнес и-мэйл үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, төгрөгөөр..... 26
Хүснэгт 16. Клауд драйв (Cloud drive) үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, төгрөгөөр..... 26
Хүснэгт 17. Контейнер, модуляр дата төв байршуулах үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй..... 26
Хүснэгт 18. Тоног төхөөрөмж, дэд бүтэц түрээслүүлэх үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй 27
Хүснэгт 19. Нөөцлөлтийн үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй 27
Хүснэгт 20. Домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, 2017 он 27
Хүснэгт 26. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл..... 30
Хүснэгт 21. Айтүүлс ХХК-ийн зэргэлдээ компаниудын бүртгэлийн мэдээлэл 31
Хүснэгт 22. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл 33
Хүснэгт 23. Ай Си Ти групп ХХК-ийн бүртгэлийн мэдээлэл 33
Хүснэгт 24. Ай Си Ти групп ХХК-ийн охин компаниудын эзэмшлийн хувь 33
Хүснэгт 25. Ворлд френдс ХХК-ийн бүртгэлийн мэдээлэл 34
Хүснэгт 27. Үнэт цаас гаргагчийн хяналтын багцыг эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл 35
Хүснэгт 28. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, 2013-2016 он /төгрөгөөр/ 41
Хүснэгт 29. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан, 2013-2016 он /төгрөгөөр/..... 42
Хүснэгт 30. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн үнэлгээний дүн..... 47
Хүснэгт 31. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээний дүн 49
Хүснэгт 32. Хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаар хийсэн бизнесийн үнэ цэнийн тооцоолол..... 53
Хүснэгт 33. Тохируулга хийсэн цэвэр хөрөнгийн аргаар хийсэн бизнесийн үнэлгээний тооцоолол 54
Хүснэгт 34. Салбарын орлого, үйлчилгээний төрөл, эзлэх хувь, 2016.06.30..... 75
Хүснэгт 35. Шилэн кабелийн сүлжээг байгуулсан байгууллагууд 76
Хүснэгт 36. Улс хоорондын интернэтийн урсгалыг дамжуулсан байдал..... 78
Хүснэгт 37. Интернэт хэрэглэгчдийн тоо, холбогдох технологиор 80
Хүснэгт 38. Интернэт хэрэглэгчдийн тоо, холбогдох технологиор 87
Хүснэгт 39. Хамгийн олон Монгол вэбсайт байршуулж буй сүлжээ 94
Хүснэгт 40. Хамгийн олон Монгол вэбсайт байршуулж буй улс орнууд 95
Хүснэгт 41. Монгол Улсад вэбсайт байршуулах үйлчилгээ үзүүлж буй компаниуд 95
Хүснэгт 42. Домэйн нэрийн үнийн харьцуулалт..... 99
Хүснэгт 43. Байршуулах үйлчилгээний үнийн харьцуулалт..... 99
Хүснэгт 44. Бусад үйлчилгээний үнийн харьцуулалт 100
Хүснэгт 45. Модулийн төрлүүд 107
Хүснэгт 46. Модуляр дата төвийн /МДТ/ давуу тал 111
Хүснэгт 47. Модуляр дата төвийн эрсдэлтэй тал 112
Хүснэгт 48. Татан төвлөрүүлэх хөрөнгийн ерөнхий задаргаа, төгрөгөөр 114
Хүснэгт 49. Тоног төхөөрөмжийн задаргаа, төгрөгөөр 114

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ТТС 1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЗХ
Он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

Хүснэгт 50. Модуляр дата төвийн хүчин чадлын үзүүлэлт 115
Хүснэгт 51. Модуляр дата төвд шаардлагатай эд хогшлын жагсаалт 115
Хүснэгт 52. Үнэт цаас гаргагчийн 2017-2021 оны орлогын төсөөлөл, мянган төгрөгөөр 116
Хүснэгт 53. Үнэт цаас гаргагчийн 2017-2021 оны борлуулалтын төсөөлөл, мянган төгрөгөөр 117
Хүснэгт 54. Модуляр дата төвийн 2017-2021 оны борлуулалтын төсөөлөл, мянган төгрөгөөр 118
Хүснэгт 55. Хувьцаа эзэмшигчийн хөрвүүлэн эзэмших хувьцааны тоо, эзэмшлийн хувь 132
Хүснэгт 56. Арилжааны банкуудын цахим хуудас 137
Хүснэгт 57. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, хувиар 139
Хүснэгт 58. Татан төвлөрүүлэх хөрөнгийн задаргаа, 75 хувиар 142
Хүснэгт 59. Үнэт цаас гаргагчийн 2011-2016 оны санхүүгийн байдлын тайланд хийсэн бүтцийн шинжилгээ 146
Хүснэгт 60. Үнэт цаас гаргагчийн 2011-2016 оны хураангуй орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээ 147
Хүснэгт 61. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдалд хийсэн харьцааны шинжилгээ 147
Хүснэгт 62. Хөрөнгө оруулалтын өгөөж 150

ГРАФИК

График 1. 2016 оны борлуулалтын мэдээ 19
График 2. Айтүүлс ХХК-ийн харилцагчдын бүтэц 20
График 3. Мэдээллийн технологи, харилцаа холбооны стандартын төрөл, дэд салбараар 69
График 4. Монгол Улсын болон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 74
График 5. Харилцаа холбооны салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ ба ДНБ-д эзлэх хувь 74
График 6. Салбарын нийт орлого, тэрбум төгрөг 75
График 7. Улс хоорондын интернэтийн урсгал, Mbps 77
График 8. МТШХХ салбарын нийт ажиллагсдын тоо, мянга 78
График 9. Их сургууль төгсөгчид болон мэдээллийн технологийн чиглэлээр төгсөгчдийн тоо, харьцаа 78
График 10. Мэдээллийн технологийн чиглэлээр төгсөгчдийн боловсролын зэргийн байдал 78
График 11. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо 79
График 12. Харилцаа холбооны салбарын хэрэглэгчдийн тоо 80
График 13. 3G технологи хэрэглэгчдийн тоо 81
График 14. Дата хэрэглээ, Тера.байт/Terabyte 81
График 15. Хэрэглээнд гарсан ухаалаг утасны үйлдлийн систем, хувиар, 2015 он 82
График 16. Интернэтийн үүсгэсэн эдийн засаг, 2010 он 83
График 17. Интернэт болон үүрэн утасны хэрэглээний өсөлтийн төсөөлөл 84
График 18. Сүлжээний бэлэн байдлын индекс, Монгол Улс (2007-2015) 84
График 19. Монгол Улсын СББИ-ийн дэд индексийн үзүүлэлтүүд (2011-2015) 86
График 20. Улс орнуудын СББИ-ийн үзүүлэлтүүд 87
График 21. Монгол Улсад вэб байршуулж буй байгууллагууд, зах зээлд эзлэх хувь 96
График 22. Борлуулалтын орлогын өсөлт /сая.төг/ 116
График 23. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт 140

ЗУРАГ

Зураг 1. Модуляр дата төвийн паркийн эскиз зураг 21
Зураг 2. Монгол Улсын газар нутгийн газар хөдлөлтийн мужлалт 61
Зураг 3. Монгол Улсын газар нутгийн үерийн эрсдлийн түвшин 61
Зураг 4. Аптайм Институтээс гэрчилгээ авсан дата төвүүдийн газарзүйн байршил 91
Зураг 5. Швейцарийн Swisscom AG-ийн Berne-Wandorf дата төв 91
Зураг 6. Контейнер/модуляр дата төвийн гадаад байдал 105
Зураг 7. Контейнер/модуляр дата төвийн дотоод зохион байгуулалт 106
Зураг 8. Контейнер/модуляр дата төвийн план зураг 106
Зураг 9. Модуляр дата төвийн паркийн зохион байгуулалт 107
Зураг 10. Уламжлалт дата төвийн хүчин чадлын эрэлтийн муруй 110

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЗХ
он сар ... өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

Зураг 11. Модуляр дата төвийн хүчин чадлын эрэлтийн муруй *110*

СХЕМ

Схем 1. Үнэт цаас гаргагчийн одоогийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц..... *28*
Схем 2. Үнэт цаас гаргагчийн толгой болон зэргэлдээ компаниудын нэгдэл..... *30*
Схем 3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид ба эзэмшлийн хувь..... *32*
Схем 5. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулахад хөрвөх хувьцаа..... *132*
Схем 6. Үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд байршуулах үе шат *133*
Схем 7. Үнэт цаас худалдан авах алхмууд *136*
Схем 8. Үнэт цаасыг олон нийтэд сурталчилах хөтөлбөр *138*

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА



Үнэт цаас гаргагч:	Айтүүлс ХХК
Үйл ажиллагааны чиглэл:	Мэдээллийн технологи
Нийт гаргах хувьцааны тоо:	34,452,124 ширхэг
Олон нийтэд санал болгох хувьцаа:	13,387,980 ширхэг буюу 38.86%
Олон нийтэд санал болгох үнэ:	100.00 төгрөг
Хувьцааг арилжих арга:	Тогтоосон үнээр санал болгох
Татан төвлөрүүлэх хөрөнгө:	1,338,798,000 төгрөг
Татсан хөрөнгийн зарцуулалт:	Модуляр дата төвийн парк
Андеррайтер:	Стандарт инвестмент ҮЦК

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№01

НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

Айтүүлс ХХК нь 2011 оноос эхлэн мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд цаашид газарзүйн нөөц байршил болох Дархан хотод Модуляр дата төвийн паркийг барьж ашиглалтанд оруулснаар дотоодын төдийгүй гадаадын компаниудад дэлхийн жишигт нийцсэн цахим мэдээллийн байршуулалт, дамжуулалт, хадгалалтын үйлчилгээг үзүүлж, харилцагч, үйлчлүүлэгчдийнхээ үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийг зорьж байна. Эх орны эдийн засаг болон мэдээллийн технологийн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор Модуляр дата төвийн парк байгуулах төслийг хэрэгжүүлэх гэж байна.

Үнэт цаас гаргагчийн танилцуулга

Айтүүлс ХХК нь 2011 онд программ хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан бөгөөд 2012 оноос эхлэн домэйн нэрийн бүртгэл, вэб байршуулалт, сервер байршуулах, виртуал серверийн түрээс, бизнес и-мэйл ашиглалт зэрэг интернет технологид суурилсан бүтээгдэхүүн, үйчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүст үзүүлж, тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангасаар ирсэн. Үнэт цаас гаргагч нь 2017 оны байдлаар 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлж, 3,700 гаруй харилцагчид үйлчилгээ үзүүлэн, хамтран ажиллаж байна. Компанийн гол үйлчилгээнүүд нь сервер байршуулах, виртуал болон физик сервер түрээслүүлэх, вэб байршуулах үйлчилгээнүүд юм. 2016 онд компанийн харилцагчдын тоо тасралтгүй нэмэгдэж 3,700 гаруй болсон ба дотоодын “Бизмэйл” үйлчилгээг шинээр нэвтрүүллээ.

Үнэт цаас гаргагч нь бизнесийнхээ өсөлтийг хангах, үйл ажиллагаагаа тогтвортой хөгжүүлэх зорилгоор 2015 онд олон улсын түвшний TIER II стандартын шаардлагыг хангасан дата төвийг Улаанбаатар хотод байгуулсан бөгөөд үүний үр дүнд компанийн бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээ, серверүүд нь бие даасан, тасралтгүй, найдвартай байдалд шилжиж чадсан. Тус дата төвийн хүчин чадлыг 2016 онд хоёр дахин нэмэгдүүлсэн. Компани нь үйлчилгээнийхээ чанарыг сайжруулж, харилцагчдын интернэт ашиглалт, вэбтэй холбоотой гарсан доголдлыг цаг алдалгүй арилгах, цаашид доголдол гаргахгүйн тулд дата төвдөө долоо хоногийн 24 цагийн турш системийн администраторууд ажиллуулж, төвд байршиж буй серверүүд болон вэб сайтуудын интернэт орчин дах тасралтгүй, хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Ийнхүү, үнэт цаас гаргагч нь өнгөрсөн 5 жилийн хугацаанд 100 хувь дотооддоо сервер байршуулах болон дагалдах үйлчилгээг чанартай үзүүлж, мэдлэг чадвартай ажилтнууд, дэлхийн шилдэг техник технологи, зөв менежментээр ажилласны үр дүнд мэдээллийн технологийн салбарын тэргүүлэх компаниудын нэг болж чадсан юм. Тодруулбал, Айтүүлс ХХК нь Монголын программ хангамжийн салбарын 2015 оны “Шилдэг үйлчилгээ” үзүүлэгч компаниар, компанийн системийн инженер Л.Мөнхтөр нь “Мэдээллийн технологийн оны шилдэг Инженер”-ээр тус тус тодорсон байна. Мөн, 2016 онд “Цахим нотариат” төслийн дэд

бүтцийн ханган нийлүүлэгчээр ажиллахаар шалгаруулалтад тэнцэж, Best of Mongolia 2016 олон нийтийн санал асуулгад “Оны шилдэг мэдээллийн технологийн компани”-аар шалгарав.

Компанийн онцлох үйл явдлууд

Огноо	Онцлох үйл явдал	Хэрэглэгчид /өссөн дүнгээр/
2011 он	− Компани үүсгэн байгуулагдав.	
2012 он	− Домэйн нэр бүртгэлийн үйлчилгээ үзүүлж эхлэв. − Нэмэлт үйлчилгээнүүдийг дамжуулан борлуулж эхлэв. − Вэб хостинг, Виртуал сервер үйлчилгээг үзүүлж эхлэв.	370
2013 он	− Вэб байршуулах үйлчилгээг үзүүлж эхлэв. − Өөрийн мэйл болон Drive үйлчилгээг шинээр нэвтрүүлэв.	610
2014 он	− Рееэллэр хостингийн үйлчилгээг нэвтрүүлэв. − Физик серверийн үйлчилгээг үзүүлж эхлэв.	1,350
2015 он	− Монголын сайтуудын холбооны гишүүн болов. − Компанийн үндсэн дата төвийг байгуулж (TIER II) ашиглалтанд оруулав. − Олон улсын APNIC байгууллагын гишүүн болов. − Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбооны гишүүнээр элсэв. − Интернет түгээлтийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл бүхий Си нет ХХК-ийг шилжүүлэн авч, үйлчилгээ үзүүлж эхлэв.	3,000
2016 он	− Дотоод сервертэй мэйл үйлчилгээ нэвтрүүлэв. − СЗХ болон МХБ-д үнэт цаасаа бүртгүүлж, нээлттэй компани болох эхлэлийг тавив. − Best of Mongolia 2016 олон нийтийн санал асуулгад “Оны шилдэг мэдээллийн технологийн компани”-аар шалгарав. − Үндсэн дата төвийг өргөжүүлэх, тохижилтын ажлууд хийгдэв.	3,700

Үнэт цаас гаргагч нь цахим мэдээлэл хадгалалтын үйлчилгээгээ өргөжүүлэх, аюулгүй байдлыг бүрэн хангах зорилгоор 2016 оноос Дархан-Уул аймаг дах өөрийн эзэмшлийн газарт газарзүйн нөөц, “Модуляр дата төвийн парк” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Шинээр баригдах Модуляр дата төв буюу зөөвөрлөн тээвэрлэхэд хялбар, өгөгдлийн ачааллын хүчин чадлыг хүссэн хэмжээгээр нэмэгдүүлэх боломжтой, цахилгааны болон хөргөлтийн бие даасан дэд бүтэцтэй, нэг ба түүнээс дээш угсармал модулиудаас бүрдэх цогц дата төв нь үндсэн серверээсээ газарзүйн хувьд алслагдмал байршилтай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн TIER III стандартыг хангахуйц байх ба энэ нь байгаль, цаг уурын эрсдэл, давагдашгүй хүчин зүйлсийн эрсдлийг бууруулан, мэдээллийг давхар хадгалах боломжийг бүрдүүлэх юм. Ингэснээр үндсэн дата төвд дотоод, эсхүл гадны хүчин зүйлсээс хамаарч үйл ажиллагааны доголдол үүсэхэд нөөц дата төв хэвийн ажиллаж байгаа нөхцөлд үйлчлүүлэгчийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал алдагдахгүй байх давуу талтай. Модуляр дата төвийн паркийг байгуулснаар Айтүүлс ХХК нь дата төвийн үндсэн үйлчилгээг үзүүлэхээс гадна орчин үеийн дэвшилтэт технологи болох клауд /үүлэн тооцоолол/ төрлийн цогц үйлчилгээг дотоодын зах зээлд нэвтрүүлж, Монгол Улсын мэдээллийн технологийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулах юм.

Алсын хараа, эрхэм зорилго:

Айтүүлс ХХК нь байгуулагдсан цагаасаа эхлэн дараах алсын хараа, эрхэм зорилгод хүрэхийн төлөө ажиллаж байна.

Алсын хараа: Олон улсын стандартын шаардлага хангахуйц байршуулах үйлчилгээ үзүүлэгч дэлхийн компани болох

Уриа: Зогсолтгүй хөгжиж, амжилтаараа ялгаръя

Эрхэм зорилго: Мэдээллийн технологийн шилдэг шийдлийг ашиглан, хэрэглэгчиддээ тасралтгүй, найдвартай үйлчилгээг хүргэх

Үнэт зүйлс:

- Ажилтан, түүний компаниа гэсэн хүсэл эрмэлзэл
- Хэрэглэгчийн мэдээлэл
- Компанийн нэр хүнд, бизнесийн ёс зүй
- Дотоод болон гадаад хамтын ажиллагаа

Үнэт цаас гаргагчийн хаяг, байршил

Айтүүлс ХХК нь 2017 оны 3-р сарын байдлаар харилцагчиддаа ойртон, Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 8-р хорооны Амарын гудамжны 22-р байрны 7 давхарт үйл ажиллагаа явуулж байна. Компани нь үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах зорилгоор өөрийн эзэмшлийн байранд үндсэн дата төвийн үйлчилгээгээ явуулдаг. Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 2-р хорооны 34-р байрны 2 тоот байрыг эзэмшдэг ба үндсэн дата төв нь нийслэл хотын Чингэлтэй дүүргийн 1-р хорооны, Жигжиджавын гудамж 5/3 хаягт байршиж байна.

Төслийн байршил:

Шинээр байгуулах Модуляр дата төвийн парк нь Улаанбаатар хотоос 220 км зайд орших, дэд бүтэц хөгжсөн, цахилгаан эрчим хүчний бие даасан эх үүсвэртэй, Монгол Улсын аж үйлдвэрийн томоохон төв болох Дархан-Уул аймгийн Дархан хотод байршина.

Компанийн оффис болон үндсэн дата төвийн байршил

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаас гаргагчийн Улсын бүртгэлийн мэдээлэл

Компанийн оноосон нэр	Айтүүлс ХХК
Үүсгэн байгуулагдсан огноо	2011/04/11
Регистрийн дугаар	5468361
Бүртгэлийн дугаар	9011662016
Компанийн хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Үйл ажиллагааны чиглэл	Мэдээлэл технологи, программ хангамжийн үйлчилгээ
Хувьцаа эзэмшигчдийн тоо	1
Компанийн албан ёсны хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, 34-р байр, 2 тоот
Гүйцэтгэх захирал	И.Алтантулга
Утас	75755585, 70164444
И-мэйл	info@itools.mn
Цахим хуудас	www.itools.mn

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ш. 5444381

Компанийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээ

Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээ

Үнэт цаас гаргагч нь 2011 оны 4-р сарын 13-нд анх “Интеллижент түүлс” гэдэг оноосон нэрээр Улсын бүртгэлд бүртгүүлэн, 9011662016 дугаар бүхий Улсын бүртгэлийн гэрчилгээг авч байсан ба 2012 оны 3-р сарын 22-нд оноосон нэрээ Айтүүлс ХХК болгон өөрчилж, СЗХ-ны 2016 оны 20 дугаар тогтоолын дагуу 2016 оны 2-р сард Айтүүлс ХК болгон өөрчилсөн байсныг 2017 оны 3-р сарын 7-ны өдөр эргүүлэн Айтүүлс ХХК болгосон байна.

Газар эзэмших гэрчилгээ

Үнэт цаас гаргагч нь Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг даргын 2016 оны 5-р сарын 25-ны өдрийн А/174 тоот шийдвэрээр Дархан сумын 12-р багт байршилтай, нэгж талбарын 4506102458 дугаар бүхий 1,500 м.кв газрыг 5 жил, 4506102457 дугаар бүхий 1,000 м.кв газрыг 5 жилийн хугацаатайгаар тус тус эзэмшиж буйг 000319838, 000319837 дугаар бүхий Аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээнүүд гэрчилж байна.



Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ

Үнэт цаас гаргагч нь Нийслэлийн Улсын бүртгэлийн газарт Y-2205018687 дугаарт бүртгэлтэй Баянгол дүүргийн 2-р хороо, 2-р хороолол, 34-2 тоот хаягт байршилтай 86 м.кв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгчийн эрхийг олгосон Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн 000444869 дугаар бүхий гэрчилгээг, мөн үндсэн дата төвийн байршиж буй Y-2202024358 дугаарт бүртгэлтэй Чингэлтэй дүүргийн 1-р хороо, Жигжиджавын гудамж 5/3 тоот хаягт байршилтай 72 м.кв зоорийн давхрын үл хөдлөх эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгчөөр гэрчилсэн 000463567 дугаартай гэрчилгээг эзэмшиж байна.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд байгууллага, аж ахуйн нэгжүүдэд цахим орон зайд үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлдэг домэйн нэрийн бүртгэл, и-мэйл, вэб хост, сервер түрээс, нөөцлөлт, сервер байршуулалт, интернэтийн үйлчилгээ зэрэг интернэт технологи болон дата төвд суурилсан цогц үйлчилгээг үзүүлж байна. Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний 80 гаруй хувийг өөрийнх нь үндсэн бүтээгдэхүүн эзэлдэг бол үлдсэн 20 орчим хувийг гуравдагч этгээдээс дамжуулан борлуулж буй бүтээгдэхүүн эзэлдэг. Үнэт цаас гаргагч нь цаашид өөрийн нөөц боломжийг ашиглаж, дамжуулан борлуулж буй

бүтээгдэхүүнийг орлох шинэ бүтээгдэхүүн зах зээлд гаргаж, дамжуулан борлуулж буй бүтээгдэхүүний эзлэх хувийг бууруулах бодлого баримтлан ажиллаж байна. Тухайлбал, жил гаруйн хугацаанд туршин хөгжүүлсний эцэст Монголд анх удаа 100 хувь дотоодын сервер дээрээс ажилладаг бизнес и-мэйл буюу “БизМэйл” үйлчилгээг 2016 оны 5-р сараас эхлэн шинээр нэвтрүүлж, 220 гаруй байгууллагад хүргэн үйлчилж байна.

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйлчилгээ нь вэб байршуулах, вэб сервер байршуулах, сервер түрээслүүлэх юм. Эдгээрийг тодруулбал:

- Вэб буюу цахим хуудас байршуулах нь аж ахуйн нэгж, байгууллагын вэб сайтыг интернэт орчинд буюу серверт тохирсон хэмжээний зайд байршуулан, домэйн нэрийг нь холбож, олон нийтэд хүргэх үйлчилгээ;
- Сервер /вэб сервер/ байршуулах үйлчилгээ нь аж ахуйн нэгж, байгууллагын серверийг дата төвдөө байршуулан, мэдээллийн аюулгүй байдал, тасралтгүй, найдвартай ажиллагааг нь хангах үйлчилгээ;
- Сервер /физик болон виртуал/ түрээслэх үйлчилгээ нь дата төвд байршиж буй өөрийн серверийг бусдад түрээслэх үйлчилгээ юм.

Сервер гэдэг нь тусгай программ хангамж суулгасан, өндөр хурдны интернэтэд холбогдсон, байнга асаалттай байж, вэб сайтын хэвийн үйл ажиллагааг хангадаг тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг хэлнэ. Энэхүү тоног төхөөрөмж нь үнэтэй байдаг тул хэрэглэгч бүр сервер худалдан авах шаардлагагүй ба физик болон виртуал хэлбэрээр өөрийн хэрэгцээнд тохируулан түрээслэж болдог. Хэрэглэгчийн хэрэгцээг тодорхойлсны дараа тухайн хэрэглэгчид тохирох үзүүлэлттэй серверийг зохиомол байдлаар /виртуалаар/ үүсгэн, хэрэглэгчид түрээслүүлж болдог. Сервер нь хэт халж, гэмтэл амархан авах магадлалтай ба байнга буюу өдрийн 24 цаг тасалдалгүй хэвийн ажиллах ёстой тул тодорхой хэмийн сэрүүн орчинд, цахилгаан, интернэтийг нь таслахгүй хэвийн ажиллагааг нь хангадаг, мөн аюулгүй байдлыг нь хамгаалдаг дата төв хэмээх тусгай үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагад хадгалуулдаг.

Үнэт цаас гаргагч нь хэрэглэгчиддээ вэб болон сервер байршуулах үйлчилгээг цогцоор нь хүргэх зорилгоор 2015 онд олон улсын TIER II стандартын шаардлагад нийцсэн дата төвийг Улаанбаатар хотын А зэрэглэлийн бүсэд байршиж буй өөрийн байранд байгуулж,

ашиглалтанд оруулсан. Энэхүү дата төв нь цахилгааны нөөц эх үүсгэвэртэй, агаарын хэмийг сэрүүцүүлэх тоноглолтой, өдөр бүр 24 цагийн турш тасралтгүй ажиллах нөхцлийг хангасан юм. Үнэт цаас гаргагч нь 2016 онд дата төвийнхээ хүчин чадлыг бараг 2 дахин нэмэгдүүлж, зориулалтын хөргөгч төхөөрөмж худалдан авсан. Үнэт цаас гаргагч нь дата төвдөө 2017 оны байдлаар дорх сервер, тоног төхөөрөмжүүдийг ашиглаж байна.

Хүснэгт 1. Дата төвд 2017 оны 3-р сарын байдлаар ашиглаж буй сервер, тоног төхөөрөмж

Дата төвийн үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хүчин чадал	Ашиглалтын хувь	Ашиглагдаагүй нөөцийн хувь
Серверүүд	ширхэг	15	60%	40%
CPU	GHz	250		
RAM	GB	1,000		
Storage	TB	60		
Хөргөлтийн систем	kW	26	80%	20%
Нөөц цахилгааны эх үүсвэр	kW	12	50%	50%
Цахилгаан цэнэг баригч/UPS	kW	18	30%	70%
Урсгал/сүлжээний хүчин чадал				
Гадаад урсгал	Mbps	100	90%	10%
Дотоод урсгал	Mbps	10,000	10%	90%
Рак	ширхэг	10	50%	50%
Ашиглалтын талбай	$м^2$	32	39%	61%
Нөөцийн дундаж үзүүлэлт				**51%**
Ашиглалтын дундаж үзүүлэлт				**49%**

Дата төвийн серверүүдийн ашиглагдаагүй нөөц 50 хувиас их байх тусмаа сайн ба энэ нь дата төвд доголдол үүссэн тохиолдолд өгөгдлийг зөөн байршуулах зэргээр учирч болох эрсдлийг бууруулах давуу тал болдог байна.

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, 2013 онд борлуулалтын орлого 155.7 сая төгрөг, 2014 онд 268.4 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оныхоос 72 хувиар өссөн бол 2015 оны эцсээр компанийн борлуулалт 312.6 сая төгрөгт хүрч, өмнөх оныхоос 16.5 хувиар өслөө. Өнгөрсөн 2016 онд Айтүүлс ХХК нь 474.9 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оныхоос даруй 52 хувиар өссөн байна.

График 1. 2016 оны борлуулалтын мэдээ



2016 оны борлуулалтын орлогод эзлэх бүтээгдэхүүний хувь хэмжээг харахад компанийн үндсэн үйлчилгээ болох хост буюу вэб байршуулалт, виртуал болон физик сервер байршуулалт, сервер түрээс болон домэйн нэрийн үйлчилгээг харилцагчид хамгийн ихээр хэрэглэж байна. Энэ онд компанийн бусад орлого мөн өндөр хувьтай гарсан нь тендерт идэвхтэй оролцож, нэмэлт ажил хийсэнтэй холбоотой байна.

Үнэт цаас гаргагч нь 2017 оны байдлаар вэб байршуулах үйлчилгээний Монголын нийт зах зээлийн 18 хувийг эзэлж байгаа ба дотооддоо хамгийн их цахим хуудас байршуулж чадсан дата төвтэй бөгөөд цаашид энэ хурдаар өсвөл 2021 онд зах зээлийн 45 хүртэлх хувийг эзлэх боломжтой гэж үзжээ /Монголд үйл ажиллагаа явуулж, өөрийн цахим хуудсыг идэвхтэй ажиллуулдаг аж ахуйн нэгжүүдээс санамсаргүй байдлаар түүвэрчлэн, гурван мянган вэб сайтын байршлыг судалж тооцоолсон байна/.

Компани одоогийн байдлаар нийт 3,700 гаруй харилцагчидтай ба харилцагчдын бүтцийг харвал ихэнх нь аж ахуйн нэгжүүд, 18 хувь нь хувь хүмүүс, 11 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, 7 хувь нь орон нутгийн байгууллагууд, 7 хувь нь төрийн болон боловсролын байгууллагууд, 4 хувь нь гадаадын харилцагчид, үлдсэн нэг хувь олон улсын төсөл хөтөлбөрүүд байна. Сүүлийн жилүүдэд Айтүүлс ХХК-ийн үйлчлүүлэгчдийн тоо тогтмол өсч, том харилцагчид нэмэгдэж байгаа ба 2 хувьд хүрсэн байна.

График 2. Айтүүлс ХХК-ийн харилцагчдын бүтэц



Үнэт цаас гаргагч нь 2016 оноос газарзүйн нөөц Модуляр дата төвийн парк байгуулах төслийг хэрэгжүүлэхээр ажилласан ба уг модуляр дата төвийг байгуулснаар вэб байршуулалт, сервер байршуулалт, сервер түрээс, өгөгдөл хадгалалт, нөөцлөлтийн үйлчилгээнийхээ хүчин чадлыг нэмэгдүүлж, клауд буюу үүлэн тооцооллын технологид суурилсан үйлчилгээнүүдийг шинээр нэвтрүүлэхээр төлөвлөж байна. 2017 оны байдлаар Модуляр дата төвийн парк байгуулах газрын зөвшөөрлийг 5 жилээр сунгуулан, хашаа татан сайжруулалт хийснээс гадна, эскиз зургийг гаргаж, Дархан-Уул аймгийн Ерөнхий архитектороор батлуулаад байна. Мөн барилгын ажлыг эхлүүлэхэд шаардлагатай зөвшөөрлүүдийг холбогдох газруудаас авч дууссан байна.

Зураг 1. Модуляр дата төвийн паркийн эскиз зураг

Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь интернэт орчинд суурилсан, дата төвийн болон интернэт түгээлтийн 7 төрлийн үндсэн үйлчилгээг 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр төрөлжүүлэн зах зээлд нийлүүлж байна. Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглээний онцлогоос хамааруулан дараах үндсэн төрлүүдэд ангилна. Үүнд:

Хүснэгт 2. Үйлчилгээний төрлүүд

№	Үйлчилгээ	Тайлбар
1	Байршуулах үйлчилгээ	Вэбсайт, вэбд суурилсан системүүд, и-мэйл болон зориулалтын сервер, тоног төхөөрөмжүүдийг зориулалтын дата төвд байршуулах үйлчилгээ Тусгай сервер дээр тодорхой хэмжээний зайн үйлчилгээг аваад, вэб сайтыг байршуулж, домэйн нэр холбон тохируулснаар вэб сайт ажиллаж, бусдад харагдах боломжтой болдог.
2	Тоног төхөөрөмж, дэд бүтэц түрээслүүлэх үйлчилгээ	Хэрэглэгчид шаардлагатай сервер, тоног төхөөрөмж, дэд бүтцийг түрээслүүлэх үйлчилгээ /өөрийн хэрэгцээнд тохирсон түрээсийн үйлчилгээ авах нь үнэтэй сервер, тоног төхөөрөмж худалдан авч ашигласнаас хямд байдаг/
3	Нөөцлөлтийн үйлчилгээ	Айтүүлс ХХК-ийн үзүүлдэг бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээ болон хэрэглэгчийн өөр газарт байршуулсан мэдээллийн системийг нөөцлөн, эрсдлээс сэргийлэх, шаардлагатай үед нөөцийг сэргээн, учирсан эрсдлээс хохирол багатай гарах боломжийг олгодог үйлчилгээ
4	Дагалдах үйлчилгээ	Айтүүлс ХХК-ийн үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг дагалдах бусад үйлчилгээ /и-мэйл, түгээлт, г.м./

5	Мэдээллийн аюулгүй байдлын үйлчилгээ	Хэрэглэгчдийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үзүүлж буй зөвлөх буюу гүйцэтгэх үйлчилгээ
6	Сургалт	Харилцагч, хэрэглэгчдэдээ зориулсан хэрэглэгчийг чадавхжуулах, мэдлэг олгох үйлчилгээ
7	Тусламж	Компаниас үзүүлж буй үйлчилгээг ашиглах үед тулгардаг аливаа үйл ажиллагааны болоод техникийн асуудлуудыг шийдвэрлэхэд хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Үйлчилгээний төрөл тус бүрийг бүтээгдэхүүний нэр төрлөөр нь ангилан дор харуулав. Үүнд:

Байршуулах үйлчилгээ

Хүснэгт 3. Байршуулах үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд

№	Бүтээгдэхүүн	Төрөл	Тайлбар
1	Дундын серверт вэб байршуулах /Shared hosting/	4	Олон тооны вэб сайтыг интернэтэд зэрэг байршуулан, вэб серверээр хангах үйлчилгээ юм. Танилцуулга, блог зэрэг жижиг хэмжээтэй вэб сайт байршуулахад тохиромжтой.
2	Хост дамжуулан борлуулах /Reseller hosting/	3	Гадны вэб хостингийн бүтээгдэхүүнийг гэрээний үндсэн дээр худалдан авч ашиглан, эцсийн хэрэглэгчдэд дамжуулан борлуулна. Олон тооны вэб сайт хийдэг, хөгжүүлдэг аж ахуйн нэгж, хувь хүмүүст тохиромжтой үйлчилгээ.
3	Виртуал сервер /VPS - Virtual Private Server/	4	Виртуал сервер (VPS) гэдэг нь физик буюу бодит сервер дээр виртуалчлалын технологийг ашиглан, бие даасан хүчин чадалтай бүрэн хандалтын эрхтэй, харилцан хамааралгүй ажиллахаар тохируулагдсан, зохиомол байдлаар үүсгэсэн сервер юм. Өөрөөр хэлбэл хийсвэр хувийн сервер буюу нэг сервер дээр хэд хэдэн сайт байрлаж ачаалал үүсгэхийн оронд хийсвэрээр тус тусад нь сервер мэт зохицуулж, сайтууд хоорондоо хамааралгүй ажиллана. Үнэтэй физик сервер худалдан авахгүйгээр хямд зардлаар сервер ашиглах боломжийг хэрэглэгчдэд олгодог.
4	Сервер байршуулах /Dedicated server/	4	Хэрэглэгчийн өөрийнх нь серверийг байнга буюу жилийн 365 хоног 24 цагт, байнгын асаалттай байлгах боломжийг бүрдүүлсэн дата төвд байршуулах үйлчилгээ юм. Хэрэглэгч нь сервер, тоног төхөөрөмжөө аль хэдийнээ худалдан авсан боловч, дэлхийн стандартад нийцсэн орчин, хязгааргүй хурдтай интернэт холболт бүхий дата төвд байршуулснаар байнгын анхаарал, хяналт, аюулгүй байдлыг хангах үйлчилгээг авна.
5	Бизнес и-мэйл	2	Байгууллагад зориулсан албан ёсны и-мэйлийн үйлчилгээг өөрийн эх үүсвэрээс өсхүл гаднаас

			дамжуулан борлуулдаг.
6	Бизнес драйв	1	Дата хадгалах онлайн орон зайн үйлчилгээ. Үйл ажиллагаа онлайн горимд шилжиж буй өнөө үед мэдээлэл буюу датаг онлайн хадгалах нь тоног төхөөрөмж, олон газар байршуулах багтаамжийг хэмнэхээс гадна нэгэн зэрэг хандаж, өөрчлөлтийг хийх боломжийг олгодог давуу талтай юм.
7	Контейнер/модуляр дата төвийн үйлчилгээ		Дархан-Уул аймагт баригдах “Модуляр дата төвийн парк”-ийн үйл ажиллагаа эхлэхэд энэ үйлчилгээг үзүүлж эхэлнэ.

Тоног төхөөрөмж, дэд бүтэц түрээслүүлэх үйлчилгээ

Хүснэгт 4. Түрээслүүлэх үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд

№	Бүтээгдэхүүн	Тайлбар
1	Сервер түрээслүүлэх үйлчилгээ	Сервер худалдан авч ашиглах нь үнэтэй бөгөөд маш том, эсвэл олон сайт байршуулахад тохиромжтой байдаг. Хэрэв хэрэглэгч серверийн тоног төхөөрөмжийг худалдан авах шаардлагагүй, зардал багатай гэж үзвэл физик серверийг түрээслэн ашиглах нь илүү тохиромжтой. Физик сервер түрээслэн ашиглах нь дараах давуу талуудтай. Үүнд: – Өндөр дүнтэй худалдан авалт хийхгүй. – Хэрэгцээ шаардлагыг хангасан зохистой техник үзүүлэлт бүхий сервер ашиглах боломжтой. – Зогсуур буюу сервер байршуулах үйлчилгээний төлбөр төлөгдөхгүй. – Серверийн техник, ашигт ажиллагаанд санаа зовох шаардлагагүй.
2	Контейнер/модуляр дата төв түрээслүүлэх үйлчилгээ	Дархан-Уул аймагт баригдах “Модуляр дата төвийн парк”-ийн үйл ажиллагаа эхлэхэд энэ үйлчилгээг үзүүлж эхэлнэ.

Нөөцлөлтийн үйлчилгээ /back up/

Хүснэгт 5. Нөөцлөлтийн үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд

№	Бүтээгдэхүүн	Тайлбар
1	Вэбсайт нөөцлөлт	Харилцагчийн вэб сайтыг тодорхой хугацааны давтамжтайгаар нөөцөлж авах үйлчилгээ
2	Өгөгдлийн сангийн нөөцлөлт	Дархан-Уул аймагт баригдах “Модуляр дата төвийн парк”-ийн үйл ажиллагаа эхлэхэд энэ үйлчилгээг үзүүлж эхэлнэ.
3	Виртуал серверийн нөөцлөлт	Харилцагчийн виртуал серверийн датаг тодорхой хугацааны давтамжтайгаар нөөцөлж авах үйлчилгээ
4	Физик серверийн нөөцлөлт /Dedicated Server/	Харилцагчийн физик серверийг датаг тодорхой хугацааны давтамжтайгаар нөөцөлж авах үйлчилгээ

Дагалдах үйлчилгээ

Хүснэгт 6. Дагалдах үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд

№	Бүтээгдэхүүн	Төрөл	Тайлбар
1	Домэйн нэр бүртгэх	26	Интернэтэд байршуулах вэб сайтын хаяг буюу тухайн хэрэглэгчийн сонгосон нэр, өргөтгөл бүхий домэйн нэрийг олгож, бүртгэх үйлчилгээ
2	SSL /Secure socket layer/ сертификат үүсгэх	5	SSL сертификат нь сервер болон хэрэглэгчийн хооронд дамжуулж буй мэдээллийг нууцлах, аюулгүй байдлыг нь хадгалах технологи юм. Хэрэглэгчээс сервер рүү илгээж байгаа мэдээллийг encrypt буюу шифрлэж нууцлан илгээх ба серверээс хэрэглэгчид ирж байгаа мэдээллийг ямар нэг өөрчлөлтгүй, бүрэн бүтэн дамжуулах механизмыг үүсгэсний баталгаа болно.
3	Ай Пи /IP – Internet Protocol/ хаяг олгох	1	Виртуал сервер түрээслүүлэх, сервер байршуулах үйлчилгээнүүдэд бодит IP хаяг үүсгэх үйлчилгээ үнэ төлбөргүй багтдаг. Түүнчлэн, дээрх хоёр үйлчилгээ болон вэб байршуулах хязгааргүй үйлчилгээнд хүссэн тооны IP хаягийг нэмэлтээр үүсгэж өгдөг.

Мэдээллийн аюулгүй байдлын үйлчилгээ

Хүснэгт 7. Мэдээллийн аюулгүй байдлын үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд

№	Бүтээгдэхүүн	Тайлбар
1	Байршуулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах	Байршуулах үйлчилгээ ашиглаж буй системийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах
2	Мэдээллийн аюулгүй байдлын зөвлөх үйлчилгээ	Байгууллага, хувь хүмүүст мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх
3	Системийн аюулгүй байдал	Байгууллага, хувь хүмүүсийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр үйлчилгээ үзүүлэх

Сургалт

Хүснэгт 8. Сургалтын үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд

№	Бүтээгдэхүүн	Тайлбар
1	Бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх сургалт	Хэрэглэгчиддээ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн төрөл зүйл, боломжуудыг таниулах, илүү үр дүнтэй ашиглаж сурахад нь дэмжлэг үзүүлэх
2	Интернэт орчинд аюулгүй ажиллах тухай сургалт	Байгууллага, хувь хүмүүст зориулсан интернэт орчинд аюулгүй ажиллах, интернэт ашигласан луйвар, хакерлаг гэмт хэргүүдээс хэрхэн сэргийлэх тухай мэдлэг олгох

Тусламж

Хүснэгт 9. Тусламжийн үйлчилгээнд хамаарах бүтээгдэхүүнүүд

№	Бүтээгдэхүүн	Тайлбар
1	Онлайн тусламж үзүүлэх	https://secure.itools.mn системээр дамжуулан хэрэглэгчиддээ ажлын цагаар борлуулалтын, 24 цагийн турш техникийн тусламжийн үйлчилгээг тус тус үзүүлдэг.
2	Утсаар тусламж үзүүлэх	75755585 дугаарын утсаар хэрэглэгчиддээ ажлын цагаар борлуулалтын, 24 цагийн турш техникийн тусламж үзүүлдэг.
3	Хэрэглэгчид хүрч үйлчлэх	Харилцагчийн дуудлагаар байранд нь очиж техникийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ

Айтүүлс ХХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ нь бусад ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй компаниудтай харьцуулахад илүү хямд байдаг. Үйлчилгээнийхээ үнэ цэнийг тогтоохдоо дэлхийн зах зээлийн жишигт нийцсэн төлбөрийн давтамж болон үнийг үндэслэсэн бөгөөд хэрэглэгчид сонгосон үйлчилгээгээ аль болох урт хугацаанд ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор урт хугацааны давтамжинд хөнгөлөлт үзүүлэх бодлого барьдаг.

Хүснэгт 10. Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн тойм

№	Бүтээгдэхүүн. үйлчилгээ	Төлбөрийн мөчлөг	Үнийн хязгаар
1	Байршуулах үйлчилгээ	Сар, улирал, хагас жил, жил, 2 жил, 3 жил	29,000₮ – 5,644,800₮
2	Тоног төхөөрөмж, дэд бүтэц түрээслүүлэх үйлчилгээ	Сар	400,000₮-өөс эхэлнэ
3	Нөөцлөлтийн үйлчилгээ	Сар	20,000₮-өөс эхэлнэ
4	Дагалдах үйлчилгээ	Сар, жил	4,900₮-өөс эхэлнэ
5	Мэдээллийн аюулгүй байдлын үйлчилгээ	Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагаас хамаарна	
6	Сургалт	Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагаас хамаарна	
7	Тусламж	Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагаас хамаарна	

Бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрийн үнийн дэлгэрэнгүйг дор хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Хүснэгт 11. Вэб байршуулах (Shared hosting) үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, төгрөгөөр

№	Бүтээгдэхүүний нэр	Сар	Улирал	Хагас жил	Жил	2 жил (-7%)	3 жил (-14%)
1	Shared hosting [Нэг домэйнтэй]	-	-	-	79,000	148,000	207,000
2	Shared hosting [Олон домэйнтэй]	-	-	-	179,000	334,000	465,000

3	Shared hosting [статик вэб]	-	-	-	29,000	52,940	74,820

Хүснэгт 12. Реселлер (Reseller hosting) байршуулах үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй

№	Бүтээгдэхүүний нэр	Сар	Улирал	Хагас жил	Жил	2 жил	3 жил
1	Reseller hosting	100,000	279,000	516,000	948,000		

Хүснэгт 13. Виртуал сервер (VPS) байршуулах үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, төгрөгөөр

№	Бүтээгдэхүүний нэр	Сар	Улирал (-8%)	Хагас жил (-15%)	Жил (-23%)	2 жил (-31%)	3 жил (-38%)
1	VPS 1 (1core, 1Gb, 15Gb)	52,000	144,000	264,000	480,000	864,000	1,152,000
2	VPS 2 (1core, 2Gb, 30Gb)	88,400	244,800	448,800	816,000	1,468,800	1,958,400
3	VPS 3 (2 core, 4Gb, 60Gb)	149,500	414,000	759,000	1,380,000	2,484,000	3,312,000
4	VPS 4 (4 core, 8Gb, 120Gb)	254,800	705,600	1,293,600	2,352,000	4,233,600	5,644,800

Хүснэгт 14. Сервер байршуулах (Dedicated server) үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, төгрөгөөр

№	Бүтээгдэхүүний нэр	Сар	Улирал	Хагас жил	Жил	2 жил	3 жил
1	1 unit	89,000	-	-	-	-	-

Хүснэгт 15. Бизнес и-мэйл үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, төгрөгөөр

№	Бүтээгдэхүүний нэр	Үнэ
1	Сэцэн бизнес и-мэйл Өвөрмөц дизайн (iPhone, Android) 2ГВ багтаамж Хуанли, тэмдэглэл, ажлын төлөвлөгөө	12,000₮/жил*хэрэглэгч
2	Бизнес и-мэйл Өвөрмөц дизайн (iPhone, Android) 5ГВ багтаамж Хуанли, тэмдэглэл, ажлын төлөвлөгөө	12,000/жил*хэрэглэгч

Хүснэгт 16. Клауд драйв (Cloud drive) үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, төгрөгөөр

№	Бүтээгдэхүүний нэр	Сар	Улирал	Хагас жил	Жил	2 жил	3 жил
1	Сэцэн бизнес драйв	-	-	-	30,000	60,000	90,000

Хүснэгт 17. Контейнер, модуляр дата төв байршуулах үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй

№	Бүтээгдэхүүний нэр	Сар	Улирал	Хагас жил	Жил	2 жил	3 жил
1	MDC Colocation	Дархан-Уул аймагт баригдах “Модуляр дата төвийн парк -ийн үйл					

		ажиллагаа эхлэхэд энэ үйлчилгээг үзүүлж эхэлнэ

Хүснэгт 18. Тоног төхөөрөмж, дэд бүтэц түрээслүүлэх үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй

№	Бүтээгдэхүүний нэр	Сар
1	Сервер түрээслүүлэх үйлчилгээ	Серверийн хүчин чадал, хэрэглээнээс хамаарч, 400,000 төгрөгөөс эхэлнэ
2	Контейнер/модуляр дата төв түрээслүүлэх үйлчилгээ	Дархан-Уул аймагт баригдах "Модуляр дата төвийн парк"-ийн үйл ажиллагаа эхлэхэд энэ үйлчилгээг үзүүлж эхэлнэ.

Хүснэгт 19. Нөөцлөлтийн үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй

№	Бүтээгдэхүүн	Сар
1	Вэбсайт	20,000₮
2	Өгөгдлийн сан	Хэмжээ, нөөцлөх давтамжаас хамаарч 20,000₮-өөс эхэлнэ
3	Виртуал сервер	Хэмжээ, нөөцлөх давтамжаас хамаарч 20,000₮-өөс эхэлнэ
4	Физик сервер	Хэмжээ, нөөцлөх давтамжаас хамаарч 20,000₮-өөс эхэлнэ
5	Архиваас сэргээх үйлчилгээ	Хэмжээнээс хамаарч 25,000₮-өөс эхэлнэ

Хүснэгт 20. Домэйн нэрийн бүртгэлийн үйлчилгээний үнийн дэлгэрэнгүй, 2017 он

№	Өргөтгөл/Top Level Domain	Үнэ /жилийн/
1	.MN	80,000₮
2	.COM	29,900₮
3	.INFO	39,900₮
4	.NET	39,900₮
5	.BIZ	39,900₮
6	.ORG	39,900₮
7	.TV	89,900₮
8	.ASIA	39,900₮
9	.PRO	39,900₮
10	.CO	89,900₮
11	.PW	29,900₮
12	.MOBI	89,900₮
13	.XXX	204,000₮
14	.SX	28,000₮
15	.DE	29,900₮
16	.ES	29,900₮
17	.US	29,900₮
18	.CA	39,900₮
19	.EU	29,900₮
20	.ME	89,900₮
21	.TEL	28,000₮
22	.IN	29,900₮
23	.BZ	89,900₮

24	.CC	39,900₮
25	.WS	28,000₮
26	.NL	28,000₮
27	.NAME	29,900₮

Үнэт цаас гаргагчийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц

Үнэт цаас гаргагч компани нь Ай Си Ти групп ХХК-ийн 100 хувийн эзэмшлийн охин компани юм. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд компани нь Төлөөн удирдах зөвлөлгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас Гүйцэтгэх захирлыг томилдог бөгөөд компани одоогоор дөрвөн албатай, нийт 10 ажилтантай ажиллаж байна.

Схем 1. Үнэт цаас гаргагчийн одоогийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц



Үнэт цаас гаргагчийн албадын чиг үүрэг

Албаны нэр	Ажлын үндсэн чиг үүрэг
Гүйцэтгэх удирдлага /Гүйцэтгэх захирал (1)/	Компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Үүнд: - Шийдвэр гаргах - Ажилтнуудыг удирдлагаар хангах
Хөгжүүлэлтийн алба /Системийн инженер (1), Хөгжүүлэгч (1)/	Компанид шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, тохируулах, техник, программ хангамжийн шийдэл гаргах, хөгжүүлэх, компанийн мэдээллийн аюулгүй байдлыг хангана. Үүнд: - Компанийн технологийн шинэ шийдлийг хэрэгжүүлэх - Одоо байгаа системийг тасралтгүй сайжруулах - Техникийн нарийн асуудлыг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх Мэдлэгийн сангаа тэлж бусад ажилтнуудад сургалт явуулах
Техникийн алба /Системийн ахлах	Айтүүлс ХХК-ийн хэрэглэгчдэд үзүүлж буй үндсэн болон нэмэлт бүтээгдэхүүн, үйлчилгээний 24/7 тасралтгүй, хөвөөгүй ажиллагаа, серверийн найдвартай аюулгүй үйл ажиллагааг хангах ажиллах үүрэгтэй.

администратор (1), Системийн администратор (3)/	Үүнд: - Дата төвийн дотоод үйл ажиллагааг удирдах - Систем, серверийн хэвийн үйл ажиллагааг хангах - Хэрэглэгчдэд тусламж үзүүлэх - Бие даасан дотоод системүүдийг хөгжүүлэх - Компанид шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, тохируулах, техник, программ хангамжийн шийдлийг гаргах - Техник, программ хангамжтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, тэдгээрийг тохируулах - Серверийн хөгжүүлэлт, засвар, шинэчлэлтийг хийж байх - Бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах - Шинэ бүтээгдэхүүнийг техникийн түвшинд нэвтрүүлэх
Хөгжүүлэлтийн алба /Системийн инженер (1), Хөгжүүлэгч (1)/	Компанид шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, тохируулах, техник, программ хангамжийн шийдэл гаргах, хөгжүүлэх, компанийн мэдээллийн аюулгүй байдлыг хангана. Үүнд: - Компанийн технологийн шинэ шийдлийг хэрэгжүүлэх - Одоо байгаа системийг тасралтгүй сайжруулах - Техникийн нарийн асуудлыг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх - Мэдлэгийн сангаа тэлж бусад ажилтнуудад сургалт явуулах
Борлуулалт, санхүүгийн алба /Борлуулалтын менежер (1), Нягтлан бодогч (1)/	Байгууллагын маркетингийн үйл ажиллагаа, бодлого төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжүүлэх, борлуулалт, ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан шинэ бүтээгдэхүүн бий болгох, маркетингийн урамшуулал, идэвхжүүлэлтийг оновчтой зохион байгуулах замаар бизнесийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана. Монгол Улсын НББ-ийн холбогдох хууль, тогтоомж, олон улсын НББ-ийн стандарт, толгой компанийн санхүү, НББ-ийн журамд нийцүүлэн, - Компанийн мөнгөн хөрөнгийн хөдөлгөөнийг зохицуулах, хураах, хадгалах, бүртгэх - Авлага, өглөгийн тооцоо бодох, баталгаажуулах, хоорондын тооцоо хийх - Ажилтнуудын цалин болон бусад зардлыг тооцон бодох, хяналт тавих - Санхүүгийн тайлан, мэдээг гаргах болон тэдгээрт дүн шинжилгээ хийж удирдах ажилтнууд болон эрх бүхий байгууллагад тайлагнах - Үндсэн хөрөнгийн тооллого, бүртгэлийг хийх
Тусламж, харилцагчид үйлчлэх алба /Тусламжийн ажилтан (1)/	Харилцагчдын хэрэгцээнд нийцүүлэн, шаардлагатай тусламж үзүүлэх үйлчилгээг хариуцна.

Гүйцэтгэх удирдлага

Үнэт цаас гаргагчийн Компанийн дүрэмд компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлэхээр заасан бөгөөд компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 1-р сарын 25-ны өдрийн ХХ14/03 тоот тогтоолоор Идэрмөнх овогтой Алтантулгыг гүйцэтгэх захирлаар

томилсон байна. Компанийн хувьцаа эзэмшигчид Гүйцэтгэх захиралтай үр дүнгийн гэрээг байгуулан ажиллаж байгаа ба тэрээр компанийн хувьцааг эзэмшдэггүй болно.

Идэрмөнх овогтой Алтантулга нь 1986 онд Баянхонгор аймгийн Баацагаан суманд төрсөн, одоо Улаанбаатар хотын иргэн ба нийслэлд эхнэрийн хамт амьдардаг. Тэрээр санхүүч мэргэжилтэй, 2003-2007 онд Улаанбаатар хотод ШУТИС-ийн харьяа КТМС-ийн санхүүгийн удирдлага мэргэжлээр Бакалаврын зэрэгтэй төгссөн. Ажлын туршлагын хувьд 2007-2009 онд Аэро Монголиа ХХК-ийн нислэг үйлдвэрлэлийн мэргэжилтэн, 2009-2011 онд Ремикон ХК-ийн маркетингийн менежер, 2011-2012 онд Инфо актив ХХК-ийн ерөнхий менежерээр ажиллаж байсан байна. Тэрээр 2017 оны 3-р сарын 7-ны өдрийн байдлаар бусдад хугацаа хэтэрсэн ямар нэгэн өр зээлгүй, ял шийтгэлгүй, хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэн шалгагдаж байсан удаагүй болно. Мөн 2017 оны 3-р сарын байдлаар өөрийн харьяа дүүргийн татварын хэлтэст татварын өр төлбөргүй байна.

Эрх бүхий албан тушаалтнууд

Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд одоогийн компанийн дүрмээр Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулаагүй байна.

Гүйцэтгэх захирал болон компанийн бусад эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд нь компанийн хувьцааг эзэмшдэггүй ба цаашид эзэмших тухай ямар нэгэн гэрээ, хэлцэл одоогоор байгуулаагүй.

Хүснэгт 21. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын талаарх мэдээлэл

№	Эрх бүхий албан тушаалтнууд	Эрхэлж буй албан тушаал	Хаяг	Хувьцаа эзэмшдэг эсэх
1	И.Алтантулга	Гүйцэтгэх захирал	Айтүүлс ХХК	үгүй
2	Ц.Цацралгэрэл	Нягтлан бодогч	Айтүүлс ХХК	үгүй

Айтүүлс ХХК-ийн нягтлан бодогч Цогттуяа овогтой Цацралгэрэл нь 1987 оны 11-р сарын 8-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн ба нийслэлийн 72-р сургуульд 1995-2005 онд суралцаж, 2005-2009 онд Мандах бүртгэл Дээд сургуулийг хяналт шалгалт, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлээр дүүргэсэн. Тэрээр 2010-2012 онд Тавин-Ус ХХК-д ерөнхийн нягтлан бодогчоор, 2012-2015 онд Энержи ресурс ХХК-д ахлах нягтлан бодогчоор ажиллаж байсан туршлагатай ба Айтүүлс ХХК-д 2016 оноос нягтлан бодогчоор ажиллаж байна. Ц.Цацралгэрэл нь компанийн хувьцааг эзэмшдэггүй ба 2017 оны 3-р сарын байдлаар татварын өргүй, шүүхийн шийдвэрээр бусдад төлөх төлбөргүй байна. /Гүйцэтгэх захирал И.Алтантулгын талаар гүйцэтгэх удирдлага хэсэгт товч танилцуулсан болно./

Компанийн нэгдэл

Үнэт цаас гаргагчийн толгой компани Ай Си Ти групп ХХК нь дөрвөн охин компанитай компанийн нэгдэл юм.

Схем 2. Үнэт цаас гаргагчийн толгой болон зэргэлдээ компаниудын нэгдэл



Толгой компани - Ай Си Ти групп ХХК

Ай Си Ти групп ХХК нь Ворлд френдс ХХК-ийн охин компани ба Монгол Улсын стратегийн салбар болох мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг нэгдэл компаниудын толгой компани юм. Ай Си Ти групп ХХК нь мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг дөрвөн компанийг нэгдмэл удирдлага, бодлогоор ханган ажилладаг.

Зэргэлдээ компани - Айдэйм ХХК

Айдэйм ХХК нь тоон контентийг олон улсын чанар, стандартын дагуу хөгжүүлж, дэлхийн зах зээлд нийлүүлэх зорилгоор 2013 онд байгуулагдсан ба мэргэжлийн хөгжүүлэлтийн компани юм. Дараах төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нийлүүлж байна. Үүнд:

- Вэб хөгжүүлэлт
- Десктоп аппликэйшн хөгжүүлэлт
- Мобайл аппликэйшн хөгжүүлэлт

Зэргэлдээ компани - Айконтент ХХК

Ай контент ХХК нь 2013 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд сошиал медиаг шинэ түвшинд гаргасан арга хэлбэрийг ашиглаж, хамгийн бага зардлаар зорилтот зах зээлд нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлдэг. Тус компани нь дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- Сегментлэсэн маркетинг
- Сошиал ТВ
- Сугалаа автоматжуулалт
- Тоон контентийн агрегатор

Зэргэлдээ компани - Си нэт ХХК

Си нэт ХХК нь интернэт үйлчилгээний чиглэлээр 2015 онд үүсгэн байгуулагдсан ба Монгол Улсын хуулийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон 1041/Б/IS96 дугаар бүхий “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт интернэтийн үйлчилгээ үзүүлэх” тусгай зөвшөөрлийн гэрчилгээг эзэмшдэг.

Хүснэгт 22. Айтүүлс ХХК-ийн зэргэлдээ компаниудын бүртгэлийн мэдээлэл

	Ай контент ХХК	Ай дэйм ХХК	Си нэт ХХК
Бүртгэлийн дугаар	9011404038	9011406021	9011542092
Регистрийн дугаар	5696631	5696186	5956056
Бүртгэлийн огноо	2013.08.04	2013.08.04	2015.04.20
Үйл ажиллагааны чиглэл	Мэдээллийн технологи, программ хангамж, гадаад худалдаа	Мэдээллийн технологи, программ хангамж, гадаад	Мэдээлэл технологийн үйлчилгээ, гадаад худалдаа

		худалдаа	
Гүйцэтгэх захирал	А.Баттамир	А.Золбоо	И.Алтантулга
Компанийн хаяг	УБ хот, Баянгол дүүрэг, 6-р хороо, 10-р хороолол, 14А, 19 тоот	УБ хот, Баянгол дүүрэг, 6-р хороо, 10-р хороолол, 14А, 19 тоот	УБ хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Баянмонгол, 412, 124 тоот
Утас	99106605	99066270	99078211
Цахим шуудан	info@icontent.mn	info@itheme.mn	info@cnet.mn
Цахим хуудас	www.icontent.mn	www.itheme.mn	www.cnet.mn

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө, өөрийн хөрөнгө, үнэт цаасны тухай

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ компанийн дүрэмд зааснаар 905,758,223.28 төгрөг, нийт зарласан болон гаргасан хувьцааны тоо 21,064,144 ширхэг, эргүүлэн худалдан авсан хувьцаа байхгүй, гаргасан хувьцаа нь энгийн хувьцаа бөгөөд нэг бүр нь 43.00 төгрөгийн нэрлэсэн үнэтэй байна. Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хэмжээ 2016 оны эцсийн байдлаар 1.4 тэрбум төгрөг байгааг дорх хүснэгтээр харуулав.

Үзүүлэлтүүд	2016.12.31 (₮)
Биет бус хөрөнгө	56,290,331
Биет хөрөнгө	1,561,997,167
Нийт хөрөнгө	**1,618,287,498**
Богино хугацаат өр төлбөр	197,788,183
Урт хугацаат өр төлбөр	-
Нийт өр төлбөр	**197,788,183**
Өөрийн хөрөнгийн дүн	**1,420,499,315**

Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн хувьцааг толгой компани Ай Си Ти групп ХХК 100 хувь эзэмшдэг бол толгой компани Ай Си Ти групп ХХК нь хоёр хувьцаа эзэмшигчтэй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн бүтцийг дор харуулав.

Схем 3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид ба эзэмшлийн хувь



Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны эзэмшиж жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгчийн мэдээллийг дорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 23. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

№	Нэр	Регистрийн дугаар	Эзэмшлийн хувь	Эзэмшиж буй хэлбэр
Айтүүлс ХХК-ийн хувьцаа эзэмшигч				
1	Ай Си Ти групп ХХК	5721261	100%	Охин компани
Ай Си Ти групп ХХК-ийн хувьцаа эзэмшигчид				
1	Ворлд френдс ХХК	5710707	62.5%	Охин компани
2	А.Баттамир		37.5%	Хяналтын багц эзэмшигч
Ворлд френдс ХХК-ийн хувьцаа эзэмшигч				
1	Ц.Ганболд		100%	Хувьцаа эзэмшигч

Айтүүлс ХХК-ийн хувьцаа эзэмшигч, бенефициар өмчлөгчид

Хувьцаа эзэмшигч - Ай Си Ти групп ХХК

Ай Си Ти групп ХХК нь үнэт цаас гаргагчийн толгой компани бөгөөд Монгол Улсын стратегийн салбаруудын нэг мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Ай Си Ти групп ХХК нь охин компаниудаа нэгдмэл удирдлага, бодлого менежментээр ханган ажилладаг.

Хүснэгт 24. Ай Си Ти групп ХХК-ийн бүртгэлийн мэдээлэл

Компанийн оноосон нэр	Ай Си Ти групп ХХК
Бүртгэлийн дугаар	9011411114
Регистрийн дугаар	5721261
Бүртгэлийн огноо	2013.06.13
Үйл ажиллагааны чиглэл	Мэдээллийн технологи
Гүйцэтгэх захирал	Г.Лхамсүрэн
Компанийн хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13-р хороолол, 39-61
Утас	75755585, 99106605
Цахим шуудан, вэбсайт	info@ictgroup.mn, www.ictgroup.mn

Хүснэгт 25. Ай Си Ти групп ХХК-ийн охин компаниудын эзэмшлийн хувь

Охин компаниуд	Эзэмшил	Үйл ажиллагааны чиглэл
Айтүүлс ХХК	100 хувь	Мэдээллийн технологи
Айдэйм ХХК	100 хувь	Мэдээллийн технологи, программ хангамжийн үйлчилгээ, гадаад худалдаа
Айконтент ХХК	100 хувь	Мэдээллийн технологи, программ хангамжийн үйлчилгээ, гадаад худалдаа
Си нэт ХХК	100 хувь	Мэдээллийн технологийн үйлчилгээ, гадаад худалдаа

Ай Си Ти групп ХХК-ийн хувьцаа эзэмшигчид

Ай Си Ти групп ХХК нь 2017 оны 3-р сарын байдлаар хоёр хувьцаа эзэмшигчтэй ба компанийн хувьцааны 62.5 хувийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд Ворлд френдс ХХК, үлдсэн 37.5 хувийг Монгол Улсын иргэн А.Баттамир нар тус тус эзэмшиж байна. Ворлд френдс ХХК нь 2017 оны 1-р сарын 30-ны өдөр Ай Си Ти групп ХХК-ийн 62.5 хувийн хувьцааг Стандарт капитал ХХК-аас Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан.

Хувьцаа эзэмшигч – Ворлд фрэндс ХХК

Ворлд френдс ХХК нь 2013 онд Улаанбаатар хотноо байгуулагдсан, барилга зам тээвэр, худалдаа үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг ба цаашид эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах бүхий л салбарт, ялангуяа мэдлэгт суурилсан өндөр технологийн салбарт хөрөнгө оруулалт хийх стратеги баримтлан ажиллаж байна. Ворлд френдс ХХК нь 2017 оны 3-р сарын байдлаар нэг хувьцаа эзэмшигчтэй байгаа нь Монгол Улсын иргэн Цоодол овогтой Ганболд байна. Ц.Ганболд нь Улаанбаатар хотод 1958 оны 5-р сарын 4-ний өдөр төрсөн ба одоогоор уугуул хотдоо эхнэрийн хамт амьдарч байна. Тэрээр нийслэлийн 12-р сургуулийг дүүргэж, тухайн үеийн мах комбинат одоогийн Махимпекс ХК-аас ажлын гараагаа эхэлж, тус компанид 14 жил ажилласан байна. 1990 оноос хувиараа бизнес эрхэлж эхэлсэн ба 2013 онд Ворлд френдс ХХК-ийг үүсгэн байгуулсан. Ц.Ганболд нь 2017 оны 3-р сарын байдлаар татварын өргүй, шүүхийн шийдвэрээр бусдад төлөх төлбөргүй байна.

Хүснэгт 26. Ворлд френдс ХХК-ийн бүртгэлийн мэдээлэл

Компанийн оноосон нэр	Ворлд френдс ХХК
Бүртгэлийн дугаар	9011410107
Регистрийн дугаар	5710707
Бүртгэлийн огноо	2013.05.15
Үйл ажиллагааны чиглэл	Бизнесийн зөвлөгөө өгөх, гадаад худалдаа
Гүйцэтгэх захирал	Д.Баярсайхан
Компанийн хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, 2-р хороолол, 34, 2 тоот
Утас	99045302

Хувьцаа эзэмшигч А.Баттамир

Адилбиш овогтой Баттамир нь 1982 онд Улаанбаатар хотод төрсөн, одоо эхнэр 5 хүүхдийн хамт амьдардаг. Тэрээр программ хангамжийн инженер мэргэжилтэй, 1998 онд Өсвөрийн зохион бүтээгчдийн төв сургуулийг “Компьютерийн оператор”-оор төгсөж, 2003 онд ШУТИС, КТМС-ийг “Программ хангамж” мэргэжлээр бакалаврын зэрэгтэй дүүргэжээ. Ажлын туршлагын хувьд А.Баттамир нь Эрчим хүчний диспетчерийн үндэсний төвд программист /Системийн администратор/, Эрчим хүчний диспетчерийн үндэсний төвд системийн инженер, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороонд мэдээллийн технологийн зөвлөх, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд мэдээллийн технологийн

зөвлөх/системийн инженер, Айтүүлс ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалтан хашсан ба 2013-2016 онд Ай Си Ти групп ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаад 2017 оноос Айконтент ХХК-ийн захирлын үүргийг гүйцэтгэж байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч

Компанийн тухай хуулийн 56.1-д зааснаар компанийн хувьцааны хяналтын багц буюу компанийн гаргасан энгийн хувьцааны 33.3 хувь буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмших этгээдийг хяналтын багц эзэмшигч гэнэ. Үнэт цаас гаргагчийн хувьд нэг хувьцаа эзэмшигчтэй ба түүний толгой компани Ай Си Ти групп ХХК нь компанийн хувьцааг дангаараа 100 хувь эзэмшдэг. Ай Си Ти групп ХХК нь хоёр хувьцаа эзэмшигчтэй ба 2017 оны 3-р сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсад бүртгэлтэй Ворлд френдс ХХК нь нийт хувьцааны 62.5 хувийг, Монгол Улсын иргэн А.Баттамир үлдсэн 37.5 хувийг тус тус эзэмшиж байна. Ворлд френдс ХХК-ийн нийт хувьцааг Монгол Улсын иргэн Ц.Ганболд дангаараа эзэмшиж байна.

Хүснэгт 27. Үнэт цаас гаргагчийн хяналтын багцыг эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл

№	Нэр	Регистрийн дугаар	Эзэмшлийн хувь	Эзэмшиж буй хэлбэр
Айтүүлс ХХК-ийн хувьцаа эзэмшигч				
1	Ай Си Ти групп ХХК	5721261	100%	Охин компани
Ай Си Ти групп ХХК-ийн хувьцаа эзэмшигчид				
1	Ворлд френдс ХХК	5710707	62.5%	Охин компани
2	А.Баттамир		37.5%	Хяналтын багц эзэмшигч
Ворлд френдс ХХК-ийн хувьцаа эзэмшигч				
1	Ц.Ганболд		100%	Үүсгэн байгуулагч

Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигчдийн талаарх тодорхойлолтууд

Үнэт цаас гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтнууд, хувьцаа эзэмшигч, жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгчид нь хугацаа хэтэрсэн өр зээлтэй эсэх, хуулийн дагуу тохиромжтой этгээд мөн эсэхийг тодруулахын тулд татварын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тодорхойлолт гаргуулж авсныг дорх хүснэгтэд харуулав.

Иргэн, хуулийн этгээд	Татварын өртэй эсэх	Хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх
Үнэт цаас гаргагч - Айтүүлс ХХК	3,643,297.10 төгрөгийн өртэй	Өр төлбөргүй
Гүйцэтгэх захирал – И.Алтантулга	Өргүй	Өр төлбөргүй
Нягтлан бодогч – Ц.Цацралгэрэл	Өргүй	Өр төлбөргүй
Хувьцаа эзэмшигч - Ай Си Ти групп ХХК	5,331,742.50 төгрөгийн өртэй	Өр төлбөргүй
Ай Си Ти групп ХХК-ийн хувьцаа эзэмшигч – Ворлд френдс ХХК	2,090,049.50 төгрөгийн өртэй	Өр төлбөргүй
Ай Си Ти групп ХХК-ийн хувьцаа	36,000.00 төгрөгийн өртэй	Өр төлбөргүй

эзэмшигч - А.Баттамир		
Ворлд френдс ХХК-ийн хувьцаа эзэмшигч – Ц.Ганболд	Өргүй	Өр төлбөргүй

Үнэт цаас гаргагч Айтүүлс ХХК нь 2017 оны 3-р сарын 28-ны өдрийн байдлаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын (ААНОАТ) 2,285,306 төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татварын (НӨАТ) 1,028,051 төгрөг, хувь хүний орлогын албан татварын (ХХОАТ) 329,940 төгрөг буюу нийт 3,643,297 төгрөгийн татварын дутуу төлөлттэй байна. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал И.Алтантулга, нягтлан бодогч Ц.Цацралгэрэл нар нь Татварын ерөнхий газарт өргүй байна.

Үнэт цаас гаргагчийн 100 хувийн хувьцаа эзэмшигч Ай Си Ти групп ХХК нь 2017 оны 3-р сарын 28-ны өдрийн байдлаар ААНОАТ-ын 2,901,022 төгрөг, ХХОАТ-ын 332 төгрөг, НӨАТ-ын 2,430,388 төгрөг, нийт 5,331,743 төгрөгийн татварын өртэй байна. Ай Си Ти групп ХХК-ийн 62.5 хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигч Ворлд френдс ХХК нь 2017 оны 3-р сарын 28-ны өдрийн байдлаар ААНОАТ-ын 1,507 төгрөг, ХХОАТ-ын 2,088,543 төгрөгийн өртэй, нийт 2,090,050 төгрөгийн татварын өртэй байна. Ай Си Ти групп ХХК-ийн 37.5 хувийн хяналтын багцыг эзэмшигч А.Баттамир авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн татварын өр 36,000 төгрөг Ворлд френдс ХХК-ийн хувьцаа эзэмшигч Ц.Ганболдын хувьд ямар нэгэн татварын өргүй байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх газраас дээр дурдагдсан этгээдүүдийг 2017 оны 3-р сарын байдлаар шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн төлбөргүй гэж тодорхойлжээ.

Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр

Компанийн тухай хуулийн 62.1.4, 62.2.1 дүгээр зүйлийн дагуу үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 11-р сарын 10-ны өдрийн ээлжит бус хурлын 14 тоот тогтоолоор компанийн хэлбэрийг өөрчилж, хувьцаа нэмж гарган, анх удаа олон нийтэд санал болгох замаар Дархан-Уул аймагт Модуляр дата төвийн парк байгуулах үйл ажиллагааг санхүүжүүлэх шийдвэрийг гаргасан ба 2017 оны 3-р сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 08 тоот тогтоолоор татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн, нийтэд санал болгох хувьцааны тоо ширхэг, үнэ, анхдагч зах зээлд байршуулах аргыг тогтоосон байна.

Үнэт цаас гаргагч нь Дархан-Уул аймагт байгуулах Модуляр дата төвийн паркийг барихад нийт 1,338,798,000.00 төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлэх, үүний тулд 13,387,980 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган, нэг бүрийг нь 100.00 төгрөгийн тогтоосон үнээр, тогтоосон үнээр санал болгох арилжааны аргаар олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн. Нэмж гаргаж буй 13,387,980 ширхэг энгийн хувьцаа нь олон нийтэд санал болгон гаргасны дараах нийт хувьцааны 38.86 хувьтай тэнцүү байна. Түүнчлэн, компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар тогтжээ.

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэрэгжилтийн тухай

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээ, хэлцэлд 45.3 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гэрээ, хэлцэл хамаарна. Айтүүлс ХХК нь сүүлийн нэг жилийн хугацаанд ийм хэмжээний үнийн дүн бүхий дараах гэрээ, хэлцлийг хийсэн байна. Үүнд:

- 2016 оны 12-р сарын 28-ны өдөр захиалагч Албан журмын даатгагчдын холбоо ГҮТТБ-тай байгуулсан, 79.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий "Хамтран ажиллах гэрээ № МС-01"-ээр мэдээллийн сангийн аюулгүй байдлын сайжруулалтыг хийх үүрэг хүлээсэн ба үйлчилгээг амжилттай үзүүлж, гэрээ дуусгавар болсон.
- 2016 оны 11-р сарын 21-ний өдөр гүйцэтгэгч Стандарт инвестмент ҮЦК ХХК-тай байгуулсан № Г17/08 тоот андеррайтерийн үйлчилгээ авах гэрээгээр төлөвлөсөн нийт хөрөнгийг бүрэн босгосон тохиолдолд компаниас андеррайтерт 66.9 сая төгрөгийг төлөх үүрэг хүлээсэн байна.
- 2016 оны 11-р сарын 23-ны өдөр Ай Си Ти групп ХХК-тай байгуулсан Менежментийн үйлчилгээний Х/01 дугаартай менежментийн үйлчилгээ авах гэрээ нь нийт 57.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий ба үнэт цаас гаргагч сар бүр өөрийн толгой компанид 4,750,900 төгрөг төлөх үүрэг хүлээсэн байна. Тус гэрээгээр Ай Си Ти групп ХХК нь компанийн бодлого, стратеги төлөвлөлт, хөрөнгө оруулалт, санхүүжилт, хүний нөөцийн бодлого, компанийн засаглал, нягтлан бодох бүртгэл, бүтээгдэхүүний борлуулалт болон дотоод хяналтын асуудлаар зөвлөх, дэмжлэг үзүүлэх чиглэлээр менежментийн үйлчилгээ үзүүлэхээр тохирсон. Энэхүү гэрээний төлбөрийн хэмжээг толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн өмнөх жилийн дундаж актив, ажилтны тоонд үндэслэн, харилцан тохиролцож тогтоохоор заасан бөгөөд үнэт цаас гаргагч нээлттэй компани болсноор шинэ бүрэлдэхүүнтэй Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг томилж, компанийн засаглал, бүтцийг өөрчлөх тул тус гэрээг тухайн үед дуусгавар болгоно.

Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай

Компанийн тухай хуулийн 87.1.1-р зүйлд заасны дагуу их хэмжээний хэлцэлд "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбоотой хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/" багтдаг.

Айтүүлс ХХК-ийн хувьд их хэмжээний хэлцэл хийх эрхийн хязгаарыг Гүйцэтгэх захиралтай хийсэн гэрээнд тусгасан. 2015 оны 4-р сарын 13-ны өдрийн Г15/02 дугаартай гэрээний 4.2.21-д зааснаар Гүйцэтгэх захирал нь их хэмжээний /хэмжээ заасан/ хэлцэл хийхдээ удирдлагаас бичгээр зөвшөөрөл авч байх үүрэг хүлээнэ ...энэ зүйлийн И-д зааснаар 30,000 ам. доллар буюу түүнээс дээш үнийн дүнтэй гэрээ хэлцэл хийхэд зөвшөөрлийг бичгээр авахаар заасан байгаа нь 30,000 ам.доллараас доош үнийн дүнтэй тэнцэх гэрээ хэлцэл хийхэд удирдлагаас бичгээр зөвшөөрөл авахгүйгээр хийж болохоор байна.

Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой 51 гэрээтэй хууль нэг бүрчлэн танилцсан ба эдгээр нь Иргэний хууль болон Компанийн засаглалын кодексийн заалтуудыг зөрчөөгүй байна. Айтүүлс ХХК нь сүүлийн гурван жилийн дотор их хэмжээний болон, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй байна.

Компанийн тухай хуулийн 89-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж буй компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай хуулийн 89.1.1-89.1.4 зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийсэн бол сонирхлын зөрчилтэй этгээдэд тооцогдоно. Компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч Ай Си Ти групп ХХК нь үнэт цаас гаргагчтай дээр дурдсан Менежментийн үйлчилгээний гэрээг байгуулсан нь Компанийн тухай хуулийн 89.3.1 зүйлд хамаарах тул сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарахааргүй байна. Ай Си Ти групп ХХК-ийн хувьцаа эзэмшигчид болох А.Баттамир, Ворлд френдс ХХК, түүний хувьцаа эзэмшигч Ц.Ганболд нар нь үнэт цаас гаргагчтай ямар нэгэн гэрээ хэлцэл хийгээгүй байна. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд болох гүйцэтгэх захирал И.Алтантулга, нягтлан бодогч Ц.Цацралгэрэл, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь компанитай шууд байгуулсан гэрээ, хэлцэл байхгүй. Айтүүлс ХХК нь гүйцэтгэх захирал И.Алтантулгын хувьцааг нь эзэмшдэг Стандарт капитал ХХК-ийн охин компани болох Стандарт инвестмент ҮЦК ХХК-тай дээр дурдсан Андеррайтерийн үйлчилгээний гэрээг байгуулсан ба И.Алтантулга нь Стандарт капитал ХХК-ийн хувьцааны 6 хувийг эзэмшиж байгаа нь Компанийн тухай хуулийн 89.1.3 зүйлд заасан 20 хувиас доош байгаа тул мөн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарахааргүй байна.

Компанийн засаглалын кодексийг хэрхэн мөрдөж буй талаарх мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дах заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.10 дах заалт, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас 2004 онд батлагдсан “Компанийн засаглалын зарчмууд”-ыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос 2007 оны 12-р сарын 26-ны өдөр батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа ба дараах журмуудын төслүүдийг батлан мөрдөхөөр боловсруулсан байна. Үүнд:

- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай журам
- Ногдол ашгийн журам
- Дотоод хяналтын журам
- Мэдээллийн үйл ажиллагааны журам гэсэн таван журам багтаж байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцааг анх удаа олон нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, Компанийн дүрмийг батлуулан, компанийн засаглалын журмуудыг Компанийн тухай хуулийн дагуу батлан, дагаж мөрдөх болно.

Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого

Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого нь Монгол Улсын Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм, зохицуулах байгууллагаас гаргасан бусад дүрэм журамд үндэслэн боловсруулагдсан байх ба компанийн хувьцааг олон нийтэд санал болгон худалдах ажиллагаа амжилттай болсон тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар компанийн Ногдол ашгийн журмын төслийг хэлэлцүүлэн батлах болно. Ногдол ашгийн журмаар үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг олгох, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна. Журам нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дийлэнх олонхийн саналаар батлагдснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

Үнэт цаас гаргагчийн “Ногдол ашгийн журам”-ын төслөөс:

Ногдол ашгийн бодлого

- Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дуусснаас хойш 50 хоногийн дотор Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/ гаргана. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.
- Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- Ногдол ашиг хуваарилах хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна. Ногдол ашгийн хуваарилах хэлбэр, аргыг сонгохдоо хувьцаа эзэмшигчдийн оршин суугаа газар, ногдол ашгийг шуурхай хүлээн авах боломжийг харгалзана.

Ногдол ашгийн хэмжээг тодорхойлох

- Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн хэмжээг тодорхойлохдоо компанийн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хассан хэсгээс тооцно.
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрт хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.
- Компани ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг ТУЗ нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулан хэлэлцүүлэх ба тухайн жил ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрдлэсэн бол хуваарилахгүй болсон үндэслэл, шалтгаан, хөрөнгө, санхүүгийн тооцоолол, цаашид ногдол ашиг хуваарилах талаар авч хэлэлцүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах үүрэгтэй.

Ногдол ашиг хуваарилах

- Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлдөлтэй ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, Компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
- Компани эргүүлэн худалдан авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

- Компани нь үнэт цаасны хадгаламжийн байгууллагаас гаргасан хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үндэслэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг жагсаалтыг гаргана.
- Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдөр нь тухайн тайлангийн жилийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдөр байна.
- Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хуулийн 47-р зүйлд заасан нөхцөл болон холбогдох журамд заасан шаардлагыг хангасан байна.
- Ногдол ашиг хуваарилах шийдвэрт ТУЗ дараах зүйлийг тусгана. Үүнд:
  - Тухайн төрлийн нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ;
  - Ногдол ашгийг олгож эхлэх, дуусах огноо;
  - Олгох арга зам, хэлбэр (Компани өөрөө болон эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан эд хөрөнгө, бэлэн мөнгө, бусад үнэт цаасаар олгох гэх мэт) ;
  - Бусад холбогдох асуудал.
- Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдсанаас хойш 7 хоногоос илүүгүй байхаар тооцож, ногдол ашиг тараах хугацааг тогтооно.
- Ногдол ашиг олгох талаар хувьцаа эзэмшигчдэд нийт орон даяар тараагддаг өдөр тутмын сонин, орон даяар цацагдах эрх бүхий телевиз, радиогоор мэдээлнэ. Уг мэдээлэлд нэгж хувьцаанд хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээ, ногдол ашгийг ямар хэлбэрээр олгох, ногдол ашиг тарааж эхлэх болон дуусах огноо, ногдол ашгийг компани эсвэл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан тараахын аль нь болох, мэргэжлийн зуучлагч байгууллагын нэр, хаяг, ногдол ашиг тараах байгууллагын ажиллах цагийн хуваарь, ногдол ашгийн талаар лавлагаа авах утасны дугаар зэргийг тусгасан байна. Мөн хувьцаа эзэмшигчийн харилцах данс болон хадгаламжийн данс, үнэт цаасны хадгаламжийн дансанд болон гүйлгээгээр шилжүүлэн авч болох талаар дурдсан байх шаардлагатай. Компани нь өөрийн цахим хуудсанд энэ талаарх мэдээллийг оруулна.
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтлөнө. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкин дах дансанд шилжүүлэх бодлого баримтална.

Ногдол ашгийн талаар тайлагнах

- Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед ногдол ашгийн хуваарилалтын тайланг гаргаж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУС
5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

Хариуцлага

- Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.
- Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг Гүйцэтгэх захирал хариуцна.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл

Айтүүлс ХХК-ийн 2013-2015 оны санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүдийг дор харуулав.

Хүснэгт 28. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, 2013-2016 он /төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2013.12.31	2014.12.31	2015.12.31	2016.12.31
Эргэлтийн хөрөнгө	103,273,567	322,126,174	268,647,113	334,504,994
Үндсэн хөрөнгө	76,417,122	530,230,833	1,302,605,474	1,157,605,474
Эргэлтийн бус хөрөнгө	76,417,122	530,230,833	1,348,605,474	1,283,782,504
Нийт хөрөнгө	**179,690,689**	**852,357,007**	**1,617,252,587**	**1,618,287,498**
Богино хугацаат өр төлбөр	81,238,359	224,164,838	152,524,012	197,788,183
Урт хугацаат өр төлбөр	-	-	-	-
Өр төлбөр	**81,238,359**	**224,164,838**	**152,524,012**	**197,788,183**
Хувийн өмч	116,402,967	610,387,536	902,758,223	905,758,223
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	526,279,542	460,721,652
Хуримтлагдсан ашиг	(17,950,638)	17,804,632	35,690,809	54,019,440
Эзэмшигчдийн өмч	**98,452,329**	**628,192,168**	**1,464,728,575**	**1,420,499,315**
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	**179,690,689**	**852,357,007**	**1,617,252,587**	**1,618,287,498**

Үнэт цаас гаргагч нь 6 дах жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа тул бизнесийн ажиллагаа нь жигдэрч, санхүүгийн байдалд нь эерэг өөрчлөлтүүд орсон байна. Нийт хөрөнгийн хэмжээ нь 2013 оны эцсээр 179.7 сая төгрөг байсан бол 2016 оны эцсийн байдлаар энэ тоо 9 дахин өсч, 1.62 тэрбум төгрөгт хүрсэн. Үүний дотор үндсэн хөрөнгийн хэмжээ 76.4 сая төгрөгөөс 1.1 тэрбум төгрөг болж өссөн нь компани гурван жилийн дотор үндсэн хөрөнгө болох газар, оффисийн байр болон дата төвийн тоног төхөөрөмжүүдэд хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой. Эргэлтийн хөрөнгийн хэмжээ нь 103.2 сая төгрөгөөс 334.5 сая төгрөг болж нэмэгдсэн хэдий ч нийт хөрөнгөд эзлэх хувь 2013 оноос 2016 оны хооронд 57.5-аас 20.7 хувь болж буурсан нь үндсэн хөрөнгийн хувь нэмэгдсэнтэй холбоотой юм. Өмнөх онтой харьцуулахад компанийн нийт эргэлтийн хөрөнгө 2016 онд 334.5 сая төгрөг болж 65.8 сая

СЭХ
он . сар . . . өдөр
2017 . 09 . 27
БҮРТГЭВ
№ 01

төгрөгөөр буюу 20.7 хувиар өссөн ба энэхүү өсөлтөд бараа материал, урьдчилж төлсөн зардал өссөн нь голлон нөлөөлсөн. Хөрөнгийн бүтцийн хувьд эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 2015 онд 16.6 хувь, 2016 онд 20.7 хувь, эргэлтийн бус хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 83.3 хувь, 2016 онд 79.3 хувь болж том хэмжээний өөрчлөлт гараагүй байна.

Үнэт цаас гаргагч нь урт хугацаат өр төлбөргүй, харин богино хугацаат өр төлбөрийн хэмжээ 2013 оны эцэст 81.2 сая төгрөг байсан бол 2016 оны эцсийн байдлаар 2.4 дахин нэмэгдэж 197.8 сая төгрөг болсон байна. 2013 оны эцсийн байдлаар нийт өр төлбөрийн 10.3 хувийг дансны өглөг, 21.9 хувийг татварын өр, 48.5 хувийг урьдчилж орсон орлого бүрдүүлсэн бол 2014 оны эцсийн байдлаар 36.5 хувийг дансны өглөг, 62.8 хувийг урьдчилж орсон орлого тус тус бүрдүүлж, 2015 оны эцсийн байдлаар дансны өглөг 39 хувь, урьдчилж орсон орлого 53.1 хувь байсан бол 2016 оны эцсээр цалингийн өглөг 13.8 хувь, дансны өглөг 22.7 хувь, урьдчилж орсон орлого 58.6 хувь болсон байна. Компани нь 2015-2016 онд хоёр удаа хөрөнгийн үнэлгээ хийлгэж, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл болон хасагдуулгыг тайландаа тус бүр тусгасан байна. Ашиг алдагдлын хувьд алдагдлын хэмжээ сүүлийн жилүүдэд буурсаар 2014 оны жилийн эцсээр хуримтлагдсан ашгийн хэмжээ анх удаа эерэг гарч, 17.8 сая төгрөгт хүрсэн байна. Харин 2015 оны эцсийн байдлаар энэ тоо өсч 35.7 сая төгрөг, 2016 оны эцсийн байдлаар өмнөх оныхоос 51.3 хувиар өсч 54.0 сая төгрөг болжээ.

Хүснэгт 29. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан, 2013-2016 он /төгрөгөөр/

Орлогын үзүүлэлтүүд	2013.12.31	2014.12.31	2015.12.31	2016.12.31
Борлуулалтын орлого	155,719,573	268,486,227	312,663,010	474,905,307
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	39,895,117	168,908,674	84,679,757	95,126,634
Нийт ашиг/алдагдал	**115,824,456**	**99,577,553**	**227,983,253**	**379,778,673**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	178,166	25,705	4,742,366	14,178,670
Үндсэн үйл ажиллагааны зардал	125,335,528	109,603,488	220,836,286	367,961,232
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	6,435,210	10,865,527	-	
ТТӨА/алдагдал	(15,768,116)	(20,865,757)	11,889,333	20,613,937
Татварын зардал	-	-	781,685	2,285,306
ТТДА/алдагдал	(15,768,116)	(20,865,757)	11,107,648	18,328,631
Ногдол ашиг	-	-	-	
Цэвэр ашиг/алдагдал	**(15,768,116)**	**(20,865,757)**	**11,107,648**	**18,328,631**

Компанийн орлогын тайлангаас харахад борлуулалтын орлого нь жил бүр өсч байгаа нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа өргөжиж буйг илтгэж байна. 2013 оны эцсээр компанийн борлуулалтын орлого 155.7 сая төгрөг байсан бол 2014 онд 268.4 сая төгрөг, 2015 онд 312.7 сая төгрөг, 2016 онд 474.9 сая төгрөгт хүрсэн байна. Үнэт цаас гаргагч нь 2015 онд шинээр дата төвийн үйлчилгээ нэвтрүүлсэн тул үндсэн үйл ажиллагааны зардал өмнөх онуудтай харьцуулахад нэмэгдсэн ч цэвэр ашгийн хэмжээ 2015 онд анх удаа эерэг гарч, 11.1 сая төгрөгт хүрсэн. 2016 онд цэвэр ашгийн хэмжээ 18.3 сая төгрөг гарч, 65 хувиар өссөн ч үндсэн үйл ажиллагааны зардал мөн 147.1 сая төгрөг буюу 67 хувиар өссөн байна. 2016 оны нийт

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

үйл ажиллагааны зардалд цалингийн зардал 28.5 хувь, менежментийн зардал 20.4 хувь, элэгдлийн зардал 17.3 хувь тус тус эзэлсэн (санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээс).

Үнэт цаас гаргагчийн 2013 оны 12-р сарын 31, 2014 оны 12-р сарын 31 болон 2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангуудыг Си Эс Ай Аудит ХХК хянаж, компанийн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйгээний тайлан, тодруулга нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн гэж дүгнэсэн. Харин 2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд Сүлд-Аудит ХХК аудит хийж, тайлан нь компанийн тухайн жилийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан гэж дүгнэсэн байна.

Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн тухай мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь урт хугацаат өр төлбөргүй, харин богино хугацаат өр төлбөрийн хэмжээ нь 2016 оны эцсийн байдлаар 197.8 сая төгрөг байна. Энэ нь өмнөх жилүүдтэй харьцуулбал 2013 оны 81.2 сая төгрөгөөс 4 дахин их, харин 2014 оны 224.2 сая төгрөгөөс 1.1 дахин бага, 2015 оны 152.5 сая төгрөгөөс 1.3 дахин их үзүүлэлт юм. Компанийн санхүүгийн тайлагналыг аккруэл суурьяар бүртгэдэг тул богино хугацаат өр төлбөрийн ихэнх хувийг урьдчилж олсон орлого бүрдүүлдэг ба энэ нь үйл ажиллагаа өргөжих тусам нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2016 оны нийт өр төлбөрийн 58.6 хувийг урьдчилж орсон орлого бүрдүүлж байгаа бол үлдсэн 41.4 хувийг бусад өглөг эзэлж байна. Үүнд, урьдчилж орсон орлого 115.8 сая төгрөг, дансны өглөг 44.8 сая төгрөг, цалингийн өглөг 27.2 сая төгрөг, татварын өглөг 3.8 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 0.05 сая төгрөг байна. Үнэт цаас гаргагч нь урт хугацаат өр төлбөргүй бөгөөд урьдчилж орсон орлогын хэмжээ өндөр байгаа нь компанийн өр төлбөрийн эрсдлийн хэмжээг бууруулж байна. Түүнчлэн, Сүлд-Аудит ХХК-ийн аудитын дүгнэлтэд үнэт цаас гаргагч нь эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө бүрэн барагдуулах боломжтой гэсэн нь эрсдэл багатайг илтгэж байна. Ерөнхийдөө өр төлбөр эздийн өмчийн харьцаа 1-ээс ихгүй байхыг, өрийн харьцаа 0.5-аас ихгүй байхыг зохистой гэж үздэг ба Айтүүлс ХХК-ийн хувьд 2016 оны эцсийн байдлаар өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа нь 0.14, өрийн харьцаа нь 0.12 байна.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
116218260 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 5444381

ХОЁР. ХАРААТ БУС ДҮГНЭЛТҮҮД

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 10.8-д заасны дагуу үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй, тухайн үйлчилгээг үзүүлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагаар бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ, аудитын болон хууль зүйн хөндлөнгийн дүгнэлтүүдийг гаргуулсан байх шаардлагатай ба эдгээр тайлан, дүгнэлтүүд нь энэхүү танилцуулгын салшгүй хэсэг юм. Үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээг Сүлд-Аудит ХХК /РД: 2867656/, хөрөнгийн үнэлгээний болон бизнесийн үнэлгээний үйлчилгээг Атен ХХК /РД: 5491428/, хууль зүйн зөвлөгөөг Өмгөөллийн Монгол Зарга ХХН /РД: 5756804/ тус тус үзүүлсэн ба тэдгээрийн хараат бус тайлан, дүгнэлтүүдээс дор толилуулав. Тайлангуудын бүрэн эхийг энэхүү танилцуулгын хавсаргав.

Хараат бус аудиторын дүгнэлт

Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй, үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий, хараат бус аудитын байгууллага **Сүлд-Аудит ХХК** нь Айтүүлс ХХК-ийн 2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланг хянаж, аудитын дүгнэлтийг гаргасан. Аудитор нь үнэт цаас гаргагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянаж, аудитын ажлын баримтуудад үндэслэн дүгнэлт гаргаж, санхүүгийн тайланд аудит хийх явцад анхаарал татсан санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, дотоод хяналтын системийг сайжруулах тухай асуудлуудыг дүгнэлтэд багтаасан байна. 2017 оны 2-р сарын 6-ны өдөр байгуулсан Г17/07 тоот гэрээний дагуу 2016 оны жилийн санхүүгийн тайланд өгсөн хараат бус аудиторын дүгнэлтийг дор толилуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан, зөрчилгүй дүгнэлт

Бид 2016 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлан тэмдэглэлээс бүрдсэн Айтүүлс ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлан тэмдэглэлээс бүрдсэн Айтүүлс ХХК-ийн 2016 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулж байна. Үнэт цаасны танилцуулга, хавсаргасан бичиг баримтад тусгасан санхүүгийн мэдээлэл нь бодит байдалд нийцэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу

компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай материаллагт тооцогддог.

Санхүүгин тайлангийн аудитад хүлээсэн аудиторын үүрэг хариуцлагын бусад тодорхойлолтыг Айтүүлс ХХК-ийн http://www.itools.mn/ сайтад оруулсан. Уг тодорхойлолт нь манай аудиторын тайлангийн нэг хэсэг юм.

Удирдлагад өгөх зөвлөмж

Айтүүлс ХХК-ийн санхүүгийн тайлангаар хөндөгдсөн дорх гол асуудалд зөвлөмж өгсөн байна.

1. Бодит байдал: Айтүүлс ХХК нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, санхүүгийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөөгүй байна.
   Зөвлөмж: Цаашид байгууллагын нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагааг улас боловсронгуй болгох үүднээс, мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17-р зүйлийн 2-т зааснаар "...Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж мөрдөх..." үүргийг аж ахуйн нэгж байгууллагын

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

удирдлагад хариуцуулсан билээ. Иймд байгууллага нь борлуулалтын салбарын онцлогийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Монгол Улсын нутаг дэвсгэр дээр мөрдөгдөж байгаа санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль, салбарын дээд газрын дүрэм журамд нийцүүлэн, Нягтлан бодох бүртгэлийн бодлогоо шинээр боловсруулан, мөрдөн ажиллах нь зүйтэй.

2. Бодит байдал: Татвар, нийгмийн даатгалын шимтгэлд 27.3 сая төгрөгийн өглөгтэй тайлагнасан эрсдэлтэй.

   Зөвлөмж: Нийгмийн даатгалын тухай хуулийн 16.1, энэ хуулийн 4-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, Татварын ерөнхий хуулийн дагуу ирээдүйд хүү, алданги, торгууль тооцогдож, төлөвлөгдөөгүй эрсдэл гарах магадлалтай.

Нэмэлт тайлбар

Үнэт цаас гаргагч нь аудитын өгсөн зөвлөмжийн дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2017 он гарсаар боловсруулж, 6-р сараас эхлэн санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж эхлээд байна. Энэхүү баримт бичгийн талаар Сүлд-Аудит ХХК нь 2017 оны 5-р сарын 23-ны өдөр дараах дүгнэлтийг өгсөн. Үүнд:

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого нь “Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт-д нийцсэн санхүүгийн тайлан гаргах шаардлага, МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам, 4.7 дугаар заалтын 4.7.2 “Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан нь “Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт-д нийцсэн байна гэсэн шаардлагуудыг хангасан байна гэж үзэж байна.

Хөрөнгийн үнэлгээ

Атен ХХК-ийн хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий үнэлгээчид Айтүүлс ХХК-ийн хөрөнгийн үнэлгээг 2016 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 2017 оны 2-р сарын 2-ны өдрийн 1/2017 тоот гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн. Атен ХХК /РД: 5491428/ нь 2011 онд үүсгэн байгуулагдсан, хөрөнгийн үнэлгээ, зар сурталчилгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох шаардлагыг ханган, “Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үнэлгээний үйлчилгээ үзүүлэх” эрх бүхий байгууллагаар бүртгэгдсэн. Үнэлгээний зорилго нь Айтүүлс ХХК хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгон, Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхтэй холбоотой компанийн хөрөнгийг дахин үнэлүүлж, санхүүгийн тайлан бүртгэлд тусгах байв.

Үнэлгээчдийн баг нь үнэлгээг бодит үнэ цэнэд суурилан, Олон улсын үнэлгээний стандарт, Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, хөрөнгийн үнэлгээтэй холбоотой эрх бүхий байгууллага, дотоод, гадаадын мэргэжлийн байгууллагаас гаргасан бусад хууль тогтоомж, дүрэм, заавар, норм норматив, санхүүгийн тайлагналын болон нягтлан бодох

УЛААНБААТАР ХОТ itools АЙТҮҮЛС ХХК
УЛААНБААТАР ХОТ СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК ТТС3981 ᠬᠣᠲᠠ 5444381

бүртгэлийн холбогдох стандартууд зэрэг хууль эрх зүйн актуудын хүрээнд үнэт цаас гаргагчийн эд хөрөнгийн тоо хэмжээ, ашигласан хугацаа, байршил, одоогийн төлөв байдал, цаашид ашиглах боломж зэргийг судлан, газар дээр нь биечлэн очиж, шаардлагатай хэмжилт, үзлэгийг хийж, холбогдох баримт бичгүүдтэй танилцсаны үндсэн дээр хөндлөнгийн байр сууринаас хийсэн.

Айтүүлс ХХК-ийн санхүүгийн тайлан бүртгэлд бүртгэгдсэн, газар, барилга, машин тоног төхөөрөмж, компьютер дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил, биет бус хөрөнгө гэсэн хөрөнгийн 6 ангилалд хамаарах нийт 141 хөрөнггийн өнөөгийн үнэ цэнийг өртөг, орлогын хандлага болон зах зээлийн харьцуулалтын аргаар үнэлж, 2016 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт **1,157,046,027.80 төгрөг** гэж тогтоосон байна. Үүнд газар эзэмших эрхийн үнэ цэнэ 694.2 сая төгрөг, компанийн барилга, байгууламжийн үнэ цэнэ 324.8 сая төгрөг, техник, тоног төхөөрөмжийн үнэ цэнэ 19.1 сая төгрөг, компьютер, дагалдах хэрэгслийн үнэ цэнэ 94.6 сая төгрөг, тавилга, эд хогшлын үнэ цэнэ 24.4 сая төгрөг төгрөг байна.

Хүснэгт 30. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн үнэлгээний дүн

№	Эд хөрөнгийн нэр төрөл	Тоо ш	Хөрөнгийн дахин үнэлгээгээр		
			Бүрэн орлуулах өртөг	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Газар	2	694,176,147.08		694,176,147.08
2	Барилга	2	324,761,357.53		324,761,357.53
3	Машин, тоног төхөөрөмж	12	24,762,360.15	5,646,843.40	19,115,786.75
4	Компьютер, дагалдах хэрэгсэл	63	151,847,929.33	57,279,438.56	94,568,490.77
5	Тавилга, эд хогшил	62	35,132,625.50	10,708,379.83	24,424,245.67
6	Биет бус хөрөнгө	-	-	-	-
Бүгд дүн			1,230,680,689.60	73,634,661.79	1,157,046,027.80

Хөрөнгийн үнэлгээлгээр үнэт цаас гаргагчийн эзэмшлийн дараах хөрөнгүүдийг үнэлсэн байна. Үүнд:

1. *Газар*: Дархан-Уул аймгийн Дархан сумын 12-р баг, 7-р хороололд байрлах 1,500 м.кв, 1,000 м.кв талбайтай эзэмшлийн хоёр газар – Дархан-Уул аймгийн Дархан сумын Засаг даргын 2014 оны 281 тоот шийдвэрээр орон сууц, үйлчилгээ, хүүхдийн цэцэрлэг барих зориулалтаар 2 жилийн хугацаатай газар эзэмших эрх авсныг 2016 оны 5-р сарын 27-ны өдөр эрх бүхий байгууллагаас 5 жилийн хугацаатай сунгасан байна. Тус газар нь хотын төвдөө ойр, Олон улсын худалдааны төвийн зүүн талд байрласан нь байршлын хувьд харьцангуй давуу талтай. Газрын урд хэсгээр төвийн дулааны ил шугамтай, зүүн талд нь төвийн цахилгааны дэд станц байрласан нь цаашид газрын сайжруулалт хийж, барилга байгууламж барихад тохиромжтой. Газрын сайжруулалт бүрэн хийгдээгүй, харуул хамгаалалттай, төмөр хашаагаар хүрээлэгдсэн.
2. *Барилга*: 1) 25 оффис нь 1960 онд ашиглалтад орсон Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 2-р хороо, 2-р хороллын 34-р байрны 2 тоот хаягт (3 давхар байрны

давхарт) байрших 86 м.кв талбайтай (цэвэр талбай 75.39 м.кв) үйлчилгээний зориулалтын ажлын байр – цутгамал бетон шугаман суурьтай, 640 мм-ийн тоосгон ханатай, угсармал бетон хучилттай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон, дотор дулааны болон цахилгааны шугамын засвар үйлчилгээг 2011 онд хийж гүйцэтгэсэн, дотор зохион байгуулалтыг оффисын зориулалтаар өөрчилсөн. Хотын төвд төв зам дагуу нүүрэн байрлалтай тул үйлчилгээ эрхлэхэд тохиромжтой, цаашид зориулалтаар нь ашиглаж, бизнесийн болон эдийн засгийн үр ашиг олох боломж өндөртэй. 2) Дата төв нь 2003 онд ашиглалтад орсон Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 1-р хорооны Жигжиджавын гудамжны 5/3 хаягт (3 давхар байрны зоорийн давхарт) байрших үйлчилгээний зориулалттай 72 м.кв (цэвэр талбай 47.30 м.кв) хэмжээтэй өрөө - цутгамал бетон суурьтай, 480 мм-ийн тоосгон хана, угсармал бетон хучилттай бөгөөд төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон, тусгай зориулалтын антистатик шалтай, вакум цонхтой, серверийн өрөөг шилэн хаалтаар тусгаарласан.

3. *Машин, тоног төхөөрөмж:* Компанийн баланст 32 нэрийн 32 ширхэг хөрөнгө бүртгэгдсэн байснаас хөрөнгийн ангилал буруу бүртгэгдсэн 11 нэрийн 11 хөрөнгийг “компьютер, дагалдах хэрэгсэл” ангилалд, 13 нэрийн 13 хөрөнгийг “тавилга, эд хогшил” ангилалд тус тус шилжүүлж үнэлгээ тогтоосон ба энэ ангилалд хамрагдсан 8 нэрийн 12 хөрөнгийн чанар байдал сайн, хэвийн ажиллагаатай, цаашид үйл ажиллагаандаа үргэлжлүүлэн ашиглах боломжтой.
4. *Компьютер, дагалдах хэрэгсэл:* Үнэлгээнд 58 нэрийн 63 хөрөнгө хамрагдснаас 59 хөрөнгийн чанар байдал сайн, хэвийн ажиллагаатай, цаашид үйл ажиллагаандаа үргэлжлүүлэн ашиглах боломжтой. Үзлэгийн үеэр байгаагүй 1 хөрөнгө (нөүтбүүк), цаашид хэвийн ашиглагдах боломжгүй, элэгдлээрээ өртгөө нөхсөн зарим хөрөнгийн өнөөгийн үнэ цэнийг 0-тэй тэнцүү гэж үзсэн байна.
5. *Тавилга, эд хогшил:* Үнэлгээнд хамрагдсан 59 нэрийн 62 хөрөнгийн чанар байдал сайн, хэвийн ажиллагаатай, цаашид үйл ажиллагаандаа үргэлжлүүлэн ашиглах боломжтой.
6. *Биет бус хөрөнгө:* Компанийн баланст 5 нэрийн 5 тооны хөрөнгө бүртгэгдснээс WMWare, Апекс санхүүгийн программ, Мазаалай биз нэрээр бүртгэгдсэн хөрөнгүүд нь биет бус хөрөнгө НББОУС 38 стандартад заасан хөрөнгөөр хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангахгүй гэж үзсэн. Харин WHMCS программ болон Cybermarket нэрээр бүртгэгдсэн 2 хөрөнгө нь тухайн тайлант хугацаанд биет бус хөрөнгөөр анхлан бүртгэгдэх тул дахин үнэлгээнд хамрагдахгүй гэж үзсэн байна.

Бизнесийн үнэлгээ

Айтүүлс ХХК-ийн бизнесийн хараат бус хөндлөнгийн үнэлгээг 2017 оны 2-р сарын 2-ны өдөр байгуулсан 1/2017 тоот гэрээний дагуу **Атен ХХК** 2016 оны 12-р сарын 31-ний өдрөөр Олон улсын үнэлгээний стандартууд, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 274/240 тоото тушаалаар батлагдсан “Бизнесийн үнэлгээний аргачлал”, Үнэлгээчдийн ёс зүйн дүрэм зэрэг дотоодын хууль тогтоомжийн дагуу үнэлгээнд хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний зорилго нь хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгон арилжих (IPO хийх), хөрөнгө оруулалт татах, Модуляр дата төв байгуулах

бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхтэй холбоотой Айтүүлс ХХК-ийн бизнесийн 100 хувийн өмчлөлийн үнэ цэнийг үнэлгээний өдрөөр тодорхойлох юм.

Үнэлгээчид нь энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ үнэт цаас гаргагчаас өгсөн "Модуляр дата төвийн парк"-ийн төсөл, аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангууд, үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан зэрэг анхдагч мэдээлэл, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүд, салбарын мэргэжилтнүүдийн судалгаа, мэдээлэл болон цахим хуудас дах мэдээ зэрэг хөндлөнгийн мэдээлэлд анхан шатны хяналт, магадлагаа хийж шинжилсэн байна. "Үнэлгээний олон улсын стандарт 200: Бизнес ба бизнесийн хувь оролцоо"-д "*Аж ахуйн нэгжийн үнэ цэнийг тодорхойлохдоо бизнесийн өмчийн үнэ цэнийн нийт дүн дээр өр төлбөр болон өр төлбөрт хамаарах үүрэг хариуцлагын үнэ цэнийг нэмж, эдгээр өр төлбөрт дайчилж ашиглах боломжтой мөнгө болон түүнтэй адилтгах зүйлийг хасч тооцно*" гэж заасны дагуу бизнесийн үнэ цэнийг тодорхойлоход хамгийн өргөн хэрэглэгддэг орлогын хандлагын "Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга" болон өртгийн хандлагын "Цэвэр хөрөнгийн арга"-ыг сонгож үнэлгээний тооцоололд ашиглажээ. Бизнесийн үнэ цэнийг тодорхойлоход түгээмэл хэрэглэдэг өөр нэг арга болох зах зээлийн хандлагын аргыг шаардлагатай мэдээллийн хүрэлцээ хомс, баталгаажилт хангалтгүй, зах зээлийн хандлагаар үнэлгээ тогтоохоор олсон мэдээлэл нь компанийн мэдээлэлтэй бодитоор харьцуулагдах нь эргэлзээтэй гэж үзэн, үнэлгээнд хэрэглээгүй байна.

Ийнхүү үнэлгээний өдөр болох 2016 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэ цэнийг эцсийн үр дүнг тооцохдоо үнэлгээг компани зах зээлд хувьцаагаа нээлттэй гаргах, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, Модуляр дата төвийн паркийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хийж буй тул "Модуляр дата төвийн парк" төсөл хэрэгжүүлэн, үйл ажиллагаагаа цаашид өргөжүүлэх төсөөллөөр хийгдсэн орлогын хандлага буюу **"Цэвэр мөнгөн гүйлгээг хорогдуулах арга"-аар** хийгдсэн үнэлгээний тооцооллыг 100 хувь хүлээн зөвшөөрч, нийт **4,409,072,540.00 (дөрвөн тэрбум дөрвөн зуун есөн сая далан хоёр мянга таван зуун дөч) төгрөгөөр** тогтоосон.

Хүснэгт 31. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээний дүн

Бизнесийн үнэлгээний арга, хандлага	Тухайлсан үнэ цэнэ, төгрөг	Ач холбогдлын хувь	Жинлэсэн үнэлгээ, төгрөг
Цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах арга (Орлогын хандлага)	4,409,072,540.00	100%	4,409,072,540.00
Зах зээлийн харьцуулалтын арга (Зах зээлийн хандлага)	-	0%	-
Тохируулга хийгдсэн цэвэр хөрөнгийн арга (Өртгийн хандлага)	1,407,821,199.56	0%	-
Нийт бизнесийн үнэ цэнэ			**4,409,072,540.00**

Бизнесийн үнэлгээнд ашигласан арга тус бүрээр үнэлгээчдийн гаргасан зарим тооцоолол болон тайлбарын дэлгэрэнгүйг дор толилуулав.

Орлогын хандлага: хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаарх бизнесийн үнэ цэнэ

Орлогын хандлага нь компанийн ирээдүйн мөнгөн гүйлгээг өнөөгийн үнэ цэнэд хувиргах замаар үнэ цэнийг тогтоодог хандлага юм. Энэ хандлага нь үнэлэгдэж буй компани бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх хугацаанд бий болгох мөнгөн гүйлгээг тооцоолж капиталжуулах замаар үнэ цэнийг тогтоодог. Капиталжуулалтаар тохирох хорогдуулгын хувийг хэрэглэн, ашиг эсвэл ирээдүйн цэвэр мөнгөн урсгалыг бизнесийн үнэ цэнийн мөнгөн дүнд хувиргадаг. Орлогын хандлагад орлого капиталжуулалтын арга, хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга, эрсдлээр тохируулсан цэвэр өнөөгийн үнэ цэнийн арга (rNPV), опционы үнэлгээний загварууд зэрэг аргууд байдаг. Эдгээрээс хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргыг ямар ч үйл ажиллагаа явуулж буй компанийн хувьд ашиглаж болдог ч байнгын алдагдалтайгаар үйл ажиллагааг явуулж буй компанид хэрэглэх нь тохиромж багатай байдаг бол үйл ажиллагаа нь тогтвортой, ашигтай ажиллаж байгаа, өсөх хандлагатай буюу эдийн засгийн тогтвортой өсөлттэй компанид хэрэглэх нь илүү тохиромжтой байдаг.

Орлогын хандлагаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлоход хамгийн өргөн хэрэглэгддэг “Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга” нв компанийн ирээдүйн төсөөлсөн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход хэрэглэдэг арга юм. Хорогдуулж буй мөнгөн гүйлгээний төрлөөс хамаарч өмчийн өртөг эсвэл капиталын жигнэсэн дундаж өртөг гэх мэт хорогдуулалтын хувийн аль зохистойг хэрэглэн, ирээдүйн мөнгөн гүйлгээг өнөөгийн үнэ цэнэд хувиргадаг.

Айтүүлс ХХК нь 2011 онд байгуулагдсан бөгөөд 2012-2016 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, бизнесийн төлөвлөгөө, үйл ажиллагааны бусад мэдээлэлд шинжилгээ хийн, үйл ажиллагааны бус болон илүүдэл хөрөнгөтэй холбоотой орлого, зарлагын гүйлгээг оруулан, зохих залруулгыг хийн, татварын өмнөх ашиг, татварын зардлын тооцоог нягталж шалгасны дараа цэвэр ашгийг тооцоолон гаргаж, улмаар цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлон гаргасан. Бизнесийн үнэлгээний тооцооллыг “Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга”-аар хийж гүйцэтгэхдээ дараах таамаглалуудыг үндэслэл болгов. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэх бөгөөд 2017 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Модуляр дата төвийн парк” төсөлд түрээсээр байрлуулах контейнерийн тоо 2017 онд 5 ширхэг, 2018 онд 8 ширхэг, 2019 онд 12 ширхэг, 2020 онд 15 ширхэг, 2021 онд 15 ширхэгт хүрсэн байхаар, компани 2017 онд 1 ширхэг контейнер центр худалдаж авахаар тус тус төлөвлөсөнг үндэслэл болгосон.
- Хувьцаа гарган хөрөнгө оруулалт татахаар төлөвлөж буй 1,34 тэрбум төгрөгийн санхүүжилтээр оффисын барилга, дата центрийн барилга, контейнер центр, түүнд шаардлагатай цахилгаан, дулаан, дэд бүтцийг байгуулахаар төлөвлөснийг мөнгөн урсгалд тусгасан.
- Айтүүлс ХХК-ийн охин компани болох Си нэт ХХК нь ISP тусгай зөвшөөрөлтэй, бөгөөд Айтүүлс ХХК-ийн зүгээс интернет урсгал ашиглалтын зардлыг төлж ажиллахаар төлөвлөгдөн байгуулагдсан ба модуляр дата центрийн үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотойгоор үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн зүгээс 2017 оны 2-р сараас охин компанийн статусыг салгах үйл ажиллагааг явуулахаар болсон

тул түүнтэй холбоотой тохируулгыг 2017-2021 оны мөнгөн урсгалын таамаглалд тусгасан.

- Айтүүлс ХХК-ийн 2012-2016 оны өнгөрсөн үеүд дэх бизнесийн үйл ажиллагааг шинжилсний үндсэн дээр 2017-2021 оны борлуулалтын орлогын өсөлтийг 1.34-1.79 хувь өсөх боломжтой байгааг тус тус тусгасан.
- Хүчин чадал ашиглалтыг 2017-2020 онуудад төлөвлөсөн борлуулалтын орлогын 80 хувь, 2021 онд 90 хувь байхаар тооцоонд тусгасан. Түүнчлэн, судалгаа хөгжүүлэлт, борлуулалт, маркетингийн зардлыг үйл ажиллагааны зардлын 5% орчим байхаар бизнесийн таамаглалд тусгасан нь бодит байдалд нийцнэ гэж үзсэн. Учир нь Айтүүлс ХХК-ийн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан салбарын төлөв, хандлагын мэдээллийг шинжлэн үзсэний үндсэн дээр компанийн явуулж буй үйлчилгээ, модуляр дата төвийн үйл ажиллагааны өртгөтгөл, шинэчлэл нь аюулгүй байдлыг дээд зэргээр хангасан, хандалтын өндөр хурдыг хангаж байж, тогтмол зар сурталчилгаа, маркетингийн бодлого /хөнгөлөлт, урамшуулалт г.м./-ыг уян хатан хэрэгжүүлж байж амжилтанд хүрнэ, борлуулалтын төлөвлөсөн орлогод хүрэх дэмжлэг байх болно гэж тооцоолсон.
- Компанийн үзүүлж буй үйлчилгээний тариф прогнозын хугацаанд өөрчлөгдөхгүй хэмээн таамагласан.
- Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнг шинжлэн үзэхэд борлуулалтын орлогын 0.20-0.63 хувийг эзэлж байсан бөгөөд 2017-2021 онуудын ББӨ-ийн таамаглахдаа борлуулалтын орлогын дунджаар 0.22-0.24 хувийг эзэлнэ гэж тооцоолон тусгасан.
- Үйл ажиллагааны зардлын өөрчлөлт 2012-2016 онд дунджаар 0.83-2.01 байсан бөгөөд сүүлийн жилийн өсөлт 1,73 байв. Хэдийгээр Айтүүлс ХХК нь 2017-2021 оны бизнес төлөвлөгөөндөө үйл ажиллагааны зардлыг 6.1-6.5% өсөлттэй байхаар тусгасан ч үйл ажиллагаа өргөжин тэлж байгаа, инфляцийн өсөлт, валютын ханшны өсөлт зэргийг харгалзан сүүлийн жилийн өсөлтийг тооцоонд тусгах нь зүйтэй хэмээн үнэлгээчид тооцоолсон.
- Ажлын капиталын өөрчлөлтийг 2012-2016 оны өнгөрсөн үйл ажиллагааны санхүүгийн үр дүнд шинжилгээ хийж тооцоолсон.
- Олон улсын байгууллага (Global Insight, Ibbotson, Damodaran)-ын судалгаагаар АНУ-ын инфляцын урт хугацааны өсөлтийн хувь 2.47% орчимд, Монгол улсын инфляци үнэлгээний өдрийн байдлаар 0,5% гэж тооцсоны дагуу сонгосон нь олон улсын түвшинд нийцнэ гэж үзсэн.
- Хорогдуулах хувийг нийлбэрийн арга (Cumulative), капиталын хөрөнгө үнэлгээний загварын арга (CAPM), жинлэсэн дундаж өртгийн арга (WACC) аргуудаар тооцож, харьцуулан, бизнесийн үнэлгээний тооцоололд илүү нийцтэй аргаар тооцсон хүүний түвшинг авч ашиглана.

Хорогдуулгын хувийн тооцоолол:

Ирээдүйн тогтмол биш орлогыг өнөөгийн үнэ цэнэд шилжүүлэх хүүний хувийг хорогдуулах хувь буюу дискаунтын хүү гэдэг. Хорогдуулах хувийг тооцдог маш олон аргууд байдаг

СЗХ
он сар өдөр
2017.09.27
БҮРЛГЭВ
№ 01

бөгөөд энэхүү бизнесийн үнэлгээний тооцоололд практик туғээмэл хэрэглэддэг “жинлэсэн дундаж өртгийн арга (WACC)”-аар тооцсон хүүний түвшин болох 23.02 хувийг ашигласан.

Үлдэх үнэ цэнийн тооцоолол:

Прогнозын хугацаанаас хойшх мөнгөн урсгалыг үйлдвэрлэл тасралтгүй үргэлжлэнэ гэсэн таамаглалаар Гордоны загвараар тооцоолсон бөгөөд бизнесийн прогнозын хугацаанаас хойших урт хугацаат өсөлтийн хувийг тус компанийн хэрэгжүүлж буй төсөлтэй, улс орны эдийн засгийн байдалтай уялдуулан 1.64%-аар тооцсон.

Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
Борлуулалтын орлого	788,558,865	1,621,482,650	2,556,826,666	3,764,371,879	5,961,430,176
Борлуулалтын өртөг	127,810,721	191,367,914	330,774,828	525,033,185	1,007,835,006
Борлуулалтын хорогдол ба буцаалт	-	-	-	-	-
Нийт ашиг (алдагдал)	**660,748,144**	**1,430,114,737**	**2,226,051,838**	**3,239,338,694**	**4,953,595,170**
Түрээсийн орлого	-	-	-	-	-
Хүүний орлого	8,329	17,126	27,004	39,758	62,963
Ногдол ашгийн орлого	-	-	-	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-	-	-	-
Бусад орлого	7,322,932	15,057,858	23,743,907	34,957,746	55,360,673
Орлогын дүн	**7,331,261**	**15,074,984**	**23,770,912**	**34,997,504**	**55,423,636**
Борлуулалт, маркетингийн зардал	30,429,204	53,591,450	83,941,779	1222,515,240	169,580,485
Ерөнхий ба удирдлагын зардал	608,584,077	1,071,828,994	1,678,835,583	2,450,304,810	3,391,609,698
Үүнд: элэгдлийн зардал	-	-	-	-	-
Санхүүгийн зардал	-	-	-	-	-
Бусад зардал	3,242,850	4,365,223	5,876,056	7,909,800	10,647,437
Зардлын дүн	**642,256,130**	**1,129,785,666**	**1,768,653,418**	**2,580,729,850**	**3,571,837,620**
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-	-	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-	-	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-	-	-	-
Олз (гарз)-ын дүн	-	-	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг	**25,823,274**	**315,404,055**	**481,169,332**	**693,606,348**	**1,437,181,186**
Татварын зардал	2,582,327	31,540,405	48,116,933	69,360,635	143,718,119
Татварын дараах ашиг	**23,240,947**	**283,863,649**	**433,052,399**	**624,245,713**	**1,293,463,067**
Мөнгөн бус зардал	-	-	-	-	-
Ажлын капиталын өөрчлөлт	36,058,310	37,684,979	28,124,691	30,615,423	33,120,851
Капиталын зардал	-	-	-	-	-
Цэвэр мөнгөн гүйлгээ	**59,299,257**	**321,548,628**	**461,177,090**	**654,861,136**	**1,326,583,918**
Хорогдуулах хувь	23.02%	23.02%	23.02%	23.02%	23.02%

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

Прогнозын хугацаа	1	2	3	4	5
Ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнийн коэффициент	0.9016	0.7329	0.5958	0.4843	0.3937
Өнөөгийн үнэ цэнэ	**53,464,898**	**235,670,445**	**274,767,372**	**317,165,272**	**522,288,079**
Урт хугацаат өсөлтийн хувь					1.64%
Цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах хувь					23.02%
Прогнозын хугацаанаас цааших үлдэх өртгийн өнөөгийн үнэ цэнэ					**3,005,716,475**
Орлогын хандлагаарх бизнесийн үнэ цэнэ					**4,409,072,540**

Хүснэгт 32. Хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаар хийсэн бизнесийн үнэ цэнийн тооцоолол

Өртгийн хандлага: цэвэр хөрөнгийн аргаарх бизнесийн үнэ цэнэ

Өртгийн хандлага бол түүнийг өмчлөгч анх барьж бүтээсэн буюу олж эзэмшсэнээс бага үнээр
борлуулахыг хэзээ ч хүсэхгүй гэсэн таамаглалд үндэслэн үнэ цэнийг тогтоодог хандлага юм. Өртгийн хандлага нь зах зээлийн үнэ цэнээрээ хэмжигдсэн бизнесийн нийт хөрөнгөөс бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн өр төлбөрийг хасч тодорхойлсон цэвэр хөрөнгийг илэрхийлдэг. Өртгийн хандлагын цэвэр хөрөнгийн (хөрөнгөд суурилсан) арга, үлдэгдэл (устгалын) өртгийн арга гэж байдаг ба шинээр эхэлж байгаа бизнес, эсвэл эхлээд удаагүй байгаа бизнесийн хувьд тэдгээрийн талаар зах зээлээс мэдээлэл олдохгүй байх, эсвэл мөнгөн урсгалын талаарх түүхэн мэдээлэл хомс байх тохиолдолд өртгийн хандлагыг хэрэглэхийг дэмждэг.

Цэвэр хөрөнгийн арга нь нийт хөрөнгийн (мөнгийг хассан) зах зээлийн бодит үнэ цэнээс одоогийн өр төлбөрийн (хүүтэй өр төлбөрийг хассан) зах зээлийн бодит үнэ цэнийг хасч, бизнесийн байгууллагын өмчийн үнэ цэнийг тодорхойлдог. Дансны үнэ нь үнэлгээний өдөр буюу 2016 оны 12-р сарын 31-ний өдрөөрх зах зээлийн бодит үнэ цэнийн үндэслэлтэй тооцооллыг илэрхийлж чадахгүй байх магадлалтай тул компанийн хөрөнгийн дансны үнийг зах зээлийн үнэд шилжүүлэхтэй холбоотой таамаглал дэвшүүлэн, хэд хэдэн тохируулгыг авч үзсэн болно. Үүнд:

- Компани нь авлага эргэн төлөгдөх чадварт шинжилгээ хийсний үндсэн дээр цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл нь бууруулж авлагаа үнэлдэг бөгөөд компанийн өгсөн мэдээлэлд тулгуурлан, авлагын насжилтын шинжилгээнд суурилан авлагын үнэ цэнийн бууралтыг хэмжиж хасч тохируулсан.
- Бараа материалын дансны үнэд бодит үнэ цэнээс давсан хэтрэлт байж болзошгүй гэж таамаглан ашиглагдахгүй байгаа бараа материалын үлдэгдэл өртгийг хасч тооцсон.
- Ирээдүйд компанид эдийн засгийн өгөөж оруулахааргүй урьдчилгаа тооцоо болон урьдчилж төлсөн зардлыг хасч тохируулах байсан ч компани ийм шинж бүхий үргүй зардал байхгүй гэж бидэнд мэдэгдсэн.
- Үндсэн хөрөнгийн хувьд 2016 оны 12-р сарын 31-ний байдлаар хараат бус үнэлгээчнээр хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэн учраас нэмэгдэл тохируулга шаардахгүй гэж үзсэн.

- Биет бус хөрөнгийн хувьд нягтлан бодох бүртгэлдээ тусгаагүй 1 бизнест нь эдийн засгийн үр өгөөж өгч байгаа бол олж илрүүлэх, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхлан өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэсэн хөрөнгүүдийн шинж байдалд дүгнэлт хийн, хөрөнгөөр хүлээн зөвшөөрөгдөх шалгуурыг хангаж буй эсэхийг магадлан, шаардлагатай бол тохируулга хийх нь зүйтэй гэж үзсэн.

Хүснэгт 33. Тохируулга хийсэн цэвэр хөрөнгийн аргаар хийсэн бизнесийн үнэлгээний тооцоолол

Хөрөнгө, үзүүлэлтүүд	2016/12/31 тайлангаар	Тохируулга/ элэгдэл	Үнэлгээгээр
Мөнгөн хөрөнгө	16,189,047.46	-	16,189,047.46
Дансны авлага	66,992,942.73	(8,939,465.43)	58,053,477.30
Татвар, НДШ-ийн авлага	3,343,960.05	-	3,343,960.05
Бараа материал	120,372,340.90	(1,646,000.00)	118,726,340.90
Урьдчилж төлсөн зардал	127,606,703.45	-	127,606,703.45
Эргэлтийн хөрөнгийн дүн	**334,504,994.59**	**(10,585,465.43)**	**323,919,528.96**
Үндсэн хөрөнгө	1,157,046,028.18	-	1,157,046,028.18
Биет бус хөрөнгө	56,290,330.51	(2,092,649.90)	54,197,680.61
Урт хугацаат хөрөнгө оруулалт	70,446,145.00	-	70,446,145.00
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**1,283,782,503.69**	**(2,092,649.90)**	**1,281,689,853.79**
Нийт хөрөнгийн дүн	**1,618,287,498.28**	**(12,678,115.33)**	**1,605,609,382.95**
Нийт өр төлбөр			**197,788,182.98**
2016 оны 12-р сарын 31-нээрх компанийн үнэ цэнэ (төгрөг)			**1,407,821,199.56**

Хуулийн дүгнэлт

Үнэт цаас гаргагчид хууль зүйн зөвлөгөө өгөх эрх бүхий **Өмгөөллийн Монгол Зарга ХХН** нь 2017 оны 3-р сарын 17-ны өдөр байгуулсан Г17/08 дугаартай гэрээний дагуу бие даасан хууль зүйн дүгнэлтийг гаргасан. Энэхүү дүнэлтийг хийхдээ Өмгөөллийн Монгол Зарга ХХН-ийн хуульчид шинжлэх ухааны харьцуулалтын аргыг хэрэглэсэн ба үнэт цаас гаргагчийн Компанийн дүрэм, журмууд, гэрээ, бусад бичиг баримт, эрх зүйн актууд нь Монгол Улсын хууль, тогтоомж, журмын зүйл, заалтуудтай нийцэж байгаа эсэх, хэрэв хуульд нийцээгүй бол ямар зүйл, заалтыг зөрчсөн, үг сонголтонд алдаа гаргасан уу, утгын алдаа гарсан уу гэдгийг хууль зүйн талаас нь дүгнэсэн болно.

Хуульч нь дүгнэлтийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24, 25.3-т заасныг үндэслэн хууль дээдлэх, хараат бус байх, шударга ёсны зарчмуудыг баримтлан, Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрлийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголын Компанийн

СЗХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

засаглалын кодекс, Үнэт цаасны бүртгэлийн журам, бусад хууль тогтоомжуудыг үндэслэн гаргасан. Хууль зүйн дүгнэлтийн ерөнхий дүгнэлтийг дор толилуулав.

Дүгнэлт

1. “Айтүүлс” ХХК нь программ хангамжийн үйлчилгээ, мэдээлэл технологийн үйлчилгээг хөгжүүлж, энэ салбарт шинэ технологи бий болгох зорилготойгоор үйл ажиллагаагаа өргөжүүлж, Компанийн эрх зүйн үндэс болсон Компанийн дүрэм, Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад журмуудыг Монгол Улсын Компаний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан батлаж, дагаж мөрдөж байна.
2. Компани нь 2011 оны 4-р сарын 11-ний өдрийн 01 дугаартай үүсгэн байгуулах шийдвэрийн дагуу “Интеллижент Түүлс” ХХК нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаад “Айтүүлс” ХХК болон нэрээ өөрчлөн бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулж ирсэн нь хуулийн дагуу байна.
3. Компанийн Гүйцэтгэх захирлыг компанийн хувьцаа эзэмшигчид томилж, чөлөөлөх бөгөөд Компанийн тухай хуулийн 83, болон Компанийн дүрмийн 6 дугаар бүлэгт заасны дагуу Хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаагаа явуулдаг байна.
4. Компанийн Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрмийн 6 дугаар бүлэгт заасны дагуу дагуу гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж, хууль болон Компанийн дүрэм, Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад журмуудад нийцүүлэн компанийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, шийдвэр гаргах, зэргээр Компанийн тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
5. Компанийн үйл ажиллагаандаа мөрдөж хэрэгжүүлж байгаа дүрэм, журмууд нь Компанийн ажилтан албан тушаалтнуудын хариуцлага, сахилга дэг журам, ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлага, хариуцлагын тогтолцоо, дотоод хяналтыг бий болгож сахилга дэг журмыг тогтоосон, Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн, харилцагчийн эрх ашгийг хүндэтгэж, харилцан хариуцлага хүлээх шаардлага тавьсан байна.
6. Компани нь үйлчлүүлэгчтэй болон гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцлийг Компанийн тухай хууль, Иргэний хууль, зэрэг хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн байх бөгөөд компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагаваргүй гэж үзэж байна. Түүнчлэн, Компанийн тухай хуулийн 87, 92 дугаар зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл сүүлийн 3 жилийн хугацаанд хийгдээгүй байна.
7. Компанийн эрхлэж буй үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл шаардагдахгүй аж ахуйн үйл ажиллагаанд хамаарна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар тусгай зөвшөөрөл авсан баримт байхгүй байна.
8. Компани нь Улсын бүртгэлийн Y2205018687 дугаартай Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, 2-р хороолол, 34 байр, 2 тоотод хаягтай үйлчилгээний байр, Улсын бүртгэлийн Y22020243583 дугаартай Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 5/3 байр хаягтай дата төвийн давхар, Дархан-Уул аймаг, Дархан сум, 12 дугаар баг, 7-р хороололд орших, нэгж талбарын 04506102457 дугаар

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 5444381

бүхий 1,000 м^2 газрыг 5 жилийн хугацаатай, орон сууц, хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар эзэмших эрх, Дархан-Уул аймаг, Дархан сум, 12 дугаар баг, 7-р хороололд орших, нэгж талбарын 04506102458 дугаар бүхий 1,500 м^2 газрыг 5 жилийн хугацаатай, орон сууц, хүүхдийн цэцэрлэгийн зориулалтаар эзэмших эрхийг тус тус эзэмшдэг ба эдгээр үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх, газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна.

9. Компанийн жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч нь Компанийн хувьцааг 100% эзэмшдэг толгой компани болох “Ай Си Ти групп” ХХК юм. “Ай Си Ти групп” ХХК-ийн хяналтыг хэрэгжүүлэгч нь 62.5%-ийн хувьцаа эзэмшигч “Ворлд Френдс” ХХК, 37.5%-ийн хувьцаа эзэмшигч Адилбишийн Баттамир юм. “Ворлд Френдс” ХХК-ийн хяналтыг хэрэгжүүлэгч нь 100% хувьцаа эзэмшигч нь Цоодолын Ганболд байна.
10. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй ба гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь дээд боловсролтой, удирдах чадварын хувьд ажлын туршлагатай, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, Монгол Улсын “Компанийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, бусад хууль тогтоомж, мөн “Компанийн засаглалын кодекс”-т заасан шаардлагыг тус тус хангаж байна.
11. Компани нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өргүй, улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчилгүй, Хувьцаат компани болохтой холбогдуулан Хувьцаат компанийн дүрмийн төсөл, Компанийн засаглалын журмуудын төслийг боловсруулсан нь Монгол Улсын хууль тогтоомж, “Компанийн засаглалын кодекс”-т нийцсэн байна.
12. Компанийн анх удаа олон нийтэд санал болгон хувьцаа гаргах шийдвэрийг Компанийн тухай хуулийн 62.2.1, 62.2.10-т Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал гаргахаар заасны дагуу “Ай Си Ти Групп” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2017 оны 3-р сарын 24-ний өдрийн 08 тоот тогтоолоор Дархан хотод барих гэж буй Модуляр дата төвийн паркийг санхүүжүүлэх зорилгоор нэмж хувьцаа гарган, анх удаа олон нийтэд санал болгох аргаар 1,338,798,000 төгрөгийг татан төвлөрүүлэх, 13,387,980 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгохоор нэмж гаргах, олон нийтэд анх удаа санал болгох нэгж хувьцааны үнийг 100 төгрөгөөр тогтоох, анхдагч зах зээлийн арилжааг “Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга”-аар зохион байгуулах, одоогийн хувьцаа эзэмшигчид нь хөрөнгө татан төвлөрүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар заасан байна.
13. Компанийн үнэт цаас бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтуудаар нотлогдож байна гэж дүгнэж байна. Тиймээс, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.2.2-т заасан шаардлага, Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.5-д заасны дагуу энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргаж байна.

СЭХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

ГУРАВ. ТӨСЛИЙН ТУХАЙ

Төслийн товч танилцуулга

ТӨСЛИЙН НЭР:	МОДУЛЯР ДАТА ТӨВИЙН ПАРК
Төслийн үйл ажиллагаа:	Олон улсын TIER III стандартын газарзүйн нөөц Модуляр дата төвийг Дархан хотод байгуулж, контейнер дата төвийн түрээс, сервер байршуулалт, өгөгдөл хадгалах, нөөцлөлтийн үйлчилгээ зэрэг дата төвийн цогц үйлчилгээг үзүүлнэ.
Төслийн хугацаа:	2017-2021 он
Төсөл хэрэгжих газар:	Дархан-Уул аймаг
Нийт хөрөнгө оруулалт:	1,388,798,000 төгрөг
Үндсэн зорилго:	Газарзүйн нөөц байрлалд Модуляр дата төвийн паркийг байгуулан ашиглалтанд оруулж, нийгэм эдийн засгийн бүхий л салбарын байгууллага, аж ахуйн нэгжүүдэд дэлхийн жишигт нийцсэн цахим мэдээллийн дамжуулалт, хадгалалтын үйлчилгээг үзүүлж, тэдгээрийн ашиг орлого, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх замаар төслийн хөрөнгө оруулалтыг богино хугацаанд нөхөж, эдийн засагт болон мэдээлэл, технологийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулна.
Зорилтууд:	– Газарзүйн нөөц байршилд дата төвийн үйлчилгээний орчин үеийн чиг хандлагыг тодорхойлж буй модуляр дата төвийн парк байгуулж, шинэлэг үйлчилгээг Монголд нэвтрүүлэх. – Энэхүү төслийг хэрэгжүүлж, үйлчилгээгээ тэлснээр 2021 он гэхэд вэбсайтын зах зээлийн 35 хувийг эзлэх. – Одоогийн байдлаар бараг 100 хувь гадаадаас импортлож байгаа албан буюу бизнес и-мэйлийн үйлчилгээг дотооддоо хангаж, импортыг орлох.
Үр дүн, үр нөлөө:	Монгол Улсын мэдээллийн технологийн салбарын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулна. Богино хугацаанд өндөр өгөөжийг хэрэглэгчид болон хөрөнгө оруулагчид хүртэх боломжтой. Үйлчлүүлэгчид чанартай үйлчилгээ авч, тэдний мэдээллийн аюулгүй байдал хангагдана. Үйлчлүүлэгчдэд төдийгүй улс орны эдийн засагт үр ашиг авчрах зэрэг шууд бус үр нөлөө гарна. Төслийг хэрэгжүүлэхэд 1.34 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татаж, нийт 10.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 4.9 тэрбум төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажиллана.

Төслийн үндэслэл

Мэдээллийн технологи нь өөрөө цахим тооцоолуур болон программ хангамжийг хэрэглэн, мэдээллийг хувиргах, хадгалах, хамгаалах, боловсруулах, дамжуулах болон гайдвартайгаар

УЛААНБАА
itools
АЙТҮҮЛС
1116218269 ☎ 5468361
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЗХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

хүлээн авах тухайг судалдаг салбар юм. Энэ салбарын хөгжил нь харилцаа холбооны салбартай салшгүй холбоотой бөгөөд мэдээлэл, харилцаа холбооны салбарыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт үр ашигтайгаар нэвтрүүлж хөгжүүлэх нь өргөн уудам газар нутагтай, байгалийн эрс тэрс уур амьсгалтай, хүн ам тархай суурьшсан, эдийн засаг нь хөгжиж буй түвшинд байгаа манай улсын хувьд чухал ач холбогдолтой юм. Монгол Улсад мэдээлэл, харилцаа холбооны салбар үүсээд 94 жил болсон ч мэдээллийн технологийн салбарт гарсан чухал өөрчлөлтүүд 1994 оноос эхлэлтэй гэж үздэг.

Мэдээллийн технологи харилцаа холбооны салбар нь өнөөгийн дэлхий дахины хөгжлийн чиг хандлагыг тодорхойлогч, улс орнуудын нийгэм эдийн засгийн хөгжлийн хурдасгуур хэрэгсэл болохын зэрэгцээ бусад салбартай харьцуулахад зорилгодоо хамгийн бага зардлаар хүрэх, хөрөнгө оруулалтаа хамгийн богино хугацаанд нөхөх, дотоод нөөц бололцоогоо хамгийн үр ашигтайгаар ашиглах боломжийг олгодог онцгой салбар юм. Тийм ч учраас мэдээллийн технологийн салбарын хөгжил, гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, дэлхийн ихэнх улс орон тодорхой хөтөлбөр, дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлж байна.

Мэдээлэл технологи, харилцаа холбооны салбарын хөгжил дэвшилд төр засгийн оролцоо, дэмжлэг асар их шаардагддаг бөгөөд сүүлийн жилүүдэд манай улсын Засгийн газраас тус салбарыг улс орны хөгжлийн хурдасгуур гэж үзэн, эрчимтэй хөгжүүлэх талаар шат дараалсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд мэдээллийн технологи нь төр, нийгэм, эдийн засгийн тогтолцоо, иргэдийн амьдралд нэвтэрч, төрийн байгууллагын үйл ажиллагаа цахимжиж, цахим засаг, цахим боловсрол, цахим эрүүл мэнд, цахим банк зэрэг хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна. Статистик мэдээллийг авч үзвэл 2016 оны хагас жилийн байдлаар манай улс нийт 3.1 сая бүртгэлтэй үүрэн холбооны хэрэглэгч, үүнээс 2.1 сая ухаалаг утас хэрэглэгч, 2.43 сая гаруй интернэтийн байнгын хэрэглэгч, 752 орчим мянган КаТВ хэрэглэгч, 36.3 мянган км шилэн кабельтай болж, 2015 оны эцсийн байдлаар салбарын нийт орлого 933.3 тэрбум төгрөг, нийт хөрөнгө оруулалт 204.6 гаруй тэрбум төгрөг байгаа нь 5 жилийн өмнөхтэй харьцуулахад 2 дахин нэмэгдсэн үзүүлэлт юм.

Мэдээллийн технологи нь бизнесийн төдийгүй бүх салбарт тухайн байгууллагын үйлчилгээний шуурхай байдал, ашиг орлого, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээс гадна үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал, манай улсын хувьд эдийн засгийн салбар дунд банк санхүүгийн салбарт мэдээллийн технологийн хэрэглээ, хэрэгцээ шаардлага нь олон улсын хөгжлийн түвшинг даган хурдацтай хөгжиж байна. Банкууд нь харилцагчиддаа үйлчилгээгээ зардал багатай, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэхийн тулд, мөн санхүүгийн салбарт эзлэх байр суурь, улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө зэргээс үүдэн цахим банкны үйлчилгээгээ сүүлийн жилүүдэд хурдацтай нэмэгдүүлсээр байна. Өнөөгийн иргэдийн банкны хэрэглээг 2015 оны байдлаар авч үзвэл хадгаламжийн дансны тоо 2.8 сая, харилцах дансны тоо 7.9 сая, зээлийн дансны тоо 846 мянга, нийт ашиглагдаж буй картын тоо 4.0 сая, мобайл банкинд бүртгүүлсэн иргэдийн тоо 1.9 сая, интернэт банкинд бүртгүүлсэн иргэд 800 мянгад хүрээд байна.

Банкны салбар тутмын хадгаламж, зээл болон орлого, зарлагын гүйлгээ зэрэг бүхий л үйлчилгээний мэдээлэл нь цахим хэлбэрт шилжин, мэдээллийн санг маш их хэмжээгээр бий

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУЛС
ХХК
11621826 ᠳᠤ. 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ᠳᠤ. 5444381

болгож байгаа бөгөөд эдгээр мэдээлэл нь ихэнхдээ банкны өөрийн сервер компьютерт хадгалагдаж байдаг. Банкууд төдийгүй санхүүгийн салбар, үйлчилгээний бусад салбарууд тэр чигээрээ мэдээллийн технологиос хамааралтай болсон энэ цаг үед хадгалагдаж буй мэдээллийн үнэ цэнээс үүдэн өнөөгийн тулгамдаж буй мэдээллийн технологийн гол асуудал бол цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах явдал юм.

Мэдээллийн аюулгүй байдал гэж мэдээлэл болон мэдээллийн санд зөвшөөрөлгүй хандах, мэдээллийг ашиглах, ил болгох, өөрчлөх, хуулах, устгах, мэдээллийн санг ашиглах үйл ажиллагааг тасалдуулах, хянах, мэдээллээ алдах зэргээс хамгаалахыг хэлэх бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хангаж чадахгүйд хүрвэл улс орны эдийн засаг болон үндэсний аюулгүй байдалд хүртэл сөргөөр нөлөөлөх боломжтой. Цахим мэдээллийн аюулгүй байдлын асуудал нь зөвхөн банк, санхүүгийн байгууллагаар хязгаарлагдахгүй ба төрийн байгууллагууд, цэргийн байгууллагууд, бизнес эрхлэгчид, хувь хүмүүс зэрэг мэдээллийн санг цахимаар бий болгож байдаг бүгдэд хамааралтай байдаг.

Банк, санхүүгийн байгууллага болон бусад цахим мэдээллийн санг үүсгэн, хадгалж байдаг аж ахуйн нэгжүүд нь одоогоор үйл ажиллагаа явуулж буй үндсэн байршилдаа өөрсдийн мэдээллийн аюулгүй байдлыг тодорхой хэмжээнд хангаж байгаа ч энэ нь олон улсад дагаж мөрдөгддөг мэдээллийн аюулгүй байдлын стандарт, шаардлагыг хангаж чадахгүй байна. Банк, санхүү болон бусад салбарын мэдээллийг хадгалах үйл ажиллагаанд тавигдаж буй олон улсын стандартад мэдээллийг газар хөдлөлт, үер ус гэх мэт байгалийн гамшигт үзэгдэл болон санаатай халдлагад өртөх эрсдлийг бууруулсан нөөц байршилд давхар хадгалахыг шаарддаг. Тиймээс, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангахын тулд аж ахуйн нэгж, байгууллагууд нь мэдээллийн сангаа газар хөдлөлт, үер зэрэг байгалийн гамшигт үзэгдэл, бусад давагдашгүй хүчин зүйлсэд өртөхөөс сэргийлсэн газарзүйн нөөц байршилд цахилгаан, өндөр хурдны интернэтэд холбогдсон дэд бүтэц бүхий газар байрших сервер болон сүлжээний төхөөрөмжүүдээр тоноглогдсон, тасралтгүй, найдвартай ажиллагаатай мэдээлэл хадгалах дата төвд давхар хадгалуулж байх шаардлагатай болж байна.

Манай улсын хэмжээнд мэдээлэл хадгалах зориулалт бүхий тусгай дата төвүүд цөөн тоогоор байгаа ч үйлчлэх цар хүрээ, зориулалт, стандартын хувьд мэдээллээ хадгалуулах хэрэгцээ, шаардлагатай тулгараад байгаа өсөн нэмэгдэж буй хэрэглэгчдэд бүгдэд нь хүрч үйлчилж чадахгүй байна. Түүнчлэн, мэдээллийн технологийн салбар нь манай улсад хорь гаруй жил, тэр дундаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа ч бүрэн хөгжиж чадаагүй, гаднаас бүтээгдэхүүн үйлчилгээ импортлох нь их байна. Тухайлбал, одоогийн байдлаар албан буюу бизнес и-мэйлийн үйлчилгээг бараг 100 хувь гадаадаас импортолж байгаагаас гадна бусад орны сүлжээ, серверүүдэд вэб байршуулах нь их байна. Айтүүлс ХХК нь өнгөрсөн 5 жилийн хугацаанд Монголын вэбсайтын зах зээлийн 18 хувийг эзэлж чадсан ба цаашид энэхүү хурдаар явбал 2021 он гэхэд нийт зах зээлийн 45 хувийг эзлэх боломжтой ба үйл ажиллагааны цар хүрээ, хүчин чадлыг нэмбэл түүнээс дээш их хувийг ч эзлэх боломжтой юм. Гадны байгууллагуудын үйлчилгээнээс хараат бус, цаг хугацаа, орон зайн зөрүүгээс хамааралгүйгээр төрөлх хэлээрээ үйлчилгээ авах нь үйлчлүүлэгчдэд таатай нөхцлийг бүрдүүлэхээс гадна импортыг багасгаж, улс орны эдийн засагт эерэгээр нөлөөлөх юм.

Түүнчлэн, Монгол Улс стратегийн ач холбогдол бүхий газарзүйн байршилтай тул цаашид

СЗХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

үйлчилгээнийхээ стандартыг сайжруулан, олон улсын газарзүйн нөөц дата төвүүдийн өлгий болж, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагуудад үйлчилгээ үзүүлэх бүрэн боломжтой юм.

Тиймээс, манай улсын төдийгүй дэлхий нийтийн мэдээллийн технологийн салбарын хөгжилд тулгамдаж буй асуудлуудын нэгдүгээрт зүй ёсоор тавигдаж буй мэдээлэл хадгалах, аюулгүй байдлыг нь хангах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын стандартад нийцсэн, чанартай бөгөөд үр ашигтай үйлчилгээг дотооддоо нэвтрүүлэх нь энэхүү төслийн үндэслэл болж байна.

Үнэт цаас гаргагч нь олон улсын TIER III стандартад нийцсэн, эдийн засгийн болон үйл ажиллагааны хамгийн үр ашигтай хувилбар болох Модуляр дата төвийн паркийг газарзүйн нөөц байршилд буюу Улаанбаатар хотоос 220 км зайд байрших Дархан хотод байгуулах төслийг 2017-2021 онд хэрэгжүүлэх гэж байна. Дархан хот нь нийслэл хоттой ойрхон, цахилгаан, дулаан, зам тээвэр, мэдээллийн технологийн дэд бүтцийн хувьд орон нутгаас хамгийн сайн хөгжсөн газар тул энэхүү төслийг хэрэгжүүлэх байршлаар сонгосон болно.

Улаанбаатар хот нь газар хөдлөлтийн 7-8 баллын идэвхжил бүхий бүсэд хамаардаг бөгөөд дээд тал нь 6.8 магнитуд буюу 9 баллын хүчтэй газар хөдлөлт болох магадлалтай гэж тооцогддог. Түүнчлэн, өндөр нарийвчлалтай сансрын зураг, хээрийн ажлын судалгаагаар Улаанбаатар хотын орчмын 200 км хүрээнд шулуун ан цавууд тогтоогдсон нь болзошгүй газар хөдлөлтийн голомтууд болж болох талтайг эрдэмтэд, судлаачид тодорхойлсон байна. Улаанбаатар хотод 2005 онд 1,000 орчим газар хөдлөлт болж байсан бол 2016 онд 1,139 удаа газар хөдлөлт болж, жилээс жилд идэвхжиж байгаа нь эрдэмтдийн судалгаагаар тогтоогдсон бөгөөд хотын одоогийн мөрдөж байгаа газар хөдлөлийн бичил мужлалаар нийт талбайн 25 хувь нь 6 баллын мужид, 52 хувь нь 7 баллын мужид, 23 хувь нь 8 баллын мужид хамаарагдаж байгаа бөгөөд болзошгүй газар хөдлөлтийн улмаас хотын нийт барилга байгууламжийн 70 гаруй хувь, хүн амын 5-6 хувь нь өртөх магадлалтай гэж судлаачид үздэг. Төслийн байршлаар сонгосон Дархан-Уул аймаг нь газар хөдлөлтийн 7 баллын бүсэд хамаарагддаг бөгөөд Дархан хотоос баруун тийш 60 гаруй км зайтай Сэлэнгийн хөндий дэх 6.1-6.5 баллын хүчтэй газар хөдлөлтийн төвийг эс тооцвол ойр орчимд нь өөр хүчтэй газар хөдлөлтийн төв одоогоор илрээгүй байна.

Төсөл хэрэгжих байршил

Үнэт цаас гаргагч нь нөөц Модуляр дата төвийн парк байгуулах төслийг Монгол Улсын аж үйлдвэрийн томоохон төв, дэд бүтэц хөгжсөн, олон улсын авто зам болон төмөр замын зангилаан дээр орших Дархан-Уул аймгийн Дархан суманд буюу олон нийтийн дунд ярьж хэвшснээр Дархан хотод хэрэгжүүлнэ. Дархан хот нь байршлын хувьд дараах давуу талуудтай юм. Үүнд:

Газар хөдлөлтийн давтамж харьцангуй бага

Улаанбаатар хот нь газар хөдлөлтийн хамгийн идэвхжилтэй 7-8 баллын бүсэд хамрагддаг бөгөөд хамрах хүрээ нь 200 км хүртэл хэмжээгээр хязгаарлагддаг. Төслийн байршил нь

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУС
5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ш. 5444381

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

Улаанбаатар хотоос 220 км зайд байршдаг учраас Улаанбаатар хотын газар хөдлөлтийн бүсийн хамрах хүрээнд багтахгүй.

Зураг 2. Монгол Улсын газар нутгийн газар хөдлөлтийн мужлалт



Үерийн эрсдлийн түвшин харьцангуй бага

Үерийн эрсдлийн үнэлгээгээр манай орны хангайн болон төвийн бүсийн аймгууд болох Хөвсгөл, Булган, Архангай, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Төв, Өвөрхангай болон Ховд аймгууд үерийн эрсдэл өндөртэйд тооцогддог ба манай улсын хүн амын 40 гаруй хувь суурьшдаг Улаанбаатар хотод үерийн эрсдэл маш өндөр гарсан байдаг.

Зураг 3. Монгол Улсын газар нутгийн үерийн эрсдлийн түвшин

Хог хаягдал бага

Улаанбаатар хотоос жилд шатааж устгах 7,994 тн, дахин ашиглах 1,354 тн, бүлж устгах 998 тн, дахин боловсруулах 455 тн, нийт 10,801 тн аюултай хог хаягдал үүсч байгаа нь тус бүс

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУЛС
ХХК
УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ᠬᠣᠲᠠ 5444381

нутагт аюултай хог хаягдлаас үүдэн гамшиг, хохирол үүсэх магадлал өндөр байгааг харуулж байна. Мөн нийслэлийн хэмжээнд өнгөрсөн хугацаанд 60 удаа хорт бодис алдагдаж байсан тохиолдол гарч байжээ. Харин Дархан хотын хэмжээнд химийн бодисын хэрэглээ харьцангүй бага бөгөөд одоогоор ямар нэгэн хор хөнөөл хохирол гарч байгаагүй байна.

Цацраг идэвхит бодисын хэрэглээ бага

Монгол Улсад цацраг идэвхит бодис хэрэглэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо сүүлийн үед харьцангуй нэмэгдэж байна. Улаанбаатар хотын хэмжээнд 40 гаруй аж ахуйн нэгж, байгууллагад 1,200 үүсгүүр бүртгэлтэй байна. Эдгээрээс өндөр идэвхижилтэй, олон үүсгүүр бүхий 14 байгууллага байгаа бөгөөд нийт үүсгүүрийн идэвхжилт 17,000 Ки давсан талаар мэдээлжээ. Эдгээр байгууллага нь хамгаалалт, хадгалалт хангалтгүй, гал түймэр, газар хөдлөл, үер, гадны халдлагад өртөх, тээвэрлэлтийн явцад осол гарах магадлал өндөр байгаа бөгөөд цацрагийн осол гарвал хэд хэдэн дүүргийн нутаг дэвсгэрт олон жилийн хугацаагаар хүн амьдрах боломжгүй болох аюултай. Дархан хотын хэмжээнд мөн бодисын хэрэглээ харьцангүй бага бөгөөд одоогоор ямар нэгэн хор хөнөөл хохирол гарч байгаагүй.

Дэд бүтцийн хөгжил

Хэд хэдэн тунелийн шилэн кабел тавигдсан, цахилгаан эрчим хүчний үндсэн эх үүсвэртэй, дата төвийн үйл ажиллагаанд шаардлагатай дэд бүтэц хөгжсөн.

Зах зээлийн судалгаа

Салбарын хөгжил

Мэдээлэл, харилцаа холбооны салбар Монгол Улсад анх 1921 онд үүсгэн байгуулагдснаас хойш 94 жил болжээ. 1921 оны 7-р сарын 19-ний өдөр МОНТА буюу Монголын цахилгаан мэдээ нэртэй Үндэсний мэдээллийн ууган байгууллага байгуулагдаж байсан нь өнөөгийн МОНЦАМЭ агентлаг юм. Мөн онд Шуудан, цахилгаан мэдээний ерөнхий хороо байгуулагдсан бол Холбооны яам 1944 онд байгуулагдаж байжээ. Холбооны яамыг 1990 онд Холбооны ерөнхий газар болгон өөрчилж, 1999 онд татан буулгаж, Дэд бүтцийн яаманд эрхэлсэн асуудлыг шилжүүлсэн байна. 1994 онд Монголд анх удаа компьютер угсарч, цахим мэдээ ашигласан ба интернэтийг 1996 онд анх хэрэглэж эхэлсэн. Улмаар 2000 оноос мэдээлэл, харилцаа холбооны салбарт төрөөс чухал ач холбогдол өгч эхэлсэн нь тус онд “Мэдээлэл, холбооны технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”-ыг боловсруулж, 2002 онд Харилцаа холбооны зохицуулах хороо, Ерөнхий сайдын дэргэдэх Мэдээлэл, харилцаа холбооны технологийн зөвлөлийг тус тус байгуулан, 2003 онд Мэдээллийн технологийн Үндэсний парк, 2004 онд одоогийн Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрыг байгуулснаар илэрч байна. 2005 онд төрөөс “Цахим засаг” мастер төлөвлөгөө, “Цахим Монгол” хөтөлбөрийг баталж, бүх нийтийг компьютержүүлэх аян өрнөж, 2009 онд онлайн худалдаа үйлчилгээ, 2010 онд олон нийтийн сүлжээ, ухаалаг утасны хэрэглээ нэвтэрч эхэлжээ. 2002 нээлттэй засаг порталыг үүсгэж, 2009 онд Үндэсний дата төвийг байгуулж, 2013 онд төрийн үйлчилгээний ТҮЦ машинуудыг ашиглаж эхэлсэн нь Монгол улсын Засгийн газраас мэдээллийн технологийг ашиглах нээлттэй, нил тод, хүртээмжтэй ажиллах бодлого барьж байгаагийн илрэл юм. Түүнчлэн,

СЭХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

“Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2016-2025/”-ын баримт бичгийн төслийг 2015 онд боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, 2015 оны 12-р сарын 18-ны өдөр Монгол Улсын Их хуралд өргөн барьжээ.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд салбаруудын мастер төлөвлөгөө, хөтөлбөр төслүүдийг улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн бөгөөд 2000 оноос өнөөг хүртэлх хугацаанд хөдөө орон нутагт мэдээлэл, харилцаа холбооны шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх техник, технологийн суурь дэд бүтэц бүрдэж, шилэн кабелийн сүлжээний нийт урт 33,466 км, радио релейний сүлжээний тархалт 8,400 км-т хүрч, манай улсын бүх аймаг сумын төв, томоохон суурингууд суурин болон хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбогджээ. Түүнчлэн, Монгол Улсад интернэтийн үйлчилгээ нэвтэрсэн 20 жилийн хугацаанд 60 орчим компани интернэтийн үйлчилгээ эрхэлж, гадаад гарцын урсгалын хэмжээ 55Гбит/сек, интернэтийн байнгын хэрэглэгчдийн тоо нэг сая, интернэтийн үйлчилгээний цэг 205 болсон байна. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 2002 онд 235 мянга байсан бол өнөөгийн байдлаар 4.9 саяд хүрч, 100 хүнд ногдох үүрэн телефон хэрэглэгчийн тоо 144 болсон нь хөгжиж буй орнуудын болон дэлхийн дунджаас харьцангуй өндөр болсон. Хөдөлгөөнт холбооны 3 дахь үеийн технологийг нэвтрүүлэх ажлыг 2010 оноос эрчимтэй хэрэгжүүлж, 340 гаруй сум, суурин газрыг хамарчээ.[1]

Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарт гарсан үйл явдлын он цагийн товчоон

- 1937 - Холбооны техникум байгуулагдсан
- 1939 - 200 хэрэглэгчийн багтаамжтай станц ашиглалтанд орсон
- 1950 - Агаарын зэс шугам ашиглалтанд орсон
- 1960 - Цахилгаан холбооны үйлчилгээний төв барилга ашиглалтанд орсон
- 1967 - МУИС-д хобооны инженер бэлтгэж эхэлсэн
- 1969 - Политехникийн дээд сургууль байгуулагдаж Холбооны тэнхимтэй болсон
- 1985 - Их дээд сургуулиуд компьютер, АСУ системийн хөтөлбөр, сургалттай болсон
- 1989 - Аналоги радио релейний шугам
- 1991 - Мэдээллийн технологийн сургууль байгуулагдсан
- 1992 - Тоон технологийн станц суурилуулж эхэлсэн
- 1993 - IDD, DDD ярианы үйлчилгээ
- 1994 - Сансрын холбооны Орбит станцыг өргөтгөн, Наран болгож, олон улсын яриа дамжуулж эхэлсэн
- 1994 - Монголд анх компьютер угсарсан
- 1994 - Цахим мэдээ ашиглаж эхэлсэн
- 1995 - Монголын цахилгаан холбоо компанийн хувьчлал явагдсан
- 1995 - Үүрэн холбооны Мобиком оператор, GSM технологи
- 1996 - Интернэт ашиглаж эхэлсэн
- 1996 - Интернэтийн үйлчилгээний Датаком компани
- 1996 - Анхны хувийн дээд сургууль байгуулагдсан (Цахим)

[1] “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын төслийн танилцуулга

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

- 1998 - МХХТ-ийн нөлөөгөөр хувь хүнийг хөгжүүлэх төлөвлөгөө
- 1998 - ВиСАТ систем
- 1999 - Үүрэн холбооны Скайтел компани, CDMA технологи
- 1999 - Боловсролын салбарын Эрдэмнэт сүлжээ
- 2001 - ШУТИС-ийн Мэдээллийн технологийн сургалтын төв
- 2001 - Монголын хөгжлийн гарц төсөл
- 2002 - Нээлттэй засаг портал
- 2002 - Шилэн кабелийн сүлжээ
- 2002 - Улаанбаатар хотод утасгүй холбоо – WLL
- 2002 - Гадаадын хөрөнгө оруулалттай мэдээллийн технологийн дээд сургууль (Хүрээ)
- 2005 - Бүх нийтийг компьютержүүлэх аян
- 2005 - WIMAX (Улус нэт)
- 2006 - NGN
- 2006 - ICT EXPO
- 2007 - Олон улсын МТ-ийн боловсролын төв (АПТЕК)
- 2008 - Үүрэн холбоо бүх сумдад нэвтэрсэн
- 2009 - Онлайн худалдаа, үйлчилгээ
- 2009 - Монголын сайтын холбоо
- 2009 - 3G үйлчилгээ
- 2010 - Олон нийтийн сүлжээ, фэйсбүүк, твиттер гэх мэт
- 2010 - Ухаалаг утасны хэрэглээ
- 2011 - Мэдээлэл холбооны судалгаа хөгжлийн төв
- 2013 - Засгийн газрын 11-11 төв

Төрийн бодлого, зохицуулалт

Мэдээлэл, харилцаа холбооны бодлого нь Харилцаа холбооны тухай, Радио долгионы тухай, Шуудангийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиуд болон Монгол Улсын Их Хурлын 2000 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал”, 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгагдсан стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны бодлогын баримт бичиг, зорилтот хөтөлбөр, төслүүдийн баримт бичгээр дамжин хэрэгжиж ирсэн. Сүүлийн жилүүдэд төрөөс мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх тал дээр онцгой анхаарч, үндэсний хэмжээнд олон бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж байна. Эдгээрийг цаг хугацааны дараалаар дор дурдав. Үүнд:

- 1994 он Цахилгаан холбоог 2010 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө
- 1995 он Харилцаа, холбооны тухай хууль
- 1999 он Радио долгионы тухай хууль
- 2000 он Мэдээлэл, холбооны технологийг /МХТ/ 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУЛС ХХК
УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
ТТС3981 ᠬᠣᠲᠠ 5444381

СЭХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

- 2001 он Харилцаа холбооны тухай хуулийн шинэчилсэн найруулга
- 2002 он МХТ-ийг дунд хугацаанд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө
- 2002 он Шуудангийн салбарын мастер төлөвлөгөө
- 2003 он Шуудангийн тухай хууль
- 2005 он “Цахим засаг” мастер төлөвлөгөө
- 2005 он “Цахим Монгол” хөтөлбөр
- 2007 он Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө
- 2008 он Бүртгэл, мэдээллийн тогтолцоог бий болгох хөтөлбөр
- 2008 он Аутсорсинг хөгжүүлэх мастер төлөвлөгөө
- 2010 он Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого
- 2010 он Мэдээллийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөр
- 2010 он Радио телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх хөтөлбөр
- 2010 он “Өрх бүрт шуудан” хөтөлбөр
- 2011 он “Өргөн зурвасын өндөр хурдны сүлжээ” хөтөлбөр
- 2011 он Цахим гарын үсгийн тухай хууль
- 2011 он Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- 2012 он “Үндэсний хиймэл дагуул” хөтөлбөр
- 2012 он “Цахим засаг” хөтөлбөр
- 2014 он Шилэн дансны тухай хууль
- 2015 он Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах зохицуулалтын чиглэл
- 2016 он Суурин өргөн зурвасын интернэтийн үйлчилгээний талаар баримтлах бодлогын чиглэл

Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлд “...биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологи, нано технологи”-ийг тодорхойлсон ба Монгол Улсын Засгийн газраас боловсрол, эрүүл мэнд, төрийн алба, бизнесийн салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх, тэдгээрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхээр ажиллаж байна. Мөн мэдээлэл, харилцаа холбоог хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй дээр дурдсан үндэсний хэмжээний 8 хөтөлбөр нь одоогоор 71 хувийн гүйцэтгэлтэй байна гэж Засгийн газраас дүгнэжээ. Цаашид дээрх хөтөлбөр арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн олон улсын чиг хандлага, нийгэм, эдийн засгийн эрэлт хэрэгцээ, технологийн өөрчлөлт шинэчлэлттэй уялдуулан, дэлхий даяар түргэн хурдацтай хөгжиж байгаа тус салбарт төрөөс баримтлах бодлогыг шинэ шатанд тодорхойлж, улс орны хэмжээнд нэгдсэн бодлого боловсруулж, мөрдөж ажиллах гэж байна. Саяхан Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баталсан ба энэхүү 2016 оноос таван жилээр 3 үе шаттай хэрэгжих бодлогын баримт бичгигт эдийн засгийн бодлогын, нийгмийн тогтвортой хөгжлийн, байгаль орчны тогтвортой хөгжлийн, тогтвортой хөгжлийн засаглалын гэсэн 4 үндсэн бүлэг, 43 зорилт, 20 үндсэн үзүүлэлтийг

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
2017
1116218269 ⚲ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ⚲ 5444381

тодорхойлж Монгол Улс 2030 онд хөгжлийн ямар түвшинд хүрэхийг төсөөлсөн байна. Энэхүү үзэл баримтлалд мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр дэд бүтцийг хөгжүүлж ашиглалт, хүртээмжийг сайжруулах, тоон хуваагдлыг арилгаж, өргөн зурвасыг бүх нийтэд хүртээмжтэй болгох, тогтвортой хөгжлийг хангах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан мэдээлэл, харилцаа холбооны зорилтуудыг дурьдвал:

I үе шат (2016-2020): Нийт хүн амын 70 хувийг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамаарсан ижил үнэ, тарифыг мөрдөж, Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалын хэмжээг арав дахин нэмэгдүүлэх.

II үе шат (2021-2025): Нийт хүн амын 90 хувийг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбож, хөдөө, орон нутгийн хүн амын 70 хувь нь өргөн зурвасын интернэтийн үйлчилгээ ашиглах, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 50-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлэх.

III үе шат (2026-2030): Нийт хүн амын 95 хувийг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбож, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 85-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөн ашиглах.

Ийнхүү, тус үзэл баримтлалд нийцүүлэн, шинээр “Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах зохицуулалтын чиглэл”, “Суурин өргөн зурвасын интернэтийн үйлчилгээний талаар баримтлах бодлогын чиглэл” тус тус баталж, 2016 оноос хэрэгжүүлж эхлээд байна.

Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2015 оны 10 дугаар тушаалаар “Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015 оны 68 дугаар тогтоолоор “Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах зохицуулалтын чиглэл” тус тус батлагдснаар дараа үеийн хөдөлгөөнт үүрэн холбооны систем, технологи нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэж, үүрэн холбооны операторууд 2016 оны 4-р сараас эхлэн 4G LTE технологийг Улаанбаатар хотод нэвтрүүлж эхлээд байна. Дараа үеийн 4G LTE технологийн давуу тал нь хязгаарлагдмал нөөцтэй давтамжийн хэрэглээ үр ашигтай болж, хэрэглэгчид гар утсаараа одоогийн хэрэглээний түвшнээс илүү өргөн зурвасыг (их хэмжээний өгөгдлийг богино хугацаанд татах, дамжуулах г.м) ашиглах боломжтой юм.

Суурин өргөн зурвасын интернэтийн үйлчилгээний талаар бодлогын баримтлах чиглэл

"Монгол Улсад интернэтийн үйлчилгээг ижил үнэ, тарифаар хүргэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2016 оны 123 дугаар тогтоолын хүрээнд Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас “Суурин өргөн зурвасын интернэтийн үйлчилгээний талаар баримтлах бодлогын чиглэл”-ийг баталж, 2016 оны 3-р сараас хэрэгжүүлж эхлээд байна. Бодлогын баримтлах чиглэлд “мэдээлэл татах хурд 1Мб/сек-ээс багагүй, мэдээлэл илгээх хурд 300 Кб/сек-ээс багагүй байх хөдөлгөөнт бус интернэт

холболтыг суурин өргөн зурвасын интернэт гэнэ” хэмээн тодорхойлж, үйлчилгээний ялгааг тогтоож өгсөн ба Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК нь орон нутгийн өгөгдлийн сүлжээнд өргөтгөл хийж, 16 аймгийн төвийг 1Гб/сек багтаамжтай сүлжээнд холбожээ.

Хот хоорондын үндсэн сүлжээ, дамжуулах байгууламжийн өндөр өртөгтэй холбоотой хөдөө, орон нутгийн интернэтийн үйлчилгээнд нийслэлээс хоёр дахин их үнэ тариф мөрддөг нь (1Мб/сек урсгал 160 мянган төгрөг) эцсийн хэрэглэгчдэд хүрэх үйлчилгээний үнэ тариф өндөр байх үндсэн шалтгаан байсныг арилгах үүднээс хот, хөдөөд интернэтийн үйлчилгээний ижил үнэ, тарифыг мөрдүүлж эхэллээ. Үндсэн сүлжээгээр дамжуулах интернэтийн үнэ, тариф буурснаар орон нутагт интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагын зах зээл илүү нээлттэй болж, хэрэглэгчдийн тоо нь 2016 онд 30%-иар өсч, үйлчилгээний чанар, хурд 3 дахин нэмэгдэнэ гэж урьдчилан тооцолсон байна.

Интернэтийн үйлчилгээний үнэ тарифын мэдээлэл

Хурд	Хуучин тариф, төгрөгөөр	Шинэ тариф, төгрөгөөр
Интернэтийн бөөний үйлчилгээний үнэ тариф		
1Mbps	160,000	80,000
2Mbps	320,000	160,000
Суурин интернэтийн эцсийн хэрэглэгчид хүрэх үнэ, тариф		
1Mbps	55,000	13,000 (өрх)
1Mbps	75,000	13,000 (байгууллага)

Эх үүсвэр: Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар

Дээрх бодлогын баримт бичгүүдээс гадна Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас 2015 онд “*Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2016-2025/*”-ын баримт бичгийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснийг Засгийн газар дэмжиж, Монгол Улсын Их хуралд өргөн барьсан ба 2016 оны I улиралд Улсын Их хурлаар хэлэлцүүлж, II улирлаас эхлэн хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байсан ч түр хойшлуулж, 2016 онд шинээр батлагдсан “Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, түүнийг дагаж гарах журамд нийцүүлэн баримт бичгийг дахин боловсруулж, Засгийн газар, Сангийн яаманд танилцуулахаар ажлын хэсэг ажиллаж байна[2].

Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого нь мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг бүх нийтийн хэрэглээ болгох, мэдлэгт суурилсан нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд мэдээлэл, харилцаа холбооны дэвшлийг өргөн хүрээтэй нэвтрүүлсний үндсэн дээр Монгол Улсын хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг тодорхойлж, салбарыг нэгдсэн бодлогоор хангах юм. Тус бодлогод “Мэдээлэл, харилцаа холбооны хөгжил, дэвшил нь Монгол Улсын хөгжлийн хурдасгуур байна” гэж заасан ба дараах 8 стратегийн зорилгыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох замаар салбарын хөгжлийн таатай орчныг бүрдүүлнэ.

[2] Цагаан ном 2016, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар /МТШХХГ/

2. Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангах мэдээлэл, харилцаа холбооны үндэсний суурь сүлжээ, дэд бүтцийг төрийн дэмжлэг, хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулна.
3. Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээний төрөл, хүртээмж ба чанарыг нэмэгдүүлнэ.
4. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн судалгаа-хөгжлийн (ICT R&D) төв, шинжлэх ухаан технологийн парк, кластер байгуулах ажлыг эрчимжүүлэх, хууль эрхзүй, бизнесийн болон хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхижуулах замаар Монгол Улсад инноваци, судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бий болгоно.
5. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үндэсний тоон контент, программ хангамжийн үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэрлэлийн үйл явц, удирдлага, хяналтад мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх замаар олон улсын зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлнэ.
6. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалтын үр ашгийн тогтвортой өсөлтийг хадгалан хөгжүүлнэ.
7. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, байгууллагын мэдээллийн бүрэн бүтэн байдал, үнэн зөв, хамгаалагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах замаар мэдээллийн аюулгүй байдлыг хангана.
8. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхижүүлэх, төрийн үйл ажиллагааны инновацийг дэмжиж, цахим засгийн хөгжлийг боловсронгуй болгох замаар Ухаалаг засгийг хөгжүүлнэ.

Энэхүү бодлогыг хэрэгжүүлснээр гарах үр дүнг 2015 оны түвшин, үзүүлэлтүүдтэй харьцуулан хэмжихүйцээр тодорхойлж өгсөн ба бодлогын үр нөлөөнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн уялдаа холбоо, тус салбарын хурдацтай хөгжил, дэлхийн чиг хандлага, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын идэвхжил, цахим болон интернэт орчны хууль эрхзүйн орчин улам боловсронгуй болж, иргэдийн амьдрал, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд эерэг өөрчлөлт гарахаар байна.

Түүнчлэн, 2015 онд Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл, Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл, Цахим засгийн тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан нь төрөөс мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэхэд чухал ач холбогдол өгч байгааг харуулж байна. Эдгээр хууль батлагдах нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх юм.

Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийн төсөл

Мэдээллийн технологийн хөгжил асар хурдацтай хөгжиж буй өнөө үед мэдээллийн аюулгүй байдал нь дэлхий нийтийн анхаарлын төвд буй асуудлуудын нэг болсон тул мэдээлэл, харилцаа холбооны салбарын бодлого боловсруулагчид 2002 оноос мэдээллийн аюулгүй байдал, эрх зүйн орчны судалгаа хийж, хуулийн төсөл, мэдээллийн аюулгүй байдлын

СЗХ
он . сар . . . өдөр
2017 . 09 . 27
БҮРТГЭВ
№ 01

зөвлөмжийг боловсруулан ажилласны үр дүнд Кибер аюулгүй байдлын газраас "Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль"-ийн төслийг шинэчлэн боловсруулж, 2016 оны 2-р сард Улсын Их Хуралд өргөн барьжээ. Энэхүү хууль батлагдснаар улс орны хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлын асуудлаар нэгдсэн удирдлага, хяналтын тогтолцоог бий болгож, мэдээлэл эзэмшиж буй төр, хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоо, тэдний эрх, үүрэг тодорхой болж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, байгууллага, ард иргэдэд учирч болзошгүй сэтгэл зүйн болоод эдийн засгийн хохирол буурах эрх зүйн таатай орчин бүрдэнэ.

Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төсөл

Манай улсад цахим бизнес, онлайн үйлчилгээний хэрэглээ улам бүр өсөн нэмэгдэж, цахим орчинд өгөгдөл төвлөрсөөр байгаа ба өгөгдөл цуглуулах, боловсруулах, дамжуулах, баталгаажуулах, хадгалах ажиллагаа өргөжихийн хирээр өгөгдлийн нууцлал алдагдах, өгөгдлийн давхардал, зөрүүтэй байдал үүсэх, улмаар төрийн байгууллага, хувь хүний халдашгүй байдал зөрчигдөх хандлага байна. Цахим орчин дахь хувь хүн, байгууллага, төрийн өгөгдөл мэдээллийг хамгаалах тусгайлсан зохицуулалт одоогоор байхгүй ба МТШХХГ-аас энэ асуудалд анхаарч "Өгөгдөл хамгаалах тухай" хуулийн төслийг боловсруулжээ. Хуулийн төсөлд өгөгдөл тойрсон дотоодын харилцааны асуудлаас гадна дэлхий дахины технологийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан үүлэн тооцоолол (Cloud computing), их өгөгдөл (Big data)-ийг ашиглах харилцаа, зохицуулалтын талаар ч судлан тусгахаар ажиллаж буй юм байна.

Цахим засгийн тухай хуулийн төсөл

Төрийн үйл ажиллагаа цахимжих хөгжлийн явцад төрийн байгууллагууд тус тусдаа мэдээллийн сүлжээ, сан байгуулж түүнийгээ өөрсдөө сайн ашиглаж байна. Хөгжлийн дараагийн шатанд төрийн байгууллагууд, салбар хоорондын мэдээллийн солилцоо хялбар болж, мэдээлэл давхардалгүй нэг эх үүсвэр ашиглах, төрийн онлайн үйлчилгээ ашиглах, мэдээллийн удирдлагын нэгдсэн тогтолцоотой болох, түүний тулд эрх зүйн орчноо бүрдүүлэх нь чухал байгаа тул МТШХХГ-аас энэ талаар олон улсын туршлага, чиг хандлагын судалж, "Цахим засгийн тухай хууль"-ийн төсөл боловсруулж, 2017 онд Засгийн газар, УИХ-д өргөн барихаар ажиллаж байна.

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарт мөрдөгдөж буй стандартууд

Одоогийн байдлаар Монголын мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарт 238 стандарт[3] мөрдөгдөж байгаагийн тал хувь нь заавал мөрдөгдөх, бусад нь сонгон хэрэглэх эрх зүйн төлөвтэй байгаа ба эдгээрийг төрөл, салбараар нь ангилахад 35 хувь нь мэдээллийн технологийн, 27 хувь нь радио телевизийн, 18 хувь нь шуудангийн, 14 хувь нь цахилгаан холбооны, үлдсэн 7 хувь нь бусад чиглэлийн стандарт байна. 2015 онд мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн чиглэлээр 14 шинэ стандарт баталж, 3 стандартыг шинэчлэсэн байна.

График 3. Мэдээллийн технологи, харилцаа холбооны стандартын төрөл, дэд салбараар



[3] http://www.crc.g

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУЛС
ХОТ
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

Сүүлийн жилүүдэд манай улсад мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбар хурдацтай хөгжиж, мэдээлэл, цахилгаан холбоо, интернетийн үйлчилгээ үзүүлэгч, төр хувийн хэвшлийн байгууллага, компаниуд дата төв байгуулан хөгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор 2015 оны 9-р сарын 24-ний өдөр Стандартчиллын үндэсний зөвлөлөөс “Дата төвийн цахилгаан холбооны дэд бүтэц” үндэсний стандартыг баталсан байна. Уг стандарт нь дата төвийг Монгол Улсад байгуулах, ашиглах, дэд бүтцэд тавигдах үндсэн шаардлагыг тогтоох, оновчтой зохион байгуулах үндсэн зорилготой ба Монгол Улсын Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасны дагуу сонгон хэрэглэх эрх зүйн төлөвтэйгээр батлагдсан байна. Энэхүү стандартыг дата төвийн тоног төхөөрөмжийн төлөвлөлт, кабельжуулалт, холболтын систем болон сүлжээний төлөвлөлт зэрэг дата төвийг байгуулах загварын талаар системтэй ойлголтыг олон улсын хэмжээнд стандартчилсан АНУ-ын ANSI/TIA 942 “Telecommunications Infrastructure Standard for Data Centers” дата төвийн стандартыг баримтлан боловсруулжээ. Мэргэжилтнүүдийн үзсэнээр “Дата төвийн цахилгаан холбооны дэд бүтэц” үндэсний стандарт нь нэг эзэмшигчтэй энгийн, байгууллагын дата төвөөс эхлээд олон эзэмшигчтэй томоохон интернэт хостинг хүртэлх дата төв, тэдгээрийн компьютер, тоног төхөөрөмжийн өрөөний цахилгаан холбооны дэд бүтцэд тавигдах хамгийн анхан шатны шаардлагыг тодорхойлж жишиг болгосон, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай дата төвийг байгуулахад чухал ач холбогдолтой, шалгуур болгон ашиглах стандарт болсон байна. Түүнчлэн, 2015 онд батлагдсан мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн салбарын стандартууд дунд “Дата төвийн цахилгаан холбооны дэд бүтэц”, “Харилцаа холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмжид тавих аюулгүй байдлын шаардлага” гэсэн хоёр сонгон хэрэглэх стандарт нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд илүү хамаарч байна.

Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд

Мэдээлэл, харилцаа холбооны салбарт төрөөс баримталж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжүүлэх, шинэ дэвшилтэт техник, технологийг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт нэвтрүүлэх, эрх зүй, эдийн засгийн оновчтой зохицуулалтаар хангаж, иргэдэд төрийн болон мэдээлэл харилцаа холбооны төрөл бүрийн хэрэглээ, үйлчилгээг чанарын өндөр түвшинд хүргэх, тэдгээрийн хүртээмжийг сайжруулах, шударга өрсөлдөөний нөхцлийг бүрдүүлэх үүргийг 1995 онд байгуулагдсан *Харилцаа холбооны зохицуулах хороо* хэрэгжүүлж ажилладаг. Харилцаа холбооны зохицуулах хороо нь цахим орчны мэдээллийн аюулгүй байдлыг хангах, өргөн зурвасын үйлчилгээ, хэрэглээг нэмэгдүүлж, мэдээллийг хүртэх тоон хуваагдлыг багасгах, өргөн нэвтрүүлэг, контентийг хөгжүүлэх, хэрэглэгчийн мэдээллийн технологийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг хийдэг.

2000 оноос дэлхийн улс орнуудын жишгийг даган, Монгол Улсын Их хурал, Засгийн газар мэдээлэл, харилцаа холбоог төрийн бодлогын тэргүүлэх чиглэл гэж хүлээн зөвшөөрч, мэдээлэл, харилцаа холбооны салбарын тогтолцоог шинэчилсэн. Үүний хүрээнд 2004 оны 10-р сард Засгийн газрын тохируулагч агентлаг болох Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар (МХХТГ) байгуулагдан, төрөөс мэдээлэл, харилцаа холбоо, технологийн талаар баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болсон юм. 2008 онд байгууллагын

нэр Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газар (МШХХТГ) гэж, 2012 онд Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар (МТШХХГ) болж, 2016 онд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (ХХМТГ) болж өөрчлөгдсөн байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудангийн үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, Монгол Улсын XXI зууны хөгжлийн үндсэн хурдасгуур болгож, мэдлэг оюунд тулгуурласан мэдээлэлжсэн нийгмийг хөгжүүлэхэд орших ба долоон үндсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

Нэг. “Үндэсний хиймэл дагуул” хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Монгол Улс 2016 он гэхэд үндэсний хоёр төрлийн хиймэл дагуултай болох зорилго тавьсан ба тэдгээр нь тандан судалгааны болон харилцаа холбооны гэсэн үүрэг зориулалттай хоёр өөр орбитод байрлана. Холбооны хиймэл дагуул нь дэлхийгээс 36,000 км алслагдсан тойрог замд байрлах бөгөөд бидний өдөр тутам ашигладаг харилцаа холбоо, интернэт, телевиз, гар утасны үйлчилгээнд ашиглагдах юм. Судалгааны хиймэл дагуул нь харьцангуй нам орбитод байрлан, судалгаа шинжилгээнд ашиглагдах олон төрлийн дүрст мэдээллүүдээр биднийг хангах юм. Үндэсний хиймэл дагуултай болсноор улс орны мэдээлэл, харилцаа холбооны технологийн чадавхи сайжирч, хөгжлийн дараагийн шатанд гарахад чухал хөшүүрэг болох юм.

Үндэсний хиймэл дагуул хөөргөх хөтөлбөрийг Засгийн газрын 2012 оны 11-р сарын 24-ний өдрийн 137-р тогтоолоор баталсан ба хөтөлбөр 2013-2016 онд зургаан шатлалтайгаар хэрэгжиж, хиймэл дагуулыг 2016 онд хөөргөхөөр төлөвлөсөн байна. Монгол Улс өөрийн хиймэл дагуултай болох нь өөр орны хиймэл дагуул ашиглахгүй байхаас авахуулаад үндэсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтойгоос гадна газарзүйн байрлалаас үл хамааран иргэд, ялангуяа малчид, аж ахуйн нэгж, байгууллагууд нийт улс орон даяар утасгүй холбооны үйлчилгээг хямд үнээр авах боломж нээгдэх үр нөлөөтэй юм. Түүнчлэн, өөрийн хиймэл дагуултай холбогдсноор үндэсний өргөн дамжуулалтын хөтөлбөр хэрэгжих ба нийт айл өрх 50 хувийн хямд үнээр өргөн зурвасын өндөр хурдны интернэт, телевизийн дамжуулалттыг хүлээн авах боломжтой болно.

Хоёр. Төрийн түгжрэлгүй үйлчилгээг хүргэх

Энэхүү зорилтын хүрээнд вэб болон мобайл аппликэйшн технологи дээр суурилсан нэгдсэн үйлчилгээний портал системийг хөгжүүлэх /нэг цонхны үйлчилгээ, 300 төрийн үйлчилгээ/, Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж хэвшүүлэх, “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ боломжит цахим үйлчилгээг нэвтрүүлэх болон төрийн байгууллагуудын мэдээллийг нэгдсэн дата сантай холбох системийг хөгжүүлнэ.

“Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй, чирэгдэлгүй болгож, цаг хугацаа, орон зай, нөөцийг /мөнгө/ хэмнэх зорилгоор 2012 оны 4-р сарын 4-ний өдөр Засгийн газраас 101 тоот тогтоолоор баталж, 2012-2016 онд хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар иргэний цахим үйлчилгээг анх удаа хэрэглээнд нэвтрүүлж, ТҮЦ машиныг ашиглан, 13 төрлийн

СЭХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Мөн ezasag.mn-ээр тэрийн 25 төрлийн үйлчилгээг үзүүлэхээс зэрэг 6 үйлчилгээ нь нэвтэрч, иргэдэд цахимаар газар өмчлүүлэх ажлыг эхлүүлж, цахим татварын тайлан, камерын торгуулийн систем, замын цагдаагийн бэлэн бус торгуулийн системийг нэвтрүүлсэн.

Үндэсний дата төвийн даргын мэдээлснээр төрөөс иргэдэд үзүүлж буй 360 төрлийн үйлчилгээ байдгаас 160-ыг цахимаар үзүүлэх боломжтой. ТҮЦ машин нь одоогоор 500,000 гаран үйлчилгээг үзүүлж, төсвөөс 4 тэрбум төгрөг хэмнэснээс гадна иргэдийн цаг хугацааг асар ихээр хэмнэж чадсан. Ийнхүү "Цахим засаг" үндэсний хөтөлбөр нь иргэдэд хүрч эхэлснээр иргэдийн цахим үйлчилгээ авах дадал бий болж, манай цахим хэрэглэгчийн чадамж дээшилж, цахим хэрэглээ улам бүр ихсэх хүлээлттэй байна.

Гурав. Хямд үнэтэй өндөр хурдны интернэт нэвтрүүлэх

Энэ зорилтын хүрээнд дараах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Сумдад өндөр хурдны, өргөн зурвасыг түгээх сүлжээ байгуулах төсөл
- Гэр хорооллыг интернэтжүүлэх төсөл
- Хөдөө орон нутагт интернэтийн үнийг бууруулах тухай
- "Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ" үндэсний хөтөлбөр

Дөрөв. Тоон өргөн нэвтрүүлгийг нэвтрүүлэх

Олон улсын цахилгаан холбооны байгууллагын 2006 онд зохион байгуулсан Радиогийн их хурлаар 2015 он хүртэлх хугацаанд дэлхий даяараа радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээ, үйлчилгээг тоон технологид шилжүүлэх шийдвэр (GE-06) гаргасан ба Европын бүх орон 2015 онд, Ази, Номхон далайн бүсийн орнуудаас ихэнх нь 2013 онд аналоги өргөн нэвтрүүлгийн сүлжээг бүрэн зогсоохоо албан ёсоор зарлажээ. Өнөөгийн байдлаар дэлхийн олон орон аналоги системтэй радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг бүрэн зогсоож, тоон радио, телевизийн өргөн нэвтрүүлэгт шилжсэн бөгөөд Монгол Улс радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системд бүрэн шилжүүлэх зорилгоо амжилттай хэрэгжүүлж, шилжилтийг 2015 онд бүрэн дуусгасан.

Тав. Оюуны бүтээмжтэй, өндөр цалинтай ажлын байр

Энэ зорилтыг салбарын мэргэжилтнүүд, дотоодын компаниудын чадавхийг бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлж байна. Үүнд дараах ажлууд хийгдэж байна.

- Мэдээлэл технологийн хүний нөөцийн /Model Team/ албан тушаалыг шинэ ангилалтай болгох /Database Architector, Reverse Engineering, Project Manager, Coder/
- Мэдээллийн технологийн хүний нөөцийн /Model Team/ мэргэжлийн сертификаттай уялдуудан цалингийн системийг хэрэгжүүлэх /Oracle Certified Master, CCNP, PMP, ArcGISDP/

Зургаа. Олон улсын э-бүтээгдэхүүнийг хөгжүүлэх

Энэ зорилтын хүрээнд Монгол хүний оюун ухаанаар бүтсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргахад төрөөс дэмжлэг үзүүлж, "Мэдээллийн технологи, харилцаа холбооны судалгаа хөгжлийн төв" -ийг байгуулна. Мөн, үндэсний программ хангамжийн олон улсад өрсөлдөх

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
2017
1116218269 ☎ 5468361

АЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

чадварыг дээшлүүлж, Монгол контентийн үйлдвэрлэлийн бизнесийг бодлогоор дэмжиж, эрх зүйн орчныг бий болгоно. Олон улсын стандартын дагуу программ хангамж, системийг олон үе шаттайгаар туршин хүлээн авч баталгаажуулдаг лаборатори байгуулах юм.

Долоо. Шууданд суурилсан дэвшлийг бий болгох

Энэхүү зорилтын хүрээнд дараах ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хүргэлтийн үйлчилгээг олон улсын түвшинд хүргэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих
- Хаягжилтын шинэчлэлийг бүрэн төгс хэрэгжүүлж дуусгах
- Төрийн захиргааны баримт бичгүүдийг шууданжуулах /Шүүхийн зарлан, торгуулийн хуудас г.м/
- Шуудан, илгээмжийн үйлчилгээг автоматжуулж, цахим марк, богино үсэгт мэдээ /SMS/ үйлчилгээг шууданд нэвтрүүлэх

Банк, санхүүгийн салбарын мэдээллийн технологийн аюулгүй байдал

Банк, санхүүгийн байгууллага болон бизнесийн байгууллагууд нь хэрэглэгчийнхээ эрх ашгийг хамгаалах мөн үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулах зорилгоор мэдээллийн сангийн аюулгүй ажиллагаанд ихээхэн анхаарал хандуулж байна. Нөгөөтэйгүүр, салбарын зохицуулах байгууллагуудын зүгээс банк болон бусад мэргэжлийн оролцогчдыг мэдээллийн технологийн аюулгүй байдалд илүүтэй анхаарч, олон улсын стандартыг мөрдөж ажиллахыг шаардаж эхэлсэн нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөхөөр байна. Тухайлбал, Монголбанкнаас “Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам”-ыг (https://www.mongolbank.mn/documents/regulation/paymentsystem/2016/itpaymentsystem.pdf) 2016 онд батлан мөрдөж эхэлсэн ч банкны мэдээллийн технологийн эрсдлийг удирдах, аюулгүй байдлыг хангахад олон улсын стандартыг нэвтрүүлэх, шаардлагад нийцүүлэх зорилгоор “Банкны мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн журам”-ын төслийг (https://www.mongolbank.mn/documents/regulation/control_check/20170501_bankforIT.pdf), боловсруулан хэлэлцүүлж буй бөгөөд ойрын хугацаанд батлуулахаар ажиллаж байна. Энэхүү журмын төсөлд “Үндсэн төв” гэж үндсэн бүртгэлийн систем болон дэд систем тэдгээрийн сервер, тоног төхөөрөмж байршиж буй төвийг, “Нөөц төв” гэж үндсэн төвд онцгой нөхцөл үүссэн үед хэвийн үйл ажиллагааг хангах зорилго бүхий үндсэн бүртгэлийн систем болон дэд системийн нөөц, тэдгээрийн сервер, тоног төхөөрөмж байршиж буй төвийг, “Онцгой нөхцөл” гэж мэдээллийн систем болон сервер тоног төхөөрөмжийн алдаа, хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, гал түймэр, газар хөдлөлт, хүчтэй салхи, үер, аянга зэрэг гэнэтийн осол, байгалийн гамшиг болон бусад шалтгаанаар мэдээллийн систем хэвийн үйл ажиллагаагаа алдахыг хэлнэ гэж тайлбарлажээ. Улмаар журмын төслийн 3.2-т “**Нөөц төв нь үндсэн төв байрлаж буй байршлаас хамгийн багадаа 200 км зайтай үндсэн төвд нөлөөлөх боломжтой онцгой нөхцөлд өртөхөөргүй газар зүйн алслагдмал байршилд байна**” гэж заасан ба үндсэн болон нөөц төвүүд нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлахаар тусгасан байна.

Зах зээлийн бусад мэдээлэл

Монгол Улсын мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын эдийн засгийн үзүүлэлтүүд жилээс жилд өсч байна. Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) хэмжээ сүүлийн 4 жил тасралтгүй өссөн ба ДНБ-д мэдээлэл, харилцаа холбооны салбарын эзлэх хувь мөн адил жил бүр нэмэгдсэнийг графикаар харууллаа.

График 4. Монгол Улсын болон нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ

Эх сурвалж: ҮСХ

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2011 оноос эхлэн эрс өсч эхэлсэн бөгөөд 2015 оны байдлаар 23.2 их наяд төгрөгт хүрсэн. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ мөн өссөн ба 2015 онд 7.6 сая төгрөгт хүрсэн байна. Түүнчлэн, Дэлхийн банкны 2015 оны 7-р сарын 1-ний өдрийн тайланд дурдсанаар манай улсын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,280 ам.долларт хүрч, Монгол улс "Дундаас дээгүүр орлоготой" (upper middle income) гэсэн ангилалд багтсан байна.

Статистикийн мэдээг шинжилбэл мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын (МТХХ) нийт бүтээгдэхүүний хэмжээ 2007 онд 166 тэрбум төгрөг байсан бол салбарт тогтвортой өсөлт явагдсаар 2014 оны эцэс гэхэд 2.8 дахин өсч, 472 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь өндөр өсөлттэй байсан дотоодын нийт бүтээгдэхүүний 2.2-3.3 хувийг эзэлж байна.

График 5. Харилцаа холбооны салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ ба ДНБ-д эзлэх хувь

Эх сурвалж: ҮСХ

МТХХ-ны салбарын нийт орлого сүүлийн 5 жилийн хугацаанд жил бүр тасралтгүй өссөөр 2015 онд 933.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 9.8 хувиар өсчээ. Салбарын орлогыг 2016 оны эхний хагас жилийн байдлаар авч үзвэл нийт орлогын 45.8 хувийг үүрэн холбооны үйлчилгээ, 7.24 хувийг интернэтийн үйлчилгээ, 16.17 хувийг телевизийн үйлчилгээ эзэлж байна. Интернэтийн үйлчилгээний өмнөх жилийн үзүүлэлтийг харвал 2013 онд 8 хувь, 2014 онд 8.83 хувь байсан байна.

График 6. Салбарын нийт орлого, тэрбум төгрөг

Хүснэгт 34. Салбарын орлого, үйлчилгээний төрөл, эзлэх хувь, 2016.06.30

Үйлчилгээний төрөл	%
Үүрэн утасны холбоо	45.81%
Интернэт	**7.24%**
IPTV	7.94%
Интернэт бөөний үйлчилгээ	**7.61%**
Мэдээлэл холбооны сүлжээ	4.2%
Эфирийн телевиз	16.17%
Кабель шугам, угсралт	3.35%
Суурин телефон холбоо	2.11%
Сансрын холбоо	1.52%
Шуудан	1.44%
бусад	2.25%

Эх сурвалж: ХХЗХ

Хөрөнгө оруулалт

Мэдээлэл харилцаа холбооны салбарын нийт хөрөнгө оруулалт 2013 оныг хүртэл 10 хувь орчмын тогтмол өсөлттэй байсан бол 2014 онд 2 дахин өссөн байна. Монгол услын эдийн засгийн бууралт зэргээс үүдэн 2015 оны эцсийн дүнгээр өмнөх оноос 14.5 хувиар буурч 204.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.



Эх сурвалж: ХХМТГ

Шилэн кабелийн сүлжээ

МТШХХГ-ын зүгээс хэрэгжүүлж буй зорилтот хөтөлбөрүүдийн хүрээнд 2000 оноос хойш өнөөдрийг хүртэл Улаанбаатар хот болон аймгийн төвүүд, сум, суурин газрыг холбосон нийт 36,381 км урт шилэн кабельтай болжээ. Үүнд:

Хүснэгт 35. Шилэн кабелийн сүлжээг байгуулсан байгууллагууд

Байгууллага	Шилэн кабелийн урт
Жемнэт	2,265 км
Рэйлком төв	1,406 км
Скайнетворкс	7,493 км
Мобиком нетворкс	7,757 км
Мэдээлэл холбооны сүлжээ	17,462 км
Нийт	**36,381 км**

Эх сурвалж: ХХЗХ

Эдгээр байгууллагууд нь Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос мэдээлэл харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшдэг ба тэдгээрийн талаарх товч мэдээллийг дор танилцуулав.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК: Өнөөгийн байдлаар тус компани нь Монгол Улсын өндөр хурдны шилэн кабелийн сүлжээний 70 орчим хувь буюу 21 аймаг, 227 сумыг хамарсан 17,462 км шилэн кабелийн сүлжээг эзэмшдэг. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Мэдээлэл холбооны үндсэн сүлжээний өргөтгөл шинэчлэл” төслийн хүрээнд 140 сумдыг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбох ажлыг хийж байна.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл болох тоон суваг түрээс, өгөгдлийн суваг, ярианы суваг, шөрмөсийн түрээс, улс хоорондын сүлжээний үйлчилгээ, байр талбай, цамхагийн түрээс, худаг, сувагчлал, физик сүлжээ ашиглалтын түрээс, техник, менежментийн үйлчилгээнүүдийг тус тус үзүүлдэг.

Мобиком нэтворкс ХХК: Мобиком нэтворкс ХХК нь сүлжээний үйлчилгээг дагнан эрхлэх зорилгоор 2014 онд Мобиком корпораци ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани болон байгуулагдсан. Монгол Улсын урд хилээс хойд хил хүртэл хил дамнасан нийт 7,457 км шилэн кабелийн сүлжээг байгуулан, түүний ашиглалт, үйлчилгээг хариуцан

ажилладаг. Тус компани нь Гонконг болон АНУ-ын портод холбогдсон ба дамжуулах төхөөрөмжийн нягтруулгын төрөл нь DWDM (OTN), SDH системийг ашигладаг.

Скайнэтворкс ХХК: Скайнэтворкс ХХК нь Монгол Улсын нутаг дэвсгэрт мэдээлэл холбооны хот хоорондын сүлжээ байгуулах, түүнийг ашиглах 245/А-2/ICN05 тоот тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Улаанбаатар хотын хэмжээнд өндөр хурдны шилэн кабелийн сүлжээг анх байгуулан, мэдээлэл, харилцаа холбооны салбарын дэд бүтцийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсаар ирсэн бөгөөд энэ хугацаанд сүлжээ нь хотын ихэнх цэгт хүрч, шилэн кабелийн урт нийтдээ 7,493 км хүрээд байна.

Жемнэт ХХК: Тус компани нь 2008 онд олон улсын болон орон нутгийн мэдээлэл, холбооны сүлжээний чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготойгоор байгуулагдсан. Одоогийн байдлаар Монгол Улсын урд хилээс хойд хил хүртэл 2,265 км шилэн кабелийн сүлжээтэй бөгөөд энэхүү сүлжээг 400 гега.байт хүртэл өргөтгөх боломж бүхий DWDM төхөөрөмж, 2.5 гега.байт багтаамж бүхий SDH төхөөрөмж суурилагдсан сүлжээг бий болгосон. Улс хоорондын интернэтийн урсгалаа ОХУ-ын ТрансТелеком компани, БНХАУ-ын Чайна Телеком компани, Чайна Юником компани болон интернэтийн үндсэн порт эзэмшигч АНУ-ын Level3, Европын Global Crossing, Interoute зэрэг компаниудаас авдаг.

Интернэтийн урсгалын үйлчилгээ

Дээр дурдсан байгууллагууд нь шилэн кабелиар дамжуулан улс хоорондын интернэтийн урсгалын үйлчилгээг үзүүлдэг.

График 7. Улс хоорондын интернэтийн урсгал, Mbps

Эх сурвалж: ХХЗХ

2015 оны 6-р сарын эцсийн байдлаар дөрвөн компанийн эзэмшдэг шилэн кабелиар дамжсан дотоодын нийт урсгалын 78.94 хувь, 2016 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар улс хоорондын урсгалын 85 хувь нь Жемнэт ХХК-ийн шилэн кабелиар дамжсан байна.

Хүснэгт 36. Улс хоорондын интернэтийн урсгалыг дамжуулсан байдал

Компанийн нэр	Дотоодын нийт урсгал, 2015.06.31	Улс хоорондын урсгал, 2016.06.30
Рэйлком төв	1.59%	0.85%
Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК	3.68%	3.54%
Мобиком нэтворкс ХХК	15.79%	10.26%
Жемнэт ХХК	78.94%	84.99%

Эх сурвалж: ХХЗХ

Боловсон хүчин

2015 оны байдлаар МТХХ-ны салбарын нийт ажиллагсдын тоо 16 мянгад хүрсэн ба энэ нь Монгол Улсын нийт ажиллагсдын 1.39 хувийг эзэлж байна.

График 8. МТШХХ салбарын нийт ажиллагсдын тоо, мянга



Эх сурвалж: ҮСХ

Мэдээллийн технологийн чиглэлээр 600 гаруй байгууллага, 16 мянга орчим ажилтан ажиллаж байна. Түүнчлэн, Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг төрийн болон хувийн хэвшлийн 27 их дээд сургуульд жилд 1,000 гаран төгсөгч суралцдаг байна.

График 9. Их сургууль төгсөгчид болон мэдээллийн технологийн чиглэлээр төгсөгчдийн тоо, харьцаа

Эх сурвалж: ҮСХ

Монгол Улсын хэмжээнд дотоодын их сургууль төгсөгчдөөс математик, компьютерийн чиглэлээр 2014/2015 оны төгсөгчдийн тоо өмнөх онуудтай харьцуулахад бага байна.

График 10. Мэдээллийн технологийн чиглэлээр төгсөгчдийн боловсролын зэргийн байдал



Эх сурвалж: БСШУЯ

Математик, компьютерийн мэргэжлээр дотоодод төгсөгчдөөс зөвхөн компьютерийн мэргэжлээр төгсөгчдийг дотор нь зэрэглэлээр нь ангилж, сүүлийн гурван жилийн байдлаар дээрх графикт харуулав. Энэ салбарт төгсөгчдийн 97 хувь нь бакалавр зэрэглэлээр, тэдгээрээс 2-3 хувь нь магистр зэрэглэлээр, 0.1-0.3 хувь нь доктор зэрэглэлээр төгссөн байна.

Иргэдийн интернэт, үүрэн утас, компьютерийн хэрэглээ

Монгол Улсад интернэтийн үйлчилгээ үзүүлэхээр ХХЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудыг 2016 оны хагас жилийн байдлаар харахад нийт 72 байна. Эдгээр байгууллагууд нь Dial-Up, DSL, FTTH-шилэн кабель, коксиал кабель, GPRS, 3G, EVDO, Wimax, VSAT, EDGE технологи ашиглан хэрэглэгчиддээ интернэтийн үйлчилгээ хүргэж байна.

График 11. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын тоо



Эх сурвалж: ХХЗХ

Монгол Улсын хэмжээнд үүрэн утас, интернэтийн хэрэглээ болон компьютерийн хэрэглээ жил ирэх тусам асар хурдацтайгаар өсч байна. 2015 оны эцсийн байдлаар Монгол Улсын хүн амын тоо 3 саяд хүрсэн ба үүрэн утас хэрэглэгчдийн тоо нь давхардсан тоогоор 5.56 саяд хүрч байгаа нь дунджаар нэг иргэнд 1.8 ширхэг утас оногдож байна. Мөн интернэт байнгын хэрэглэгчдийн тоо 2,4 сая байгаа нь 10-55 насныхан бүгд хэрэглэгч байж болохуйц харагдаж байна. Мөн Монгол Улсад бүртгэгдсэн компьютерийн тоо 2015 оны сүүлээр 581 мянган ширхэг байсан нь 3 хүн бүрийн дунд дунджаар 1 компьютер байсныг илтгэнэ.

График 12. Харилцаа холбооны салбарын хэрэглэгчдийн тоо

Эх сурвалж: ҮСХ

Монголчуудын үүрэн утас, компьютер болон интернэт хэрэглээг 2009 онтой харьцуулахад үүрэн утас хэрэглэгчийн тоо 1.8 дахин өссөн, интернэт байнгын хэрэглэгчийн тоо 23 дахин өссөн, компьютерийн тоо 3.2 дахин өссөн байна. Энэхүү өсөлт нь утас, компьютер болон интернэт, үүрэн утасны ярианы үнэ цалинтай харьцуулахад буурсантай холбоотой юм. Интернэт хэрэглэгчдийн тоо жил бүр өсч байгааг сүүлийн 3 жилийн байдлаар дорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 37. Интернэт хэрэглэгчдийн тоо, холбогдох технологиор

Он	xDSL	Шилэн кабель	GPRS,EDGE, 3G, EVDO	Wi-Fi	Wi-MAX	Бусад	Нийт
2012	36,695	65,256	520,012	5,281	24,587	2,178	**654,009**
2013	40,684	107,886	655,107	10,444	24,322	2,700	**841,143**
2014	29,244	168,003	1,734,414	11,700	16,394	2,394	**1,962,149**
2015	24,123	157,244	2,222,112	16,413	10,265	2,611	**2,430,157**
2016.06	25,630	174,884	2,281,280	14,574	14,071	2,261	**2,512,700**

Эх сурвалж: ХХЗХ, Харилцаа холбооны салбарын үндсэн үзүүлэлтүүд

2016 оны эхний хагас жилийн байдлаар интернэт хэрэглэгчдийн 90.8 хувь нь 3G технологи ашиглан интернэтэд холбогдсон ба энэ нь ухаалаг утасны хэрэглээ өссөнтэй холбоотой байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт байгууллагуудын 70 орчим хувь нь өөрийн гэсэн цахим хуудастай бөгөөд тус бүр 1Мбит/сек-10Мбит/сек хүртэл хурдтай интернэт ашиглаж байгаа ба интернэт хэрэглэгчдийн 98 хувь нь шилэн кабель болон хөдөлгөөнт холбооны технологид суурилсан интернэтийн үйлчилгээ хэрэглэж байна.[4]

2015 оны байдлаар интернэт хэрэглэгчдийн 90.0 хувийг иргэд, 9.95 хувийг аж ахуйн нэгж болон төсвийн байгууллага эзэлж байгааг, мөн нийт хэрэглэгчийн 84 хувь нь Улаанбаатар хотоос, 13 хувь нь аймгийн төвөөс, 4 хувь нь сумаас холбогдсон байгааг ХХЗХ-ны тайлангаас харах боломжтой байна.

---

[4] "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын төслийн танилцуулга

3G хэрэглэгчдийн тоо 2016 хагас жилийн байдлаар 2,281,280 байсан нь 2014 оны эцсийн байдлаарх хэрэглэгчдийн дүнтэй харьцуулахад 72.7 хувийн өсөлттэй байна. 2016 оноос 4G технологи нэвтэрч, хэрэглэгчид хамгийн багадаа 5-7 дахин илүү хурдаар хөдөлгөөнт өргөн зурвасын интернэтэд холбогдох боломжтой болж байгаа юм.

График 13. 3G технологи хэрэглэгчдийн тоо



Эх сурвалж: ХХЗХ, Харилцаа холбооны салбарын 2016 оны эхний хагас жилийн үндсэн үзүүлэлтүүд

Дата хэрэглээний хувьд 2016 оны эхний хагас жилийн дата хэрэглээ 8,333 тера.байт хүрч, 2015 оны мөн үеийнхтэй харьцуулахад 1.9 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 14. Дата хэрэглээ, Тера.байт/Terabyte



Эх сурвалж: ХХЗХ, Харилцаа холбооны салбарын 2016 оны эхний хагас жилийн үндсэн үзүүлэлтүүд

Үүрэн утасны 4 оператор компани тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, Монгол Улсын 21 аймаг, 330 сум, сууринд үйлчилгээ үзүүлж, Монгол Улсын нийт газар нутгийн 95 хувьд хүрч ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд интернэтэд суурилсан контентийн хэрэглээ олон нийтийг өргөн хүрээгээр хамарч байна. Интернэтэд суурилсан фэйсбүүк, твиттер, youtube, инстаграм, бизнетворк зэрэг олон нийтийн сүлжээнд монголчууд олноороо нэвтэрч, өргөн хүрээнд ашиглаж байна.

График 15. Хэрэглээнд гарсан ухаалаг утасны үйлдлийн систем, хувиар, 2015 он



Эх сурвалж: ХХЗХ

Дээрх графикаас харахад андройд үйлдлийн системтэй гар утсыг монголчууд голлон хэрэглэж байна. 2016 оны эхний хагас жилийн байдлаар нийт ухаалаг утас хэрэглэгчдийн 84 хувь буюу 1,695,802 хэрэглэгч андройд үйлдлийн системтэй утас хэрэглэж байна. Харин iOS /Apple/ үйлдэлтэйг 11.4 хувь буюу 231,108 хэрэглэгч хэрэглэж байна. Гэхдээ 2014 оны эцэстэй харьцуулахад андройд үйлдлийн системтэй утасны хэрэглээ 161 хувь өссөн бол iOS /Apple/ үйлдэлтэй утасны хэрэглээ 42 хувь өссөн байна.

Олон улсын МТХХ-ны салбарын хөгжил ба Монгол Улсын эзлэх байр суурь

Харилцаа холбоо тэр дундаа мэдээллийн технологийн эрин болсон энэ үед салбарын хөгжил асар хурдтай явж байгаа ба Монгол Улс дэлхийн хэмжээнд аль байдлаараа давуу талтай, аль талаараа хоцролттой явааг тодорхой баримтуудтай оруулав.

Харилцаа холбооны үүсэл хөгжил нь эрт дээр үеэс буюу МЭӨ 3000 онд эхэлсэн гэж үздэг бол мэдээллийн технологи нь 1840 оны үед “Морс” үсгүүдийг анх ашигласнаар бий болжээ. XIX зууны сүүлийн жилүүдэд утас болон радио бүтээгдэж, 1940-өөд онд “Цахим тоон интегратор ба компьютер” (Electronic Numerical Integrator and Computer - ENIAC) нэртэй анхны компьютер зохион бүтээгдсэн байна. Харин XX зууны дунд үеэс өнөөдрийг хүртэл мэдээлийн технологийн хөгжил маш хурдацтай хөгжиж байна. Ялангуяа, сүүлийн 20 жилийн хугацаанд мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын эдийн засагт оруулж буй хувь нэмэр маш өндөр болж байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн дэх мэдээлэл технологийн шинэлэг бүтээгдэхүүнүүд (innovative industries) нэмэгдсээр байгаа ба хүмүүсийн өдөр тутмын амьдрал мэдээллийн технологи өргөн хэрэглэддэг болсон тул нийгмийн харилцаанд шинэ эрин үеийг бий болгож байна. Дэлхийн өндөр хөгжилтэй орнууд технологийн энэхүү хөгжлийг бусад орнуудаас хавьгүй өндөр хувиар ашиглаж чадаж байгаа бол хөгжиж буй орнууд арай бага хэмжээгээр ашиглаж байна. Тухайлбал, мэдээллийн технологийг хөгжүүлж хэрэгжүүлснээр 1990-ээд онд бусад орнуудын эдийн засаг удааширч байхад АНУ-ын эдийн засаг хүчирхэгжиж, инфляци нь буурч, ажилгүйдлийг хамгийн бага түвшинд хүргэж чадсан байна.

2010 онд интернэт нь дэлхийн нийт эдийн засагт 1,672 тэрбум ам.долларыг буюу нийт ДНБ-ий дунджаар 2.9 хувийг бүрдүүлжээ. Үүнд хөгжиж буй орнууд 366 тэрбум ам.долларын эдийн засгийг бүтээсэн бол BRIC-ийн улсууд үүний 66.4 хувийг буюу 243 тэрбум ам.долларыг бүрдүүлсэн байна. Харин Африкийн орнууд ердөө 8 тэрбум ам.долларын хэмжээтэй эдийн засгийг бүрдүүлж чаджээ. Энэ тоог нэг хүнд ногдох хэмжээгээр тооцвол хөгжсөн оронд 1,488 ам.доллар, хөгжиж буй оронд 119 ам.долларын хэмжээтэй эдийн засгийг интернэтийн эдийн засаг үүсгэж байна.

График 16. Интернэтийн үүсгэсэн эдийн засаг, 2010 он



Эх сурвалж: ХХЗХ

Дэлхийн банкнаас 2009 онд хийсэн судалгаагаар, хөгжиж буй оронд өндөр хурдны интернэтийн холболт 10 хувиар өсөхөд эдийн засагт нь 1.3 хувийн өсөлт харагдаж байсан байна. Интернэтийн өсөлтийн хурдыг дэлхийн хэмжээнд харуулсан зарим баримтаас дурдъя.

- *Гар утаснаас интернэтэд орох холболт өдөр ирэх тусам өсч байна*. 2008 онд энэ тоо 200 сая байсан бол 2013 онд 2.2 тэрбумд хүрчээ. Түүнчлэн, үүрэн утсаар болон суурин холболтоор авч буй интернэтийн хурдыг хурдасгах тал дээр ахиц гарсаар байна.
- *Гар утас болон үйлчилгээний үнэ буурч байна*. 2012-2013 онд ухаалаг утасны үнэ дунджаар 13 хувь буурч, 337 ам.долларт хүрсэн. Мөн гар утасны үйлчилгээний хөлс буурсан хэвээр байна.
- *Хотжилт тэлсээр байна.* 1950-2011 онд дэлхий нийтээр хотжилт хурдацтай явагдснаар хотын хүн амын тоо 750 саяас 3.6 тэрбумд хүрч, нийт хүн амын талаас их нь хот суурин амьдарч байна. Хотын хүн ам болон интернэтийн хэрэглээний өсөлт хоорондоо шууд хамааралтай байна.
- *Дундаж орлоготнуудын тоо ихэсч байна.* Дэлхий нийтээр дундаж орлогой хүмүүсийн нэг удаад ашиглах боломжит орлогын хэмжээ өссөн, ялангуяа хөгжиж буй оронд энэ хувь хэмжээ 2005 онд орлогын 5 хувь байсан бол 2009 онд 25 хувь болж өсчээ. Интернэтийн үнэ буурах тусам хэрэглээ улам бүр өсч байна.
- *Интернэтийн ашиглалтын давуу талууд нэмэгдсээр байна.* Хөгжиж буй орнуудад интернэт хэрэглээний өсөлтийн хурд нь хөгжсөн орныхтой харьцуулахад харьцангуй өндөр байна. Учир нь санхүүгийн үйлчилгээ, мобайл сургалт, мобайл эрүүл мэнд

цахим боловсрол гэх мэт ногоон технологийн интернэт үйлчилгээний төрөл хөгжих хэрэгцээ шаардлага илүү байдаг.

Түүнээс гадна интернэт хэрэглээ болон үүрэн утасны хэрэглээ жил ирэх тусам өсч байгаа болон цаашид өсөх магадлалтайг дорх графикт харуулав.

График 17. Интернэт болон үүрэн утасны хэрэглээний өсөлтийн төсөөлөл

Эх сурвалж: ХХМТГ

2012 оноос 2017 оны хооронд утаснаас интернэтэд холбогдох холболт жил ирэх тусам өсч, 2013 онд 73.4 хувь байсан нь 2017 онд 90.1 хувь болж өсөх тооцоолол гарсан байна. Дэлхийн эдийн засгийн форумаас 2001 оноос эхлэн жил бүр дэлхийн улс орнуудын "Сүлжээний бэлэн байдлын индекс - СББИ" (Networked Readiness Index)-ийг тооцоолон гаргаж байна. СББИ нь тухайн улс орны мэдээлэл, харилцаа холбооны технологийн бий болгож буй боломжуудыг ашиглах хандлагыг хэмждэг хэмжүүр юм. 2015 оны байдлаар 143 орныг хамруулсан судалгааг гаргахад Монгол Улс 143 орноос 61-т жагссан байна. Харин 2013 онд 59-т (144 орноос), 2014 онд 61-т (148 орноос) жагсаж байсан нь Монгол Улс зарим орнуудтай харьцуулахад мэдээллийн технологийг өргөнөөр хэрэглэж, тогтвортой хөгжүүлж байгааг харуулж байна. СББИ-ийг 1-7 гэсэн оноогоор харуулдаг бөгөөд Монгол Улсын 2007-2015 оны үзүүлэлтийг графикаар харууллаа.

График 18. Сүлжээний бэлэн байдлын индекс, Монгол Улс (2007-2015)



Эх сурвалж: Дэлхийн мэдээлэл технологийн тайлан, 2007-2015 он

СББИ нь дотроо дэд индексүүдтэй ба дорх үзүүлэлтүүдээр тодорхойлогддог ба:

- *Орчныг тодорхойлох дэд индекс*: Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын хөгжил нь тухайн орны зүгээс хэрхэн дэмиж, зохицуулж байгаагаас хамаардаг. Энэхүү үзүүлэлтээр тухайн орны эдийн засгийн болон зохицуулалтын орчин нь мэдээллийн технологийн шинэ санаа, бизнесүүдийг төрөөс дэмждэг байдлыг харуулдаг.
  - *Улс төр, эрх зүйн орчин*: Улс төр болон эрх зүйн орчин нь тухайн оронд мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлөөр дамжуулж, бизнесийн үйл ажиллагааг дэмжих боломжийг нээсэн эсэх, мөн оюуны өмчийн хамгаалалт, программ хангамжийн хэрэглээ, шүүх байгууллагын хараат бус байдал, хууль тогтоох байгууллагын үр дүнтэй ажиллагааны байдал болон холбогдох дүрэм журмын чанар болон цар хүрээг хэмждэг.
  - *Бизнес, инновацийн орчин*: Шинээр бизнес эхлүүлэхэд бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийг хэмждэг. Жишээ нь татварын орчин, технологийн чадвар, өрсөлдөх чадвар, шинэлэг бүтээлийн эрэлт хэрэгцээ, инновацитай холбоотой төслүүдийг санхүүгийн эх үүсвэр, гэх мэт.
- *Бэлэн байдлын дэд индекс:* Тухайн улс орны дэд бүтэц болон бусад хүчин зүйлс нь мэдээлэл, харилцаа холбооны технологийг өөртөө хэрхэн шингээх (ашиглах) чадвартай байгааг хэмжинэ.
  - *Дэд бүтэц*: Тухайн улсын мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтэц нь энэ салбарын хөгжилд хэр нөлөөлж байгааг хэмжинэ. Жишээ нь: гар утасны сүлжээ, олон улсын интернэтийн давтамжийн урт, интернэтийг аюулгүй байршуулах серверүүд болон эрчим хүчний үйлдвэрлэлийн нөхцөл байдлыг хэмждэг.
  - *Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ:* Улс орны хэмжээнд үүрэн телефоны хэрэглээний өртөг, интернэтийн үнэ гэх мэт 17 төрлийн мэдээллийн технологийн үйлчилгээний үнийн чөлөөлөлт хэр байгаагаар хэрэглэгчдийн худалдан авах чадварыг танддаг /учир нь чөлөөт өрсөлдөөн дунд үйлчилгээний жижиглэнгийн үнэ урт хугацаанд буурдаг/.
  - *Хэрэглээний чадвар*: Мэдээлэл, харилцаа холбооны технологийг хэрэглэгчдийн буюу хүн амын чадавхийг хэмждэг ба хүн амын дунд боловсролын байдал, ерөнхий боловсролын тогтолцооны чанар, ялангуяа математик болон шинжлэх ухааны боловсрол болон насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдсан байдлыг авч үздэг.
- *Хэрэглээний байдлын дэд индекс*: Мэдээлэл, харилцаа холбооны технологийн гол хэрэглэгчид болох засгийн газар, бизнесийн байгууллагууд болон иргэдийн ашиглалтын байдлыг хэмждэг.
  - *Хувь хүний хэрэглээ*: Хувь хүмүүсийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний байдлыг хэмжихдээ тухайн улсад үүрэн телефон ашиглаж буй, интернэт ашиглаж буй, компьютер эзэмшиж буй болон нийгмийн сүлжээг ашиглаж буй хүн амын тоогоор тодорхойлдог.
  - *Бизнесийн хэрэглээ*: Аж ахуйн нэгж, байгууллагууд нь өөрсдийн үйл ажиллагаанд интернэт, мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашигладаг эсэх, боловсон

СЗХ он сар өдөр 2017 09 27 БҮРТГЭВ № 01

хүчний сургалт, мөн компаниуд шинэ технологийн бүтээгдэхүүнийг патентжуулж авч буй байдлыг хэмждэг.

– *Төрийн хэрэглээ*: Төр нь мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжүүлэх бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэхэд хэр анхаардаг, өөрийн үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны технологийг хэрхэн ашигладаг, цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлдог.

- *Нөлөөллийн дэд индекс*: Мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарын эдийн засаг болон нийгэмд үзүүлж буй үр нөлөөг тооцоолдог.
  – *Эдийн засгийн үр нөлөө*: Технологийн болон технологийн бус инновацаар дамжуулан мэдээлэл, харилцаа холбооны технологийн эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг хэмждэг. Үүнд патент авах хандалтын тоо, шинэ бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн процесс, байгууллагын загвар гаргахад мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашигласан байдлыг хэмждэг.
  – *Нийгмийн үр нөлөө*: Мэдээлэл, харилцаа холбооны технологийн нийгмийн хөгжилд үзүүлж буй үр нөлөөг хэмждэг. Тухайлбал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, эрчим хүчний хэмнэлт, иргэдийн нийгэм дэх оролцоо сайжрахад мэдээлэл, харилцаа холбооны технологи нөлөөлсөн байдлыг авч үздэг. Үүнийг сургуулийн орчин дах интернэт хэрэглээ, төрийн үйлчилгээний шуурхай байдал, цахим үйлчилгээгээр дамжуулан иргэдийг хууль боловсруулахад оролцуулж буй байдлаар хэмждэг.

Монгол Улсын хувьд эдгээр үзүүлэлтүүд 2011-2015 онд байнгын өсөлттэй байсныг дорх графикаас харна уу.

График 19. Монгол Улсын СББИ-ийн дэд индексийн үзүүлэлтүүд (2011-2015)



Эх сурвалж: Дэлхийн мэдээлэл технологийн тайлан 2015 он

Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн түвшин дэлхийн хэмжээнд ямар түвшинд байгааг "Мэдээлэл технологийн тайлан 2015"-д тусгасан байдлыг харахад манай улс нь Азийн хөгжиж буй улс орнуудаас дээгүүр үзүүлэлттэй байна.

УЛААНБААТАР ХОТ itools АЙТУУЛС ХХК 1116218260 5468361

УЛААНБААТАР ХОТ СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК ТТС3981 5444381

График 20. Улс орнуудын СББИ-ийн үзүүлэлтүүд



Эх сурвалж: Дэлхийн мэдээлэл технологийн тайлан 2015 он

Түүнчлэн, Монгол Улсын интернет хэрэглээ, хурдны түвшинг олон улстай харьцуулан үзвэл манай улс эхний 7-р байранд явж буй нь сайн үзүүлэлт юм. Дэлхийн дундажтай харьцуулахад манай улсын интернетийн хэрэглээ 2.3 дахин өндөр байна.

Хүснэгт 38. Интернэт хэрэглэгчдийн тоо, холбогдох технологиор

№	Улс	Дундаж хурд (Mb/s)
-	*Дэлхийн дундаж*	32.5
1	Singapore	135.7
2	Hong Kong	105.2
3	South Korea	95.3
4	Macau	83.1
5	Japan	82.9
6	Indonesia	79.8
7	Mongolia	78.9
8	Taiwan	78.8
9	Qatar	77.8
10	Romania	73.6

Эх сурвалж: Дэлхийн мэдээлэл технологийн тайлан 2015 он

Дата төв

Мэдээлэл технологи, интернэтийн хэрэглээ өсч, цахим үйлчилгээ нэмэгдэх тусам цахим өгөгдлийн хэмжээ ихэсч, хэрэглэгчдийн, ялангуяа төрийн байгууллагууд болон хувийн компаниудын үйл ажиллагаа нь цахим мэдээллийн боловсруулалт, байршуулалт, хадгалалт, аюулгүй байдлаас хамааралтай болж байна. Тиймээс дата төв хэмээх цахим мэдээлэл

СЗХ
2017 09 27
№ 01

өгөгдлийг байршуулж, аюулгүй байдлыг нь хангах цогц үйлчилгээг үзүүлдэг дэд бүтцийг дэлхий даяараа хэрэглэж эхлээд байна.

Мэдээллийн технологи гэрлийн хурдаар хөгжиж байгаатай зэрэгцэн, мэдээлэл солилцох явцад гадны халдлагад өртөх, мэдээлэл алдагдах явдал хялбаршиж байна. Тиймээс, дата мэдээллийг хамгаалах, найдвартай хадгалах зорилгоор тусгай зориулалтын тоног төхөөрөмжүүд дээр байршуулж, шаардлагатай үед эргэн сэргээх үйлчилгээг дата төвүүд гүйцэтгэг.

Дата төв гэж юу вэ?

Дата төв гэдэг нь мэдээллийн технологийн төхөөрөмж болох сервер болон сүлжээний төхөөрөмжүүд, түүнтэй холбоотой мэдээлэл хадгалах төхөөрөмжүүдийг байршуулж, тасралтгүй бөгөөд аюулгүй ажиллах үйлчилгээг үзүүлдэг тусгай төв юм. Дата төв нь байнгын болон нөөц цахилгааны эх үүсвэр, сүлжээний холболт, хяналтын систем, камерын хяналт, галын хамгаалалт, хөргөлтийн систем болон гадны цахим халдлагаас хамгаалах хамгаалалтын төхөөрөмжүүдээр бүрэн тоноглогдсон байна. Дата төв нь дараах бүрэлдэрүүн хэсгүүдээс бүрддэг. Үүнд:

Агаарын температур, чийгшил тохируулах систем: Энэ нь дата төвийн серверийн өрөөний температурыг 16–24°C, чийгшлийг тогтмол 40–55 хувьд барьж байх зориулалттай. Серверийн өрөөний дулаан ердийн үед байнга өсдөг. Учир нь дотор нь байрлах төхөөрөмжүүдийн цахилгаан зарцуулалт болон өөрийн ажиллагаа нь үргэлж дулаан ялгаруулдаг. Тэр дулааныг багасгаж өгснөөр төхөөрөмжүүдийн хэвийн ажиллахаар үйлдвэрээс зааж өгсөн стандарт температур, чийгшлийн хэмжээ тогтож, төхөөрөмжийн эдэлгээ уртасч, ажиллагаа сайжирна.

Нөөц цахилгааны эх үүсвэр: Үүнд зэрэгцээ холбосон өндөр хүчдэлийн эх үүсвэр, дизел генераторууд болон тог баригч UPS-ууд орно. Найдвартай ажиллагааны үүднээс бүх төхөөрөмж нь А болон В гэсэн хос давхар холболттой байна. Хэрэв аль нэг холболтонд асуудал үүсэхэд нөөц давхар холболт нь автоматаар ажиллаж эхэлдэг байхаар тохируулдаг. Цахилгааны дэд станцтай байх ба тэр нь генератор, тог баригчтайгаа автоматаар хосолж ажиллана.

Найдвартай ажиллагаа: Аянга зайлуулагч, гал унтраах хийн систем, газар хөдлөлтөд тэсвэртэй барилга байгууламж зэрэг бусад шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнээс гадна мэдээллийн сүлжээ, өгөгдлийн нууцлал, хамгаалалтын тал дээр төрөл бүрийн дээд зэрэглэлийн техник, технологийг ашигласан байдаг.

Дата төвийн байршил болон үйл ажиллагааны аюулгүй байдал нь үйлчлүүлэгчдийн тавьдаг гол шалгуур бөгөөд дэд бүтцийн хувьд олон улсын болон дотоодын стандартуудыг баримталж ажилласнаар өрсөлдөх чадвар нь сайжирдаг.

Дата төвөөс үйлчилгээ авахын давуу талууд:

- Найдвартай интернэтэд холбогдоно, холболтын хурд сайн байна.
- Өндөр зардал бага.
- Таны вэбсайт, онлайн үйлчилгээ тасралтгүй ажиллаж, хэрэглэгчиддээ саадгүй хүрнэ.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУС
116218260 ᠳ. 5468381

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ᠳ. 5444381

СЭХ
он . сар . . . өдөр
2017 . 09 . 27
БҮРТГЭВ
№ 01

- Хамгаалалтын систем сайн тул мэдээллийн аюулгүй байдал хангагдана.
- Дата сэргээлт, нөөцлөлт хийлгэх боломжтой, г.м.

Дата төвийн хөгжлийн тухай

Дата төвүүд нь анхны компьютер үүсч байх үетэй зэрэгцэн үүсч хөгжсөн. Дээр үеийн компьютерын систем нь ажиллуулахад тусгай орчин нөхцөл шаарддаг, овор хэмжээ ихтэй, нарийн төвөгтэй бүтэцтэй байсан ба маш олон кабель шугам ашиглан, хэсэг тус бүрийг нь холбодог байжээ. Тэр бүрт тусгай хайрцаг, өргөгдсөн хөндий шал болон кабелийн тавиур зэргийг ашигладаг байна. Мөн хуучны компьютерууд нь цахилгаан их зарцуулдаг, их халдаг байсан ба хамгаалалт чухал байсан нь тэр үед ихэнх компьютеруудыг цэргийн зориулалтаар ашиглаж байсантай холбоотой. Тиймээс дата төв рүү орж гарах хүмүүсийг хянадаг байжээ.

1990 оноос сервер компьютерүүд бий болсоноор хуучин компьютеруудыг байрлуулдаг байсан өрөө серверүүдээр дүүрэх болсон. Сүлжээний төхөөрөмжүүдийг тэр өрөөнд байрлуулахад кабель холбох зэрэгт хялбар байсан тул серверүүдийг тийм өрөөнд олноор нь байлгах санаа анх төржээ. Тэх үед компьютерт зориулсан тусгай өрөө буюу дата төвийг ажиллуулж эхэлсэн байна. Хожим Олон улсын цахилгаан холбооны байгууллагуудаас дата төвийн стандартыг гаргаж эхэлсэн. Дата төв нь тасралтгүй мөнхийн ажиллагаатай байх ёстой гэсэн бичигдээгүй хууль байдаг ба орчин үед байгаль орчинд хор нөлөөгүй, бага зардлаар найдвартай ажиллах дата төвүүд бий болж байна. 1973 онд бизнесийн тасралтгүй, тогтмол ажиллагааг хэвшүүлэх зорилгоор дата төвийн “Гамшгийн нөхөн сэргээлт”-ийн ерөнхий схем, төлөвлөгөө анх хэрэглээнд нэвтэрч эхэлсэн байна.

1980-аад онд “виртуалчлал” анх бий болж, өртөг багатай сүлжээний төхөөрөмжөөр холбогдсон харилцагчийн сервер төрлийн компьютер үүссэн байна. 1990-ээд оны сүүлээр байгууллагууд аажим аажмаар интернэтэд холбогдож, өнөөгийн ухаалаг дата төвийн дэд бүтцүүд бий болсон ба 2000 он гарахад компьютерийн хэрэглээ улам бүр өсчээ. Дата төвүүд цахилгаан ихээр хэрэглэдэг. Жишээлбэл, 2000 оны эхээр АНУ-ын нийт цахилгаан хэрэглээний 1.5 хувь нь дата төвийнх байсан гэсэн тооцоо гарчээ. Иймээс дата төвийн цахилгааны үр ашигт ажиллагааг сайжруулах тал дээр ажилласнаар 2007 оноос сэргээгдэх эрчим хүчийг дата төвүүдэд ашиглах боломжтой болсон байна.

Түүнчлэн, 2007 онд Sun Blackbox компани нь том хэмжээний сервер, компьютеруудыг байршуулах суурин дата төвийн технологи, дэд бүтцийн шаардлагад нийцсэн зөөврийн “Модуляр” буюу контейнер дата төвийн шийдлийг санаачилсан байна. Энэ нь 280 ширхэг серверийг байршуулах хүчин чадалтай зөөврийн контейнер байсан ба суурин дата төв ажиллуулах нийт өртгийн нэг хувьтай тэнцэхүйц зардлаар ижил үйл ажиллагаа үзүүлэх чадвартай байжээ. Сүүлийн үед Модуляр дата төв гэж зөөвөрлөн тээвэрлэхэд хялбар, өгөгдлийн ачааллын хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжтой, цахилгааны болон хөргөлтийн бие даасан дэд бүтцийн шийдэл бүхий нэг ба түүнээс дээш угсармал модулиудаас бүрддэг цогц дата төвийг хэлж байна. 2010 он гарсаар мэдээлэл технологийн салбарт үүлэн тооцооллын дата төв гэдэг ухагдахуун шинээр бий болсон нь дата төвүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, өгөгдлүүдийн урсгалыг өсгөх зориулалттай байна.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮДС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

Монгол Улсын хувьд анхны томоохон дата төв нь 2009 онд байгуулагдсан Үндэсний дата төв УТҮГ (Улсын төсөвт үйлдвэрийн газар) юм. Тус төвийг төрийн цахим дата, мэдээ, мэдээллийг хадгалах, хамгаалах, боловсруулалт хийх, төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг байгуулах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах, “Цахим засаглал”-ын хүрээнд хэрэгжүүлэх төрийн бодлого, хөтөлбөрүүдийн суурь дэд бүтцийг тавих зорилгоор байгуулсан ба төрийн цахим үйлчилгээ өргөжих тусам дата төвийн хүчин чадлыг нэмэх шаардлага гарч, 2013-2014 онд хүчин чадлыг нь хоёр дахин нэмсэн байна. Үндэсний дата төв нь төрийн байгууллагуудаас гадна хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд мэдээллийн технологид суурилсан үйлчилгээг үзүүлсээр ирсэн. Одоогоор Үндэсний дата төв УТҮГ-т 1,319 төсвийн байгууллага, 330 аж ахуй нэгжийн цахим хуудас байршиж байна. [5]

Дата төвийн олон улсын стандарт

Дата төвийн хадгалж буй мэдээллийн ач холбогдол, хэмжээ, үйл ажиллагааны хүчин чадал зэргээс шалтгаалан ашиглагдах тоног төхөөрөмжүүд болон хамгаалалтын систем нь өөр байдаг. Харилцаа холбооны аж үйлдвэрийн холбоо (Telecommunications industry association) болон АНУ-ын Үндэсний стандартын институтын (American national standards institute) зүгээс 2005 онд TIA-942 буюу Дата төвийн дэд бүтцийн 4 түвшний стандартыг гаргасан. Үүнд:

TIER 1: Жижиг байгууллагуудад үйлчилгээ үзүүлдэг ба компьютерийн систем, цахилгаан болон бусад тоног төхөөрөмжүүд нь нөөцгүй байдаг. Цахилгааны хязгаарлалтыг 10 минутаас дээш хугацаанд давж гарах дэд бутэц байдаггүй. 99.676 хувийн ашиглалт хангах боломжтой.

TIER 2: Цахилгааны нөөцийн болон агаарыг сэрүүцүүлэх тоног төхөөрөмжтэй. Цахилгааны өөрийн эх үүсгэвэр ашиглаж, 24 цагийн цахилгааны хязгаарлалтыг давж гарах боломжтой. 99.741 хувийн ашиглалт хангах боломжтой.

TIER 3: Цахилгааны нөөцийн системтэй. Мөн агаарыг сэрүүцүүлэх нөөц тоноглолтой. Цахилгааны хязгаарлалтыг 72 цагийн турш давж гарах хүчин чадалтай. 99.982 хувийн ашиглалт хангах боломжтой.

TIER 4: TIER-3-ын бүх шаардлагыг хангасан. Цахилгааны хязгаарлалтыг 96 цагийн турш давах боломжтой. Өдөр бүр 24 цагийн хараа хяналт тавьдаг баг ажилладаг. Байршлын сонголтыг болон хамгаалалтыг өндөр түвшинд хийдэг.

Эдгээр стандартын гэрчилгээг АНУ-д төвтэй Аптайм Институтээс (Uptime Institute) олгодог ба одоогийн байдлаар тус байгууллагаас дэлхийн хэмжээнд 70 орны 637 дата төв холбогдох стандартын гэрчилгээг авсан байна.

---

[5] “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын төслийн танилцуулга

Зураг 4. Аптайм Институтээс гэрчилгээ авсан дата төвүүдийн газарзүйн байршил

Эх сурвалж: Uptime Institute

Тухайлбал, Европд TIER 4 стандартыг хангасан долоон компани байдгийн нэг нь Швейцарь улсын Swisscom AG компанийн Berne-Wandorf Data Center юм. Энэхүү дата төвийг барихад гурван жилийн турш 62.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, 2015 оны 1-р сард ашиглалтанд оруулсан ба тус төв нь 5,000 сервертэй, 10,000 үйлчлүүлэгчтэй, 55,000 куб.м талбай бүхий байртай ажээ.

Зураг 5. Швейцарийн Swisscom AG-ийн Berne-Wandorf дата төв

Манай өмнөд хөрш БНХАУ-д TIER IV гэрчилгээтэй гурав, TIER III гэрчилгээтэй 12, TIER II гэрчилгээтэй нэг дата төв байдаг бол хойд хөрш ОХУ-д TIER IV гэрчилгээтэй нэг, TIER III гэрчилгээтэй 17 дата төв, Казакстанд TIER III гэрчилгээтэй хоёр дата төв байна.

Манай улсын хувьд одоогийн байдлаар Хаан банкны дата төв TIER II гэрчилгээг авсан гэсэн албан ёсны мэдээлэл байна. Түүнчлэн, 2015 онд Мобиком корпораци болон Мобинет ХХК хамтран, TIER III стандартыг хангасан газарзүйн нөөц дата төвийг Дархан хотод ашиглалтанд оруулсан тухай мэдэгдсэн юм.

Дата төвийн хөгжлийн чиг хандлага

Дата төвийн хэлбэр, зохион байгуулалтад өөрчлөлт орж, тасралтгүй хөгжүүлэлт хийгдсээр байна. Дата төвийн хамгийн сүүлийн үеийн шийдэл нь модуляр, уян хатан, суурилуулалт болон өөрчлөлтийг хурдан хийх боломжтой, зөөврийн чанартай болсон. Үүнд контейнер дата төвийн шийдэл орохоос гадна модуляр буюу урьдчилан инженерчлэгдсэн, урьдчилан үйлдвэрлэгдсэн олон хэсгээс бүрдсэн загвар мөн багтана. Модуляр хэсгүүд нь цахилгааны дэд станц, эрчим хүчний нөөц эх үүсгэвэр, агаарын хэм болон чийгшлийг тохируулах тоног төхөөрөмж, хамгааллын систем болон бусад шаардлагатай үйлчилгээтэй хамт интеграцлагдан суурилуулагдсанаар нэгэн цөм болж, дата төвийн байгууламж болно.

Нэг байршилд суурин байхаар байгуулагддаг уламжлалт дата төвтэй харьцуулахад контейнер эсхүл модуляр загварын дата төв нь бага зардлаар хурдан угсарч суурилуулах үр ашигтайгаас гадна дата төвийн хүчин чадлыг, өөрөөр хэлбэл хэрэглэгчдийн серверүүдийн хүчин чадлыг бага багаар нэмэх эсхүл бууруулах боломжийг олгодог уян хатан шинж чанартай юм. Түүнчлэн, орчин цагийн дата төвүүд “Cloud” буюу үүлэн тооцооллын технологийн ачаар гар утас, зөөврийн компьютер зэрэг хэрэгслүүдээр орон зай, цаг хугацаанаас үл хамааран мэдээ, мэдээллийг шуурхай авч, түүнийг ашиглах боломжийг олгож, нэмүү өртгийн зардлыг багасгаж байна.

Дата төвийг гамшгаас хамгаалах, нөхөн сэргээх /Disaster recovery/

Дата төвийг гамшгаас хамгаалах, гамшгийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд нөхөн сэргээх зорилгоор газарзүйн нөөц дата төвийг байгуулдаг. Нөөц дата төвийн байршлыг хатуу тогтоосон нэгдсэн стандарт, дүрэм журам одоогоор байхгүй боловч улс орны болон орон нутгийн онцлогоос шалтгаалан тухайн байгууллага өөрөө тодорхойлдог. Үүнд дараах хүчин зүйлсийг харгалзан үздэг.

- Газар хөдлөлт, хөрсний цөмрөлт
- Үерийн гамшиг, цунами
- Гал түймэр
- Бусад байгалийн гамшиг (хуй салхи, галт уулын дэлбэрэлт, г.м.)
- Үйлдвэрлэлийн бүс, атомын цахилгаан станц, дайн, мөргөлдөөн, цэргийн сургуулилт, халдварт өвчний голомт гэх мэт эрсдэл дагуулсан газруудаас аль болох хол байх, харин

дэд бүтэц, цахилгааны үүсгэвэрт ойр байх шаардлагатай.

Газар нутаг багатай орнуудын хувьд дата төвийг хөрш улс руу хөтлөх бүр гуравдагч улс оронд байршуулдаг. Зарим өндөр хөгжилтэй орнуудад стратегийн чухал байгууллагуудыг заавал газарзүйн нөөц дата төвд мэдээллээ хадгалуулж, эрсдлээ бууруулах шаардлага тавьдаг. Газарзүйн нөөц дата төвүүд үндсэн дата төвийнхөө тусгал мэт ажиллаж, өгөгдлүүдийг нөөцөлж, back up хийж байх зориулалттай бөгөөд нэг дата төвд асуудал гарахад нөгөө нэгт нь үйл ажиллагаа шилжиж, үйлчлүүлэгчдийн датаг хамгаалж, интернэт орчин дах ажиллагаа, программ хангамжинд суурилсан ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх, тасралтгүй байлгах ач холбогдолтой юм.

Газар хөдлөлт: Монгол орны суурин газрын 75 орчим хувь нь газар хөдлөлтийн 7 болон түүнээс дээш, 12 суурин газар нь газар хөдлөлтийн 9 болон түүнээс дээш баллын бүс нутагт оршиж байна. Газар хөдлөлтийн 7 болон түүнээс дээш баллын бүс нутагт манай нийт хүн амын 86 хувь амьдарч байна.

“Улаанбаатар хотын газар хөдлөлтийн эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ” хөтөлбөрийг 2009 онд Засгийн газрын 157-р тогтоолоор баталжээ. Энэ хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаагаар Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт үүсэх магадлал бүхий голомт идэвхжиж, магнитут нь 6.5-6.8 хүчтэй байх бөгөөд энэ нь Улаанбаатар хотын хэмжээнд 9-10 баллын доргилт үүсэх үндэслэлтэй гэж эрдэмтэд дүгнэлт гаргасан. Улаанбаатар хотын Согино-Сонсголонгийн бүс нутагт 2005 оны 4-р сараас газар хөдлөлтийн өндөр идэвхжилт ажиглагдаж эхэлсэн нь Улаанбаатар хотод бодит аюул учруулж болохуйц техтоник тогтцын эвдрэлийн үзэгдэл явагдаж эхэлснийг харуулдаг. 1995-2009 оны хооронд Улаанбаатар хот орчмын бүсэд нийт 600 гаруй сул хүчтэй /магнитут нь 4.2 буюу түүнээс доош/ газар хөдлөлтийн төв тодорхойлогдсны 50 орчим нь 1995-2003 онд тохиолдсон бол 2005 оны 4-р сараас эхлэн 450 орчим болж мэдэгдэхүйцээр өссөн байна. Энэхүү идэвхтэй бүс нь Эмээлт болон Сонгино орчмын бүс нутагт 30 орчим км урт, 13 орчим км гүний хэмжээтэй томоохон талбайг хамарч байгааг урьдчилсан судалгаагаар тогтоосон байна.

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлийг бууруулах, болзошгүй шууд болон шууд бус аюулаас урьдчилан сэргийлэх, үнэлгээ хийх, гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, бэлэн байдлыг хангах шаардлагатайг Онцгой байдлын ерөнхий газраас мэдэгдсэн байдаг. Тиймээс, газар хөдлөлтийн идэвх өндөртэй нийслэл хотын бүсэд Монгол Улсын гол стратегийн мэдээллүүд нэг дор хадгалагдаж байгаа нь үндэсний хэмжээнд эрсдэл дагуулж байна. Дархан-Уул аймагт газарзүйн нөөц дата төв барьж, цогц үйлчилгээ үзүүлэх нь энэхүү эрсдлийг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулах болно.

Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь хэмжээ болон өрсөлдөгчид

Үнэт цаас гаргагчийн өрсөлдөгчдийг дотоод болон гадаад гэж ангилж болно. Үүнд: Монгол улсад ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй дотоодын компаниуд нь дотоод өрсөлдөгчид юм. Вэбсайт байршуулах болон бусад ижил төрлийн үйлчилгээг дотоодын хэрэглэгчдэд шууд бусаар үзүүлж буй гадны компаниуд нь үнэт цаас гаргагчийн гадаад өрсөлдөгчид юм. Гадаад өрсөлдөгчид олон бөгөөд хүчтэй ч тэдгээр нь Монгол Улсын хэрэглэгчдийн хэрэгцээ

СЭХ
он сар ... өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

зах зээлээ болгодоггүй, дотоодын компаниуд тэдэн рүү хандлаг тул гол өрсөлдөгчид гэж үзэхгүй байж болно.

Байршуулах үйлчилгээ

Байршуулах үйлчилгээ буюу хостингийн үйлчилгээ гэдэг нь аливаа вэбсайт, вэбд суурилсан үйлчилгээ болон бусад клауд төрлийн үйлчилгээг дата төвд байршуулсан зориулалтын төхөөрөмжүүд ашиглан, интернэтийн сүлжээнд холбох үйлчилгээ юм. Монголд энэ төрлийн үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчит Үндэсний дата төв УТҮГ, хувийн өмчит Айтүүлс ХХК, Датаком ХХК, Мэйжикнэт ХХК зэрэг компаниуд байна.

Байршуулах үйлчилгээ ашиглагчдын хэрэгцээ шаардлагыг ерөнхийд нь 3 ангилж болно. Үүнд:

- Өөрийн үйл ажиллагаа, компани, брэндийг олон нийтэд танилцуулах зорилгоор вэбсайт ажиллуулах
- Мэдээллийн сайт, төрөл бүрийн онлайн үйлчилгээний сайтууд гэх мэт үндсэн бизнесийн үйл ажиллагаагаа явуулах зорилгоор вэбсайт ажиллуулах
- Хүргэлт, түгээлт гэх мэт үндсэн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор вэбсайт, вэбд суурилсан системүүд ажиллуулах

2017 онд идэвхтэй ажиллаж буй 3,000 вэбсайтаас санамсаргүй аргаар түүвэрлэн, байршуулах үйлчилгээний зах зээлийн талаар бичил судалгаа явуулахад хамгийн олон Монгол вэбсайт байршуулсан эхний 25 сүлжээг дорх хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 39. Хамгийн олон Монгол вэбсайт байршуулж буй сүлжээ

1	AS63962 iTools JSC	18.21	“Айтүүлс” ХХК	Монгол
2	AS40034 Confluence Networks Inc	12.6	Датаком ХХК, Мэйжинет ХХК болон бусад Датаком ХХК-ийн ресэллерүүд	Гадаад
3	AS46606 Unified Layer	9.18	Univied Layer, Justhost, Bluehost, Hostmonster	Гадаад
4	AS56301 National Data Center building	8.22	Үндэсний Дата төв УТҮГ	Монгол
5	AS9484 Mobinet LLC. AS Mobinet Internet Service Provider	5.42	Мобинет ХХК	Монгол
6	AS45237 Bodicom ISP Ulaanbaatar	4.36	Бодь ком ХХК, Мэйжикнет ХХК	Монгол
7	AS36351 SoftLayer Technologies Inc.	4.06	Softlayer	Гадаад
8	AS26496 GoDaddy.com, LLC	3.01	Godaddy	Гадаад
9	AS45204 GEMNET LLC	1.71	Жемнет ХХК	Монгол
10	AS15169 Google Inc.	1.65	Google	Гадаад
11	AS20013 CyrusOne LLC	1.60	Cyruxone	Гадаад
12	AS38805 STXCitinet, Leading Internet & VOIP Service Provider, Ulaanbaatar, Mongolia	1.55	Ситинет ХХК	Монгол
13	AS29873 The Endurance International Group, Inc.	1.50	Endurance International	Гадаад
14	AS8560 1&1 Internet AG	0.90	1&1	Гадаад
15	AS30496 Colo4, LLC	0.85	Colo4	Гадаад
16	AS33070 Rackspace Hosting	0.85	Rackspace	Гадаад
17	AS23352 Server Central Network	0.80	Server Central Network	Гадаад

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ⚖ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ⚖ 5444381

18	AS22612 Namecheap, Inc.	0.70	Namecheap	Гадаад
19	AS55342 Homenet	0.70	Хоүмнэт ХХК	Монгол
20	AS17882 The first E-commerce and TriplePlay Service ISP in Mongolia.	0.65	Univision	Монгол

Эх сурвалж: Айтүүлс ХХК-ийн тооцоолсноор, 2017 он

Монгол Улсад интернэт нэвтэрснээс хойш вэбсайтуудыг Монголд байршуулах хэд хэдэн оролдлогуудыг компаниуд хийж байсан боловч төдийлөн амжилттай болж байгаагүй. Харин Үндэсний дата төв болон үнэт цаас гаргагчийн байршуулах үйлчилгээ нэвтэрснээс хойш байршуулах үйлчилгээний зах зээлд Монгол Улсад байршуулах тоо хэмжээ нэмэгдэж эхэлсэн байна.

Хүснэгт 40. Хамгийн олон Монгол вэбсайт байршуулж буй улс орнууд

№	Улс	Хувь	№	Улс	Хувь
1	АНУ	52.8	**13**	Англи	0.35
2	Монгол	34.7	**14**	Франц	0.35
3	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	2.51	**15**	Гонконг	0.25
4	Британийн арлууд	1.65	**16**	Чех	0.2
5	Канад	1.2	**17**	Швейцарь	0.2
6	Япон	1	**18**	Дани	0.15
7	Бүгд Найрамдах Солонгос Улс	0.85	**19**	Австри	0.15
8	Голланд	0.75	**20**	Украйн	0.1
9	Сингапур	0.6	**21**	Швед	0.1
10	Оросын Холбооны Улс	0.6	**22**	Малайз	0.1
11	Хятад	0.5	**23**	Бусад орнууд	0.5
12	Австрали	0.45			

Эх сурвалж: Айтүүлс ХХК-ийн судалгаагаар

Эдгээрээс Монгол Улсад байрлаж буй 691 вэбсайтыг байршуулж буй байгууллагуудаар нь эрэмбэлэн жагсаасныг дорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 41. Монгол Улсад вэбсайт байршуулах үйлчилгээ үзүүлж буй компаниуд

1	AS63962 iTools JSC	“Айтүүлс” ХХК	41.26
2	AS56301 National Data Center building	Үндэсний Дата Төв ҮТҮГ	21.29
3	AS9484 Mobinet LLC. AS Mobinet Internet Service Provider	Мобинет ХХК	10.91
4	AS45237 Bodicom ISP Ulaanbaatar	Бодь ком ХХК, Мэйжикнет ХХК	12.03
5	AS45204 GEMNET LLC	Жемнет ХХК	0.91
6	AS38805 STXCitinet, Leading Internet & VOIP Service Provider, Ulaanbaatar, Mongolia	Ситинэт ХХК	3.38
7	AS55342 Homenet	Хоүмнэт ХХК	2.03
8	AS17882 The first E-commerce and TriplePlay Service ISP in Mongolia.	Юнивижн ХХК	1.88
9	AS10076 ERDEMNET ISP	Эрдэмнет ХХК	1.45
10	AS38051 Boldsoft Co., Ltd	Болдсофт ХХК	1.45
11	AS24320 Railcom - Commercial Center,	Рэйлком төв	0.72
12	AS38818 YOKOZUNANET LLC	Юкозуна нэт ХХК	0.72
13	AS4850 Digicom LLC	Дижиком ХХК	0.72
14	AS58598 Mongolia		0.72
15	AS16219 SKY C&C LLC	Скай Си энд Си ХХК	0.58
16	AS134241 Khulan Content LLC	Хулан контент ХХК	0.58

17	AS24559 G-Mobile Corporation	Жи-мобайл ХХК	0.58
18	AS38218 ULUSNET LLC. Mongolian Internet Provider	Улс нэт ХХК	0.43
19	AS45509 BMDNET LLC, AS Content Service Provider Ulaanbaatar, Mongolia	Би Эм Ди Нэт ХХК	0.43
20	AS9934 Mongolia Telecom	МЦХ	0.43
21	AS58439 ICNC LLC	Ай Си Эн Си ХХК	0.29
22	AS10109 Topica LLC, Internet Service Provider,Ulaanbaatar, Mongolia	Топика ХХК	0.14
23	AS133453 Mogul Service and Support Co., Ltd.	Могул сервис энд саппорт ХХК	0.14
24	AS134074 Golomt Bank	Голомт банк	0.14
25	AS38869 Skynetworks LLC	Скайнетворкс ХХК	0.14
26	AS55408 Univision LLC	Юнивижн ХХК	0.14
27	AS55801 OPTINET LLC	Оптинэт ХХК	0.14
28	AS55805 MobiCom Corporation	Мобиком Корпораци ХХК	0.14
29	AS56293 Kewiko LLC	Кевико ХХК	0.14
31	AS58726 #203, Express tower		0.14
32	AS9789 Datacom Co.,Ltd	Датаком ХХК	0.14

Эх сурвалж: Айтүүлс ХХК-ийн тооцоолсноор, 2017 он

График 21. Монгол Улсад вэб байршуулж буй байгууллагууд, зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Айтүүлс ХХК-ийн тооцоолсноор, 2017 он

Дээрх графикаас харахад үнэт цаас гаргагч Айтүүлс ХХК нь байгуулагдаад удаагүй ч TIER II стандартад нийцсэн дата төвийн үйлчилгээг дотооддоо үзүүлж эхэлснээр дотооддоо хамгийн олон Монгол вэбсайт байршуулсан компани болжээ. Түүнчлэн, Монголд вэб байршуулах үйлчилгээний зах зээлийн хамгийн их буюу 41 хувийг үнэт цаас гаргагч эзэлж байна.

СЗХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

Дотоодын гол өрсөлдөгчид

Мобиком корпораци ХХК /Мобинэт/

Мобиком корпораци нь өөрийн үндсэн үйл ажиллагаатай уялдуулан дата төв ажиллуулсаар ирсэн. 2015 онд газарзүйн нөөц дата төвийг Улаанбаатар хотоос 220 км зайд Дархан хотод ашиглалтанд оруулсан нь олон улсын TIER III стандартыг хангасан гэж мэдээлсэн. Хэвлэл мэдээллийн сувгаар мэдээлснээр тус дата төвийн байгууламжийн гол онцлог нь энгийн барилгаас дээврийн даац нь 1.5 дахин, арматурын чанарын үзүүлэлт 4 дахин, таазны өндөр 1.6 дахин, шалны даац 2.4 дахин илүү бат бөх ажээ.

Үзүүлж байгаа үйлчилгээнүүд:

- Сервер байршуулах
- Виртуал сервер байршуулах
- Вэб байршуулах үйлчилгээ
- Домайн нэр

Датаком ХХК

Датаком ХХК нь 1994 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба Монголд интернэт үйлчилгээг нэвтрүүлсэн анхдагч компани юм. Тус байгууллага нь ICANN (International Corporation for Assigned Names and Numbers) олон улсын корпорацийн албан ёсны итгэмжлэлтэйгээр үйл ажиллагаа явуулдаг.

Үзүүлж байгаа үйлчилгээнүүд:

- Домайн нэр
- Вэб байршуулах
- И-мэйлийн үйлчилгээ
- SSL сертификат

Үндэсний дата төв ҮТҮГ

“Үндэсний дата төв” Улсын төсөвт үйлдвэрийн газар (ҮДТ ҮТҮГ) нь 2009 оны 6-р сарын 24-ний өдөр байгуулагдсан ба төрийн цахим дата, мэдээ мэдээллийг хадгалах, хамгаалах, боловсруулалт хийхээс гадна хувийн хэвшлийн байгууллагуудад мэдээллийн технологид суурилсан үйлчилгээг үзүүлдэг. “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллуудын мэдээллийн нэгдсэн санг байгуулах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах

суурь дэд бүтцийг байгуулахаар ажиллаж байна. Тус төвийн хөгжлийн үе шат дараах байдалтай байна. Үүнд:

- Эхэн үед мэдээлэл хадгалдаг “Цахим архив” хэлбэртэй байсан.
- Мэдээллийг байршуулдаг “Hosting” хэлбэрт шилжсэн.
- Мэдээлэл солилцдог “Exchange” хэлбэрээр ажиллана.
- Цаашид мэдээллийн цэгцэрсэн тогтолцоог “Bigdata” хэлбэрээр ажиллуулна.

Үзүүлж байгаа үйлчилгээнүүд:

- Домэйн нэр
- Вэб байршуулах
- Виртуал сервер байршуулах
- Зогсуур түрээслүүлэх
- Цахим засаглалын үйлчилгээ үзүүлэхэд дэд бүтцийг хариуцан ажиллах. Үүнд дор дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба 2016 онд нийт 60 гаруй төрийн үйлчилгээг иргэн өөрийн цахим иргэний үнэмлэхийг ашиглан авах боломжтой болох юм байна.
    - Замын цагдаагийн бэлэн бус торгуулийн системийн бааз болон холболтууд
    - ТҮЦ машин, Төрийн үйлчилгээний машиныг (ТҮЦ) улс даяар 108 цэгт суурилуулсан.
    - Албан журмын даатгал
    - Камерийн торгуулийн систем, Замын хөдөлгөөний Удирдлагын төвтэй хамтран ажилладаг.
    - E-immigration, Гадаадын иргэн харъяатын асуудал эрхлэх газартай хамтран ажилладаг.
    - Цахим виза, Гадаад харилцааны яамтай хамтран ажилладаг.
    - Цахим татварын үйлчилгээ, Татварын ерөнхий газартай хамтран ажилладаг.
    - Цахим тендер, Худалдан авах ажиллагааны газартай хамтардаг.

Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр төрөөс хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг” төслийн хүрээнд Үндэсний дата төвийн гамшгийн үед нөхөн сэргээх нөөц төвийг Багануур хотод байгуулахаар төлөвлөж байгаа ба төслийн ТЭЗҮ, бизнес төлөвлөгөө зэргийг боловсруулахаар ажиллаж байна.

Мэйжик нэт ХХК

Мэйжик нэт ХХК нь 1996 Датаком ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулагдан, анхны интернэт үйлчилгээг үзүүлж байсан. 1997 оноос тусдаа бие даасан компани болж, хэлбэр бүтцээ өөрчлөн үйл ажиллагаа үрэлжлүүлсэн. Харин 2003 оноос Датаком ХХК-ийн охин компани Дата нэт ХХК-тай нэгдэн, Мэйжик нэт ХХК нэрээрээ мэдээлэл технологи, праграм хангамж, интернэтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Үзүүлж байгаа үйлчилгээнүүд:

- Домайн нэр

- Вэб байршуулах
- И-мэйлийн үйлчилгээ
- SSL сертификат
- Байгууллагын шилэн кабелийн холболт

Бүтээгдэхүүн, үйлчилгээний харьцуулалт

Дээрх компани, байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, хөлсийг тус бүрийн нийтэд зарласан үнээр харьцуулан, дорх хүснэгтэд харууллаа.

Домэйн нэр:

Хүснэгт 42. Домэйн нэрийн үнийн харьцуулалт

№	Домайн нэрийн төрөл	Жилийн төлбөр /төгрөг/			
		Айтүүлс	Мобинэт	Датаком	Мэйжикнэт
1	.com	24’900	25’000	-	
2	.info	24’900	25’000	60’000	
3	.net	24’900	25’000	-	
4	.org	24’900	25’000	-	
5	.name	24’900	25’000	60’000	
6	.biz	24’900	25’000	70’000	
7	.mobi	-	25’000	60’000	
8	.mn	54’900	65’000	60’000	63’0000
9	.cc	-	75’000	70’000	
10	.asia	24’900	75’000	70’000	
11	.tv	44’900	85’000	80’000	
12	.co	24’900	-	-	
13	.host	54’900	-	-	
14	.ru	12’900	-	-	

Эх сурвалж: Айтүүлс ХХК-ийн судалгаагаар

Байршуулах үйлчилгээ:

Хүснэгт 43. Байршуулах үйлчилгээний үнийн харьцуулалт

№	Байршуулах үйлчилгээний төрөл	Жилийн төлбөр /төгрөг/			
		Айтүүлс	Мобиком	Датасом	Мэйжикнэт
1	Вэб байршуулах хязгааргүй үйлчилгээ	Нэг домэйнтэй 79’000	156’000	102’000	192’000
		Олон домэйнтэй 179’000			
2	Виртуал сервер (VPS) түрээслүүлэх үйлчилгээ	15GB – 480’000 30GB – 816’000 60GB – 1’380’000	15GB– 478’800 30GB– 838’800 60GB– 1’318’800		
3	Сервер байршуулах үйлчилгээ	1’068’000	1’590’000		
4	Физик сервер түрээслэх үйлчилгээ				

Эх сурвалж: Айтүүлс ХХК-ийн судалгаагаар

СЭХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

Бусад үйлчилгээ

Хүснэгт 44. Бусад үйлчилгээний үнийн харьцуулалт

№	Үйлчилгээний төрөл	Сарын төлбөр /төгрөг/			
		Айтүүлс	Мобиком	Датасом	Мэйжикнэт
1	SSL сертификат	4’920		7’500	8500
2	IP хаяг	4’900	6’800		
3	Албан и-мэйл	1’000		2’000	2000
4	Архийвлах үйлчилгээ				
5	Хяналтын үйлчилгээ				
6	Хамгаалалтын үйлчилгээ				

Эх сурвалж: Айтүүлс ХХК-ийн судалгаагаар

Орчны дүгнэлт, SWOT шинжилгээ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад орчны шинжилгээ

Эдийн засгийн өсөлт: 2013 онд Монгол Улсын ДНБ-ий хэмжээ 19.2 их наяд төгрөг, 2014 онд 22.2 их наяд, 2015 онд 23.2 их наяд төгрөг байсан ба өсөлтийн хувь он тус бүрээр 12.3, 11.6, 7.8, 2.3 хувь байжээ. Харин 2016 болон 2017 онд өсөлтийн хувь өмнөх онуудтай харьцуулахад буурах хүлээлттэй байгаа ба өсөлтийн хувь 2-3 хувийн хооронд байхаар төсөөлж байна.

Хүн амын өсөлт: Монгол Улсын хүн амын тоо 2013 онд 2.93 сая, 2014 онд 2.995 сая, 2015 онд 3.06 саяд хүрсэн бол 2016 оны эцэст хүн амын өсөлт өмнөх онуудтай ойролцоо буюу 2.1 хувь өссөнөөр 3.12 саяд, 2017 онд төрөлтийн тоо бага зэрэг буурч, 2 хувьд хүрч, 3.18 саяд хүрэхээр байна.

Монгол Улсын өрхийн сарын дундаж орлого: Өрхийн нийт орлогын хэмжээ 2013 онд 959 мянган төгрөг, 2014 онд 1,080 мянган төгрөг болсон дүн 2015 онд 1,047.2 болж бага зэрэг буурсан ч өсөлтийн хувь ирэх 2 жилд өсөлт үргэлжлэх боловч өсөлтийн хурд буурч, 3-5 хувь байх хүлээлттэй байна.

Аж ахуйн нэгжүүд: Монгол Улсад бүртгэлтэй болон үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн /ААН/ тоо жил бүр өсч байна. 2013 онд нийт 99,603 ААН бүртгэлтэй байснаас 55.1 хувь нь үйл ажиллагаа явуулсан, 2014 онд бүртгэлтэй 113,602 ААН, тэдгээрийн 52.7 хувь нь үйл ажиллагаа явуулжээ. Харин 2015 онд нийт 126.5 мянган ААН бүртгэлтэй байсан бол тэдний 50.8 хувь нь үйл ажиллагаа явуулсан. Үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн тооны өсөлт жилд 5.8-8.9 хувьтай байна. Харин ирэх хоёр жилийн хугацаанд энэхүү өсөлт үргэлжилнэ гэсэн хүлээлт байна.

Төрөөс баримталж буй бодлого: Төрөөс мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт хиглэсэн бодлогуудыг 1994 оноос хэрэгжүүлж эхэлсэн ба 2000 оноос мэдээллийн технологид онцгой ач холбогдол өгч, “Цахим Монгол”, Цахим засаглал” зэрэг тусгай бодлого,

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ТТС 1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. 2015 онд "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийг боловсруулж, Улсын их хуралд өргөн мэдүүлсэн нь тус салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх дунд хугацааны нэгдсэн бодлогоор хангахаар төрөөс анхаарч, тогтвортой дэмжиж байгаагийн илрэл юм. Түүнчлэн, 2015 онд Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль, Өгөгдөл хамгаалах тухай хууль, Цахим засгийн тухай хуулийн төслүүдийг боловсруулсан нь төрөөс мэдээллийн аюулгүй байдалд онцгойлон анхаарч эхэлснийг илтгэнэ.

Салбарын орлого: Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын нийт орлого 2013 онд 784 тэрбум төгрөг, 2014 онд 850.4 тэрбум төгрөг, 2015 онд 933.3 тэрбум төгрөг, 2016 онд 1,100 тэрбум төгрөгт хүрэх хүлээлттэй байсан байна.

2010 оны мэдээллээр интернэт нь дэлхийн нийт эдийн засагт 1,672 тэрбум ам.доллар буюу нийт ДНБ-ий 2.9 хувийг бүрдүүлж байсан байна. Харин Монгол Улсад интернэт болон мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын ДНБ-д эзлэх хувь 3.2 хувь байжээ. Энэ тоо 2014 онд 2.2 болж буурсан ч төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн үр дүнд ирэх жилүүдэд өсөх боломжтой гэж үзэж байна.

Өргөн хэрэглээ: Дэлхий нийтээр мэдээллийн технологийн салбар хурдацтай хөгжиж, Монгол Улсын хэрэглэгчдэд цаг алдагдалгүй, харьцангуй хямд үнээр хүрч байгаа нь энэ салбарын хэрэглээний зах зээлийн тасралтгүй өсөлтийг бий болгож байна. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйлчилгээ цахим хэлбэрээр олон нийтэд хүрэх болсон нь нийт иргэдийн мэдээллийн технологитой харьцах дадлыг бий болгосоор байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан тайлангаар "Сүлжээний бэлэн байдлын индекс-СББИ"-ээрээ Монгол Улс 2013 онд 59-т (144 орноос), 2014 онд 61-т (148), 2015 онд 61-т (143 орноос) жагссан байна. Харин индексийн үзүүлэлтийг жил тус бүрээр харуулбал 2013 онд 4, 2014 онд 4.1, 2015 онд 4.2 болж өссөн үзүүлэлттэй байна. Цаашид энэ үзүүлэлт өсөх магадлал их байна.

Төслийн онцлог: Монгол Улсад одоогоор Модуляр дата төв байгуулагдаагүй байна.

Үнэт цаас гаргагч нь Модуляр дата төвийн паркийг Монголд анх удаа байгуулахаар ажиллаж байгаа ба энэхүү шинэлэг загварын дата төв нь богино хугацаанд, бага зардлаар босдог, үйл ажиллагааны зардал бага, эрчим хүч хэмнэх боломжтой, хүчин чадлаа нэмж, багасгаж болдог уян хатан шинж чанартай зэрэг маш олон давуу талтай юм.

Модуляр дата төвийг газар хөдлөлт, үер зэрэг байгалийн гамшгийн эрсдлийн түвшин бага, дэд бүтэц сайн хөгжсөн Дархан хотод барих нь газарзүйн нөөц дата төвийн үйлчилгээг үзүүлэх боломжийг олгож байна.

Үнэт цаас гаргагчийн SWOT шинжилгээ

ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	
ДАВУУ ТАЛ	*СУЛ ТАЛ*
- Үнэт цаас гаргагчийн оффис нь БГД, СБД зэрэг хотын төв байршилд байрлаж байгаа нь	- Компанийн нөөц хязгаарлагдмал тул дэлхийн хамгийн өндөр стандартын

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЭХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

хэрэглэгчдэд ойр байна. - Үнэт цаас гаргагчийн оффис болон дата төвийн барилга, Дархан хот дах шинээр барих гэж буй Модуляр дата төв байрших газар нь үнэт цаас гаргагчийн өөрийн эзэмшлийнх учраас бусдаас хараат бус байх нөхцлийг бүрдүүлж байна. - Үйл ажиллагаандаа чанартай брэндийн, дэвшилтэт тоног төхөөрөмжүүдийг ашигладаг. - Чадварлаг боловсон хүчинтэй баг хамт олныг бүрдүүлсэн, Компанийн дотоод дүрэм журам, засаглал сайн. - Компанийн санхүүгийн үзүүлэлтүүд жил бүр байнга өсч байгаа ба урт хугацааны өр төлбөргүй. - Дамжуулан борлуулж буй бүтээгдэхүүнүүдийг багасгаж, өөрийн шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд гаргаж эхэлсэн. 100% дотоодын бизнес и-мэйлийн үйлчилгээг 2016 оны 5-р сард зах зээлд нэвтрүүлсэн. - Өөрийн эзэмшлийн, олон улсын болон дотоодын стандартад нийцсэн үндсэн дата төвийг 2015 оноос ажиллуулж байна. Хүчин чадлыг нь 2016 онд 2 дахин нэмэгдүүлсэн. - Интернэтийн үйлчилгээ үзүүлдэг зэргэлдээ компанитай. - Үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ хэрэглэгчдэд танигдсан. - Модуляр дата төвийн паркийн эскиз зургийг гаргаж, холбогдох байгууллагаар батлуулсан ба барилгын ажил эхлэхэд шаардлагатай зөвшөөрлүүдийг авсан.	технологи, тоног төхөөрөмжийг хараахан хэрэглэж чадахгүй байна. - Дотоод хяналт, үйл ажиллагааны стандартын хэрэгжилт сул. - Эхний жилүүдэд Модуляр дата төвийг өөрийн шилэн кабелиар холбох нь өртөг өндөртэй тул боломжгүй. - Зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг дамжуулан борлуулдаг. - Өмнө нь Модуляр дата төв угсарч ажиллуулж байсан туршлага байхгүй.

ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

НӨӨЦ БОЛОМЖ	*АЮУЛ ЗАНАЛ*
- Салбарын хөгжил, өсөлт хурдацтай нэмэгдэж байна. - Хэрэглэгч байж болох аж ахуйн нэгжүүдийн болон хүн амын өсөлт нэмэгдэж байна - Мэдээллийн технологийн хэрэглээ өдөр өдрөөр нэмэгдэж, хэрэглэгчдийн тоо өсч, онлайн үйлчилгээ авах дадал бий болж байна. - Хувийн хэвшлийн компаниудын хувьд	- 2017 онд Ерөнхийлөгчийн сонгууль явагдах тул улс төрийн өөрчлөлт, зөрчилдөөн үүсэх эрсдэлтэй. Төрийн үйлчилгээ, шийдвэр гаргалт, хэрэгжилт удаашрах магадлалтай. - Эдийн засагт нүүрлээд байгаа хямралын нөлөө удаан хугацаар үргэлжлэх нь хэрэглэгчийн худалдан авах чадвар болоод компанийн борлуултанд сөргөөр нөлөөлөх

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮДС ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
ТТС3981 ☎ 5444381

вэбсайттай болох, онлайн үйлчилгээ үзүүлэх тал дээр илүү анхаарах болсон. Гэвч, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад манай улсад цахим үйлчилгээ нь зөвхөн эхлэл төдий байгаа тул цаашид өргөжин тэлэх том орон зай бий.

- Төрийн зүгээс хэрэгжүүлж буй бодлого, дэмжлэг, хүчин чармайлт их байна. “Цахим засаглал” хөтөлбөр амжилттай хэрэгжиж, төрийн үйлчилгээ цахимжиж байна. Цахим засгийн тухай хуулийн төслийг боловсруулж, 2017 онд УИХ-д өргөн барина.
- Төрөөс мэдээлэл, харилцаа, холбооны хөгжлийн талаар 2025 он хүртэл баримтлах бодлогыг баталж хэрэгжүүлж эхэлбэл салбарыг хөгжүүлэх төрийн дунд хугацааны бодлого тодорхой болно. Тус бодлогод мэдээллийн аюулгүй байдлыг стратегийн нэг зорилго болгон онцолсон нь дата төвийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нийцэж байна.
- Мэдээлийн аюулгүй байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, 2016 оны 2-р сард УИХ-д өргөн барьсан ба Өгөгдөл хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.
- 2016 оны 3-р сараас Улаанбаатар хот, хөдөө орон нутагт интернэтийн үйлчилгээний ижил үнэ тариф үйлчилж эхэлсэн ба хурдыг тодорхойлж өгсөн. Ийнхүү хөдөөд интернэтийн үнэ 2 дахин буурснаар интернэтийн үйлчилгээ эрхлэгч байгууллагын зах зээл нэмэгдэж, хэрэглэгчдийн тоо 2016 онд 30%-аар өсч, үйлчилгээний чанар, хурд 3 дахин нэмэгдэхээр тооцоолсон байна.
- Монгол улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах зохицуулалтын чиглэлийг баталж, 2016 оны 4-р сараас үүрэн холбооны операторууд 4G LTE технологийг нэвтрүүлж эхлээд байна.
- Монгол Улс өөрийн хиймэл дагуултай болох зэрэг төрөөс хэрэгжүүлж буй бусад бодлого хөтөлбөрийн үр дүнд интернэтийн хурд сайжрах зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө.
- Гол хэрэглэгчид болох бизнесийн магадлалтай.
- Хамтран ажиллагч, нийлүүлэгчийн үйл ажиллагаанаас хамааралтай эрсдлүүд бий. /Сүлжээ, шилэн кабелийн тасралт, тэдгээрийн түрээсийн төлбөр нэмэгдэх, г.м./
- Валютын өсөлтөөс шалтгаалан импортын бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн үнэ нэмэгдэх эрсдэлтэй.
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын түвшин буурсантай холбоотой хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй байх эрсдэлтэй.
- Дата төвийн эцсийн хэрэглэгчид, үйлчлүүлэгчид мэдээллийн аюулгүй байдал, вэб байршуулах үйлчилгээний талаар сайн ойлголт мэдлэггүй.
- Дата төв ажиллуулахад шаардлагатай нарийн мэргэшлийн мэргэжилтнүүд цөөн.
- Хүчтэй өрсөлдөгч гарч ирэх.
- Дата төв, байршуулах үйлчилгээг зохицуулсан эрх зүйн орчин сул.

байгууллагууд мэдээллийн аюулгүй байдалдаа илүү ихээр анхаарах болсон. - Салбарын өрсөлдөөн багатай байна. Модуляр дата төв одоогоор байхгүй. - Төрийн зохицуулах байгууллагуудаас банк, санхүү болон мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мэдээллийн аюулгүй байдлыг хангах, учирч болох эрсдлийг бууруулах шаардлага тавигдаж эхэлсэн. - Мэдээллийн технологийн хөгжлийг даган дэлхий нийтээрээ даяарчлагдсан тул, орон зай, цаг хугацаанаас үл хамааран, бага өртгөөр бүтээгдэхүүн импортлох, гаднаас хэрэглэгчдийг татах боломжтой. - Мэдээллийн технологи нь өдрөөс өдөрт хувьсан шинэчлэгдэж байдаг тул шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ гарч, манай улсын зах зээлд нэвтрэх боломжтой ба үнэт цаас гаргагчаар дамжуулан түгээх боломжтой.	

СЗХ
он сар өдөр
2017.09.27
БАТЛАВ
№ 01

Модуляр дата төвийн байгууламж, үйлдвэрлэлийн технологи

Модуляр дата төвийн байгууламж

Модуляр дата төв нь контейнер, сервер байршуулах хэсэг, хөргөх, чийгшүүлэх систем, цахилгаан үүсгэвэрийн хэсэг, галын дохиоллын систем, хяналт, удирдлагын /зайнаас удирдах систем орно/ хэсэг зэрэг урьдчилан инженерчлэгдсэн модуль хэсгүүдийг угсарч бүтээгддэг, зөөвөрлөх боломжтой ба уламжлалт дата төвтэй ижил үйлчилгээ үзүүлэх зориулалттай юм. Уламжлалт дата төв нь “тодорхой байршилд баригддаг, тогтмол суурин бүтэц” гэгддэг ба барилгыг барилга угсралтын компаниар бариулж, шаардлагатай тоног, төхөөрөмжүүдийг суурилуулан, зориулалтын дагуу үйлчилгээ үзүүлдэг.

Модуляр дата төвийг ихэвчлэн бидний мэддэгээр бараа бүтээгдэхүүн тээвэрлэхэд хэрэглэдэг стандартын чингэлэг/контейнерийг зориулалтын дагуу /шатдаггүй, дулаалгатай хана, хөндий шал, г.м./ тоноглож, модуль хэсгүүдийг суурилуулдаг ч хэрэглэгчийн хүссэн хэмжээний өрөө, байранд суурилуулах боломжтой байдаг. Модуль хэсгүүдийг мэргэжлийн байгууллагаас тусгайлан үйлдвэрлэж, цогцоор нь нийлүүлдэг ба урьдчилан шалгаж, туршсан байдаг. Модуляр дата төвийг байгуулах нь дараах давуу талуудтай. Үүнд:

- Өгөгдөл хадгалах, боловсруулах хэрэгтэй ямар ч газар байгуулж болно.
- Дэлхийн хаана ч тээвэрлэгдэн хэрэглэгдэх боломжтой. Амархан угсрагддаг.
- Хэрэглэгчийн үндсэн дата төвтэй интеграцлагдах боломжтой.
- Өөр системүүдтэй холбогдон ажиллах, тохируулах боломжтой.
- Эдийн засагт хэмнэлттэй, өртөг зардлын хувьд үр ашигтай.
- Эрчим хүч болон бусад нөөцийг илүү үр өгөөжтэй ашигладаг, байгаль орчинд ээлтэй.
- Суурилуулалтын үеийн болон суурилуулсны дараах үйлчилгээ үзүүлэх үед гарах алдааг багасгадаг.
- Контейнер модулийн гадна тал нь салхи, шуурга, гал түймэр, газар хөдлөлт, элсний ширхэг нэвчих зэрэгт тэсвэртэй, бат бөх байдаг.
- Үйлдвэрлэгчээс баталгаа өгдөг.
- Нэг модульд нэг стандартын гэрчилгээ олгож баталгаажуулдаг тул модулийг бүрдүүлдэг олон эд ангийг тус бүрт нь сертификатжуулахаас зайлсхийх боломжтой.
- Контейнерүүдийг давхарлан тавихаас авахуулаад, орон зай байвал дата төвийн хүчин чадлыг хүссэн хэмжээгээр нэмэх боломжтой.

Зураг 6. Контейнер/модуляр дата төвийн гадаад байдал

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУЛС
5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 5444381

Зураг 7. Контейнер/модуляр дата төвийн дотоод зохион байгуулалт



1.Гадна агааржуулалтын систем
2.Зогсуур /тусгай тавиар
3.Дотор агааржуулалт систем
4.Сүлжээний систем
5.Галын систем
6.Тог хураагуур систем
7.Удирдлагын систем
8.Тогт баригчийн систем
9.Зогсуур хоорондын зай
10.Онцгой байдлын тохио
11.Зориулалтын шал

Зураг 8. Контейнер/модуляр дата төвийн план зураг



Үнэт цаас гаргагч нь Дархан хотод барих Модуляр дата төвийн паркийг контейнерэн модулиудаар байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд 900 м.кв дата төвийн барилга, 300 м.кв оффисийн барилга барьж байршуулах юм. Шинээр баригдах Модуляр дата төвийн паркийн хэтийн зохион байгууллатыг дараах зургаас харна уу.

Зураг 9. Модуляр дата төвийн паркийн зохион байгуулалт



1.Дата төвийн оффисийн барилга
2.Дата төвийн байгууламж
3.Агааржуулалтын хэсэг
4. Контейнер/модуляр дата төв
5. Контейнер шилжүүлэн зөөх төхөөрөмж

Модуляр дата төвийн үндсэн модулиуд

Хүснэгт 45. Модулийн төрлүүд

Модулийн төрлүүд	Тайлбар	Хэсгүүд
Өгөгдлийн/дата хэсгийн модуль	Мэдээллийн технологийн /сервер, сүлжээний, г.м./ тоног төхөөрөмж, эд ангиуд, тэдгээрийн цахилгааны болон хөргөлтийн системүүд байршдаг	Зогсуур болон зогсуурын хэсэг Серверүүд болон бусад тусгай төхөөрөмжүүд, тэдгээрийн хөргөлтийн нэгжүүд Цахилгаан оруулах болон дамжуулах хэсэг Галын дохиолол, гал унтраах систем, г.м.
Дэд бүтцийн модуль	Дата хэсгийн модулийг дэмжиж ажиллах зориулалттай дулаан гадагшуулах ба хөргөлтийн, цахилгаан зохицуулах ба цахилгаан үүсгэх нөөц системүүд	Эйр кондишн, чийгшил тохируулагч Хөргөлтийн систем Цахилгаан баригч, генератор Бусад
Туслах модуль	Үйл ажиллагааг хэвийн явуулахад хэрэгцээтэй бусад хэсгүүд байршдаг	Ажлын талбай/өрөө Хяналтын хэсэг Удирдлагын хэсэг, г.м.

Дата буюу ачааллын модулийн хүчин чадал нь өөр өөр байж болно. Энэ модуль нь мэдээллийн технологийн тусгай тоног төхөөрөмжүүд болон тэдгээрийг байршуулах зогсуруудтай байх ба зарим нь хөргөлтийн системгүй, цахилгаан барих болон өгөгдөл хуулж хадгалах хүчин чадал байхгүй байхад, зарим нь дулаан гадагшлуулах, тог/цахилгаан баригч төхөөрөмжүүдтэй (UPS) байж болно.

Ерөнхийдөө энэ модуль нь өөртөө агаарын солилцоо хийгч сэнс, цахилгаан тугэах, нэгж гэх мэт цахилгааны болон хөргөлтийн системтэй байдаг. Мөн галаас хамгаалах, гал унтраах

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

төхөөрөмж, аюулгүй байдлыг хангах төхөөрөмжтэй байдаг. Дата модуль нь өөрийн үйл ажиллагааг бүрэн хангах зориулалттай, гаднаас зөвхөн цахилгаан залгаад хэрэглэж болдог тул Модуляр дата төв нь хамгийн багадаа дата модультай байх ба нөхцөл байдлаас шалтгаалан дэд бүтцийн болон туслах модулиудыг нэмж болно. Эдгээр модулиуд нь бүгд урьдчилан инженерчлэгдсэн, урьдчилан үйлдвэрлэгдсэн байдаг. Модуляр дата төв нь хэд хэдэн дата модуль, дэд бүтцийн модуль болон туслах модультай байж болно. Мөн шаардлагатай бол орон нутгийн ажиллах хүчнээр барилгын нэмэлт ажил хийлгэж болно. Тухайлбал, Монголын нөхцөлд эрс тэрс уур амьсгалтай, гэмт хэрэг ихтэй тул модулиудыг задгай талбайд бус угсармал барилга дотор байршуулах нь илүү тохиромжтой гэж үзэн, Дарханд сэндвичэн хавтангаар барилга бариулахаар төлөвлөж байна.

Модуляр дата төв ба уян хатан байдал

Эзэмшлийн хэлбэр

Модуляр дата төв нь хэрэгчлэгчид модулиудыг худалдан авах, байршуулах, удирдах үйл ажиллагааг уян хатнаар зохион байгуулах боломжийг олгодог. Бүх байгууллагад тохирох нэг загвар гэж байхгүй тул модуляр дата төвд эзэмшлийн өөр өөр хэлбэрүүд байж болно. Бусад өмчийн адил худалдан авах, түрээслэх, түрээслүүлэх боломжтой тул байгууллага бүр зардал, үр ашгийн тооцоон дээр үндэслэн дараах гурван төрлийн загвараас сонгох боломжтой. Үүнд:

1. *Модуляр дата төв болон тоног төхөөрөмжүүдийг бүгдийг эзэмших*. Эдгээр нь элэгдэж, элэгдлийн зардал нэмэгдэж болохыг анхаарах хэрэгтэй юм. Модулийг байгууллагын эзэмшлийн эсхүл түрээсийн барилга, байгууламжид суурилуулж болно.
2. *Хэсэгчлэн эсвэл бүхэлд нь түрээслэх*. Байгууллагын хувьд серверүүдийг явцын дунд нэмэхээр төлөвлөж байгаа тохиолдолд модуль түрээслэх нь оновчтой байж болно. Энэ сонголт нь санхүүгийн хувьд ачаалал багатай байдаг. Өөр нэг хувилбар бол модулийг эзэмшиж, тоног төхөөрөмжүүдийг түрээслэх бөгөөд энэ нь бусдад хостингийн үйлчилгээ үзүүлэх, эсвэл хамтран байршуулах сонирхолтой байгууллагуудад илүү тохиромжтой.
3. *Үүлэн тооцооллын үйлчилгээний гэрээнд үндэслэсэн мэдээллийн технологийн дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэх*. Үйлчүүлэгч нь мэдээллийн технологийн үйлчилгээг цогцоор нь гаднаас авах эсвэл виртуалчлагдсан, үүлэн тооцоололд суурилсан байршуулах үйлчилгээ эрхлэгчээс үйлчилгээний гэрээний хүрээнд авах боломжтой. Энэ үйлчилгээг илүү өргөтгөн, модуляр дата төвийн боломж, давуу талуудыг шингээсэн, үүлэн тооцооллын үйлчилгээ санал болгож болох юм. Байгууллагад зориулсан өөр нэг сонголт нь тухайн байгууллага уламжлалт дата төвөө үргэлжлүүлэн ашиглаж, үүлэн тооцооллын үйлчилгээний гэрээнд суурилсан модуляр дата төвийг нөөц дата төв болгон ашиглах боломжтой.

Сервис үйлчилгээ

Модуляр дата төв нь нэг дороос дэмжих үйлчилгээ, сервисийг авах боломжийг өгдөг. Хэрэв байгууллага тоног төхөөрөмжүүдийг өөр өөр газраас авч байршуулсан бол /уламжлалт дата төв шиг/ тэдгээрийн баталгаа, засвар үйлчилгээг нэг цэгээс хангуулах боломжгүй. Хатуу диск гэмтэх эсвэл температурын мэдрэгч алдаа заасан эсэхээс үл хамааран утасны нэг

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУЛС
ХХК
УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЭХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

дуудлагаар хүндрэлийг шийдүүлэх боломжтой. Тухайлбал, хэрэглэгч "нүрч үйлчлэх гэмтлийн үйлчилгээ"-г сонгож болох бөгөөд энэ тохиолдолд серверүүдийн тодорхой хувь гэмтэх хүртэл модулийг ашиглаж байгаад тогтоосон хувь хэмжээнээс их хэмжээнд сервер гэмтэхэд нийт модулийг бүхэлд нь серверүүдийн хамт сольж өгдөг.

Модуляр дата төвд алсаас удирдаж, оношлох ба гэмтэл устгах боломжийг олгох нь зайлшгүй шаардлагатай байдаг. Ерөнхийдөө Модуляр дата төвд алсын зайнаас хийгддэг, өндөр зэрэглэлийн сервис үйлчилгээ байдаг ч өдөр тутмын арчилгаа, сервис хийгдэх ёстой тул өндөр зэрэглэлийн мэдлэг ур чадвартай мэргэжилтнүүдийг ажиллуулах нь чухал юм.

Нүүлгэн шилжүүлэлт

Модуляр дата төв нь контейнерэн бүтэцтэй тул зөөвөрлөх боломжтой ч тээвэрлэлт нь шинэ боломжуудыг бий болгохын зэрэгцээ харгалзан үзвэл зохих зарим асуудал, сорилтыг дагуулдаг. "Замд" тохиолдож болох алдаануудаас зайлсхийх үүднээс тухайн модулийн хийц нь тогтмол буюу хааяа зөөхөд зориулагдсан ч ямар түвшинд туршигдсан болохыг мэдэх нь чухал. Сервер эсвэл нөөцийг дахин сэргээж ашиглах циклийн үед дата төвийг газарзүйн өөр байрлалд зөөж болно. Жишээлбэл, Модуляр дата төв доторх серверүүд эсвэл хадгалах нэгжүүдийн ашиглалтын хугацаа дуусахад нийт нэгжийг бүхэлд нь үйлдвэрлэгч рүү тээвэрлэж, дахин боловсруулж болдог. Дараа нь модулийг өөрчилж засварлан, шинэ техник, төхөөрөмжүүдээр тоноглож, өөрийн талбайд байрлуулах нь шинэ модуль худалдан авахаас бага өртөгтэй байж болно.

Санхүү, төлөвлөлтийн асуудал

Модуляр дата төв нь санхүүгийн хувьд илүү үр ашигтай байдаг нь эрэлт, нийлүүлэлт дээр үндэслэн хүчин чадлаа тэлэх эсхүл агшаах боломжтой байдагтай холбоотой юм. Модуляр дата төвийн давуу талыг бататгахын тулд хүчин чадлын эрэлтийн муруйг нь уламжлалт дата төвтэй харьцуулж харъя.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮДС
2017
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

Зураг 10. Уламжлалт дата төвийн хүчин чадлын эрэлтийн муруй



Зураг 11. Модуляр дата төвийн хүчин чадлын эрэлтийн муруй



Дээрх зургуудаас харахад эрэлт ихэсч, хүчин чадлаа нэмэх шаардлагатай болоход уламжлалт дата төвийн хувьд шинээр барилга барих, байраа томосгох зэрэгт илүү их хөрөнгө, цаг хугацаа зарцуулснаар үйл ажиллагаа доголдож болохоор байна. Харин Модуляр дата төвийн

хувьд маш богино хугацаанд, бага хэмжээгээр хүчин чадлаа нэмэх боломжтойгоос гадна эрэлт багассан үед хүчин чадлаа бууруулж, эргээд нэмж болдог давуу талтай байна.

Тиймээс, Модуляр дата төв нь өсөн нэмэгдэж буй эрэлт эсвэл богино хугацааны оргил ачааллыг хангаж чадахгүй байх эрсдэл бага, эрэлтийг илүү үнэтэй гадны хостинг үйлчилгээ рүү шилжүүлэх эсвэл эрэлтийг хүчээр дарж, бизнесийн үйл ажиллагаандаа сөргөөр нөлөөлөхгүй байх боломжтой юм.

Сүүлийн үед виртуалчлал зэрэг бусад шинэлэг технологиуд гарч ирснээр дата төвийн эрэлт багасгах, мөн эдийн засгийн циклүүдээс хамаарч үйлчлүүлэгчдийн тоо буурах эрсдэл байж болно. Модуляр дата төв нь шинэ байгууламж бүтнээр барихын оронд “тухай бүрт нь” тохиромжтой хэмжээгээр нэмж байршуулах боломжийг олгодог.

Санхүүгийн бусад давуу талууд

Хүснэгт 46. Модуляр дата төвийн /МДТ/ давуу тал

Давуу тал	Тайлбар
Хөрөнгө оруулалтын өртөг бага	МДТ нь уламжлалт дата төвтэй ижил хэмжээний хүчин чадлаар ажиллаж чаддаг ч анхны хөрөнгө оруулалтын өртөг нь мэдэгдэхүйц бага байдаг. Энэ давуу талын дийлэнх хувь нь бага зай эзэлдэг, үүнээс үүдэн бага барилга байгууламж шаардаг, нягтрал өндөртэй IT төхөөрөмж ашигладагтай холбоотой. Түүнчлэн, хүчин чадлаа цаг тухай бүрт нь тохирсон хэмжээгээр нэмж, барилгын ба ажиллах хүчний өртгийг хэмнэдэг.
Эрчим хүчний хэмнэлт өндөр	Ихэнх МДТ-ийг эрчим хүчний хэмнэлттэйгээр бүтээсэн байдаг. Тэдгээрийн дулааны ачаалал нь хөргөлтийн цагирагтай ойролцоо байх бөгөөд бага агаар шаардагддаг, температур ба чийгшлийг тохируулах хүрээ нь илүү өргөн байна. Мөн, зарим МДТ үйлдвэрлэгчид хөргөлтийн сэнсний ачааллыг хамгийн бага хэмжээнд бүтээж, нийтэд нь үлээх сэнс болон эрчим хүчний хуваарилах систем зэрэг шинэлэг шийдлийг ашиглан, эрчим хүч хэмнэдэг. Энэ бүгд нийлээд эрчим хүчний ба хөргөлтийн өртгийг багасгадаг. Үүнд платформын төстэй шийдлүүдийг хооронд нь харьцуулах үед, Грийн Гридийн эрчим хүчний хэсэгчилсэн хэрэглээний үр дүнгийн метрикс (pPUE™) хэмжүүрийг ашиглавал илүү нарийвчлалтай, тодорхой үнэлгээ өгч болно.
Хөрөнгө оруулалтын үр ашиг	МДТ-ийн өөрчилж, сольж болдог шинж чанар нь зээл авах боломжийг нэмэгдүүлдэг тул байгууллагын хувьд бэлэн мөнгийг үр ашигтай зарцуулах давуу талыг олгоно.
Ашиглалтын зардал	Эрчим хүчний бага өртөг, засварын оновчтой аргачлалууд ба нэгжид ногдох элэгдлийн зардал бага байдаг тул ашиглалтын нийт зардал буурдаг.
Зах зээлд орох хугацаа	Олон сая долларын дата төвийн барилгыг барихад шаардагдах санхүүгийн зардал ба цаг алдах эрсдлээс зайлсхийх арга бол угсарч суурилуулж болдог МДТ юм. Байгууллагууд үндсэн бизнестээ нөлөөлөхгүйгээр шинэ технологи туршиж үзэхийг хүсэх нь элбэг байдаг.

Суурилуулах зардал бага	МДТ үйлдвэрлэгчид урьдчилан үгсарч, инженер хөгжлийн серверүүд, нөөцлөх төхөөрөмжүүд ба сүлжээний тоноглолуудыг санал болгодог. Өртөг багатай, үйлдвэрийн орчинд бүрэн холбогдсон МДТ-ийг суурилуулах нь уламжлалт аргаар дата төв байгуулахаас бага зардалтай. Өөр нэг давуу тал бол алдаа бага гарах бөгөөд суурилуулалтын үеийн хүндрэл багасна. Учир нь, МДТ дотор ажиллаж мэргэшсэн хүмүүс угсралтын ажлыг үйлдвэрийн орчинд гүйцэтгэж, шалгаж туршдаг.
Эрсдлийг бууруулдаг	МДТ-ийг суурилуулах нь дата төв дэх холболттой холбоотой гардаг эрсдлийг бууруулна. Өөрсдөө холбож угсрахад гардаг алдааг залруулах, дутуу ажлыг гүйцээх ээрэг засварын эрсдлийг бууруулна.
Дахин ашиглах/сэргээх	МДТ нь байгууламжийн хувьд энгийн тоног төхөөрөмжийн ажиллах хугацаанаас өөр буюу насжилт илүү урт бөгөөд өөр зорилгоор ч ашиглах боломжтой. Модуль тус бүрийн ажиллах хугацаа өөр өөр бөгөөд солиход илүү хялбар, зөөж байрлалыг нь өөрчилж болно. МДТ-ийг бусдад зарж борлуулах, түрээслүүлэхэд илүү хямд байх боломжтой.

Эрсдэлтэй талууд

Хүснэгт 47. Модуляр дата төвийн эрсдэлтэй тал

Асуудал	Товч тайлбар
МДТ нь “тоосго-шавар” байгууламж буюу уламжлалт дата төвтэй харьцуулахад хамгаалалт султай	МДТ-ийн модулиудыг цоожтой, хүнд хаалгануудд, дохиоллын систем ашиглан уламжлалт “тоосго-шавар” барилгуудын адил аюулгүй хийж болно. Зарим байгууллагууд модулиудыг барилга дотор байршуулж, гадна талаар хашаа барьж, хамгаалагч хөлслөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Ер нь МДТ хамгаалалтын бүстэй байх хэрэгтэй ба нэвтрэх хяналт, хяналтын видео камерууд зэргээс авахуулаад дотно, гадна талын хамгаалалтуудыг маш сайн төлөвлөж хийснээр гадны санаатай болон санамсаргүй халдлагаас хамгаалах боломжтой. Бусад аюулгүй байдлын асуудалд гал, цаг агаарын ноцтой үзэгдэл, газар хөдлөлт болон том оврын тээврийн хэрэгслээр (ачааны машин, кран г.м.) гэмтээх зэрэг багтана. Галын аюулгүй байдлын хувьд МДТ-ийн бүрэлдэхүүн хэсэг бүр тусгаарлагдсан байдаг нь галыг тусгаарлахад маш их нөлөөтэй. МДТ-ийн нэгжүүд нь уламжлалт дата төвүүдтэй харьцуулахад гал унтраах систем нь илүү бөгөөд гадна талаас дотогшоо эсвэл дотор талаас гадагшаа гал тархахаас хамгаалж чаддаг. Ийм сайн тусгаарлалт нь байранд гал гарсны дараа богино хугацаанд модулийг дахин ашиглах боломжтой болгодог. Гэхдээ энэ нь МДТ галд тэсвэртэй, галын аюулгүй гэж ойлгож болохгүй, харин галын тархалтыг намжаахаар бүтээгддэг юм. Гамшгаас хамгаалах оновчтой төлөвлөгөө, аюулгүй байдлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлснээр эдгээр эрсдлийг бууруулж болно.
Тээвэрлэлтийн найдвартай байдал уламжлалт	МДТ-ийг хаана суурилуулахаас хамааруулан ачааны машин, усан тээвэр болон агаарын тээврийн аль боломжтойг сонгож тээвэрлэх (гэмтэж замаар тээвэрлэх нь ховор бөгөөд асуудал ихтэй байдаг.) Тээвэрлэлтийн

байгууламжтай харьцуулахад муу	эдгээр төрөл тус бүрт өөр өөр зураг төслийн шаардлагуудыг хангах хэрэгтэй. Үүнд хамгийн багадаа цохилт, доргилт, температурын хязгаар, чийгшлийн хязгаар, бүтцийн нийлмэл байдал зэрэг багтана. Үйлдвэрлэгч нь МДТ-ийг үйлдвэрлэх явцдаа тээвэрлэлтийн асуудлуудыг тусгадаг. Жишээлбэл, усан тээврийн үед боомтод ачиж буулгахдаа дээр дээрээс нь давхарлах болон тээвэрлэлтийн тусгай аргуудыг ашиглана гэдгийг тооцдог бол хөгжиж буй орон руу ачих МДТ-ийн модулиудыг муу замаар тээвэрлэнэ гэж тооцон зураг төслийг гаргадаг.
Найдвартай байдлын хүчин зүйлс их	МДТ-ийн модулиудыг суурилуулах арга барил нь олон хүчин зүйлсээс хамаарна. Үүнд, байгууллагын шаардлагууд, тухайн орчинд ашиглагдах аппликейшнүүд, модулийг суурилуулах газрын газар зүйн байрлал болон тухайн газрын уур амьсгал багтана. Эдгээр болон бусад олон хүчин зүйлс нь суурилагдсан МДТ-үүдийн найдвартай байдалд ихээр нөлөөлнө.
Жижиг орон зай	Өөр нэг тооцох ёстой зүйл бол модуль доторх орон зай юм. Зарим модулиудын эгнээ хоорондын зай ба хүн ажиллах бусад орон зай хязгаарлагдмал байж болно. Эдгээр хязгаарлалтуудыг (энэ нь тухайн нөхцөлд ач холбогдолтой эсвэл холбогдолгүй байж болно) тооцож, ажиллах орчин аюулгүй, үр дүнтэй байх нөхцлийг хангасан ашиглалтын аргачлал процедурыг боловсруулах хэрэгтэй.
Дадлага, туршлагатай ажилтнууд дутмаг	МДТ нь манай улсын хувьд шинэ зүйл тул МДТ-ийг амжилттай суурилуулах, найдвартай, үр дүнтэй ажиллагааг хангахад ажилтнуудыг зохих ёсоор сургаж, ашиглалтын арга хэрэгслээр хангах нь зүйтэй юм. Байгууллага үнэтэй, нарийн төвөгтэй тоног төхөөрөмж авахтай адил МДТ-ийг амжилттай ашиглахын тулд тухайн тоноглол хэрхэн ажилладаг, засвар үйлчилгээг хэрхэн гүйцэтгэх, модуль дотор ба түүнтэй хэрхэн зөв ажиллах талаар тогтмол сургалт явуулж, дадлагажуулах шаардлагатай.

СЗХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

Төслийн төсөв, санхүү

Татан төвлөрүүлэх хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн 2017-2021 оны хооронд хэрэгжүүлэх “Модуляр дата төвийн парк” төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ **1,338,798,000** төгрөг байна.

Хүснэгт 48. Татан төвлөрүүлэх хөрөнгийн ерөнхий задаргаа, төгрөгөөр

№	Хөрөнгө оруулалт	Нэгж	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хувь
1	Паркийн барилга	900 м.кв	550,000	495,000,000	37.0%
2	Цахилгааны систем	1	120,000,000	120,000,000	9.0%
3	Хөргөлтийн систем	1	80,000,000	80,000,000	6.0%
4	Тоног төхөөрөмж	1	119,000,000	119,000,000	8.9%
5	Гадна дэд бүтэц	1	151,900,000	151,900,000	11.3%
6	Контейнер модуль	1	345,000,000	345,000,000	25.8%
7	Тавилга, эд хогшил	1	27,898,000	27,898,000	2.1%
Нийт дүн				**1,338,798,000**	**100%**

Татан төвлөрүүлэх хөрөнгийн 37 хувь буюу 495.0 сая төгрөгөөр Модуляр дата төвийн паркийн барилгыг барих бөгөөд барилга нь 900 м.кв талбай бүхий нэг давхар барилгын нэгж м.кв-ын үнийг 550.0 мянган төгрөгөөр тооцоолсон нь барилгыг галд тэсвэртэй, тусгай зориулалт бүхий галын аюулгүй байдлын систем, өндөр чанартай цахилгаан болон компьютерийн сүлжээ, салхивчны системтэй байхаар тооцоолсонтой холбоотой юм. Паркийн барилга дотор контейнерэн модулиудыг байршуулж, нөөц цахилгааны систем болон хөргөлтийн системийг суурилуулна.

Гадна дэд бүтцэд цахилгаан, дулаан, ус суваг, мэдээлэл холбооны сүлжээний дэд бүтцүүд багтана. Эдгээр дэд бүтцийн ажлын тоо хэмжээ, бүрдэл нь Дархан-Уул аймгийн мэргэжлийн байгууллагуудаас гаргах техникийн нөхцлүүдэд үндэслэн тооцоологдох бөгөөд төслийн тооцоололд жишиг үнийг оруулсан оруулсан байна. Цахилгааны системд 120.0 сая төгрөг зарцуулах ба энэ нь цахилгааны шугам сүлжээ, цахилгаан хангамжийн нөөц байдлаар суурилуулагдах 300кВт-ын хүчин чадал бүхий дизель генератор, түүний автомат удирдлагын цогц байх юм. Хөргөлтийн систем нь контейнер, модуляр дата төвөөс ялгарч буй дулааныг гадагшлуулах зорилготой цогц систем байна.

Тоног төхөөрөмжид паркийн барилгад байрлаж буй модуляр дата төвийн контейнерүүдийг интернэт сүлжээнд холбох шаардлагатай тоног төхөөрөмжүүд, мөн сүлжээ, цахилгаан хангамж, температур, чийгшил зэргийг хянах зориулалт бүхий хяналтын өрөөний компьютер, тоног төхөөрөмжүүд багтах юм.

Хүснэгт 49. Тоног төхөөрөмжийн задаргаа, төгрөгөөр

№	Хөрөнгө оруулалт	Тоо, ширхэг	Нэгжийн үнэ,₮	Нийт үнэ, ₮
1	Антистатик шал	30	100,000	3,000,000
2	Рак	8	1,000,000	8,000,000
3	Цахилгаан баригч	2	4,000,000	8,000,000
4	Өргөгч кран	1	100,000,000	100,000,000
Нийт дүн				**119,000,000**

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ⚡ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ⚡ 5444381

Контейнер модуль буюу модуляр дата төв нь тусгайлан тоноглосон 20 тонны контейнер байх бөгөөд дотроо компьютерийн тоног төхөөрөмжийн хэсэг, хөргөлтийн хэсэг, тог баригчийн хэсэгтэй байна. Паркийн барилга нь 30 контейнер агуулах хүчин чадалтай байх ба энэхүү төслийн хугацаанд нэг модуляр контейнер худалдан авахаар төлөвлөсөн. Цаашид модуль нэмж худалдан авах эсхүл бусдын эзэмшлийн модулийг байршуулж үйлчилгээ үзүүлэх замаар модулиудын тоог аажмаар нэмж, дотоодын төдийгүй олон улсын хэмжээний газарзүйн нөөц модуляр дата төвийн паркийг бүтээхээр төлөвлөгөөтэй байна. Тиймээс, контейнерүүдийг өргөж, зөөж байршуулахад зориулагдсан 20 тн-40 тн өргөх хүчин чадалтай өргөгч кран худалдан авах юм.

Хүснэгт 50. Модуляр дата төвийн хүчин чадлын үзүүлэлт

Үзүүлэлт	Хүчин чадал
Физик хэмжээ (Урт х Өргөн х Өндөр)	6,068 мм х 2,438 мм х 2,896 мм
Компьютер, тоног төхөөрөмжийн хүчин чадал	24 кВт
Ракны тоо, рак юнитийн тоо	4 ш, 180U
Цахилгаан тэжээл	380В/50 Hz
Цахилгаан зарцуулалт	6 кВ/Рак
Тог баригч	20 кВольт Ампер, 2+1 нөөц
Тог барих хугацаа	10 минут
Хөргөлт	20 кВт, 2+1 нөөц
Гал эсэргүүцэх систем	Heptafluoropropane

Түүнчлэн, модуляр дата төвийн үйл ажиллагааг хянаж, удирдах, хамгаалах зориулалттай хяналтын өрөөг тохижуулахад зарим тавилга, эд хогшил шаардлагатай ба задаргааг дор харуулав.

Хүснэгт 51. Модуляр дата төвд шаардлагатай эд хогшлын жагсаалт

№	Эд хогшил	Тоо, ширхэг	Нэгжийн үнэ, ₮	Нийт үнэ, ₮
1	Компьютер /PC/	4	1,250,000	5,000,000
2	Компьютер /notebook/	2	1,500,000	3,000,000
3	Принтер	2	420,000	840,000
4	Тавилга /ширээ, шүүгээ, сандал/	10	498,200	4,982,000
5	Том шүүгээ	4	669,000	2,676,000
6	Сейф	2	700,000	1,400,000
7	Гаднах хаяг /гэрлэн/	1	3,000,000	3,000,000
8	Бусад тавилга	2	3,500,000	7,000,000
Нийт дүн				**27,898,000**

Төслийн хугацаан дах ашгийн тооцоолол

“Модуляр дата төвийн парк” төслийг хэрэгжүүлснээр үнэт цаас гаргагч нь 2017-2021 оны хооронд нийт 10.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 4.06 тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, төслийн эцэст 4.99 тэрбум төгрөгийн ашиг хуримтлуулсан байхаар төлөвлөсөн байна. Төслийн хугацаан дах борлуулалтын орлого, зардал болон ашгийн үзүүлэлтийг дорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 52. Үнэт цаас гаргагчийн 2017-2021 оны орлогын тэсөөлөл, мянган төгрөгөөр

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Үндсэн үйл ажиллагааны борлуулалт	616,821	832,708	1,082,521	1,380,214	1,725,268	5,637,532
Модуляр дата төвийн борлуулалт	246,000	743,400	1,098,090	1,403,042	1,473,194	4,963,725
Нийт борлуулалт	**862,821**	**1,576,108**	**2,180,611**	**2,783,256**	**3,198,461**	**10,601,257**
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	108,578	146,580	190,554	242,956	303,695	992,363
Нийт ашиг (алдагдал)	**754,243**	**1,429,528**	**1,990,057**	**2,540,299**	**2,894,766**	**9,608,894**
Үйл ажиллагааны зардал	578,769	766,324	844,338	913,513	957,101	4,060,043
Үйл ажиллагааны цэвэр ашиг/алдагдал	175,475	663,205	1,145,719	1,626,787	1,937,665	5,548,851
Татвар, 10%	17,547	66,320	114,572	162,679	193,767	554,885
Цэвэр ашиг (алдагдал)	**157,927**	**596,884**	**1,031,147**	**1,464,108**	**1,743,899**	**4,993,966**
Хуримтлагдсан цэвэр ашиг (алдагдал)	157,927	754,811	1,785,959	3,250,067	4,993,966	-

Үнэт цаас гаргагч нь 2017 оноос хоёр төрлийн шинэ бүтээгдэхүүнийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр эхний жилүүдэд борлуулалтын орлого өндөр өсөлттэй байх ба төслийн эцэст үйл ажиллагаа тогтворжиж, борлуулалтын орлогын өсөлтийн хувь буурч байна. Төслийн цэвэр ашгийн хэмжээ борлуулалтын орлогын хэмжээтэй уялдан тогтмол өсөхөөр байна. Төслийн хугацаанд нийт 554.8 сая төгрөгийн татварыг улсын төсөвт оруулахаар харагдаж байна.

График 22. Борлуулалтын орлогын өсөлт /сая.төг/



Ирээдүйн борлуулалтын орлогын төсөөлөл

Айтүүлс ХХК нь 2016 оны эцсийн байдлаар 474.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 18.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Төслийн хүрээнд буюу 2017-2021 онд нийт 10.6 тэрбум төгрөг бүхий борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөсөн. Үүний 53.2 хувь буюу 5.63 тэрбум төгрөгийн орлого нь одоогийн үндсэн үйл ажиллагаанаас олох орлого, 46.8 хувь буюу 4.96 тэрбум төгрөг нь Дархан-Уул аймагт байгуулах Модуляр дата төвийн паркийн үйл ажиллагаанаас орох орлого байна.

Хүснэгт 53. Үнэт цаас гаргагчийн 2017-2021 оны борлуулалтын төсөөлөл, мянган төгрөгөөр

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Үндсэн үйл ажиллагааны орлого	616,821	832,708	1,082,521	1,380,214	1,725,268	5,637,532
Хостын орлого	129,547	174,888	227,354	289,877	362,346	1,184,012
Домэйний орлого	130,454	176,113	228,947	291,908	364,885	1,192,307
VPS	124,465	168,028	218,436	278,506	348,132	1,137,566
Сервер байршуулалт	64,904	87,621	113,907	145,232	181,540	593,204
SSL	6,020	8,128	10,566	13,472	16,840	55,025
И-мэйл	27,912	37,682	48,986	62,457	78,072	255,109
Сервер түрээсийн орлого	49,685	67,075	87,198	111,177	138,972	454,108
Суурилуултын орлого	11,582	15,636	20,327	25,916	32,396	105,857
Бусад орлого	72,250	97,538	126,799	161,669	202,087	660,344
Модуляр дата төвийн орлого	246,000	743,400	1,098,090	1,403,042	1,473,194	4,963,725
Нийт борлуулалт	**862,821**	**1,576,108**	**2,180,611**	**2,783,256**	**3,198,461**	**10,601,257**

Үндсэн үйл ажиллагааны орлого: Үнэт цаас гаргагч нь 2017 онд 862.8 сая төгрөгийн борлуулалт хийхээс 63.1 хувийг одоо явуулж буй үйл ажиллагаанаас, 8.4 хувийг бусад үйл ажиллагаанаас, 28.5 хувийг Модуляр дата төвийн паркийн төслийг хэрэгжүүлснээр хийхээр төлөвлөсөн байна. Модуляр дата төвийн үйл ажиллагааг 2017 оны 7-р сараас эхлүүлэхээр төлөвлөсөн тул 2017 оны орлого бага харагдаж байна. Өмнөх жилүүдэд компанийн борлуулалтын орлого дунджаар 95 хувийн өсөлттэй байсан бөгөөд төслийн таамаглалыг хийхдээ үндсэн үйл ажиллагааны борлуулалтын өсөлтийг жилд дунджаар 25-40 хувь байхаар бууруулан тооцоолсон. Айтүүлс ХХК нь үндсэн үйл ажиллагаанаас гадна аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн захиалга болон тендер шалгаруулалт зэрэг ажлуудыг бие даан болон хамтран гүйцэтгэж, бусад орлого олдог. Тухайлбал, 2016 онд 99.5 сая төгрөгийн бусад орлого олж байсан бөгөөд 2017 оноос сүүлийн 5 жилийн дундаж орлогын хэмжээгээр бууруулан тооцвол төслийн хугацаанд нийт 660.3 сая төгрөгийн бусад орлого олохоор байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын 42 хувийг вэб хостинг, домэйний борлуулалт, 30 хувийг VPS, сервер байршуулалтын орлого, 8 хувийг сервер түрээс, 8 хувийг SSL, суурилуулт, и-мэйлийн орлого эзлэж байгаа бол үлдсэн 12 хувийг бусад орлого эзлэж байна.



Модуляр дата төвийн үйлчилгээ: Шинэ үйлчилгээ болох модуляр дата төвийн паркийн хувьд төслийн хугацаанд контейнер модулиудыг худалдан авч сервер түрээслүүлэх болон бусад байгууллагын контейнер/модуляр дата төвийг байршуулж, хяналт, хамгаалалт, техникийн тусламжийн үйлчилгээг үзүүлэх юм. Энэхүү үйлчилгээ нь Монгол Улсад анх удаа хийгдэх гэж байгаа нь онцлог бөгөөд үнэт цаас гаргагч нь тус үйлчилгээг томоохон байгууллага, аж ахуйн нэгжүүдэд үзүүлж, зах зээл дээрх өөрийн байр суурийг бэхжүүлэх боломжтой юм.

Байршуулалтыг жил бүр үе шатлалтайгаар өсгөх замаар модуляр дата төвийн борлуулалтын орлогыг өсгөхөөр төлөвлөсөн байна. Тус модуляр дата төвийн парк нь 30 хүртэлх стандарт контейнерийг байршуулах багтаамжтай ба төслийн хугацаанд 15 контейнер байршуулахаар төлөвлөсөн.

Модуляр дата төв нь зөөвөрлөж болдог тул түүний түрээслүүлэх үйлчилгээ нь заавал парк дотор байх албагүй ба паркийн барилгыг ашиглалтанд оруулахыг хүлээлгүй, төсөл хэрэгжиж эхэлмэгц шинээр худалдан авсан модуляр дата төвийг түрээслүүлж эхлэх боломжтой юм. Төслийн хугацаанд модуляр дата төв байршуулах болон түрээслүүлэх үйлчилгээнээс нийт 4.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олохоор төлөвлөж байна.

Хүснэгт 54. Модуляр дата төвийн 2017-2021 оны борлуулалтын төсөөлөл, мянган төгрөгөөр

Дата төвийн борлуулалт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Нийт борлуулалт	**246,000**	**743,400**	**1,098,090**	**1,403,042**	**1,473,194**	**4,963,725**
Контейнер байршуулах	180,000	604,800	952,560	1,250,235	1,312,747	4,300,342
Нэгж үнэ	6,000	6,300	6,615	6,946	7,293	33,154
Контейнер модулийн тоо	5	8	12	15	15	15
Түрээсийн үйлчилгээ	66,000	138,600	145,530	152,807	160,447	663,383
Нэгж үнэ	11,000	11,550	12,128	12,734	13,371	60,782
Контейнер модулийн тоо	1	1	1	1	1	1

Түүнчлэн, Монголбанкнаас 2017 онд “Банкны мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн журам”-ыг боловсруулан, мөрдүүлэх гэж буйтай холбогдуулан, үнэт цаас гаргагчийн Дархан хотод барих гэж буй газарзүйн нөөц дата төвөөр үндэсний томоохон аж ахуйн нэгжүүд болох арилжааны банкууд үйлчлүүлэх боломж нэмэгдэнэ гэж тооцолж байна. Одоогоор Монгол Улсад дараах 14 банк үйл ажиллагаа явуулж байна.

- Голомт банк
- Худалдаа хөгжлийн банк
- Төрийн банк
- Хас банк
- Хаан банк
- Улаанбаатар хотын банк
- Ариг банк
- Богд банк
- Капитрон банк
- Капитал банк
- Кредит банк
- Үндэсний хөрөнгө оруулалтын банк
- Чингис хаан банк
- Тээвэр хөгжлийн банк
- Хөгжлийн банк

Эдгээр банкнаас ихэнх нь одоогоор нөөц төв ажиллуулдаггүй бөгөөд Монголбанкны журам батлагдан, мөрдөгдөж эхэлбэл шинээр барих гэж буй нөөц дата төвийн гол үйлчлүүлэгчид нь арилжааны банкууд байх боломжтой гэж үзэж байна. Үүнтэй холбоотойгоор үнэт цаас гаргагчийн нөөц дата төвийн жилийн борлуулалтын орлогын таамаглалыг тооцоолохдоо нийт орлогын 50 орчим хувийг арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага болон бусад санхүүгийн байгууллагуудаас бүрдүүлэхээр тооцоолсон. Тэдгээрийн хэрэглээ нь 2-4 rack тоног төхөөрөмж түрээслэхээс эхлээд бүтэн контейнер байршуулах үйлчилгээ, мөн түүнийг дагасан өндөр хурдны дотоод урсгалын ашиглалт байхаар тооцоолов. Модуляр дата

СЗХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 91

төвийн борлуулалтын орлогын 30 хувийг мэдээллийн технологид суурилсан компаниудаас гадна томоохон аж ахуйн нэгжүүд бүрдүүлнэ гэж төсөөлж байна. Учир нь томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьд нөөцийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулахын тулд сүүлийн үед ERP системд (Enterprise Resource Planning software) суурилж үйл ажиллагаа явуулах нь нэмэгдэж байгаа бөгөөд энэ системийг тасралтгүй хэвийн ажиллуулах, түүнээс үүсэх мэдээлэл, өгөгдлийг аюулгүй найдвартай хадгалах хэрэгцээ үүсч байгаа юм. Дата төвийн орлогын үлдсэн 20 хувийг эрчим хүч, эрүүл мэнд, бүртгэл мэдээллийн байгууллагууд зэрэг дата өгөгдөл ихтэй төрийн байгууллагуудаас бүрдүүлэх боломжтой гэж тооцоолсон.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУС
5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

Эрсдлийн шинжилгээ

ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД **ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ** ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Хувьцаанд хөрөнгө оруулах нь ямагт эрсдэлтэй байдаг тул дор дурдсан эрсдлийн хүчин зүйлстэй сайтар уншиж танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна. Дор дурдсан эрсдлийн хүчин зүйлсээс гадна хүсэлт гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлж болох өөр эрсдлүүд үүсэх боломжтойг анхаарна уу. Урьдчилан тодорхойлох боломжгүй, гэнэтийн, эрсдэл гэж тооцоогүй зэрэг энд тодорхойлоогүй эрсдлүүд нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт, ирээдүйн ашигт сөргөөр нөлөөлөх боломжтой ба энэ нь үнэт цаасны ханшид нөлөөлж, хувьцааны ханш буурвал хөрөнгө оруулагч өөрийн оруулсан бүх хөрөнгө эсвэл хөрөнгийн зарим хэсгийг алдах эрсдэлтэйг анхаарна уу.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй мэдээллийн технологийн салбар болон шинээр барих гэж буй модуляр дата төвийн үйл ажиллагаа нь шинэлэг, төдийлөн судлагдаагүй тул таамаглаагүй эрсдлүүд гархах магадлал их юм. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрсдлийн төрлүүд, тэдгээрийн магадлал, урьдчилан сэргийлэлт, эрсдлийг хэрхэн бууруулах талаар тодорхой тусгасан байх шаардлагатай.

Төрийн бодлого, улс төрийн нөхцөл байдалтай холбоотой үүсэх эрсдэл

Мэдээллийн технологийн салбарт төрөөс баримталж буй одоогийн бодлого, чиглэлд өөрчлөлт орох эрсдэлтэй. Хэдийгээр манай улсын хувьд улс төрийн байдал харьцангуй тогтвортой ч төрийн бодлого, хууль эрх зүйн орчин сонгуулийн үр дүнгээс хамааран өөрчлөгдөх, мөн засгийн газар хугацаанаасаа өмнө солигдох эрсдэл байдаг. Төсөл хэрэгжиж эхлэх 2017 онд Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль тохиож байгаа тул улс төрийн өөрчлөлт, төрийн үйл ажиллагаанд удаашралт гарах эрсдэл бий. Улс төрийн хөдөлгөөн, үймээн самуун гарч эмх замбараагүй байдал үүсэхийг үгүйсгэхгүй.

Хууль эрх зүйн орчин, хяналт, зохицуулалттай холбоотой эрсдэл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь Компанийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Татварын тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Стандартчилал тохирлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Иргэний

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУЛС ХХК
УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
ТТС3981 ☎ 5444381

хууль, Барилгын тухай хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль зэрэг хууль, холбогдох дүрэм, журам, норм стандартын хүрээнд зохицуулагддаг. Эдгээр хууль эрх зүйн зохицуулалтанд аливаа өөрчлөлт орох, тухайлбал стандарт өөрчлөгдөх, татвар, шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдэх зэрэг гэнэтийн хориг, дүрэм, журам батлагдвал хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа, бизнесээс олох ашигт нөлөөлөх эрсдэлтэй.

Түүнчлэн, дата төвийн барилга байгууламжид тавих улсын стандарт норм өөрчлөгдөх зэрэг нь үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Бизнесийн салбар, эдийн засгийн эрсдэл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд макро болон микро эдийн засгийн тогтворгүй байдал, хямрал сөргөөр нөлөөлнө. Тухайлбал, дараах нөхцөл байдал үүсэх нь эрсдэл дагуулна. Үүнд:

- Төсөв, мөнгөний бодлого өөрчлөгдөх
- Валютын ханшийн тогтворгүй байдал
- Үнийн өсөлт, инфляци
- Ажилгүйдлийн түвшин
- Түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзэл, нийлүүлэлт багасах
- Бүтээгдэхүүний эрэлт багасч, үнэ буурах

Бизнесийн салбарын хувьд тасралтгүй өсөн нэмэгдэж буй хүний хэрэглээ, техник технологийн дэвшил, хүмүүсийн амьдралын хэвшил, мэдлэг мэдээлэлд илүү ач холбогдол өгөх чиг хандлагатай холбоотойгоор тухайн салбарт бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдэж, зах зээлд хүчтэй өрсөлдөөнийг бий болгох нь салбарын эерэг болоод эрсдэлтэй тал байж болох юм.

Компанийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл

Мэдээллийн технологийн салбарын дэд бүтэц болох дата төвийн үйл ажиллагаа нь өндөр технологитой учир мэргэшсэн боловсон хүчин, технологийн нарийн ажиллагаа, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм журмууд, тэдгээрийн хэрэгжилтээс компанийн хэвийн ажиллагаа ихээхэн шалтгаалдаг. Үнэт цаас гаргагчийн хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ харилцагчдад борлуулсны дараа үйл ажиллагааг нь доголдуулахгүйн тулд үйлчилгээгээ байнга, тасралтгүй хэвийн явуулахыг шаардсан өндөр хариуцлага хүлээдэг. Тухайлбал, дата төвийн байнгын тогтмол ажиллагаанд интернэт сүлжээний тасалдал, цахилгаан хангамжийн доголдол, тоног төхөөрөмжүүдийн хөргөлтийн систем хэвийн ажиллагаа, системийн инженерүүдийн ажлын хариуцлага, 24 цагийн үйлчилгээ зэрэг маш олон хүчин зүйлс шууд нөлөөлдөг. Вэб байршуулах, сервер байршуулах, өгөгдөл мэдээлэл хадгалах үйл ажиллагаа нь орон зай, цаг хугацаа, улирлын чанараас үл хамааран тасралтгүй байж, байнгын сайжруулалт, хөгжүүлэлт хийж байхыг шаарддаг. Эдгээрийг цаг алдалгүй зөв шийдвэрлэх нь харилцагчийн итгэлийг бататгадаг ба хэрэв үйл ажиллагаа доголдож, үйлчилгээний чанар муудвал зах зээлд өрсөлдөх чадвараа богино хугацаанд алдах эрсдлийг үүсгэнэ. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, дата төвийн барилгын технологийн зөв шийдэл, ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн чанар нь

СЗХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

чухал ач холбогдолтой. Тиймээс, технологийн шийдэл болон тоног төхөөрөмжийн чанараас шалтгаалан үйл ажиллагаанд эрсдэл үүсэх боломжтой.

Компанийн менежмент, зохион байгуулалтын буруу хэв загвар нь дотоод эрсдлийг бий болгодог. Иймд үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааныхаа онцлогт зохицсон зөв менежментийн бодлогыг боловсруулан, үйл ажиллагааны доголдол үүсгэхгүйн тулд тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, ажилтны хариуцлага, үйл ажиллагаанд шаардагдах стандарт, цогц дүрэм, журмуудыг боловсруулан мөрдөх шаардлагатай.

Компанийн удирдлага, засаглалаас шалтгаалах эрсдэл

Компанийн гүйцэтгэх удирдлагын бодлого шийдвэр, менежментийн хэв маяг нь бизнесийн ашиг, маркетинг, хүний нөөцийн бодлого, нийгмийн хариуцлага гэх мэт компанийн бүх үйл ажиллагаа, нэр хүндийг тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэхэд нөлөөтэй. Нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчид болон гүйцэтгэх удирдлагын хооронд эрх ашиг, сонирхлын зөрчил үүсэх асуудал ч байдаг. Тиймээс, гүйцэтгэх удирдлагын ажлын туршлага, багийн буруу бодлого /санаатай болон санамсаргүй/, алдаатай шийдвэрээс шалтгаалан компанийн үйл ажиллагаа доголдох, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хөндөгдөх эрсдэл байхыг үгүйсгэхгүй. Түүнчлэн, компанийн хувьцааны хяналтын багц эзэмшигчид нэгж хувьцаанд ногдох саналын эрхийн дагуу аливаа бодлого шийдвэр гаргахад давамгайлж, жижиг хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөх эрсдэл байдаг. Компанийн сайн засаглал, соёлыг зөв бүрдүүлэх, хувьцааны төвлөрлийг бууруулах, хууль журмын дагуу ажиллахыг шаардах, хяналт тавихад хувьцаа эзэмшигчид идэвхтэй оролцож, эрхээ хэрэгжүүлэх хэрэгтэй байдаг. Мөн, гүйцэтгэх удирдлага, тэр дундаа шинээр байгуулагдах Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг, ажлын зохион байгуулалтыг компанийн дүрэм, журамд тодорхой тусгаж, гишүүдийг Компанийн засаглалын сургалтанд суулгах зэргээр компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх шаардлагатай.

Техник, технологитой холбоотой эрсдэл

Техник, технологийн хөгжил асар хурдацтайгаар урагшилж байгаа өнөө үед мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт техник, технологийн хоцрогдол нь үйл ажиллагааны бүтээмж, зах зээлийн өрсөлдөх чадварыг бууруулах гол хүчин зүйлд тооцогддог. Ялангуяа, мэдээллийн технологийн салбарын хөгжлийн чухал дэд бүтэц болох дата төвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас гаргагчийн хувьд технологийн хоцрогдолд орох эрсдэл их. Тиймээс, энэ тал дээр байнга судалгаа явуулан хөгжүүлэлт хийж, технологийн хөгжилтэй хөл нийлүүлж байх нь чухал юм.

Хөргөлтийн систем, цахилгааны тасралтгүй, найдвартай ажиллагаа нь дата төвийн үйл ажиллагааны суурь үндэс юм. Дата төвийн тоног төхөөрөмжийн байнгын ажиллагаа нь халалтыг бий болгодог тул тоног төхөөрөмжүүдийг тохиромжтой хэмд байлгах болон цахилгаанаар тасалдуулахгүй зэрэг техникийн шаардлагууд байнга тулгарч байдаг бөгөөд эдгээрт ихээхэн хөрөнгө оруулалт хийгддэг. Хөргөлтийн системийн доголдлоос хамаарч бүх

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
2017
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

сервер, тоног төхөөрөмжүүдэд хэт халалт үүсч, улмаар шатах аюул тулгарч болох бөгөөд цахилгаан, эрчим хүчний тасалдлаас үйл ажиллагаа зогсох магадлалтай. Иймд техник, технологийн шийдлийг хамгийн оновчтой хэлбэрээр хийж, технологи өндөр хөгжсөн бусад улс орнуудын туршлагыг судлан, үйл ажиллагаандаа нэвтрүүлж байх нь зөв бөгөөд техник, технологийн анхаарал хандуулаагүйгээс үүдэн бүтээгдэхүүний өртөг өндөр гарах, ашигт ажиллагаа буурах эрсдлүүд гарч болно.

Өрсөлдөгчидтэй холбоотой эрсдэл

Мэдээллийн технологийн салбарын дэд бүтэц болох дата төвийн чиглэлээр үнэт цаас гаргагчтай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагууд одоогоор харьцангуй цөөн байгаа ч цаашид шинээр өрсөлдөгчид зах зээлд орж ирэх бүрэн боломжтой юм. Учир нь дата төвийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхэд зохицуулах байгууллагын зүгээс тусгай зөвшөөрөл шаарддаггүй, ажиллагаа, өртөг зардлын хувьд тийм ч нүсэр биш болно. Иймд одоогоор Монголд Улсад цөөн хэдэн аж ахуйн нэгж дата төвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Мэдээллийн технологи, дата төвийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй компаниуд эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд, дотоодын томоохон аж ахуйн нэгжүүд хүчин чадал, дэвшилтэт технологийн давуу талыг ашиглан, тус зах зээлд түрэн орж ирэх боломжтой. Энэ нь үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагааг бууруулах магадлалтай юм.

Санхүүгийн эрсдэл

Санхүүгийн эрсдэлд төслийн санхүүжилтийн мөнгөн урсгал, гадаад валютын ханшийн хэлбэлзэл, тоног төхөөрөмж болон ажил үйлчилгээний үнийн хэлбэлзэл, мэдээллийн технологийн үйлчилгээний үнийн хэлбэлзэл, цаг хугацаатай холбоотой компанийн ашигт ажиллагаанд нөлөөлж болох аливаа эрсдэл орно. Тухайлбал, анхдагч зах зээлд хувьцаа гаргах ажиллагаа нь эдийн засгийн болон зах зээлийн хүндрэлтэй байдлаас хамаарч цаг хугацаандаа амжихгүй, хөрөнгө оруулалтаа бүрэн татаж чадахгүй байх эрсдэл үүсч болно. Түүнчлэн, бүтээгдэхүүн үйлчилгээний өртөг нэмэгдэх, компанийн борлуулалт буурах, хэрэглэгчдийн худалдан авах чадвар муудах зэрэг нь санхүүгийн эргэлтийг багасгах эрсдлийг дагуулна.

Санхүүгийн эрсдэл

	Эрсдлийн төрөл	Эрсдлийн түвшин	Эрсдлийн магадлал	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ
1	Санхүүжилтийн эрсдэл	Өндөр	Дунд	Анхдагч зах зээлийн арилжаа төлөвлөсний дагуу хэрэгжээгүйгээс үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө дутах, үйл ажиллагааны явц удаашрах, эсвэл амжилтгүй болох гэх мэт санхүүжилтийн эрсдэл тулгарч болно. Үүнийг урьдчилан тооцоолж, санхүүжилтийн хуваарь, үе шатыг нарийн төлөвлөж, хувилбаруудыг гаргах хэрэгтэй.
2	Тоног төхөөрөмжийн	Дунд	Дунд	Модуляр дата төвийг болон тоног төхөөрөмжийг бүгдийг гадаадаас импортоор авах тул валютын

	үнийн өсөлт			ханшаас хамааралтай үнийн өөрчлөлт гарч болно. Тиймээс, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээс цогцоор нь худалдан авч үнийн хувьд хөнгөлөлт эдлэх боломжийн талаар хэлэлцээр хийж, гэрээ байгуулан баталгаажуулах.
3	Ажил, үйлчилгээний үнийн өсөлт	Дунд	Бага	Модуляр дата төвийн гадна барилгыг барих ажлын өртөг өсөх, төлөвлөсөн хугацаа, төсөвт багтаан хийж чадахгүй, хугацаанаасаа хойшлох эрсдэлтэй тул гүйцэтгэгч компанитай гэрээ хийж баталгаажуулсан байх.
4	Гадаад валютын ханшийн өсөлт	Өндөр	Өндөр	Улсын гадаад валютын нөөцтэй холбоотойгоор долларын ханш тогворгүй байгаа тул ханшийн өсөлтийг урьдчилан таамаглаж, зохих валютаар хөрвүүлэн төлбөр төлөгдөх хүртэл хадгалах.
5	Татварын өөрчлөлт	Өндөр	Бага	Цаашид улсын төсөвт татварын хэмжээ, төрлийг нэмэгдүүлж болзошгүй ч хөнгөлөлт үзүүлэх ч боломжтой.
6	Цаг хугацааны эрсдэл	Бага	Бага	Санхүүжилт хуваариас хоцрох, гүйлгээ саатах гэх мэт төлөвлөгөөт орлого орж ирэхтэй холбоотой эрсдлийг бууруулах үүднээс худалдан авалтын хуваарийг оновчтой гаргах, хөрөнгө оруулагчдад танилцуулах.

Хүний нөөцтэй холбоотой үүсч болох эрсдэл

Үнэт цаас гаргагч нь мэргэжлийн чадварлаг баг хамт олныг бүрдүүлж, тэдгээр ажилтнуудыг тогтвортой сайн ажиллуулахын тулд сурган, мэргэшүүлэх нь чухал ач холбогдолтой бөгөөд инженер техникийн ажилчдын ур чадвар, ажлын хариуцлагаас үүсэх үйл ажиллагааны эрсдлүүдийг бууруулах боломжтой юм. Үйл ажиллагаанд шаардагдах мэргэжилтнүүдийг бэлтгэж, хүний нөөцийн цогц бодлого боловсруулж ажиллах шаардлагатай бөгөөд системийн инженер, системийн администратор зэрэг мэргэжилтнүүд нь маш чухал үүрэгтэй. Мэдээллийн технологийн мэргэжлээр Монгол Улсад олон хүн төгсдөг ч мэргэшсэн, чадварлаг ажилтан олох болон сургаж мэргэшүүлэхэд цаг хугацааны хувьд хүндрэл гардаг.

Үйл ажиллагаанд бүх түвшний ажилтнуудад тогтвортой ажиллах нөхцлийг нь бүрдүүлж чадсан байх нь үйл ажиллагааны зардлыг хэмнэх болон бүтээмж өндөртэй ажиллах үндсэн нөхцөл болдог. Чадварлаг мэргэжилтнүүддээ урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлсэн таатай ажлын байрыг бүрдүүлж, хүний нөөцийн зөв бодлого явуулж, улмаар ажилдаа хариуцлагатай хандахад чиглэгдсэн хариуцлагын тогтолцоог нэвтрүүлж, түүнийг тусгасан урт хугацааны хөдөлмөрийн гэрээг байгуулах нь чухал юм. Үнэт цаас гаргагчийн хувьд Хөдөлмөрийн дотоод журам болон бусад дотоод дүрэм, журмуудыг боловсруулан, үйл ажиллагаандаа мөрдөж хэвшсэн байна.

Үнэт цаасны зах зээлтэй холбогдон үүсч болох эрсдэл

Үнэт цаасны зах зээлтэй холбоотой эрсдэлд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжүүлэлт, санхүүжилт босгохтой холбоотой эрсдлүүдийг дурдаж болно. Үүнд, хөрөнгийн зах зээлээс

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

татахаар төлөвлөсөн хөрөнгийг татаж чадахгүй байх, зах зээлд гаргасан хувьцааны үнийн хэлбэлзэл, арилжааны идэвх, хөрвөх чадвар муу байх асуудлууд орно. Хувьцааны ханшийн өсөлт, бууралт нь хөрөнгө оруулагчдад таатай болон таагүй нөхцөл байдлыг үүсгэж байдаг. Компанийн үйл ажиллагаа, цаашдын хэтийн төлөвтэй холбоотой сайн мэдээ, мэдээлэл олон нийтэд хүрэх тэр үед зах зээлийн үндсэн зарчмаар компанийн хувьцааны эрэлт нэмэгдэж, нийлүүлэлт багасан хувьцааны ханш өсдөг. Тэгвэл хүсэлт гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой таагүй мэдээлэл, тайлан гарах, зах зээлийн орчин нөхцөл өөрчлөгдөх зэрэгт хөрөнгө оруулагчдын хувьцаа худалдан авах сонирхол буюу эрэлт багассанаар зах зээлийн зарчмын дагуу нийлүүлэлтийн илүүдлээс үүдэлтэй ханшийн бууралт явагддаг.

Нээлттэй хувьцаат компани болсноор үнэт цаасны зах зээлтэй холбоотой олон тооны дүрэм, журмуудыг мөрдөж, шаардлагатай шимтгэл хураамжийг төлөх, тайлан мэдээллийг олон нийтэд хүргэж байх хэрэгтэй болно. Энэ бүхнийг хуулиар заасан хугацаанд амжихгүй байх эрсдэл гарч болох ч энэ асуудлыг хариуцсан тусгай ажилтан томилж, ажлын төлөвлөлтөнд тусгаж өгснөөр шийдвэрлэж болно.

Давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл

Газар хөдлөлт, хөрсний гулгалт, үер гэх мэт байгалийн гамшиг, гал түймэр, халдварт өвчин, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн гэх мэт онцгой байдал, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Иймд үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц бүх нөхцөл байдлыг урьдчилан тооцоолж сэргийлэх, давагдашгүй хүчин зүйл тохиох үед хамгаалах тодорхой нөөц хэрэгсэл, гамшигт үзэгдлийн үед авах арга хэмжээ, хохирлыг бууруулах арга замуудыг төлөвлөсөн бэлэн байдлын бодлоготой байх нь чухал. Давагдашгүй хүчин зүйлсийг даван туулах зорилгоор нийт үйл ажиллагааны зардлын тодорхой хувийг тооцоолж, төсөвт тусгах, мэдээ мэдээллийн аюулгүй байдлыг хангаж давхар “backup” хийх шаардлагатай. Мөн хариуцлагын даатгал, машин механизм, тоног төхөөрөмжийн даатгал, санхүүгийн даатгал гэх мэт даатгалд даатгуулах, харилцагчдын мэдээллийг найдвартайгаар хадгалах гадаад болон дотоодын өөр байршил дах сервертэй холбогдох нөхцлийг хангаж, хохирлын хэмжээг тодорхой хэмжээгээр бууруулах боломжтой.

Аюулгүй байдлын эрсдэл

Үнэт цаас гаргагчийн эрхэлж буй бизнест аюулгүй байдал чухал ач холбогдолтой. Дата төвийн үйл ажиллагаа 24 цагийн турш тасралтгүй байх шаардлагатай, мөн төвд харилцагчдын дотоод чухал болон нууц мэдээлэл байршдаг тул найдвартай, аюулгүй байдлыг дээд зэргээр хангах шаардлагатай юм. Дата төвөөс мэдээлэл алдагдах, үйл ажиллагаа нь гадны санаатай болон санамсаргүй халдлагаас болж тасалдах эрсдэл байдаг. Эдгээрээс урьдчилан сэргийлэхийн тулд хяналт, хамгаалалтын давхар давхар тогтолцоо бий болгох нь чухал юм.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТУУЛС
ХХК
116218269 ⚡ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ⚡ 5444381

ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Монголын хөрөнгийн биржийн “Бүртгэлийн журам” болон “Анхдагч зах зээлийн арилжааны журам”, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн “Үнэт цаасны төлбөр, тооцоог Т+1 системээр гүйцэтгэх түр журам”-д тус тус үндэслэн үнэт цаасаа олон нийтэд анх удаа санал болгож байна.

Үнэт цаас гаргагч нь 2016 оны 11-р сарын 10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 14 тоот тогтоолоор Дархан хотод Модуляр дата төвийн парк байгуулахад зориулан олон нийтээс хөрөнгө татан, нээлттэй хувьцаат компани болохоор шийдвэрлэсэн. Улмаар 2017 оны 3-р сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 08 тоот тогтоолоор 13,387,980 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган, 100.00 төгрөгөөр анхдагч зах зээлд санал болгохоор тогтоосон. Энэ нь нийт хувьцааны 38.86 хувь ба нийт 1,338,798,000 төгрөг татан төвлөрүүлж, газарзүйн нөөц байршилд Модуляр дата төвийн парк байгуулна.

ҮНЭТ ЦААСНЫ НЭР	АЙТҮҮЛС
ҮНЭТ ЦААСНЫ ТӨРӨЛ	ЭНГИЙН ХУВЬЦАА
ҮНЭТ ЦААСНЫ НЭРЛЭСЭН ҮНЭ	43.00 ТӨГРӨГ
НИЙТ ГАРГАСАН ТОО ШИРХЭГ	21,064,144
НЭМЖ ГАРГАЖ БУЙ ҮНЭТ ЦААС — ТОО ШИРХЭГ	13,387,980
НЭМЖ ГАРГАЖ БУЙ ҮНЭТ ЦААС — ХУВЬ	38.86%
ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭ	100.00 ТӨГРӨГ
АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ АРГА	ТОГТООСОН ҮНЭЭР САНАЛ БОЛГОХ АРИЛЖААНЫ АРГА

Үнэт цаас эзэмшигчдийн эрх, үүрэг

Айтүүлс ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм болон хувьцаат компанийн дүрмийн төсөлд зааснаар дараах **ЭРХҮҮДИЙГ ЭДЭЛНЭ**. Үүнд:

- Бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
- ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хуваарилаагүй бол алданги төлөхийг шаардах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу компанийн нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхтэй.
  Үүнд:
  - Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;
  - Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;
  - Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
  - Хувьцаа эзэмшигч дангаарай эсвэл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компаниас хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй;
- Хувьцаа эзэмшигч нь компаниас дорх мэдээллийг шаардан авах эрхтэй. Үүнд:

- Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах;
- Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшилийн хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн дүрэм журмаар тогтоосон бусад мэдээлэлтэй танилцах;
- Компанийн бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшилийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардах эрхтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч хариуцана;

- Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;
- Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх;
- Энгийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах;
- Хувьцаа эзэмшигч нь дорх үндэслэлээр Санхүүгийн зохицуулах хороо болон шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхтэй;

Үүнд:

- Компанийн тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам, компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаагүй тохиолдолд гомдол гаргах;
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлага нь компанийн тухай хуулийн 84.4-т заасан үүргээ биелүүлээгүй бол уг албан тушаалтанаар компанид учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах;
- Компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанид учруулсан хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах;
- Компанийн энгийн хувьцааны эзэмшигч нь сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компани, түүний хараат болон охин компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах;

- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад эрх.

Компанийн хувьцаа эзэмшигчид дараах **ҮҮРГИЙГ ХҮЛЭЭНЭ**. Үүнд:

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;

- Энгийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авах хүсэлтэй этгээд нь компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу энэ тухайгаа нийтэд мэдээлэх;
- Компанийн хувьцааг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авснаар тухайн этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь хяналтын багц болон түүнээс дээш хэмжээнд хүрсэн бол хяналтын багц эзэмшигч болсон өдрөөс хойш ажлын 60 хоногийн дотор бусад хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааг сүүлийн зургаан сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал гаргах;
- Хувьцаат компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан буюу эзэмшиж байгаа этгээд нь энэ хэмжээний хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор өөрийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, тус бүрийн эзэмшлийн хувьцааны тоо зэргийн талаарх мэдэгдлийг тухайн компани болон Санхүүгийн зохицуулах хороонд тус тус бичгээр мэдэгдэх;
- Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийн хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна;
- Компанийн хувьцааг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшигч нь өөрийн эзэмшлийн үнэт цаасны тухай мэдээллээ нэгдмэл сонирхолтой этгээд болсон өдрөөс, эсхүл компанийн хувьцааны тав буюу түүнээс дээш багц болон хяналтын багцыг хамтран эзэмших болсноос хойш ажлын 3 өдрийн дотор компанид бичгээр мэдэгдэх;
- Хувьцаа эзэмшигч нь команийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ;
- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг.

Үнэт цаасыг олон нийтэд арилжих журам

Энэхүү журмын зорилго нь Айтүүлс ХХК-аас олон нийтэд санал болгож буй үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилах, арилжих үйл ажиллагааг холбогдох хууль журам, тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, олон нийтэд ойлгомжтой, хялбар байдлаар явуулахад чиглэнэ.

Үнэт цаасыг нийтэд санал болгох үнэ, анхдагч зах зээлийн арилжааны арга

Үнэт цаас гаргагчийн 2017 оны 3-р сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 08 тоот тогтоолоор олон нийтэд санал болгох энгийн хувьцааг нэг бүрийг нь **100.00 төгрөгөөр “тогтоосон үнээр санал болгох арилжааны арга”**-аар зөвхөн тотгоосон үнээр анхдагч зах зээлд санал болгохоор шийдвэрлэсэн.

Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга

Монголын хөрөнгийн биржийн 2009 оны “Анхдагч зах зээлийн арилжааны журам”-д зааснаар тогтоосон үнээр санал болгон арилжих арга гэдэг нь үнэт цаас гаргагчийн зүгээс үнэт цаасыг тогтоосон тодорхой нэг үнээр олон нийтэд санал болгон арилжих үйл ажиллагааг хэлэх бөгөөд хөрөнгө оруулагчийн зүгээс тогтоосон үнээс өндөр үнээр худалдан авах захиалга өгч болох эсхүл үнэт цаас гаргагчийн зүгээс зөвхөн нэг үнээр санал болгох хоёр хувилбар байдаг.

Айтүүлс ХХК-ийн хувьд зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд арилжааг явуулах ба зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд арилжааг явуулах үед худалдан авах захиалгын тоо ширхэг худалдах захиалгын тоо ширхгээс илүү гарсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглана. Хувь тэнцүүлэх аргаар хуваарилалт хийхэд захиалгын үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

Захиалгын хуваарилалт

Үнэт цаас гаргагчийн зүгээс жижиглэнгээр оролцож буй хөрөнгө оруулагчдыг анхдагч зах зээлийн арилжаанд идэвхтэй оролцохыг дэмжих үүднээс олон нийтэд санал болгож буй тоо ширхгээс илүү захиалга ирсэн тохиолдолд **хувь тэнцүүлэн хуваарилах хязгаарыг дараах байдлаар тогтоосон**. Үүнд:

- 50.0 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг 100 хувь биелүүлнэ.
- 50.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий захиалгуудыг хувь тэнцүүлэн хуваарилна.

Тогтоосон үнийн аргыг сонгосон үндэслэл

- Хөрөнгө оруулагчдад анхдагч зах зээлд санал болгох үнийг тодорхой нэг үнийн түвшинд буюу тогтоосон үнээр санал болгосноор хөрөнгө оруулагчдын хувьд худалдан авах шийдвэр, тооцоолол гаргахад хялбар бөгөөд үнэт цаас худалдан авах тоо хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.
- Анхдагч зах зээлээс худалдан авч буй хөрөнгө оруулагчийн хувьцаагаа хоёрдогч зах зээлд эргүүлэн худалдсанаас олохоор хүлээж буй өгөөжийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.
- Хувь тэнцүүлэн хуваарилахад захиалгын дүнгийн хязгаар тавих нь жижиг болон дунд түвшний хөрөнгө оруулагчдыг идэвхтэй оролцуулах, олон нийтэд хүртээмжтэй байлгах давуу талтай.

Олон нийтэд санал болгох үнийг тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагчийн 2017 оны 3-р сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 08 тоот тогтоолоор үнэт цаасыг олон нийтэд санал болгох үнийг 100.00 төгрөгөөр тогтоохоор шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийг гаргахдаа компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг үндэслэл болгосныг дор тайлбарлав.

Атен ХХК-ийн хөндлөнгийн үнэлгээчид үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэ цэнийг компанийн цэвэр хөрөнгө болон төслийн жилүүдэд олох борлуулалтын орлого дээр үндэслэн тогтоосон. Цэвэр хөрөнгөд суурилсан үнэлгээгээр үнэт цаас гаргагчийн 2016 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх бизнесийн үнэ цэнийг 1,407,821,200 төгрөг гэж тодорхойлсон ба Айтүүлс ХХК-ийн одоо эргэлтэд гаргасан байгаа 21,064,144 ширхэг хувьцаанд хуваавал нэгж хувьцаанд ногдох үнэ цэнэ нь 66.83 төгрөг байгаа нь компанийн 2016 оны 12-р сарын 31-ний өдрөөрх дансны үнэ болох 67.44 төгрөгтэй төгрөгтэй ойролцоо байна.

Айтүүлс ХХК-ийн бизнесийн одоогийн үнэ цэнэ

Үнэлгээний арга	Бизнесийн үнэ цэнэ, төгрөг	Хувьцааны тоо ширхэг	Нэгж хувьцааны үнэ цэнэ, төгрөг
Тохируулга хийгдсэн цэвэр хөрөнгийн арга	1,407,821,200	21,064,144	66.83

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа болох программ хангамж, мэдээллийн технологийн үйлчилгээ нь хөрөнгөд бус технологид илүүтэй суурилсан тул одоогийн хөрөнгийн үнэ цэнээс илүү ирээдүйд олох орлогын хэмжээнд суурилан үнэ цэнийг тодорхойлох нь илүү ач холбогдолтой юм. Тиймээс, хөндлөнгийн үнэлгээчид орлогод тулгуурласан хандлагын хорогдуулсан мөнгөн гүйлгээнийн аргаар тооцсон компанийн бизнесийн үнэ цэнийг 100 хувь хүлээн зөвшөөрч, үнэлгээний өдрөөрх компанийн үнэ цэнийг 4,409,072,540 төгрөг гэж дүгнэсэн.

Компани 13,387,980 ширхэг хувьцаа нэмж гарган, олон нийтэд санал болгож, 1,338,798,000 төгрөг татан төвлөрүүлсний дараах нэгж хувьцааны үнийг дараах байдлаар тооцооллоо.

Айтүүлс ХХК-ийн үнэт цаасаа олон нийтэд санал болгосны дараах бизнесийн үнэ цэнэ

Үнэлгээний арга	Бизнесийн үнэ цэнэ, төгрөг	Хувьцааны тоо ширхэг	Нэгж хувьцааны үнэ цэнэ, төгрөг
Тохируулга хийгдсэн цэвэр хөрөнгийн арга	2,746,619,200	34,452,124	79.72
Цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах арга	4,409,072,540	34,452,124	127.98

Цэвэр хөрөнгөд суурилсан аргаар үнэт цаас гаргагчийн хөрөнгө татсаны дараах бизнесийн үнэ цэнийг тооцвол 2,746,619,200 төгрөг болж, нэгж хувьцааны үнэ нь 79.72 төгрөг байхаар байна. Харин цэвэр мөнгөн урсгалыг хорогдуулах аргаар тогтоосон бизнесийн үнэ цэнэ дээр суурилан тооцоолбол нэгж хувьцааны үнэ 127.98 төгрөг болж байна. Энэ хоёр үнийн дундаж нь 103.85 төгрөг байна. Үнэт цаас гаргагчийн хөрөнгөд бус технологид илүүтэй суурилсан бизнесийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан, мэргэжлийн бие даасан үнэлгээний компанийн хүлээн зөвшөөрсөн, орлогын хандлагаар тогтоосон үнээлгээний дүнг үндэслэн, үнэт цаасыг анх удаа олон нийтэд санал болгох үнийг 100.00 төгрөгөөр тогтоосон. Ингэхдээ улс орны өнөөгийн эдийн засгийн зогсонги байдал, хөрөнгийн зах зээлийн идэвхийн түвшинг харгалзан, мөн олон нийтэд санал болгох хувийг нэмэгдүүлэх зорилгоор нэгж хувьцааны санал болгох үнийг үнэлгээгээр гарч буй үнээс 22 хувиар бууруулсан болно.

Урьд өмнө нь үнэт цаас гаргаж байсан эсэх

Үнэт цаас гаргагч нь урьд нь олон нийтэд үнэт цаас гаргаагүй бөгөөд хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгож байна.

Хөрвүүлэн эзэмших хувьцааны талаарх мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь 13,387,980 ширхэг энгийн хувьцаа олон нийтэд санал болгож байгаа нь хувьцаа нэмж гаргасны дараах нийт хувьцааны 38.86 хувьтай тэнцүү ба компанийн одоогийн 100 хувийн хувьцаа эзэмшигч Ай Си Ти групп ХХК-ийн эзэмшлийн хувь 61.14 болж буурна.

Схем 4. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулахад хөрвөх хувьцаа



Хүснэгт 55. Хувьцаа эзэмшигчийн хөрвүүлэн эзэмших хувьцааны тоо, эзэмшлийн хувь

Хувьцаа эзэмшигчид	ХК болохоос өмнөх хувь эзэмшил		ХК болсны дараа (олон нийтэд санал болгосон хувьцаа 100% арилжигдвал)	
	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
Ай Си Ти групп ХХК	21,064,144	100%	21,064,144	61.14%
Олон нийт			13,387,980	38.86%
Нийт	21,064,144	100%	**34,452,124**	**100%**

Тэргүүн ээлжинд худалдаж авах эрхээ хэрэгжүүлэх эсэх

Үнэт цаас гаргагчийн 2017 оны 3-р сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 08 тоот тогтоолоор компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нь олон нийтэд санал болгохоор нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүйгээр шийдвэрлэсэн.

Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах тухай

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 11-р сарын 23-ний өдрийн 408-р тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”, Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 12-р сарын 30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт “Үнэт цаасны бүртгэлийн журам”

2009 оны 11-р сарын 20-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан “Анхдагч зах зээлийн арилжааны журам” болон Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 17-ны өдрийн 165 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Арилжаа зохион байгуулах заавар”-т заасны дагуу явуулна.



Схем 5. Үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд байршуулах үе шат

Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх: СЗХ-ны “Үнэт цаасны бүртгэлийн журам”, МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн” журам”-ын дагуу биржид ирүүлсэн өргөдөл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.6-д заасны дагуу хууль болон журмын шаардлагыг хангасан үнэт цаасны танилцуулга, бусад баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор хянаж, бүртгэлийн шалгалт хийнэ. Шалгалтын тайланд үндэслэн үнэт цаасыг бүртгэх эсэхийг МХБ-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэж, үнэт цаасыг бүртгэхээр шийдвэрлэсэн бол шийдвэрийн хувийг зохих дүгнэлтийн хамт СЗХ-д ажлын 2 өдрийн дотор хүргүүлнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол: Үнэт цаас гаргагч нь анх удаа нийтэд санал болгохоор үнэт цаас гаргаж байгаа бол хүсэлтээ МХБ болон СЗХ-д нэгэн зэрэг гаргаж бүртгүүлнэ. Хороо нь МХБ-ээс ирүүлсэн дүгнэлт, хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдээс үнэт цаас гаргагчид өгсөн хууль зүйн дүгнэлтийг тус тус хянаж, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэхээс татгалзах үндэслэлгүй бол үнэт цаас гаргагчийн үнэт цаас болон танилцуулгыг Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Олон нийтэд сурталчилах: МХБ, СЗХ-ноос үнэт цаасыг бүртгэх шийдвэр гарсны дараа үнэт цаас, түүний танилцуулгыг олон нийтэд сурталчилж эхлэх бөгөөд тогтоол гарснаас хойш зургаан сарын хугацаанд үнэт цаасыг олон нийтэд танилцуулна.

Санхүүгийн зохицуулах хорооноос анхдагч зах зээлийн арилжаа эхлүүлэх зөвшөөрөл авах: Үнэт цаасны тухай хуулийн 12.1-т заасны дагуу СЗХ болон МХБ-ийн бүртгэлийн аль алинд

нь бүртгэгдсэн үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдаалах бөгөөд мөн энэ хуулийн 12.2-т заасны дагуу үнэт цаасыг МХБ-ийн бүртгэлд бүртгэсэн болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай МХБ-ээс гаргасан тодорхойлолт, үнэт цаас гаргагчийн хүсэлтэд үндэслэн СЗХ-оос үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргах зөвшөөрлийг олгоно. СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.4.3-т андеррайтер, эсхүл үнэт цаас гаргагч нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг, эсхүл захиалгын бүртгэлийг эхлүүлэх зөвшөөрлийг уг ажиллагааг эхлүүлэхээс өмнө гурваас доошгүй өдрийн өмнө Хороонд хүсэлт гарган авах ба хүсэлтэд хугацаа, хуваарийг тодорхой тусгана.

Анхдагч зах зээлийн арилжааг явуулах: МХБ-ийн "Анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 3-р бүлэгт заасан "Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга"-ын дагуу болон "Арилжаа зохион байгуулах заавар"-ын дагуу захиалга шивж эхэлснээс хойш нэг сарын дотор анхдагч зах зээлийн арилжааг явуулна.

Санхүүгийн зохицуулах хороонд анхдагч зах зээлийн арилжааны тайлан өгөх: Үнэт цаасны тухай хуулийн 12.4, СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.4.11-д заасны дагуу андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дуусснаас хойш ажлын 3 өдрийн дотор анхдагч зах зээлийн тайланг бэлтгэн Хороонд хүргүүлж, 4.4.14-т заасны дагуу нийтэд мэдээлнэ. МХБ-ээс анхдагч зах зээлийн арилжааны тайлан мэдээг СЗХ болон үнэт цаас гаргагчид ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ.

Санхүүгийн зохицуулах хорооноос хоёрдогч зах зээлийн арилжаа эхлүүлэх зөвшөөрөл авах: Үнэт цаасны тухай хуулийн 12.6, СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.4.13-т заасны дагуу СЗХ нь анхдагч зах зээлийн захиалгын бүртгэл болон арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй, үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон гэж үзсэн тохиолдолд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон МХБ-д үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг ажлын 3 өдөрт багтаан хүргүүлнэ.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах: Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам"-ын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна. СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.4.14-т заасны дагуу анхдагч зах зээлийн товч тайланг олон нийтэд мэдээлэхдээ ХЭХ-ын товыг зарлана.

Анхдагч зах зээлийн захиалгын бүртгэлийн тухай

Захиалга авах хуваарь, дуусах хугацаа

– Үнэт цаасны арилжаа нь МХБ-ийн үнэт цаасны арилжааны программаар хийгдэнэ. Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь МХБ-тэй харилцан тохиролцон гэрээ байгуулж, арилжаа эхлэх, үргэлжлэх, дуусгавар болох хугацааг тогтоох бөгөөд СЗХ-ны зөвшөөрлөөр уг хугацаа нь хүчин төгөлдөр болно.

– Анхдагч зах зээлийн арилжаа үргэлжлэх, дуусгавар болох хугацаа нь үнэт цаасны борлуулалтаас олохоор төлөвлөж буй хөрөнгийг шаардлагатай хэмжээнд татан төвлөрүүлэх хүртэл үргэлжлэх бөгөөд үнэт цаас гаргагчийн хувьд хоёр хувилбартай байж болохоор төлөвлөв. Арилжаа үргэлжлэх нийт хугацаа нэг сараас илүүгүй байна.

– Үнэт цаасны борлуулалтаас олохоор төлөвлөж буй хөрөнгийн 75 хувийг бүрдүүлсэн тохиолдолд үнэт цаас гаргагчийн хувьд анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож болох бөгөөд СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

Үнэт цаасны захиалга авах

– Үнэт цаасыг нийтэд санал болгон сурталчилж эхэлсэн өдрөөс хойш 10-аас доошгүй хоногийн дараа худалдан авах захиалга авч эхэлнэ.

– Үнэт цаасны захиалгыг зөвхөн тогтоосон үнээр өгөх бө түүнээс өндөр үнээр захиалга өгч болохгүй, мөн захиалганд үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

– Хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах захиалгыг брокерийн тусгай зөвшөөрөлтэй үнэт цаасны компанид өгөх бөгөөд брокер захиалгыг нь МХБ-ийн арилжааны программмд тогтсон хугацаанд шивж оруулна.

Үнэт цаасыг хэн худалдан авч болох вэ?

– Монгол Улсын болон гадаад улсын иргэн, хуулийн этгээд бүгд худалдан авах эрхтэй. Энэхүү танилцуулгад үнэт цаасыг худалдан авах эрхтэй бүх эдгээдийг хөрөнгө оруулагч гэж ойлгоно.

– Үнэт цаасыг анхдагч зах зээлээс худалдаж авахыг хүссэн хөрөнгө оруулагчид нь СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж буй үнэт цаасны компаниар зуучлуулан, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд (ҮЦТХТ) үнэт цаасны данс, үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч банкинд төлбөр тооцооны дансаа нээлгэсэн байх шаардлагатай.

Үнэт цаасыг хэрхэн худалдан авах вэ?

– Хөрөнгө оруулагч нь худалдаж авахаар төлөвлөсөн хэмжээгээр үнэт цаасны төлбөрийг шимтгэлийн хамт үнэт цаасны (эсхүл төлбөр тооцооны) дансандаа 100 хувь урьдчилан байршуулах шаардлагатай. Аль дансанд байршуулах нь арилжааны программмын сонголтоос хамаарах ба энэ талаар хөрөнгө оруулагчдад цаг тухайд нь мэдэгднэ.

– Үнэт цаасны данс болон төлбөр тооцооны дансаа нээлгэн, үнэт цаас худалдаж авахад шаардлагатай мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулсан хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах захиалгаа брокертоо өгнө. Ингэхдээ өөрийн биеэр очиж өгөхөөс гадна и-мэйлээр, утсаар, факсаар болон өөр хэлбэрээр өгөх боломжтой (өөрийн брокертой холбогдож лавлана уу).

Нэмэлт мэдээлэл:

– Үнэт цаасны дансыг СЗХ-оос брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа үнэт цаасны компаниар зуучлуулан ҮЦТХТ-д нээлгэнэ. Үнэт цаасны дансанд хөрөнгө оруулагчийн худалдан авсан бүхий л үнэт цаас байршин хадгалагдаж байдаг.

– Үнэт цаасны төлбөр тооцооны дансыг өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанитай хамтран ажилладаг, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулах эрх бүхий арилжааны банкинд нээлгэнэ. Төлбөр тооцооны дансаар одоогоор хоёрдогч зах зээлийн арилжааны хэлцлүүдийн төлбөр тооцоо Т+1 горимоор хийгдэж байна. Төлбөр тооцооны дансаар зөвхөн үнэт цаасны төлбөр тооцоо хийгдэх бөгөөд өөр зориулалтаар ашиглах боломжгүй, хөрөнгө оруулагч, үнэт цаасны компани, банк гурвын дундын данс юм.

– Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоог одоогийн байдлаар “Арилжааны төлбөр тооцоо” ХХК гүйцэтгэж байна. Тиймээс, анхдагч зах зээл дээрээс үнэт цаас худалдан авахад тус байгууллагаар дамжуулан үнэт цаасны дансандаа мөнгө байршуулдаг.

Схем 6. Үнэт цаас худалдан авах алхмуд

Алхам-1

ҮНЭТ ЦААСНЫ ДАНС НЭЭЛГЭХ
- Хүчин төгөлдөр иргэний үнэмлэх /гадаад паспорт/-ын хуулбараар
- Үнэт цаасны компанид өөрийн биеэр /итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан/ очиж үнэт цаасны данс нээлгэнэ.
- Данс нээх хураамж төлнө.

Алхам-2

ТӨЛБӨР ТООЦООНЫ ДАНС НЭЭЛГЭХ
- Хүчин төгөлдөр иргэний үнэмлэхээр
- Банкинд өөрийн биеэр /итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан/ очиж төлбөр тооцооны данс нээлгэнэ.
- Данс нээлгэхэд хураамжгүй бөгөөд дансны үлдэгдэл шаардахгүй /Банк бүр өөр нөхцөлтэй бөгөөд дээрх нь ХХБ-ны нөхцөл болно/

Алхам-3

ДАНСАНДАА МӨНГӨ БАЙРШУУЛАХ
- Хувьцаа худалдаж авахад шаардлагатай мөнгөн хөрөнгийг
- дансандаа байршуулна.
- Дансандаа аль ч банкаар дамжуулан бэлэн ба бэлэн бусаар орлого хийх боломжтой.

Алхам-4

ҮНЭТ ЦААС ХУДАЛДАЖ АВАХ ЗАХИАЛГА ӨГӨХ
- Хувьцаа худалдаж авах захиалгыг үнэт цаасны компанидаа өөрийн биеэр, и-мэйлээр, утсаар, факсаар болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан өгнө.
- Захиалгыг өгөхдөө захиалгын гэрээнд гарын үсэг зурж, бичгээр баталгаажуулна.

Алхам-5

ҮНЭТ ЦААСНЫ ДАНСАНД ХУВЬЦАА БАЙРШИХ
- Анхдагч зах зээлийн арилжааг СЗХ-оос амжилттай болсон гэж үзвэл хөрөнгө оруулагчдын захиалгын дагуу нийлүүлэлтийг хийнэ.
- Нийлүүлэлт хийгдснээр хөрөнгө оруулагчийн үнэт цаасны дансанд хувьцаа байршиж бөгөөд захиалгын биелэлтийн мэдээллийг үнэт цаасны компаниас хөрөнгө оруулагчид мэдээлнэ.
- Хувьцаа дансанд нь байршснаар хөрөнгө оруулагч хувьцаагаа хоёрдогч зах зээл дээр арилжих боломжтой болно.

Арилжааны шимтгэл

Үнэт цаасны арилжааны хэлцэл бүрийн үнийн дүнгийн тодорхой хувиар тооцдог үйлчилгээний хөлс болох шимтгэлийг үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй зохицуулах болон мэргэжлийн оролцогч байгууллагууд авдаг. Шимтгэлийн хувийг үнэт цаасны компанийн үнэт цаасны данс нээх гэрээгээр тогтоодог ба СЗХ, МХБ болон Арилжааны төлбөр тооцоо ХХК-ийн шимтгэлийн хэмжээ нь тогтмол бол үнэт цаасны компаниудын хувьд харилцан адилгүй байдаг.

Албан татвар

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 13.1.3-т заасан орлого /ногдол ашгийн орлого/-ын нийт дүнгээс, 14.1.3-т заасан орлого /хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого/-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 23.1-д заасан /10 хувь/ хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 16.3.1-д заасан “ногдол ашгийн орлого”-ын нийт дүнгээс, 16.8-д заасан “хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого”-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс энэ хуулийн 17.1, 17.2.1-д заасан хэмжээгээр /10 хувь/ албан татвар төлнө.

Валютын ханш

Үнэт цаасны арилжаа Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр /MNT/ хийгдэнэ. Ханшийг тухайн өдрийн зах зээлийн ханшаар тооцно. Арилжааны банкууд төгрөгтэй харьцах гадаад валютын ханшийг өдөр бүр шинэчлэн тогтоодог. Монголын зарим арилжааны банкуудын гадаад валютын ханшийн мэдээлэл авах цахим хуудсуудыг дор дурдав.

Хүснэгт 56. Арилжааны банкуудын цахим хуудас

Арилжааны банкууд	
Худалдаа хөгжлийн банк- www.tdbm.mn	Ариг банк- www.arigbank.mn
Хаан банк- www.khanbank.com	Улаанбаатар хотын банк- www.ubcbank.mn
Голомт банк- www.golomtbank.com	Богд банк- www.bogdbank.com
Төрийн банк- www.statebank.mn	Тээвэр хөгжлийн банк- www.transbank.mn
Хас бан- www.xacbank.mn	Кредит банк- www.creditbank.mn
Капитрон банк- www.capitronbank.mn	Капитал банк- www.capitalbank.mn
Үндэсний хөрөнгө оруулалтын банк- www.nibank.mn	

Олон нийтэд үнэт цаасыг таниулах, сурталчилах арга хэлбэр

Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны болон Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу олон нийтэд танилцуулна.

– СЗХ-ны тогтоол гарсан өдрөөс хойш олон нийтэд үнэт цаасыг сурталчилж эхлэх бөгөөд үнэт цаас гаргагч болон андеррайтерийн харилцан зөвшилцөж баталсан хөтөлбөрийн дагуу олон нийтэд үнэт цаасыг танилцууна.

– Үнэт цаасны захиалга авч эхлэх өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө үнэт цаасны тухай ерөнхий мэдээлэл, захиалга авч эхлэх, дуусах өдөр, цаг, бүргтэлийн аргын талаарх мэдээллийг олон нийтэд болон брокер, дилерийн эрх бүхий үнэт цаасны компаниудад хүргэнэ.

Схем 7. Үнэт цаасыг олон нийтэд сурталчилах хөтөлбөр

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээл дээрээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа бусдад худалдах эрх нээлттэй болно.

СЭХ
он . сар . . . өдөр
2017 . 09 . 27
БҮРТГЭВ
№ 01

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нэг бүр нь 100.00 төгрөгийн үнэтэй 13,387,980 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгон татан төвлөрүүлэх хөрөнгөөр 2017-2021 оны хооронд хэрэгжих “Модуляр дата төвийн парк” төслийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Уг төслийн хүрээнд компани нь өөрийн үндсэн дата төвийн үйл ажиллагааг өргөжүүлэхээс гадна Дархан хот дах өөрийн эзэмшлийн газарт Модуляр дата төвийн паркийг байгуулна. Төсөл хэрэгжих хугацаа 5 жил бөгөөд нийт татан төвлөрүүлэх **1,338,798,000** төгрөгийн зарцуулалтын задаргааг дор харуулав.

Хүснэгт 57. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, хувиар

№	Хөрөнгө оруулалт	Нэгж	Нэгжийн үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг	Хувь
1	Паркийн барилга	900 м.кв	550,000	495,000,000	37.0%
2	Цахилгааны систем	1	120,000,000	120,000,000	9.0%
3	Хөргөлтийн систем	1	80,000,000	80,000,000	6.0%
4	Тоног төхөөрөмж	1	119,000,000	119,000,000	8.9%
5	Гадна дэд бүтэц	1	151,900,000	151,900,000	11.3%
6	Контейнер модуль	1	345,000,000	345,000,000	25.8%
7	Тавилга, эд хогшил	1	27,898,000	27,898,000	2.1%
Нийт дүн				**1,338,798,000**	**100%**

Модуляр дата төвийн паркийг байгуулахад эхний ээлжинд буюу 2017 оны 6-р сараас эхлэн Дархан-Уул аймгийн Дархан сумын 12-р багийн нутагт байршилтай өөрийн эзэмшлийн газарт 900 м.кв талбай бүхий нэг давхар төмөр карказан сэндвичэн дүүргэлттэй барилга буюу паркийн барилгыг барьж, цахилгаан, дулаан, ус суваг, мэдээлэл холбооны сүлжээнд холбож, гадна дэд бүтцийг байгуулна. Барилга бүтээн байгуулалтын ажлыг 2017 оны 11-р сар гэхэд бүрэн дуусгахаар төлөвлөсөн байна /хавсралтаас цаг хугацааны төлөвлөлтийг харна уу/. Улмаар паркийн барилга дотор контейнерэн модулиудыг байршуулж, нөөц цахилгааны систем болон хөргөлтийн системийг суурилуулна. Паркийн барилга нь 30 контейнер модуль агуулах хүчин чадалтай ба энэхүү төслийн хугацаанд нэг модуляр контейнер худалдан авахаар төлөвлөсөн. Цаашид модуль нэмж худалдан авах эсхүл бусдын эзэмшлийн модулийг байршуулж үйлчилгээ үзүүлэх замаар модулиудын тоог аажмаар нэмж, дотоодын төдийгүй олон улсын хэмжээний газарзүйн нөөц модуляр дата төвийн паркийг бүтээхээр төлөвлөсөн болно. Тиймээс, контейнерүүдийг өргөж, зөөж байршуулахад зориулагдсан өргөгч кран авах юм. Түүнчлэн, модуляр дата төвийн паркийг байнга хянаж, удирдах, хамгаалах зориулалт бүхий хяналтын өрөөг шаардлагатай тавилга, эд хогшил, сүлжээний болон хяналтын тоног төхөөрөмжөөр тоноглоно.

Эдгээр зардлыг хувьчилж тооцвол нийт хөрөнгө оруулалтын 37.0 хувь нь паркийн барилга барих, 25.8 хувь нь контейнер модуль худалдан авах, 26.0 хувь нь цахилгааны систем, хөргөлтийн систем, тоног төхөөрөмж, тавилга бүрдүүлэх, 11.3 хувь нь гадна дэд бүтэц байгуулахад зарцуулагдахаар байна. Модуляр дата төвийн паркийн хэвийн үйл ажиллагааг хангах эргэлтийн хөрөнгө, бусад зардлыг үнэт цаас гаргагч хариуцах болно.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮДС
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

График 23. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт



Барилга, байгууламж: Паркийн барилгын хэмжээ нь 900 м.кв /45х20/ хэмжээтэй нэг давхар байх бөгөөд нийт 495,000,000 төгрөг болж байна. Гадна дэд бүтцийн зардлыг оруулаад нийт барилга, байгууламжийн зардал 646,900,000 төгрөг байна. Төслийн тооцоололд барилгын нэгж м.кв-ийн үнийг 550,000 төгрөгөөр тооцоолсон нь галд тэсвэртэй, тусгай зориулалт бүхий галын аюулгүй байдлын систем, өндөр чанартай цахилгаан болон компьютерийн сүлжээ, салхивчны системтэй байхаар тооцоолсонтой холбоотой. Гадна дэд бүтцэд цэвэр бохир ус, цахилгаан, дулаан, мэдээлэл холбооны сүлжээний дэд бүтцүүд багтана. Эдгээр дэд бүтцийн ажлын тоо хэмжээ, бүрдэл нь Дархан-Уул аймгийн мэргэжлийн байгууллагуудаас гаргах техникийн нөхцлүүдээс хамаарах бөгөөд төсөлд жишиг үнээр тооцоолон оруулсан байна.

Контейнерэн модуль: Энэ нь модуляр дата төв болгон тоноглосон 20 тонны контейнер байх бөгөөд дотроо компьютерийн тоног төхөөрөмжийн хэсэг, хөргөлтийн хэсэг, тог баригчийн гэх мэт тусгай хэсгүүдтэй ба дорх хүснэгтэд үзүүлсэн хүчин чадалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	Хүчин чадал
Физик хэмжээ (Урт х Өргөн х Өндөр)	6,068 мм х 2,438 мм х 2,896 мм
Компьютер, тоног төхөөрөмжийн хүчин чадал	24 кВт
Ракны тоо, рак юнитийн тоо	4 ш, 180U
Цахилгаан тэжээл	380В/50 Hz
Цахилгаан зарцуулалт	6 кВ/Рак
Цахилгаан баригч	20 кВольт Ампер, 2+1 нөөц
Цахилгаан барих хугацаа	10 минут
Хөргөлт	20 кВт, 2+1 нөөц
Гал эсэргүүцэх систем	Heptafluoropropane

Цахилгааны систем: Цахилгааны нөөц системд 120,000,000 төгрөг зарцуулах ба энэ нь 300кВт-ын хүчин чадал бүхий дизель генератор, түүний автомат удирдлагын цогц байх юм.

Хөргөлтийн систем: Энэ нь контейнер модуляр дата төвөөс ялгарч буй дулааныг гадагшлуулах систем бөгөөд 80,000,000 төгрөгөөр төсөвлөсөн байна.

Тоног төхөөрөмж: Үүнд паркийн барилгад байрших модуляр дата төвүүд буюу контейнэрүүдийг зөөвөрлөхөд шаардлагатай өргөгч кран, тусгай шал, сервер байршуулах ракууд, жижиг оврын цахилгаан баригч багтана. Эдгээрийг худалдан авахад нийт 119,000,000 төгрөг болно.

№	Хөрөнгө оруулалт	Тоо, ширхэг	Нэгжийн үнэ, ₮	Нийт үнэ, ₮
1	Антистатик шал	30	100,000	3,000,000
2	Рак	8	1,000,000	8,000,000
3	Цахилгаан баригч	2	4,000,000	8,000,000
4	Өргөгч кран	1	100,000,000	100,000,000
Нийт дүн				**119,000,000**

Тавилга, эд хогшил: Модуляр дата төвүүдийн сүлжээ, цахилгаан хангамж, температур, чийгшил зэргийг тогтмол хянах зориулалт бүхий ээлжийн инженерүүдийн хяналтын өрөөний компьютер, тавилга, эд хогшилд зарцуулах 27,898,000 төгрөгийн задаргааг дорх хүснэгтээс харна уу.

№	Эд хогшил	Тоо, ширхэг	Нэгжийн үнэ, ₮	Нийт үнэ, ₮
1	Компьютер /PC/	4	1,250,000	5,000,000
2	Компьютер /notebook/	2	1,500,000	3,000,000
3	Принтер	2	420,000	840,000
4	Тавилга /ширээ, шүүгээ, сандал/	10	498,200	4,982,000
5	Том шүүгээ	4	669,000	2,676,000
6	Сейф	2	700,000	1,400,000
7	Гаднах хаяг /гэрлэн/	1	3,000,000	3,000,000
8	Бусад тавилга	2	3,500,000	7,000,000
Нийт дүн				**27,898,000**

Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн хувилбар

Үнэт цаас гаргагч нь олон нийтээс татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн хэмжээнээс доош хэмжээний хөрөнгө татан төвлөрүүлсэн тохиолдолд зарим зардлыг түр хойшлуулж, төвлөрсөн хөрөнгөөр төслийн үйл ажиллагааг эхлүүлэх боломжтой юм. Тухайлбал, нийт татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн 1,338,798,000 төгрөгийн 75 хувийг буюу 1,004,098,500 төгрөг татаж чадсан тохиолдолд тэргүүн ээлжинд санхүүжүүлэн, үйл ажиллагаагаа эхлүүлж болох хувилбарыг дор толилуулаа.

Шаардлагатай хөрөнгө оруулалтын 75 хувийг татсан тохиолдолд паркийн барилгыг хэмжээг бууруулан, 585 м.кв хэмжээтэй барих боломжтой бөгөөд барилгын хэмжээтэй уялдуулан цахилгаан болон хөргөлтийн систем, гадна дэд бүтцийн зардлыг мөн бууруулж, тавилга эд

хогшлын зардлыг хасч тооцсон болно. Үнэт цаас гаргагчийн тавилга, эд хогшлыг өөрийн дотоод эх үүсвэрээс санхүүжүүлж, дараагийн жилүүдийн борлуулалтаас орох цэвэр ашгийн хөрөнгөөр гадна дэд бүтэц, паркийн барилгыг өргөжүүлэн барих боломжтой ба эхний жилд паркийн барилгын хэмжээ багасах нь төслийн үйл ажиллагаа, үр ашигт нөлөөлөхгүй юм.

Хүснэгт 58. Татан төвлөрүүлэх хөрөнгийн задаргаа, 75 хувиар

№	Хөрөнгө оруулалт	Нэгж	Нэгжийн үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг	Хувь
1	Паркийн барилга	585 м.кв	550,000	322,019,500	32%
2	Цахилгааны систем	1	100,000,000	100,000,000	10%
3	Хөргөлтийн систем	1	60,000,000	60,000,000	6%
4	Тоног төхөөрөмж	1	119,000,000	119,000,000	12%
5	Гадна дэд бүтэц	1	58,079,000	58,079,000	6%
6	Контейнер модуль	1	345,000,000	345,000,000	34%
7	Тавилга, эд хогшил	1	-	-	-
Нийт дүн				**1,004,098,500**	**100%**

ТАВ. АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

Андеррайтерийн үйлчилгээ үзүүлж буй Стандарт инвестмент ҮЦК нь үнэт цаас гаргагч Айтүүлс ХХК-тай 2016 оны 11-р сарын 21-ний өдөр “Мэргэжлийн ажил үйлчилгээ гүйцэтгэх тухай” гэрээг байгуулсан. Бид гэрээний хүрээнд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай нарийвчлан танилцаж, судалгааг явуулсны үндсэн дээр болон хараат бус хөндлөнгийн байгууллагуудын дүгнэлт, тайланд үндэслэн, холбогдох хууль, журмын дагуу энэхүү үнэт цаасны танилцуулгыг боловсруулж, андеррайтерийн дүгнэлтийг гаргаж байна. Стандарт инвестмент ҮЦК ХХК нь үнэт цаас гаргагчтай нэгдмэл сонирхолтой тул үнэт цаасны танилцуулга болон энэхүү дүгнэлтийг боловсруулахдаа хараат бус аудитор, үнэлгээчин болон хуульчийн гаргасан дүгнэлт, мэдээлэлд үндэслэн, олон нийтэд ил түгээгдсэн зах зээлийн мэдээ, баримтыг шүүж, мэргэжлийн ёс зүйг баримтлан, хуулийн хүрээнд ажиллалаа.

Андеррайтерийн дүгнэлт гаргах үндэслэл

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.3-т “Үнэт цаас гаргагч нь энэ хуулийн 5.1.1-д заасан үнэт цаасыг нийтэд санал болгохдоо андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдтэй гэрээ байгуулна” гэж, мөн хуулийн 41.1-д андеррайтерийн үйл ажиллагааг тодорхойлохдоо “Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдаж авах зэрэг ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ” гэж, түүнчлэн, Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 12-р сарын 30-ны өдрийн 2015/14 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.1-д “Хүсэлт гаргагч нь Биржийн бүртгэлд бүртгүүлэх бэлтгэл шатанд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэй андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй гэрээ байгуулан, бүртгүүлэх ажиллагааны бэлтгэлийн хангана” гэж тус тус заасан нь энэхүү андеррайтерийн дүгнэлтийг гаргах үндэслэл болж байна.

Андеррайтерийн дүгнэлт болон үнэт цаасны танилцуулгыг боловсруулахын тулд үнэт цаас гаргагчийн талаар дэлгэрэнгүй судалгаа явуулахаас гадна үйл ажиллагаа явуулж буй салбарын хөгжил, бодлого, хууль эрх зүйн орчин зэрэг макро болон микро орчинг судалж үзлээ. Үүний тулд үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах, компанийн ажилтнууд болон удирдлагатай уулзаж ярилцах, компанийн бизнес төлөвлөгөө, санхүүгийн тайлан, гэрээ болон бусад бичиг баримтуудтай танилцах, мэдээлэл, харилцаа холбооны салбарын талаарх албан ёсны тайлан, төлөвлөгөө, бодлогын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, өрсөлдөгчдийг нь судлах, харьцуулах зэрэг аргыг хэрэглэлээ. Түүнчлэн, Санхүүгийн зохицуулах хорооноос хүлээн зөвшөөрсөн эрх бүхий, бие даасан, андеррайтер болон үнэт цаас гаргагчтай нэгдмэл сонирхолгүй хуульч, үнэлгээчин, аудитороор холбогдох үнэлгээ, дүгнэлтүүдийг гаргуулсан болно.

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

Андеррайтерийн нөхцөл

Стандарт инвестмент ҮЦК нь 2016 оны 11-р сарын 21-ний өдөр Айтүүлс ХХК-тай байгуулсан гэрээнд заасны дагуу “Үнэт цаас гаргагчийн хувьцааг дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд борлуулах үйл ажиллагааг зохион байгуулах” нөхцлөөр ажиллана.

Үнэт цаас гаргагчийн тухай

Үнэт цаас гаргагч нь 2011 онд программ хангамж, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдаж, 2012 оноос эхлэн домэйн нэрийн бүртгэл, вэб байршуулалт, виртуал серверийн түрээс, бизнес и-мэйл ашиглалт зэрэг интернэтийн технологид суурилсан 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүст үзүүлж, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг нь ханган ажиллаж байна. 2015 оны 1-р сард олон улсын TIER II стандартыг хангасан дата төвийг Улаанбаатар хотод байгуулсан нь одоогийн байдлаар 4,000 орчим вэбсайт байршуулж байна. Компани дата төвөө өдрийн 24 цагийн тусламжийн үйлчилгээтэй болгосноор харилцагчдад найдвартай үйлчилгээ үзүүлж чадсан ба үүнийг Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбооноос үнэлэн, үнэт цаас гаргагчийг 2015 оны шилдэг үйлчилгээ үзүүлсэн компаниар тодорхойлсон байна. 2016 онд Айтүүлс ХХК нь үндсэн дата төвийнхөө хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлсээс гадна, шинээр аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан, 100 хувь дотооддоо байршуулж буй “БизМэйл” үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн. Ийнхүү Айтүүлс ХХК нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш 3,700 гаруй харилцагч, үйлчлүүлэгчтэй болж, тэдэнд вэбсайтаа дотооддоо байршуулж, дотоодын цахим шуудан хэрэглэж, чанартай үйлчилгээ авах боломжийг олгон, салбартаа тодорхой байр суурь эзэлж чадсан үндэсний баялаг бүтээгч компани болсон байна.

Компанийн санхүүгийн байдлыг авч үзвэл борлуулалтын орлого нь жил бүр өсч, 2015 оноос ашигтай ажиллаж эхэлсэн ба 2016 онд 18.3 сая төгрөгийн цэвэр ашигтай гарсан байна.

Орлогын үзүүлэлтүүд	2013.12.31	2014.12.31	2015.12.31	2016.12.31
Борлуулалтын орлого	155,719,573	268,486,227	312,663,010	474,905,307
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	39,895,117	168,908,674	84,679,757	95,126,634
Нийт ашиг/алдагдал	**115,824,456**	**99,577,553**	**227,983,253**	**379,778,673**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	178,166	25,705	4,742,366	14,178,670
Үндсэн үйл ажиллагааны зардал	125,335,528	109,603,488	220,836,286	367,961,232
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	6,435,210	10,865,527	-	
ТТӨА/алдагдал	(15,768,116)	(20,865,757)	11,889,333	20,613,937
Татварын зардал	-	-	781,685	2,285,306
ТТДА/алдагдал	(15,768,116)	(20,865,757)	11,107,648	18,328,631
Ногдол ашиг	-	-	-	

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС ХХК
1116218260 ᠓. 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
ТТС3981 ᠓. 5444381

СЭХ
он сар өдөр
2017.09.27
БҮРТГЭВ
№ 01

Цэвэр ашиг/алдагдал	(15,768,116)	(20,865,757)	11,197,648	18,328,631

Үзүүлэлтүүд	2013.12.31	2014.12.31	2015.12.31	2016.12.31
Эргэлтийн хөрөнгө	103,273,567	322,126,174	268,647,113	334,504,994
Үндсэн хөрөнгө	76,417,122	530,230,833	1,302,605,474	1,157,605,474
Эргэлтийн бус хөрөнгө	76,417,122	530,230,833	1,348,605,474	1,283,782,504
Нийт хөрөнгө	**179,690,689**	**852,357,007**	**1,617,252,587**	**1,618,287,498**
Богино хугацаат өр төлбөр	81,238,359	224,164,838	152,524,012	197,788,183
Урт хугацаат өр төлбөр	-	-	-	-
Нийт өр төлбөр	**81,238,359**	**224,164,838**	**152,524,012**	**197,788,183**
Хувийн өмч	116,402,967	610,387,536	902,758,223	905,758,223
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	526,279,542	460,721,652
Хуримтлагдсан ашиг	(17,950,638)	17,804,632	35,690,809	54,019,440
Эзэмшигчдийн өмч	**98,452,329**	**628,192,168**	**1,464,728,575**	**1,420,499,315**
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	**179,690,689**	**852,357,007**	**1,617,252,587**	**1,618,287,498**

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд үнэт цаасаа анх удаа санал болгож байгаатай холбогдуулан 2016 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн. Хөндлөнгийн Атен ХХК-ийн хийж гүйцэтгэсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр компанийн эзэмшлийн нийт хөрөнгийг 1,157,046,027 төгрөгөөр тогтоосон бөгөөд хөрөнгийн үнэлгээний өөрчлөлтийг 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан байна. Ашиг алдагдлын хувьд алдагдлын хэмжээ сүүлийн жилүүдэд буурсаар 2014 оны жилийн эцсээр хуримтлагдсан ашгийн хэмжээ эерэг буюу 17.8 сая төгрөгт хүрсэн байна. 2015 оны IV улирлын байдлаар энэ тоо өсч, 35.6 сая төгрөг, 2016 оны эцэст 54.0 сая төгрөгт хүрчээ.

Үнэт цаас гаргагч нь 2016 оны байдлаар урт хугацаат өр төлбөргүй ба 197.7 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй байна. Компанийн санхүүгийн тайлагналыг аккруэл сууриар бүртгэдэг тул нийт өр төлбөрийн 58.6 хувийг урьдчилж орсон орлого бүрдүүлж байгаа нь компанийн өр төлбөрийн эрсдлийн хэмжээг бууруулж байна. Хөндлөнгийн аудитор Сүлд-Аудит ХХК-ийн аудитын дүгнэлтэд үнэт цаас гаргагч нь эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө бүрэн барагдуулах боломжтой гэсэн нь эрсдэл багатайг мөн илтгэж байна. Түүнчлэн, Татварын алба болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2017 оны 3-р сарын байдлаар тодорхойлсноор үнэт цаас гаргагч нь Татварын ерөнхий газарт 3.6 сая төгрөгийн өртэй, шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд ямар нэгэн төлбөргүй гэж тодорхойлсон байна.

Компанийн удирдлага, засаглалын хувьд Айтүүлс ХХК-ийн гүйцэтгэх захирал Монгол Улсын иргэн И.Алтантулга нь Компанийн засаглалын сургалтанд хамрагдсан ба 2012 оноос Айтүүлс ХХК-д Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байгаад, одоогийн албан тушаалд 2014 оны 1-р сард томилогдсон, туршлагатай залуу боловсон хүчин юм.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ТТС 1116218260 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

СЭХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

И.Алтантулга нь 1986 онд Баянхонгор аймагт төрсөн, 2007 онд ШУТИС-ийн Компьютерийн техник, менежментийн
сургуулийг Санхүүгийн удирдлага мэргэжлээр бакалаврын зэрэгтэй дүүргэсэн ба Аэро Монголиа ХХК, Ремикон ХК, Инфо-Актив ХХК зэрэг үндэсний томоохон компаниудад маркетингийн менежер, ерөнхий менежрийн албан тушаалыг хашиж байсан ажлын туршлагатай байна. Тэрээр компанийн хувьцааг эзэмшдэггүй ба 2017 оны 3-р сарын байдлаар татварын өргүй, шүүхийн шийдвэрээр бусдад төлөх төлбөргүй байна.

Хараат бус хуульчийн дүгнэснээр үнэт цаас гаргагч нь компанийн эрх зүйн үндэс болсон Компанийн дүрэм, Компанийн хөдөлмөрийн дотоод журам болон бусад журмуудыг Монгол Улсын Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан батлаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдалд хийсэн дүн шинжилгээ

Бид мэргэжлийн үнэлгээний бие даасан байгууллага болох Файн эстимэйт ХХК-ийн 2015 онд хийсэн үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээ, дүн шинжилгээнд үндэслэн, үнэт цаас гаргагчийн 2011-2016 оны аудитлагдсан санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийлээ.

Хүснэгт 59. Үнэт цаас гаргагчийн 2011-2016 оны санхүүгийн байдлын тайланд хийсэн бүтцийн шинжилгээ

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	Дундаж
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2.15%	8.37%	0.70%	8.22%	0.33%	1.00%	3.46%
Авлага	0.00%	10.85%	40.30%	13.18%	2.07%	4.14%	11.76%
Бараа материал	7.67%	2.41%	3.13%	11.04%	6.19%	7.44%	6.31%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00%	31.47%	13.34%	5.35%	6.23%	7.89%	10.71%
Эргэлтийн хөрөнгийн дүн	9.81%	53.09%	57.47%	37.79%	16.61%	20.67%	32.57%
Үндсэн хөрөнгө	90.19%	46.91%	42.53%	62.21%	80.54%	71.50%	65.65%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	90.19%	46.91%	42.53%	62.21%	83.39%	79.33%	67.43%
Нийт хөрөнгийн дүн	100.%	100%	100%	100%	100%	100%	100%
Дансны өглөг	80.17%	0.00%	4.69%	9.62%	3.68%	2.77%	16.82%
Цалингийн өглөг	0.00%	1.20%	0.00%	0.03%	0.23%	0.24%	0.28%
Татварын өр	0.00%	1.86%	9.90%	0.13%	0.40%	1.68%	2.33%
НДШ-ийн өглөг	0.00%	0.52%	0.01%	0.00%	0.12%	0.00%	0.11%
Урьдчилж орсон орлого	11.22%	42.67%	21.95%	16.52%	5.01%	7.16%	17.42%
Бусад богино хугацаат өр төлбөр	0.00%	13.87%	8.66%	0.00%	0.00%	0.00%	3.76%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	91.39%	60.12%	45.21%	26.30%	9.43%	12.22%	40.78%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.00%
Өр төлбөрийн нийт дүн	91.39%	60.12%	45.21%	26.30%	9.43%	12.22%	40.78%
Эздийн хувийн өмч	8.94%	56.52%	64.78%	71.61%	55.82%	55.97%	52.27%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00%	0.00%	0.00%	0.00%	32.54%	28.47%	10.17%
Хуримтлагдсан ашиг	-0.33%	-16.64%	-9.99%	2.09%	2.21%	3.34%	-3.22%

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

Эздийн өмчийн дүн	8.61%	39.88%	54.79%	73.70%	90.57%	87.78%	59.22%
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	100%	100%	100%	100%	100%	100%	100%

Айтүүлс ХХК-ийн санхүүжилтийн эх үүсвэрийг сүүлийн 5 жилийн дунджаар авч үзвэл нийт эх үүсвэрийн 40.7 орчим хувийг зээллэгийн эх үүсвэрээр бүрдүүлсэн байна. Нийт эх үүсвэрийн 50-аас дээшгүй хувийг зээлээр санхүүжүүлэхийг олон улсын практикт зохистой гэж үздэгийг харгалзвал үнэт цаас гаргагчийн хувьд санхүүжилтийн эх үүсвэр зохистой байна.

Хүснэгт 60. Үнэт цаас гаргагчийн 2011-2016 оны хураангуй орлогын тайланд хийсэн бүтцийн шинжилгээ

Үзүүлэлт	2011	2012	2013	2014	2015	2016	Дундаж
Борлуулалтын орлого (цэвэр)	100%	100%	100%	100%	100%	100%	100%
Борлуулалтын өртөг	0.00%	4.22%	25.62%	62.91%	27.08%	20.03%	23.31%
Нийт ашиг (алдагдал)	100.00%	95.78%	74.38%	37.09%	72.92%	79.97%	76.69%
Бусад орлого	0.00%	0.72%	0.11%	0.01%	1.51%	0.00%	0.39%
Ерөнхий ба удирдлагын зардал	104.15%	136.18%	80.49%	40.82%	70.63%	77.48%	84.96%
Бусад зардал	0.00%	-0.01%	3.89%	1.89%	0.00%	0.57%	1.06%
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-4.15%	-39.69%	-10.13%	-7.77%	3.80%	4.34%	-8.93%
Орлогын татварын зардал	0.00%	0.00%	0.00%	0.00%	0.25%	0.48%	0.12%
Татварын дараах ашиг (алдагдал)	0.00%	-39.69%	-10.13%	-7.77%	3.55%	3.86%	-8.36%

Үнэт цаас гаргагчийн 2016 оны борлуулалтанд эзлэх ашгийн хувь хэмжээ 2012-2016 оны дунджаас өндөр түвшинд, ашгийн түвшин эерэг үзүүлэлттэй гарсан. Эхний жилүүдэд ашгийн түвшин бага байгаа нь шинээр бүтээн байгуулалт хийж, байр ашиглалтанд оруулж, тоног төхөөрөмж бүрдүүлсэн болон шинэчилсэнтэй холбоотой. Дээрх хугацаанд үйл ажиллагааны зардлын түвшин дараалан өсч байгааг цаашид анхаарах нь зүйтэй юм.

Хүснэгт 61. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдалд хийсэн харьцааны шинжилгээ

Санхүүгийн харьцааны нэр	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	Дундаж
А. Төлбөрийн чадвар болон санхүүгийн тогтвортой байдалд хийсэн шинжилгээний үр дүн							
Эргэлтийн харьцаа	0.11	0.88	1.27	1.44	1.76	1.69	1.19
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	0.02	0.32	0.91	0.81	1.10	1.08	0.71
Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн харьцаа	10.62	1.51	0.83	0.36	0.10	0.14	2.26
Санхүүгийн хөшүүрэг	-	2.51	1.83	1.36	1.10	1.14	1.32
Өрийн харьцаа	0.91	0.60	0.45	0.26	0.09	0.12	0.41
Авлага цуглуулах дундаж хугацаа	-	9.70	8.90	15.60	39.11	51.49	20.80
Б. Хөрөнгийн ашиглалт болон компанийн ашигт ажиллагааны байдалд хийсэн шинжилгээний үр дүн							
Нийт хөрөнгийн эргэц	0.08	0.42	0.87	0.31	0.19	0.29	0.36
Үндсэн хөрөнгийн эргэц	0.10	0.90	2.00	0.50	0.24	0.41	0.69
Бараа материалын эргэц /удаа/	-	0.70	7.10	1.80	0.85	0.79	1.87
Авлагын эргэц /удаа/	-	3.80	40.75	23.30	9.33	9.33	14.42
Хувь нийлүүлсэн хөрөнгийн эргэц	0.93	1.05	1.58	0.43	0.35	0.52	0.81
Ашгийн норм /нийт ашгаар тооцсон/	100%	96%	74%	37%	73%	80%	77%
Ашгийн норм /ү.а-ны ашгаар	0%	1%	0%	0%	4%	4%	1%

тооцсон/							
Ашгийн норм /цэвэр ашгаар тооцсон/	0%	-40%	-10%	-8%	4%	4%	-8%
Хөрөнгийн өгөөж	0%	-17%	-9%	-2%	1%	1%	-4%
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж	0%	-42%	-16%	-3%	1%	2%	-10%

Үнэт цаас гаргагчийн өр төлбөрөө барагдуулах чадвар нь зохистой хэмжээтэй харьцуулахад сайн, дунджаар авч үзвэл урт хугацаанд төлбөр барагдуулах чадвар нь 119 хувьтай, дунд хугацаанд 71 орчим хувьтай байна. Үнэт цаас гаргагчийн төлбөр барагдуулах санхүүгийн нөөцийн ихэнх нь авлага байгаа бөгөөд авлагын ихэнх нь дотоод авлага байгаа нь ойрын хугацаанд төлбөр барагдуулах чадварын эрсдлийг бууруулж байна, мөн компанийн санхүүгийн байдал харьцангуй тогтвортой, санхүүжилтийн эх үүсвэрийн бүтэц зохистой, өрийн болон өмчийн харьцааны үзүүлэлтүүд зохистой харьцааны шалгуурыг хангаж байна. Ерөнхийдөө өр төлбөр эздийн өмчийн харьцаа 1-ээс ихгүй байхыг, өрийн харьцаа 0.5-аас ихгүй байхыг зохистой гэж үздэг ба Айтүүлс ХХК-ийн хувьд энэ харьцаанууд 2011 онд үүсгэн байгуулагдсан жил өндөр байсан, түүнээс хойшхи жилүүдэд тасралтгүй буурч, 2016 оны эцсийн байдлаар өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа нь 0.14, өрийн харьцаа нь 0.12 болсон байна.

Дээрх эргэлтийн харьцааны шинжилгээнээс харахад компанийн авлага цуглуулах хугацаа сүүлийн 5 жилийн дунджаар 20.8 хоног байгаа нь авлагын эргэц хэвийн байгааг илэрхийлж байна. Мөн нийт хөрөнгийн эргэцийн дундаж 0.36 байгаа нь тааруухан үзүүлэлт ба өмнөх жилтэй харьцуулахад 2016 онд 0.1 нэгжээр өссөн нь хөрөнгийн ашиглалт нэмэгдэж байгааг илтгэж байна. Энэ нь нэг талаас компанийн эрхэлдэг үйл ажиллагааны онцлогтой холбоотой ч нөгөө талаас ашиг авчрах хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь доогуур байгаатай холбоотой байна.

Ерөнхийд нь дүгнэвэл 2015-2016 онд үнэт цаас гаргагч нь орлого, ашгаа зохих хэмжээгээр өсгөж чадсан байна. Энэ менежмент, нөхцөл байдлыг цаашид хэвээр хадгалж, улам хөгжүүлж ажиллах нь зах зээлд эзлэх нэр хүнд, байр суурийг дээшлүүлж, компанийн үнэ цэнэд эерэг нөлөө үзүүлэх болно.

Цаашдын төлөвлөгөө, ирээдүйн боломж

Үнэт цаас гаргагч нь 2016 оноос Дархан-Уул аймагт байрших өөрийн эзэмшлийн газарт олон улсын TIER III стандартыг хангасан “Модуляр дата төвийн парк” байгуулахаар ажиллаж байна. Модуляр дата төв гэдэг нь дата төвийн зориулалтаар үйлдвэрлэгчээс урьдчилан инженерчлэгдэж үйлдвэрлэсэн тусгай контейнерэн модулийг хэлдэг ба угсрах, зөөвөрлөн тээвэрлэхэд хялбар, өгөгдлийн ачааллын хүчин чадлыг нэмэх, хасах боломжтой уян хатан чанартай, өртөг багатай, дата төвийн хамгийн сүүлийн үеийн шийдэл юм. Монголд ийм дата төв одоогоор байхгүй ба үнэт цаас гаргагч нь энэхүү шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлэхээр зорьж байна. Түүнчлэн, энэхүү шинэлэг дата төвийг нийслэл хотоос 220 км-ийн зайд орших Дархан хотод байгуулах гэж байгаа нь газарзүйн нөөц дата төвийн үүргийг гүйцэтгэх юм.

Айтүүлс ХХК нь төслийн хугацаанд нэг ширхэг иж бүрэн модуль буюу контейнерийг худалдан авч, харилцагчиддаа дата төвийн үйлчилгээ шууд үзүүлэхээс гадна бусад байгууллагуудад модуляр дата төвийг танилцуулан нэвтрүүлж, тэдгээрийн эзэмшлийн модулийг өөрийн Модуляр дата төвийн паркад байршуулан үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн байна.

Модуляр дата төвийн парк төслийг санхүүжүүлэхэд 1.3 тэрбум гаруй төгрөг шаардлагатай ба энэхүү хөрөнгийг олон нийтээс татан төвлөрүүлэх тухай шийдвэрийг компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуулийн дагуу гаргасан байна. Айтүүлс ХХК-ийн 2017 оны 3-р сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 08 тоот тогтоолоор 13,387,980 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган, нэг бүрийг нь 100.00 төгрөгөөр олон нийтэд санал болгож, 1,338,798,000 төгрөг татан төвлөрүүлснээр компанийн нийт хувьцааны 38.86 хувийг олон нийтэд гаргахаар тогтжээ.

Татан төвлөрүүлэх хөрөнгийн задаргаа

№	Хөрөнгө оруулалт	Нэгж	Нэгжийн үнэ, төгрөг	Нийт үнэ, төгрөг	Хувь
1	Паркийн барилга	900 м.кв	550,000	495,000,000	37.0%
2	Цахилгааны систем	1	120,000,000	120,000,000	9.0%
3	Хөргөлтийн систем	1	80,000,000	80,000,000	6.0%
4	Тоног төхөөрөмж	1	119,000,000	119,000,000	8.9%
5	Гадна дэд бүтэц	1	151,900,000	151,900,000	11.3%
6	Контейнерэн модуль	1	345,000,000	345,000,000	25.8%
7	Тавилга, эд хогшил	1	27,898,000	27,898,000	2.1%
Нийт дүн				**1,338,798,000**	**100%**

Үнэт цаас гаргагч нь 2017-2021 оны хооронд Модуляр дата төвийн парк төслийг хэрэгжүүлснээр 10.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, төслийн эцэст 4.9 тэрбум төгрөгийн ашиг хуримтлуулахаар төлөвлөсөн байна. Борлуулалтын орлогын 46.8 хувийг Модуляр дата төвийн паркийн үйл ажиллагаанаас олох бөгөөд 53.2 хувийг одоо эрхэлж буй үндсэн үйл ажиллагаанаас тус тус олохоор байна

Үнэт цаас гаргагчийн 2017-2021 оны орлогын төсөөлөл, мянган төгрөгөөр

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	Нийт
Үндсэн үйл ажиллагааны борлуулалт	616,821	832,708	1,082,521	1,380,214	1,725,268	5,637,532
Модуляр дата төвийн борлуулалт	246,000	743,400	1,098,090	1,403,042	1,473,194	4,963,725
Нийт борлуулалт	**862,821**	**1,576,108**	**2,180,611**	**2,783,256**	**3,198,461**	**10,601,257**
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	108,578	146,580	190,554	242,956	303,695	992,363
Нийт ашиг (алдагдал)	**754,243**	**1,429,528**	**1,990,057**	**2,540,299**	**2,894,766**	**9,608,894**
Үйл ажиллагааны зардал	578,769	766,324	844,338	913,513	957,101	4,060,043
Үйл ажиллагааны цэвэр ашиг/алдагдал	175,475	663,205	1,145,719	1,626,787	1,937,665	5,548,851
Татвар, 10%	17,547	66,320	114,572	162,679	193,767	554,885
Цэвэр ашиг (алдагдал)	**157,927**	**596,884**	**1,031,147**	**1,464,108**	**1,743,899**	**4,993,966**
Хуримтлагдсан цэвэр ашиг (алдагдал)	157,927	754,811	1,785,959	3,250,067	4,993,966	-

Хөрөнгө оруулалтын өгөөж

Үнэт цаас гаргагчийн 2017-2021 оны хооронд хэрэгжүүлэх төслийн тооцоололд үндэслэн хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоход дараах үр дүн гарч байна. Үүнд:

Хүснэгт 62. Хөрөнгө оруулалтын өгөөж

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021
Нийт ахиуц ашиг	87.40%	90.70%	91.30%	91.30%	90.50%
Цэвэр ахиуц ашиг	18.30%	37.90%	47.30%	52.60%	54.50%
Үйл ажиллагааны ахиуц ашиг	20.30%	42.10%	52.50%	58.40%	60.60%
Татварын өмнөх ахиуц ашиг	20.30%	42.10%	52.50%	58.40%	60.60%
Нийт хөрөнгийн өгөөж	5.10%	17.10%	24.50%	28.00%	27.00%
Эздийн өмчийн өгөөж	5.50%	18.20%	25.70%	29.10%	27.90%
Нийт хөрөнгийн эргэц	5.70%	19.00%	27.20%	31.10%	30.00%
Нэгж хувьцааны өгөөж					
Нийт хувьцааны тоо ширхэг	34,452,124				
Эзэмшигчдийн өмч	2,917,224,402	3,514,108,569	4,545,255,984	6,009,364,074	7,753,262,844
Дансны үнэ	84.67	102	131.93	174.43	225.04
Нэгж хувьцаанд ногдох ашиг /EPS/, төгрөг	4.58	17.33	29.93	42.5	50.62
Үнэ ашгийн харьцаа, (P/E)	25.59	8.16	6.11	5.69	6.16
Үнэ ба эзэмшигчдийн өмчийн харьцаа, (P/B)	1.39	1.39	1.39	1.39	1.39
Хувьцааны боломжит зах зээлийн үнэ, төгрөг	117.3	141.3	182.76	241.63	311.75
Боломжит зах зээлийн үнэлгээ, төгрөг	4,041,234,145	4,868,098,433	6,296,548,071	8,324,778,604	10,740,603,472
Боломжит ханшийн өсөлт	17.30%	20.50%	29.30%	32.20%	29.00%
Боломжит ханшийн өгөөж	3.90%	12.30%	16.40%	17.60%	16.20%
Анхны хөрөнгө оруулалтын өгөөж	17.30%	41.30%	82.80%	141.60%	211.80%

Нийт ахиуц ашгийн түвшин төслийн эхний жилд 87.4 хувь байх бол төслийн эцэст 90.5 хувь хүртэл өсч байгаа нь бүтээгдэхүүний үндсэн өртөг буурч байгааг харуулж байгаа ба борлуулалтын өртгийн түвшин бага байгаа нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлогоос шууд хамааралтай юм. Мөн үнэт цаас гаргагчийн цэвэр ахиуц ашгийн түвшин төслийн жилүүдэд жилд дунджаар 42 хувь, үйл ажиллагааны ашгийн түвшин жилд дунджаар 46.8 хувь, хувьцааны дансны үнэ жилд дунджаар 23 хувь тус тус өсөхөөр байна.

Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) нь 2017 онд 4.58 төгрөг байгаа нь жил бүр өсч, 2021 онд 225.04 төгрөг хүрэхээр байна. Үйл ажиллагаа нь дөнгөж эхэлж буйтай холбоотойгоор төслийн эхний жил үнэ ашгийн харьцаа (P/E) нь өндөр гарч байгаа ч төслийн эцэст хөрөнгө оруулагчдын хувьд хүлээн зөвшөөрөгдөхүйц дүн болох 6.16 болохоор байна. Үнэт цаас гаргагчийн нэгж хувьцааны дансны үнийн өөрчлөлтөнд үндэслэн зах зээлийн боломжит ханшийг тооцоолсон бөгөөд төслийн эхний жилд зах зээлийн боломжит ханш 117.3 төгрөг байхаар, цаашид жилд дунджаар 28 хувь өсч, 2021 онд 311.7 төгрөгт хүрэхээр таамаглалаа. Энэхүү таамаглалд үндэслэн тооцоолвол Айтүүлс ХХК-ийн нэмж гаргаж буй үнэт цаасанд

анх хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчийн хувьд төслийн жилүүдэд 173-211.8 хувь хүртэлх ханшийн зөрүүний өгөөж хүртэх боломжтой байна.

Зах зээлийн орчин

Мэдээллийн технологи, интернэтийн сүлжээ нь дэлхий дахиныг холбож, хүмүүсийн амьдралд өргөнөөр нэвтэрч, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн төдийгүй төрийн үйлчилгээтэй салшгүй холбоотой болсон. Манай улсад ч мөн адил мэдээлэл, харилцаа холбооны салбар хурдацтай хөгжиж, компьютер, интернэт, ухаалаг гар утас зэрэг нь иргэдийн өдөр тутмын хэрэглээ, аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд вэбсайт, цахим үйлчилгээ нь зайлшгүй байх ёстой үзүүлэлт болсон байна. Төрөөс энэ салбарыг чухалчилж, тусгай бодлого, хөтөлбөрүүдээр дэмжсээр ирсэн ба 2016-2025 онд баримтлах дунд хугацааны бодлогын төсөл болон Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль, Өгөгдөл хамгаалах тухай хууль болон Цахим засгийн тухай хуулийн төслүүдийг боловсруулж батлуулахаар ажиллаж байна. Олон улсын түвшинд харьцуулбал Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн түвшин Азийн хөгжиж буй улс орнуудаас дээгүүр байна.

Дотоодын зах зээлийн хувьд үнэт цаас гаргагчийн үндсэн үйлчилгээний чиглэл болох дата төвийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага одоогоор цөөн байна. Вэб байршуулах үйлчилгээ үзүүлж ирсэн томоохон өрсөлдөгч компаниуд нь ихэвчлэн гадаадын сүлжээнд зуучлан байршуулдаг тул гуравдагч улсаас хамааралгүй дотооддоо үйлчилгээ үзүүлэх зах зээлийн орон зай хангалттай байгаа юм. Модуляр дата төв одоогоор Монголд байхгүй байгаа ба энэхүү шинэлэг үйлчилгээг өөрийн улсад анх удаа нэвтрүүлснээр үүрэн тооцооллын болон бусад технологид суурилсан өөр бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, нэвтрүүлэх боломжийг нээж байна.

Салбарын хөгжил дэвшил ийнхүү сайн байхын сацуу мэдээллийн технологийг дагалддаг асуудлууд мөн ар араасаа хөврөн гарч байгаагийн нэг нь мэдээллийн аюулгүй байдлын асуудал юм. Цахим мэдээллээ аюулгүй орчинд хадгалуулахыг цахим өгөгдөл, мэдээлэл эзэмшигч бүр хүсч байгаа ба үнэт цаас гаргагчийн байгуулахаар төлөвлөж буй модуляр дата төвийн парк нь цахим мэдээллийн аюулгүй орчныг жинхэнэ утгаар нь хангаж ажиллах цогц шийдэл болж чадах юм. Энэ асуудлыг төрөөс чухалчилж, хуулийн зохицуулалт хийхээр Мэдээллийн аюулгүй байдал болон өгөгдөл хамгаалах тухай хуулийн төслүүдийг 2015 онд боловсруулсан байна.

Түүнчлэн, нэг талаас мэдээллийн технологи нь орон зай, цаг хугацааны хязгаараас үл хамааран үйлчилгээ үзүүлэх боломжийг олгодог, нөгөөтэйгүүр Монгол улс байгалийн болон хүнээс үүдэлтэй давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл харьцангүй бага, стратегийн ач холбогдолтой бүс нутагт хамаарах тул гадаадаас харилцагч татаж, олон улсын дата төв болох боломж их байна.

Эрсдэл

Хөрөнгө оруулагчдын хувьд хувьцааны ханшийн өсөлт болон ногдол ашгийн өгөөж чухал байдаг тул энэхүү танилцуулгад санал болгож буй үнэт цаасны ханш урт хугацаанд тогтмол

СЭХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

өсч байгаа харагдаж байгаа ч хувьцаанд хөрөнгө оруулах нь ямагт эрсдэлтэй байдаг тул танилцуулгын эрсдлийн шинжилгээний хэсгийг сайтар уншиж танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна. Танилцуулгад дурдсан эрсдлийн хүчин зүйлсээс гадна үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлж болох өөр эрсдлүүд үүсэх боломжтой. Эрсдлүүд нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт, ирээдүйн ашигт сөргөөр нөлөөлөх боломжтой ба энэ нь үнэт цаасны ханшид нөлөөлж хувьцааны ханш буурвал хөрөнгө оруулагч өөрийн оруулсан бүх хөрөнгө эсвэл хөрөнгийн зарим хэсгийг алдах эрсдэлтэйг анхаарна уу.

Үнэт цаас гаргагчийн хувьд болзошгүй эрсдлүүдийг урьдчилан тодорхойлж, эрсдлийг зөв удирдаж чадвал үйл ажиллагаанд учрах аливаа сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах боломжтой.

Дүгнэлт

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хувьцаат компани одоогоор ганц байгаа нь Оллоо ХК юм. Харилцаа холбооны салбарт Монголын цахилгаан холбоо ХК, Монгол шуудан ХК гэсэн хоёр хувьцаат компани байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа эдгээр компаниудаас ялгаатай бөгөөд одоогоор дата төвийн үйлчилгээ үзүүлэгч цорын ганц нээлттэй хувьцаат компани болох боломжтой ба олон нийтэд нээлттэй компани болсноор энэхүү салбарыг сонирхогчдод салбарын хөгжлийн өгөөжөөс хүртэх боломжийг олгох юм.

Үнэт цаас гаргагчийн хувьд нийт хувьцааныхаа 38.86 хувийг олон нийтэд санал болгож байгаа, зах зээлийн үнэлгээ нь 1 тэрбум төгрөгөөс дээш буюу 3.4 тэрбум төгрөг, компани бүртгэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах хангалттай хэмжээний эргэлтийн хөрөнгөтэй, компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь үйл ажиллагаа явуулахад шаардагдах туршлагатай, бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр үүрэгжээгүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой зэрэг Монголын хөрөнгийн биржийн II ангиллын шалгуурыг хангаж байна гэж үзэж байна.

Үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ /тогтоосон үнэ 100.00 төгрөгөөр тооцоолсон/

Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо, ширхэг	Эзэмшлийн үнийн дүн, төгрөг	Хувь
Ай Си Ти групп ХХК	21,064,144	2,106,414,400	61.14%
Олон нийт	13,387,980	1,338,798,000	38.86%
Компанийн нийт үнэлгээ	34,452,124	3,445,212,400	100%

Бизнесийн орчны хувьд Монголд төдийгүй дэлхий дахинд эрчимтэй хөгжиж буй мэдээллийн технологийн салбарын өргөн боломж, дотоодын өсөн нэмэгдэж буй мэдээллийн технологийн хэрэглээ, төрөөс мэдээллийн технологи, цахимжуулалтын талаар баримталж буй бодлого, хөтөлбөрийн дэмжлэг нь үнэт цаас гаргагчид энэ салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулах таатай нөхцөл, нээлттэй орон зайг бүрдүүлж байна.

УЛААНБААТАР ХОТ
itools
АЙТҮҮЛС
ХХК
1116218269 ☎ 5468361

УЛААНБААТАР ХОТ
СТАНДАРТ
ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
ТТС3981 ☎ 5444381

Тиймээс, хөндлөнгийн байгууллагуудын бие даасан дүгнэлт, үнэлгээ, тодорхойлолт болон үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны танилцуулга, салбарын судалгаа, бизнесийн төлөвлөгөөнд үндэслэн, Айтүүлс ХХК-ийн үйл ажиллагаа хэдийнээ жигдэрч, ашигт ажиллагаа нь жил бүр сайжирч, цаашид интернэтэд суурилсан өндөр технологийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах чадвартай удирдлага, мэргэжлийн баг бүрдүүлж чадсан, компанийн сайн засаглалыг хангаж ажиллах боломжтой гэж дүгнэж байна. Түүнчлэн, үнэт цаас гаргагч нь нийт хувьцааны 38.86 хувийг олон нийтэд санал болгож, 1,338,798,000 төгрөгийн хөрөнгө татаж, газарзүйн Модуляр дата төвийг Дархан хотод байгуулах төсөл нь амжилттай хэрэгжсэнээр 2021 оны эцэст хувьцааны ханш анхдагч зах зээлд санал болгох тогтоосон үнэ 100.00 төгрөгөөс 311.75 төгрөгт хүрч, 3.1 дахин өсөх боломжтой гэж тооцоолоо.

Модуляр дата төвийн паркийг байгуулан, дотооддоо нэвтрүүлснээр үнэт цаас гаргагч нь мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг бүх нийтийн хэрэглээ болгох, мэдлэгт суурилсан нийгэм, эдийн засгийг хөгжүүлэхэд мэдээлэл, харилцаа холбооны дэвшлийг өргөн хүрээтэй нэвтрүүлсний үндсэн дээр Монгол Улсын хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад тодорхой хувь нэмэр оруулж чадах юм.

Салбарын хэмжээнд 2015-2016 онд чухал бодлогын баримт бичгүүд боловсруулагдаж, эрх зүйн таатай орчин бүрдэх гэж буйгаас гадна, хөдөө орон нутагт интернэтийн хурд нэмэгдэж, үнэ 2 дахин буурсан, Улаанбаатар хотод 4G LTE технологи нэвтэрч эхэлсэн зэрэг эерэг өөрчлөлтүүд гарсан нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөхөөр байна.

ЗУРГАА. АНДЕРРАЙТЕРИЙН ТАНИЛЦУУЛГА

Стандарт инвестмент ҮЦК ХХК /РД:5444381/ нь 2011 оны 1-р сарын 25-ны өдөр Улсын бүртгэлд бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн биржийн гишүүн, Монголын арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн компани юм.

Стандарт инвестмент ҮЦК ХХК нь андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд Мерекс ХК-ийн хувьцааг анх удаа нийтэд санал болгох ажиллагааг 2014 онд зохион байгуулж, нийт 2.6 тэрбум төгрөгийг амжилттай босгосон. 2015 онд Баянбогд ХК-д Стандарт проперти групп ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн. Мөн Уужимхангай ХК-д Стандарт агрикалчер групп ХХК-ийг нэгтгэх үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг хүлээж байна.

Байгуулагдснаасаа хойш “Бид санхүүгийн соёлыг түгээнэ” уриан дор нийт 30 гаруй мянган харилцагчдад брокерийн үйлчилгээ үзүүлж, 2016 оны 12-р сарын байдлаар нийт 24 гаруй тэрбум төгрөгийн арилжаа хийсэн.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ГИШҮҮНЧЛЭЛ	Огноо
Үнэт цаасны зах зээлд брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /СЗХ-ны №141 тогтоол/	2011.05.06
Монголын хөрөнгийн биржийн гишүүн /СЗХ-ны №16 тогтоол/	2011.08.17
Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /СЗХ-ны №292 тогтоол/	2011.10.12
Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /СЗХ-ны №137 тогтоол/	2012.05.09
Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн	2011.12.14
Монголын бизнесийн зөвлөлийн гишүүн	2012.01

СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ
Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 5/3
Утас/факс: 70114433
Хариуцсан ажилтан: Б.Эрдэнэжаргал (шууд холбогдох утас 99072783)
Цахим хуудас: www.standardinvestment.mn
Цахим шуудан: info@standardinvestment.mn

“Модуляр дата төвийн парк” төслийн бүтээн байгуулалтын төлөвлөлт, сараар

Хавсралт-1

№	БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ	Үргэлжлэх хугацаа /7 хоног/	2017 ОН 5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
Нэг	**Паркийн болон оффисийн барилга**	30								
1.1	Архитектур төлөвлөлтийн даалгавар авах	2								
1.2	Эскиз батлуулах	1								
1.3	Техникийн нөхцөл авах	3								
1.3.1	*Ус суваг*	3								
1.3.2	*Дулаан*	3								
1.3.3	*Цахилгаан*	3								
1.3.4	*Холбоо*	3								
1.4	Геологийн дүгнэлт гаргуулах	3								
1.4.1	*Геологийн дүгнэлт хийлгэх*	2								
1.4.2	*Экспертизээр батлуулах*	1								
1.5	Ажлын зураг	6								
1.5.1	*Ажлын зураг хийлгэх*	4								
1.5.2	*Экспертизээр батлуулах*	2								
1.6	Барилга эхлэх зөвшөөрөл авах	1								
1.7	Улаан шугам тавих	1								
1.8	Барилга угсралт, заслын ажил	12								
1.9	Улсын комисс ажиллах	4								
Хоёр	**Гадна дэд бүтэц**	9								
2.1	Дулаан	9								
2.2	Цахилгаан	9								
2.3	Ус, суваг	9								
2.4	Холбоо, шилэн кабель	9								
Гурав	**Контейнер дата төв**	4								
3.1	Захиалах	3								
3.2	Хүлээн авах	1								
Дөрөв	**Цахилгааны систем**	4								
4.1	Генератор худалдан авах	2								
4.2	Генератор суурилуулах	2								
Тав	**Хөргөлтийн систем**	4								
5.1	Агаар салхивчны систем худалдан авах	2								
5.2	Агаар салхивчны систем суурилуулах	2								
Зургаа	**Тоног төхөөрөмж**	4								
6.1	Тоног төхөөрөмж захиалах, худалдан авах	2								
6.2	Тоног төхөөрөмж суурилуулах	2								
Долоо	**Өргөгч кран**	4								
7.1	Өргөгч кран захиалах	2								
7.2	Хүлээн авч угсрах	2								
	Тавилга эд хогшил худалдан авах	2								

СЗХ
он сар өдөр
2017 09 27
БҮРТГЭВ
№ 01

itools АЙТУУЛС
УЛААНБААТАР ХОТ
1116218260 ᠬᠣᠲᠠ 5468361

СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ТТС3981 ᠬᠣᠲᠠ 5444381

ХАРААТ БУС ДҮГНЭЛТҮҮД */бүрэн эхээр/* *Бусад хавсралтууд*

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Хөрөнгийн үнэлгээ
3. Бизнесийн үнэлгээ
4. Хуулийн дүгнэлт